



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-125

1.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ	8-9
2.“Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	9-47
3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлт /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/	47-55
4.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	55-97
5.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	97-125

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 03-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 73 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Булгантуяа, Ж.Галбадрах, Н.Наранбаатар,
О.Номинчимэг, С.Одонтуяа, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, С.Цэнгүүн;

Чөлөөтэй: Б.Баярбаатар, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Ж.Баярмаа;

Тасалсан: Х.Баттулга;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-15 минут, Н.Алтанхуяг-06 минут,
М.Бадамсүрэн-30 минут, Б.Батбаатар-07 минут, Д.Батбаяр-02 минут,
Б.Батцэцэг-33 минут, Э.Батшугар-16 минут, Ж.Бат-Эрдэнэ-01 минут,
Х.Болормаа-01 минут, С.Ганбаатар-04 минут, Д.Ганбат-22 минут, Л.Гантөмөр-
23 минут, М.Ганхүлэг-01 минут, Б.Жаргалан-12 минут, Ж.Золжаргал-15 минут,
С.Лүндэг-20 минут, Ц.Мөнхтуяа-01 минут, З.Мэндсайхан-04 минут,
Н.Номтойбаяр-03 минут, Х.Тэмүүжин-06 минут, А.Ундраа-10 минут, Н.Учрал-23
минут, Г.Уянгахишиг-08 минут, Г.Хосбаяр-05 минут, Ж.Чинбүрэн-01 минут,
Л.Энх-Амгалан-09 минут, Б.Энхбаяр-50 минут, Ж.Энхбаяр-29 минут, Л.Энхнасан-
01 минут, Р.Эрдэнэбүрэн-13 минут.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасны дагуу Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Засгийн газраас 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлснийг Нийгмийн бодлогын байнгын хороонд;

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлснийг Нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсныг мэдээлэв./10:02/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-т “Нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж

шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна.” гэж заасны дагуу иргэн Рэгзэнгийн Шинэгэрэлээс нийтийн ашиг сонирхлыг хөндсөн “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3-т заасан орлогод ноогддог албан татварын хэмжээг 1 хувь болгож бууруулах” асуудлаар хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдөл ирүүлснийг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Төсвийн байнгын хороонд хуваарилсныг мэдээлэв./10:03/

Нэг.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болохыг танилцуулав.

Д.Амарбаясгалан: Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 24
Бүгд: 93
74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр“Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Авлигатай тэмцэх газрын дарга

З.Дашдаваа, мөн газрын дэд дарга Г.Азжаргал, Тамгын хэлтсийн дарга З.Баасанням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлт болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Пүрэвдорж, Б.Бейсен, О.Цогтгэрэл, Л.Мөнхбаясгалан, Д.Жаргалсайхан, А.Ариунзаяа, Х.Ганхуяг, С.Эрдэнэболд, П.Мөнхтулга, Л.Энхнасан, Ж.Чинбүрэн, Н.Номтойбаяр, Х.Тэмүүжин, Б.Батбаатар, Л.Энх-Амгалан, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, М.Мандхай, Ц.Мөнхбат, Д.Үүрийнтуяа, Б.Заяабал, Л.Мөнхбаатар, Д.Батлут нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 83

Татгалзсан: 29

Бүгд: 112

74.1 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Ж.Батжаргал, Д.Батлут, Ш.Бямбасүрэн, М.Ганхүлэг, Б.Дэлгэрсайхан, М.Мандхай, Ц.Мөнхтуяа, Ч.Номин, Л.Оюун-Эрдэнэ нарыг дэмжсэнээр тооцож, 83.0 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:18/

Уг асуудлыг 12 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлт /Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүн Э.Энхтуяа оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Энхтуяа, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Л.Мөнхбаатар нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:45/

Уг асуудлыг 12 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүн 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын даргын зөвлөх Т.Алтангэрэл, Н.Отгончимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нар танилцуулав.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 00 минут үргэлжилж, 13 цаг 00 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 00 минутаас Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Л.Мөнхбаясгалан, А.Ариунзаяа, Х.Ганхуяг, Х.Баасанжаргал, Ж.Батжаргал, Г.Очирбат, Ц.Баатархүү, М.Энхцэцэг, С.Зулпхар, Д.Энхтүвшин, Б.Батбаатар, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын даргын зөвлөх Т.Алтангэрэл, Н.Отгончимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 106
Бүгд: 112

5.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх санал хураалтыг Улсын Их Хурлын гишүүдийн ирц хангалтгүй байгаа тул хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:00/

Уг асуудлыг 16 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Нийтийн эрх зүйн хэлтсийн шинжээч О.Мандах, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Батболд, Гадаадын иргэн харьяатын газрын Захиргаа удирдлагын газрын дарга И.Баатархүү, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга Б.Батдэлгэр, Хэрэг бүртгэх албаны Зөрчлийн хэрэг бүртгэлт, мэргэжил, арга зүйн хэлтсийн дарга Т.Эрдэнэлхагва, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хуулийн тэлтсийн дарга Д.Сандаг, Хил хамгаалах ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга О.Сувд-Эрдэнэ, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ш.Маяа, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч, өмгөөлөгч Л.Данзанноров, Хууль зүйн туслалцааны төвийн Мэргэжил арга зүйн хэлтсийн дарга А.Амарсайхан нар

оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Энхтуяа, О.Цогтгэрэл, Х.Баасанжаргал, Б.Уянга, Ц.Идэрбат, Ц.Сандаг-Очир, П.Батчимэг, Б.Хэрлэн, Ц.Мөнхтуяа нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, М.Мандхай, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:31/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 32 минут үргэлжилж, 126 гишүүнээс 113 гишүүн хүрэлцэн ирж, 89.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 00 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая, 73 гишүүн бүртгэгдэж ирц 57.9 хувьтай болсон тул 2025 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 11 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Хоёрдугаарт, АТГ-ын даргыг улируулан томилох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Тавдугаарт, Хүний эрх эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Зургаадугаарт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тух шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Долоодугаарт, Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Наймдугаарт, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Есдүгээрт, Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Аравдугаарт, Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Арван нэгдүгээрт, Баталсан хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя аа.

1.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд, Цусны донорын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарын 4 гишүүн 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлснийг Нийгмийн бодлогын байнгын хороонд, Эрхтэн эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарын 4 гишүүн 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлснийг Нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан. Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя. Иргэн Рэгзэнгийн Шинэгэрэлээс Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн ХХОАТ-ын тухай хуулийн 6.3-д заасан орлогод ноогддог албан татварын хэмжээг нэг хувь болгож бууруулах асуудлаар хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдөл ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл гомдлын системд 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр нийтэлсэн. Энэ өргөдөл 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 100187 иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний дагуу Төсвийн байнгын хороонд хуваарилж байна.

Төсвийн байнгын хороо иргэдийн гаргасан өргөдөлд дурдсан асуудлыг хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй.

Хэлэлцэх асуудалдаа оръё. [Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.](#)

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн

хуралдаанд оруулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Төслүүдийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа.

Одоо Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

69 гишүүн буюу 74.2 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Эдийн засгийн байнгын хороо энэ яаралтай хэлэлцэх төслөө аваад иргэд, олон нийт, аж ахуйн нэгж бизнес эрхлэгчидтэй бас энийг хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулах нь шаардлагатай шүү. Яаралтай өргөн баригдаж байгаа төсөл учраас нөгөө олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийгдэлгүйгээр шууд орж ирж байгаа.

Тийм учраас энэ асуудлыг шийдвэрлэхдээ богино хугацаанд энэ хэлэлцүүлгийг зохион байгуулах ёстой шүү. Тэрэн дээр бас анхаараарай.

Ажлын хэсэг байгуулаад ажиллана аа.

Хэлэлцэх асуудал дараагийн асуудалд оръё. [АТГ-ын даргыг улируулан томилох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ.](#)

Холбогдох ажлын хэсгийн болон нэр дэвшигчийг танхимд оруулж ирье.

Төслийн талаар ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдаас АТГ-ын даргаар Зандраагийн Дашдавааг улируулан томилуулах тухай саналыг 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг ХЗБХ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан журмын дагуу 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг танилцуулсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар АТГ-ын даргыг улируулан томилуулах тухай асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Эрдэнэтийн 49 хувь, Дубайн гэрээ зэрэг томоохон хэргүүдэд нэр холбогдож гадаад улсад оргон зайлсан төрийн өндөр албан тушаалтнуудыг олж эх оронд нь авчран хариуцлага хүлээлгэх ажлын явцын талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг АТГ-ын даргын бүрэн эрхийн хугацаанд хийсэн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийдэг эсэх, үнэлгээтэй танилцаж болох эсэх талаар, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт туссан зорилтуудын хүрээнд хамгийн эрсдэл өндөртэй байгаа жагсаалтаа гаргаж дотоод болон гадаад хөндлөнгийн нөлөөлөл буюу улс төрчдөөс очиж байгаа нөлөөллүүдээ үнэлсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан соён гэгээрүүлэх ажлын хүрээнд цаашид хийх ажлын төлөвлөгөөний талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундром Монгол Улс өнгөрсөн жил Авлигын төсөөллийн индексээр 100 онооноос 30 оноо авсан нь АТГ-ын даргын ажлын гүйцэтгэлтэй нийцэж байгаа байгаа эсэх, ирсэн гомдол мэдээллийн хэдэн хувийг шийдвэрлэсэн, үүнээс хэдэн эмч, багш болон Боловсролын зээлийн сантай холбоотой хэдэн хэргийг шалгаж шүүхэд шилжүүлсэн дүн мэдээллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар төрийн албан хаагчдын тоо нэмэгдэж байгаа нь авлигын хэрэг бүртгэгдэж байгаа тоотой хэр уялдаатай байгаа талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг авлигатай тэмцэх асуудал нь зөвхөн нэг байгууллагын асуудал бус бүх нийтийн үйл хэрэг бөгөөд улс төрийн намуудын санхүүжилт ТӨК-удын хэт олон томилгоо, сонгон шалгаруулалт, тендер, худалдан авалт нь ил тод бус авлигыг өдөөж байгаа хүчин зүйл болох нийгмийн суурь дэд бүтцийн хүртээмжгүй байдлыг сайжруулах сэтгэлгээний хандлагыг өөрчлөх шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат АТГ зохих хэмжээнд ажлын гүйцэтгэлтэй байгаа талаар, хэн нэгнийг хилс хэрэгт хэлмэгдүүлэхгүй байх шаардлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр авлигатай тэмцэх дан ганц АТГ-ын ажил биш бөгөөд улс төрчдийн манлайллаас хамаарах үйл хэргийн талаар, бүтээмжийн менежер нэрийн доор авлигыг хөгжүүлж байгааг АТГ-т хяналт тавих, Засгийн газар үүн дээр манлайлан ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара АТГ-ын даргаар улираан ажиллахдаа алдаа дутагдал гаргахгүй, өөрийн удирдлага, зохион байгуулалт дор ажиллаж байгаа алба хаагчдыг хүний төлөө хүний эрхийн мэдрэмжтэй, хариуцлагатай ажиллуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундром авлигатай тэмцэх төсөөллийн индексийг нэмэгдүүлэхэд идэвх санаачилгатай ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурал Засгийн газрын зүгээс хэрхэн дэмжиж ажиллах талаар тус тус үг хэллээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын саналаар АТГ-ын даргыг улируулан томилуулах тухай асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72.2 хувь нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

АТГ-ын даргыг улируулан томилогдох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын саналыг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт болон Байнгын хорооноос

боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Сандаг-Очир гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Зандраагийн Дашдаваа Улсын Их Хурлын чуулганы танхимд хүрэлцэн ирсэн байна. Мөн АТГ-ын дэд дарга Азжаргал, мөн АТГ-ын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Заграагийн Баасанням нар ирсэн байна аа.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Андуураад дарчхаагүй биз дээ. Ахиж нэр өгөх үү? Тэгээд 1 хүнд 10 секундээр хугацаа тогтоогоод асуулт асуугаад үг хэлээд явчих уу? Ингээд 26 хүнээр тасаллаа. Ирсэн ирцийн дарааллаар Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж үг хэлнэ.

П.Сайнзориг: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе ээ. Би зүгээр асуулт гэхээсээ илүүтэй бас нэг зарчмын зүйлийг хэлмээр байгаа юм. Яг авлигатай тэмцэх гэхээр ерөөсөө 1 байгууллагын л асуудал юм шиг. Нэг байгууллагаас энэ авлигалын төсөөллийн индексийг нэхэж байгаа зүйлүүд бас их яригдах юм. Тэгэхээр энэ авлигалын төсөөллийн индекс муу байгаа гэдэг бол Засгийн газар, Улсын Их Хурал хэрхэн ажлаа хийж байгаа вэ л гэдэг л асуудал байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол бид өөрсдөөсөө энэ шаардах ёстой болоод байгаа юм.

Тэгэхээр энэ авлигалын төсөөллийн индексийг урагшлуулахын тулд Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийг, ТӨК-ийн засаглалын асуудлыг, Тендер худалдан авалтын тухай хуулийг, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль зэрэг энэ хуулиудыг батлах асуудал байж байгаа юм аа. Эдгээр хуулиудыг хийж байж энэ авлигалтай тэмцэх асуудал дээр нэлээн ахиц гарна аа.

Дээрээс нь сүүлийн гучаад жил дээр нийгмийн суурь дэд бүтцүүд дээр ерөөсөө хөрөнгө оруулалт хийгээгүй жишээ нь цахилгаан станц гэхэд л 40 жил хөрөнгө оруулалт хийгээгүй байгаа байхгүй юу 4 дүгээр цахилгаан станцаас хойш. Тэгэхээр энэ дэд бүтцийн хүртээмжгүй байдал чинь өөрөө энэ авлигалын суурь шалтгаан болж байгаа. Энэ хүртээмжгүй байдал дээр чинь дулаан цахилгаанд холбогдохын тулд одоо эрх мэдэлтний гэдэг юм уу үүдийг сахиж гарыг нь хүндрүүлэх ийм зүйлүүд явдаг аа. Тэгэхээр энэ зүйлүүдийг шийдэхгүйгээр авлигалын төсөөллийн индексийг урагшлуулах авлигатай тэмцэх ажил дээр ахиц гарахад том бэрхшээлтэй байгаа юм аа.

Тэгэхээр энэ дээр бид нар анхаармаар байгаа юм.

Тэгээд ер нь Транспаренси Интернэйшнал байгууллагаас бол 180 орны яг энэ улс орны энэ авлигалын төсөөллийн индексийг гаргадаг 13 шалгуур үзүүлэлтээр гаргадаг. Манай дээр энэ 13 шалгуур үзүүлэлтийн 8-ыг нь хэрэглэдэг. Тэгээд энэ шалгуур үзүүлэлтээс 8 шалгуур үзүүлэлтээс Дэлхийн банкны эрсдэлийн үнэлгээг авч үздэг, улс орнуудын эрсдэлийн үнэлгээг үздэг. Эргээд Дэлхийн өрсөлдөх чадварын төвийн удирдах ажилтны төсөөллийг үздэг, хууль дээдэх ёсны индексийг үздэг гэх зэрэг ийм 8 шалгуур үзүүлэлтийг авч үздэг ээ.

Тэгэхээр энэ 8 шалгуур үзүүлэлтийг авч үзэх үзэж байж энэ авлигалын төсөөллийн индексийг гаргадаг юм шүү гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм. Тэгэхээр энэ хууль хяналтын байгууллагын оролцоо ерөөсөө энэ төсөөллийн индексийн ерөөсөө арван гуравхан хувийг эзэлдэг. Бусад асуудлууд нь ерөөсөө макро эдийн засгийн асуудлууд байгаа, хууль эрх зүйн орчнууд байгаа, улс төрийн тогтвортой байдлын асуудлууд байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид хэд авлигалын төсөөллийн индексийг урагшлуулъя гэвэл иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг хэрхэн яаж хамгаалж байгаа юм бэ гэдэг асуудлаа шийдэх ёстой. Улс төрийн тогтвортой байдал хүчирхийллийг шийдвэрлэж байгаа байдлаа бид нар анхаарах ёстой. Төрийн үйлчилгээнийхээ үр нөлөө бүтээмжийн асуудлыг бид хэд сайжруулах ёстой. Хууль дээдлэх ёсыг сайжруулж байж энэ авлигалын төсөөллийн индекс урагшилна аа.

Түүнээс биш зөвхөн АТГ-аас бүх зүйлүүдийг нэхээд энэ зүйл урагшилдаггүй гэдэг зүйлийг би ингээд энэ ташрамд хэлмээр байгаа юм аа. Тэгээд бид хэд энэ сэтгэлгээний хувьд ч гэсэн өөрчлөгдмөөр байна. Үр хүүхдүүдээ хөгжүүлэхдээ хүртэл хүний доор битгий ороорой гэж л хэлээд байдаг. Яг эцсийн дүндээ хүнд төвөггүй амьдрах арга ухааныг заадаг байх ёстой. Эргээд ийм зүйлийг хийвэл би чамд ийм зүйлийг өгнө өө, чихэр өгнө өө ч гэдэг юм уу үр хүүхдүүдээ хүмүүжүүлдэг. Тэрнээс биш ийм зүйлийг чи сайн хийсэн байна, ийм зүйлийг дүрмийн дагуу хийсэн байна, ийм зүйлийг чи бусдад тусалж хийсэн байна гэдэг зүйлээр үр хүүхдүүдээ урамшуулж байж энэ сэтгэлгээний буюу буруу зүйлтэй эвлэрэхгүй байх хандлагад суудаг юм аа.

Тэгэхээр энэ хууль эрх зүйн орчин, энэ тал талын оролцоо, энэ хууль хяналтын байгууллагыг ажиллах бүрэн бололцоо төсөв санхүүг нь бүрдүүлэх дээрээс нь энэ ерөөсөө л сэтгэлгээ энэ дэд бүтцийн хүртээмжийг сайжруулж байж бид хэд энэ авлигалын төсөөллийн индексийг урагшлуулна гэдэг зүйлийг би энэ дашрамд хэлмээр байна.

Тэгээд Дашдаваа даргыг зарчмын хувьд дэмжиж байна. Ажилтайгаа танилцах гэдэг юм уу цаг алдах ямар ч шаардлага байхгүй. Тодорхой хийж байгаа ажлууд ч гэсэн үр дүн гарсан. Энэ өнгөрсөн цаг хугацаанд зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ажиллахаасаа гадна авлигалтай тэмцэх энэ үндэсний хөтөлбөрөө батлуулж чадсан байгаа. ФАТФ-ын жагсаалтад.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн үг хэллээ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Пүрэвдорж: Дашдаваа даргыг ерөнхийдөө дэмжиж байгаа. Тэгэхээр өнгөрсөн 2016 оноос хойш бол эрх баригчдын янз янзын хулгай гаарсан л даа. Ковидын хулгай, төсвийн хулгай, ногоон автобусны хулгай, нүүрсний хулгай, аптекийн хулгай, янз янзын хулгайнууд гарсан. Жишээ нь нүүрсний хулгай 44 их наяд төгрөгийн хохиролтой гэдэг нь үнэн байхгүй юу даа. 2019 оноос өмнө Цагаан хад-Ганцмодны хооронд хорин есхөн километр газарт нэг машин нүүрсийг 3 сая төгрөгөөр тээвэр хийдэг байсан чинь яг тэр ковидын үеэр 120 сая төгрөг болгож байгаад баахан хулгай хийчихсэн байхгүй юу даа. Жишээ нь өдөрт 600 машин 120 сая төгрөгөөр тээвэр хийгээд ингээд явахад 44 их наяд төгрөг төгрөг чинь нэг жилд 8 сарын дотор болчхож байгаа байхгүй юу даа. Тэгээд тэр жишээ нь цоо шинэ давхар чиргүүлтэй нүүрсний машиныг 360 сая төгрөгөөр худалдаж аваад банканд нь солерикт дүүргээд солерик нь дуусаагүй байж байхад 3 рейс хийгээд 360 сая

төгрөгөө олчхоод байна шүү дээ. Энэ юмыг бүгдээрээ дээр дооргүй бүгдээрээ нийлж байгаад л ингээд л хийцгээсэн.

Тийм учраас энэ дээр маш хариуцлагатай ажиллах ёстой л гэж би үзэж байгаа юм. Тийм учраас нүүрсний хулгайны талаар ямар асуудлыг яаж дэвшүүлж, тэр их мөнгийг зувчуулсан асуудлыг яаж шийдвэрлэж байгаа юм бэ гэдгийг Дашдаваа даргаас асууя.

Ер нь бол эрх баригч нар бол энэ хэтэрхий их авлигажуулж байна. Ер нь Лениний нөгөө нэг ном байдаг шүү дээ тийм нэг алхам урагшаа, 2 алхам хойшоо гэдэг энэ ийм зарчмаар ажиллаж байгаа. Жишээ нь 2016 онд Си зөвшөөрлийг Хилийн цэрэгт авто тээврийнхэн гуйж энийг бичүүлээд байж байгаач гэдэг тийм хэрэггүй бичиг байсан. Тэр бичгийг өнөөдөр 20 сая төгрөг болгосон. 20 сая төгрөг болгочихсон байгаа. Далд хэлбэрт орчихсон. 9 мянган машин Си зөвшөөрлөө 1 улиралд авахад л 100 гаруй тэрбум төгрөгийн авлигалын юм тэрүүгээр явдаг гэж яригдаад байгаа шүү дээ. Далд хэлбэрт орчихсон ингээд л байж байгаа.

Тийм учраас энэ дээр бас тодорхой арга хэмжээнүүдийг авах ёстой. Зарим хүмүүс тэр бүтээмжийн менежерийг шүүмжлээд байх шиг байгаа юм. Жишээ нь Гашуунсухайтын төмөр зам дээр өнөөдрийн байдлаар 800 гаруй хүн ажилладаг дээрээс нь 100 гаруй хүн гэрээгээр ажилладаг, 9 зуугаад хүн ажилладаг. 950-аад хүн ажилладаг. Тэгээд сардаа нөгөө 7 хоногтоо гав ганцхан тээвэр хийдэг. Тэр их олон хүмүүс тэгээд 180 хүн нь Улаанбаатар хотод энэ захиргаан дээр ажиллаж байдаг ийм л замбараагүй. Тэгээд тэр хүмүүс ерөөсөө сонгуульд ажилласан хүмүүсээ бүгдийг нь төрийн өмчийн компани руу тавьдаг ийм л схемийг өнгөрсөн хугацаанд хийлээ.

Тийм учраас тэр бүтээмжийн менежерүүдийг аваачиж тавьж тэндхийн болохгүй бүтэхгүй байгаа юмыг бас энэ хамтарсан засагт орсон АН-д тодорхой хэмжээгээр бид нарт мэдээлэл өгсний үндсэн дээр бид нар цааш цаашдын арга хэмжээгээ энэ хамтарсан засгийн хувьд авах ёстой гэж үзэж байгаа. Тэгээд энэ болгоныг ингээд л нэг янз янзаар ярьдаг.

Тэгээд энүүгээрээ далимдуулаад цаашаа ингээд засгийнхаа үйл ажиллагаанд бас нэг дэгээ тавих гэж оролддог ийм Ардын намын гишүүд байна шүү гэдгийг л хэлье.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Дашдаваа дарга хариулт өгье.

Ажлын хэсгийн 10 дугаар микрофон уу. 10.

З.Дашдаваа: Эрхэм Их Хурлын дарга,

Эрхэм Ерөнхий сайд,

Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье ээ.

Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя аа. 2022 онд нүүрсний гэх тодотголтой хэрэг гарсан. Энэ хэргийг шалгах ажлын хэсгийг Монгол УЕПГ-ын Ерөнхий прокурорын тушаалаар ЦЕГ, ТЕГ, АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсүүд хамтарсан ажлын хэсэг гараад ингээд ажиллаж байна аа.

Энэ дээр нийтдээ 103 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгаснаасаа одоогийн байдлаар 17 хэрэг шүүхэд шилжиж 14 хэргийг нь бол хэрэгсэхгүй болгож нийтдээ 44 хэрэг шалгалтын ажиллагаа үргэлжилж байна аа. Нийтдээ шүүхээр шийдэгдсэн 17 хэргээс улсад нэг 34 орчим тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлээд, 11 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн байдалтай ингээд мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ө.Шижир: Өглөөний мэнд хүргэе. Ер нь бол авлигал шударга бус байдал төрд хэт их эрх мэдэл төвлөрснөөс баялгийн шударга бус хуваарилалтаас эхэлдэг гэж боддог. Тийм учраас АТГ бол одоо соён гэгээрүүлэх үүргээ илүү ухамсарлаж ажиллаасай гэж хүсэж байна.

Ер нь бол авлигатай тэмцэх гаргийн үндсэн үүрэг бол төрийн хүнд суртал шударга бус байдлыг бий болгох, үгүй болгох ийм зүйл дээр анхаарах ёстой. Тэгээд миний гол хэлэх гэж байгаа санаа бол ер нь 2016, 2020, 2024 оны сонгуулийн жил угтсан улсын төсвүүдийн нэмэгдэл тэлэлт мөн түүнтэй холбоотой арилжааны банкнуудаас гарч байгаа бэлэн мөнгөний гаралт бол яг сонгуулийн жил болон сонгуулийн тухайн 4, 5, 6 сард өмнөх оны үетэйгээ харьцуулахад 6-аас 8 дахин ийм өсдөг. Ийм статистик мэдээлэл байна. Энэ бол сонгууль өөрөө улс төрийн, улс төрийн сонгууль өөрөө мөнгөнөөс маш их хамааралтай, мөнгөний хүчин зүйлээс маш их хамааралтай болдог гэдгийг харуулж байгаа. Тэр АТГ-ын дарга бол энэ тал дээр илүү анхаарч ажиллаасай гэж хүсье. Та энэ статистикийг заавал хараасай гэж танд хүсье.

Яагаад гэхээр та яг харьцуулж хараарай. Сонгуулийн жил тухайн сард гарсан бэлэн мөнгөний гаралт өмнөх жилийн тухайн сартай харьцуулахад хамгийн багадаа 8 дахин өссөн байгаа нь энэ бол сонгуулийн сонгууль угтсан бэлэн мөнгөтэй холбоотой. Энэ улс төрийн намуудын санхүүжилтийг заавал ярих ёстой. Улс төрийн намууд улс төрийн намын санхүүжилтийг одоо бид нар би жишээ нь хувьдаа хуульчилсан авлига л гэж үзэж байгаа. Нэг жишээ хэлэхэд одоо парламентад суудалтай, Засгийн газарт суудалтай ХҮН намын жишээ авч ярихад нийтдээ 1 тэрбум 95 сая төгрөг сонгуулиар олж хандиваар авсан байна.

Үүнийхээ 1 тэрбум 45 сая төгрөгийг зөвхөн нэг компани түүний хамаарал бүхий 37 охин компаниас 1 тэрбум 45 сая төгрөг хандив авсан байна. Нийт сонгуулийнхаа санхүүжилтийн 98 хувийг зөвхөн нэг компанийн 37 охин компаниас хамааралтай сонгуулийн хандив авсан байгаа. Энэ бол хуульчилсан авлига шүү.

Нийт сонгуулийн санхүүжилтийнхээ 98 хувийг зөвхөн нэг компанийн охин хамаарал бүхий 37 компаниас авна гэдэг бол ийм заваан жишээ дэлхийн түүхэнд байхгүй. Ийм заваан жишээ. Та нар дэлхийн улс төрийн сонгууль улс төрийн сонгуулийн санхүүжилт судлаад үзээрэй. Нийт сонгуулийн санхүүжилтийнхээ 98 хувийг зөвхөн нэг компани, түүний хамаарал бүхий 36 компаниас авдаг жишээ байхгүй. Засгийн газраас 21 хоногийн өмнө мэдэгдсэн нөгөө хууль бусаар гүйцэтгэх ажиллагаа явуулдаг хамгаалалтын компани ч байна, Интермед эмнэлэг ч байна, Белла Вистагийн СӨХ ч байна. Тэгэхээр АТГ-ын хувьд бол ийм улс төрийн намын санхүүжилт дээр маш сайн анхаарч ажиллаасай гэж хүсэх гэсэн юм.

Ер нь цаашдаа манай Их Хурал, манай Засгийн газар бид нар бүгдээрээ энэ улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг бий болгох хэт 1 компаниас хамааралтай байх, нэг компанийн харьяа бүхий 30, 40 компаниас хандив авдаг ийм байдлыг бид нар цогцлоох ёстой. Үүн дээр анхаарах ёстой, энэ хуульчлагдсан авлигал шүү. Би энийг цохож хэлэх гэсэн юм. Дэлхийн түүхэнд ийм заваан түүх байхгүй гэдгийг би дахиж хэлье.

Нийт санхүүжилтийнхээ 98 хувийг зөвхөн нэг компаниас авдаг ийм улс төрийн нам байж болохгүй. Компанийн нам юм уу, юу юм бэ энэ чинь одоо. Тэгэхээр энэ бол эрх мэдлийг хууль бусаар худалдаж авах гэсэн төрийн эрх мэдэлд хууль бусаар гаргах гэсэн тэрийгээ хуульчлагдсан хулгай болгож хийж байгаа хэлбэр шүү гэдгийг би энэ цохон тэмдэглэх гэсэн юм. Тэгээд АТГ бол соён гэгээрүүлэх урьдчилан сэргийлэх ажлаа илүү сайн анхаарч ажиллаасай. Мөн дараа нь улс төрийн намуудын санхүүжилт сонгуулийг угтсан бэлэн мөнгөний гаралт түүгээр дамжсан сонгуулийн санхүүжилтээр илүү анхаарч ажиллавал бид нарын яриад байгаа энэ бүх зүйл өөрөө байхгүй цэгцлэгдэх болно гэдгийг хэлэх гэсэн юм.

Буланы Бейсен гишүүн асуулт асууж үг хэлье.

Б.Бейсен: Эрхэм гишүүд, Ерөнхий сайд Их Хурлын даргад өглөөний мэндийг хүргэе.

Дашдаваа даргыг дэмжиж байгаа өнгөрсөн 4 жил АТГ сайн ажилласан авлигын том том хэргийг илрүүлсэн гаднаас авлигачдыг авчирсан, одоо ч ер нь орон даяар бас энэ авлигын асуудал дээр анхааралтай хандаж ажиллаж байгаа. Энэтэй холбогдуулаад хэд хэдэн асуулт асууя гэж бодож байна. Энэ хамгийн аюултай нь ковидын төсөв байгаа. Энийг шалгаж үзсэн үү? Би Ковидын түр хороонд ажиллаж байсан. Тухайн ЭМЯ, ЭМД-ын ерөнхий газрын тайлангийн зөрөө нь 267 тэрбумаар зөрж байсан. Хамгаалах гэр засгийнх нь 71.3 тэрбум, вакцин 9 тэрбумаар зөрж байсан.

Дараагийн асуудал энэ улс төрийн аль нэг танай мөрдөгчид комиссарууд улс төрийн намын аль нэг намын нөлөөлөлд автаж хэлмэгдсэн улсууд байна уу энэний тооцоо байна уу? Ер нь цагаатгах ажлыг яаж зохион байгуулж байна?

Дараа нь би Баян-Өлгий аймгаас сонгогдсон төлөөлөгч Их Хурлын гишүүний хувьд энэ тендертэй холбоотой юм маш их байдаг. Олон жил дамжиж явдаг засгаас улсаас төсвөө баталж өгдөг аль нэг удирдах ажилтны нөлөөлөл дор ороод тэгээд улсын ажил цалгарддаг. Жишээлбэл Хөх Хөтөл, Цовоо багийн чиглэлийн 600 сая төсөвтэй шилэн кабелийн төсвийг 21 онд тавиулсан одоо хүртэл ашиглалтад ороогүй. Том албан тушаалд нөлөөлөл бүхий компани авсан.

Хоёрдугаарт Хотгор нүүрсний уурхайн эмнэлэг гээд тухайн үед 265 сая төгрөгөөр ингээд 85 сая төгрөгөөр төсөв батлагдсан. Хотгор уурхайд эмнэлэг, сургууль, цэцэрлэг байдаг, уурхайчид байдаг. Өдөрт зуугаас 150 машин очдог. Энэ эмнэлгийг бариагүйн улмаас энэ хойшлогдоод нэг 7, 8 жил болж байгаа юм. Эмнэлэг нь татан буугдах шатад хүрсэн. Одоо бүр төсөв нь өссөөр байгаад тэрбум 700 сая болсон. Мөн Ногооннуур сумын биеийн тамир спорт комплекс байгаа. 6, 7 жил болж байгаа юм. Мөн адилхан төсөв нь эхлээд нөгөө 1 тэрбум хагас байсан уу одоо бараг хориод тэрбум болсон. Ийм юунуудыг шалгадаг байлгүй дээ. Ер бас төсөвтөө хяналт хийдэг үү гэдгийг асууя.

Д.Амарбаясгалан: Бейсен гишүүн үндсэндээ үг хэлчихлээ тийм ээ?

Асуултад Дашдаваа дарга хариулъя.

3.Дашдаваа: Бейсен гишүүний асуултад хариулъя.

Ковидын үеийн асуудлуудыг нэг бүрчлэн шалгаад ер нь эхнээс нь шийдвэрлээд явж байгаа гэж ойлгож болно. Манай комиссарууд хэрэг төвөгт ороосон хууль бусаар шалгасан цагаатгах ажил гэхээр манайд ерөнхийдөө бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа прокурорын хяналтад явагдаж байдаг. Ингээд одоогоор яг хүнийг хилс хэргээр асуудал үүсгэсэн асуудал манай байгууллагын хэмжээнд гараагүй байна аа.

Баян-Өлгий аймагт үйлдэгдэж байгаа авлигын хэргүүдийг шалгаж байна уу гэдэг асуудал байна. Нийтдээ Баян-Өлгий аймагт өнгөрсөн жилд Баян-Өлгий аймаг дээр 78 хэрэг, авлига, албан тушаалын гэмт хэрэг шалгагдсан байна. Энэ ингээд таны сая ярьсан энэ тендертэй холбоотой асуудлыг нягталж үзээд эргээд танд хариу өгье өө.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Цогтгэрэл: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе.

Авлигал өнөөдөр Монголын нийгмийн анхаарал татсан бухимдуулсан яг л энэ түвшинд оччихсон байгааг өнгөрсөн цаг хугацаанд өнгөрсөн жилүүдэд бид нар нийгмийн олон олон том нийгмийг хамарсан олон олон том хэргүүдээс харсан л даа. Үнэхээр энэ бол нийгмийн бухимдлыг дээд цэгт нь авчирч байгаа асуудал.

Тэгэхээр аливаа асуудал чинь өөрөө нэг их тийм бид нар авлигал гэхлээр нэг гарчихсан ийм илрэл дээр л яриад байдаг. Ил болчихсон нэг зүйл дээр учир шалтгаан гээд зүйл бий. Энийг тусад нь ялгаж салгаж бид нар асуудалд хандах ёстой учиртай. Тэгэхээр авлигалын үндэс шалтгаан чинь юу билээ гэдэг маш тодорхой авлигалын үндэс шалтгаан төртэй л холбоотой. Төрөөс зүй бус давуу тал олгосонтой л холбоотой. Төрийн албан хаагчидтай л хол холбоотой нь тодорхой. Ийм л зүйл. Тэгэхээр Монголын төр ийм том хэмжээнд данхайчихсан, төсөв нь эдийн засгийнхаа талд оччихсон ТӨК нь үлдсэн хэсгийнх нь дахиад талд оччихсон. Үлдсэн хэсгийнх нь дахиад ихэнхийг нь төрөөс тусгай зөвшөөрөл олгодог бизнесүүд эзэлчихсэн энэ тохиолдолд энэ авлига их л байж таарна шүү дээ. Тэгэхээр энэ өөрчлөлтийг хаанаас хийх ёстой гэвэл төрийн эрх барих дээд байгууллага нэг гараараа төрийг асар том данхайлгачхаад нөгөө гараараа нэг хэсэг хүмүүсийг авлигатай тэмцэж энэ бол зүгээр л нэг тийм дүр эсгэсэн ардчилал гэдэг шиг дүр эсгэсэн авлигалтай тэмцэл л энэний цаана явж байгаа шүү дээ. Үнэхээр авлигалыг бууруулъя гэж чин сэтгэлээсээ бид нар хандаж байгаа бол саяын тэр төрийн оролцоо тэр тусгай зөвшөөрлүүдийн оролцоо олон олон зүйлүүдийг багасгаж бууруулж сайжруулна гэхээсээ урьдаар ерөөсөө л энийг хэрхэн яаж танаж хасаж, багасгаж бууруулах юм, хэн нэгэн даргаас хэн нэгэн даргын гарын үсгээс хамаардаггүй болгох юм гэдэг асуудал.

Энэ асуултад хариулж байж бид нар энэ авлигалын тухай асуудал авлигалын учир шалтгаанд хариулт өгөх ёстой л гэж боддог. Тэгэхээр энэ танхимд бид нар төр

сайхан төрийг томруулна. Олон 100 мянган хүн ажиллах ёстой, олон 10 их наяд төгрөгийг зарцуулах ёстой гэдэг л шийдвэрүүд гарч байгаа тохиолдолд энэ авлигал буурахгүй ээ. Төрийг нэг хэсэг хүнээс нэхээд үнэхээр хэцүү. Тэгэхээр энэ бол үнэхээр учир шалтгаан руугаа бид нар асуудлаа ярья аа. Үнэхээр л тийм шударгаар авлигалыг бууруулъя гэж байгаа юм бол бид нар учир шалтгаан руугаа хэдүүлээ бас санал нэгтэйгээр ингэж хууль зүй, бодлого шийдвэр, төсөв төлөвлөгөө, гарч байгаа үйлдэл, энэ томилгоо, олон зүйл олон энэ зүйлүүд дээр анхаарах ёстой л гэж боддог. Дахиад нэг зүйл ард иргэдийн нэг ярьж байгаа нэг зүйл энэ Авлигалтай тэмцэх хууль үнэхээр чанга байгаадаа сул байгаадаа бас биш.

Ингээд ийм тэгш бус байгаад их дургүйцэл их байна уу гэж боддог. Тэгш бус гэдэг нь энэ авлигатай хийх тэмцэл гэдэг нь дээшээгээ зөөлөн доошоо хатуу. Би бас ингээд өөрийн мэдэх нэг ганц 2 жишээг хэлье. Жишээ нь Увс аймгийн Өлгий, Завхан, Өмнөговь гээд сумдууд байна. Бүх дарга нар нь шоронд орчихсон бүгд. Яасан гэсэн чинь тэр Эрүүгийн хуулийн 22.1 гэдэг заалтаар 300 мянган төгрөгийн хэрэгт холбогдоод мөнгө төгрөгийг нь аваагүй аваагүй нь хуулиараа ч тодорхой. Утсаар ярьсан гэнэ, тэгсэн гэнэ ингэсэн гэдэг хэргээр яасан ч хурдан шийдэгддэг юм бүгдээрээ 3, 4 жилийн ялтай. Тэр дарга нар зарим сумдад нь Засаг дарга хийх хүн олдохгүй ерөөсөө ийм ялтай ажил. Ийм ийм асуудлаар шоронд ордог бол би жишээ нь Завхан сумын Засаг дарга залуу өргөдлөө өгчихсөн. Яаж байна энэ Авлигалын хууль гэдэг нь доошоогоо ийм их айхтар хатуу ийм. Зүгээр хуулийг их хатуу чанга, сул зөөлөн буруу зөрүү ашигласандаа гэж байгаа юм биш. Ер нь дээшээ зөөлөн доошоо хатуу байна. Үнэхээр хатуу бол бүгдээрээ л хатуу хурдан шийддэг байгаач гэдэг дээр ард иргэд ийм бухимдалтай энэ яг энэ асуудал үнэхээр нэг ийм ялгамжтай байгаад дургүйцэл их байдаг болов уу гэж боддог.

Д.Амарбаясгалан: Цогтгэрэл гишүүн үг хэллээ. Тийм. Ер нь авлига авлигатай тэмцэх үндсэн суурь шалтгаан болсон олон зүйлийг энэ Их Хурлын түвшинд хуулийнх нь орчинд засаж залруулж баттай бий болгож өгөх шаардлага бол бас байна гэж үзсэн. Одоо бидний өнөөдөр хэлэлцэх энэ Хууль тогтоомжийн хууль, түүгээр дамжуулж хуулиас давсан энэ журам хэрэгжээд байгаа. Төрийн бүх шатад хэрэгжиж байгаа энэ зүйлийг хязгаарлахын төлөө хамтарч ажиллах шаардлагатай гэж ингэж үзэж байгаа юм. Одоо энэ журмын тоо өнөөдөр нийт Хууль зүйн яаманд бүртгэлтэй журмын тоо сүүлийн 14 жилийн хугацаанд л гэхэд 4 дахин нэмэгдчихсэн үзүүлэлт байж байгаа нь төр дээр нөгөө эрх мэдэл төвлөрөөд байгаа албан тушаалтан тусгай зөвшөөрөл лиценз тэгээд бусад асуудлыг шийдээд байгаагийн илэрхийлэл энд гарч ирж байна л гэж үзэж байгаа юм. Тэгэхээр бид яг өнөөдөр энэ даргын асуудлыг нэг талдаа шийдэж байна. Нөгөө талдаа хууль тогтоомжийн хуулиар, хуулиас давсан эрх олгоод байгаа журмуудыг цэгцлэх ажил давхар хийгдэх нь их чухал юм байна л гэж үзээд байгаа юм.

Тэгэхээр Цогтгэрэл даргын хэлж байгаа саналтай бол санал нэг байгаад байна аа.

Ингээд Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Л.Мөнхбаясгалан: Асуулт асууя. АТГ-ын даргад нэр дэвшиж байгаа эрхмээс асуулт асууя аа. Хэн нэгэн сайд аль нэг компаниас хандив авчхаад Засгийн газар нь тухайн компанийн хууль бус үйлдлийг илрүүлээд Улсын Их Хурал руу өргөн барьж байгаа үед хандив авсан компанийн талд эрх ашигт нь үйлчилбэл энэ танай харьяалалд шалгагдах хэрэг мөн үү энэ хууль зөрчиж байгаа юу гэсэн асуулт байна.

Ерөнхий сайдад хандаж хэлэх үг байна. Сая Хөх Монголын Хөх туг гээд аян 21 аймаг тойроод ирсэн 21 аймаг бол хамтарсан Засгийн газрыг улс орон, үндэсний эрх ашигт нийцсэн үндэсний эв нэгдлийг хангаж ажиллах ёстой гэдэг дээр санал нэг байна. Хамгийн гол нь шударга ёс тогтоох ёстой. Иргэд ядуу байгаа, ажлын байргүй байгаа нь шударга бус байдлаас авлига их байгаагаас шалтгаалсан гэж үзэж байгаа.

Тэгэхээр таны авлигатай хийх тэмцэлд итгэж улс орны хэмжээнд явах мега төслүүдийг урагшлуулах гэж бид энэ Засгийн газрыг байгуулсан. Хамтарч ажиллаж байгаа. Засгийн газрын оруулж ирж байгаа хууль төслүүдийг аль болохоор дэмжих талд нь явж байгаа. Таны Энержи ресурсээс Ухаа худгийн ордыг Засгийн газрын тэмдэглэлээр хууль бусаар авсан гэж мэдэгдсэн та өөрөө. Хууль зүйн сайд ч гэсэн мэдэгдсэн. Энэ асуудлаа яаралтай Улсын Их Хурал руу өргөн бариад оруулж ирээч ээ. Энэ тэмцлээсээ ухарч няцаж болохгүй. Энэ тэмцлээсээ ухарч няцахгүй учраас өнөөдөр 6 жил ажилласан АТГ-ын даргыг улираан томилох саналыг Улсын Их Хуралд оруулж ирж байгаа байх гэж бодож байгаа.

Тийм учраас энд эрх ашгийн зөрчилтэй санхүүгийн зөрчилтэй, зарим сайдуудын үйлдэл хэрээс хэтэрч байгаа. Энэ дээрээ та эргэж хараарай. Авлигатай тэмцэх ажлаасаа битгий ухраарай, АТГ-ын даргыг дэмжээд өгье. Тэгээд ажлаасаа битгий ухраарай гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Дашдаваа дарга асуултад хариулъя. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

З.Дашдаваа: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Яг энэ тодорхой асуудлыг бол манай байгууллага хууль дүрмийнхээ дагуу шалгаж тогтоож байж л ашиг сонирхлын зөрчил бий эсэх гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх асуудлыг бол шийдэх боломжтой хариу өгөх боломжтой байна аа. Яг одоогоор хариу шууд хариулах боломжгүй байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд Мөнхбаясгалан гишүүний асуусан асуултад хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Өнөөдөр бид нар авлигалтай хийх тэмцэл хүмүүс дээр мөрдөх байгууллагуудын түвшинд буюу нэлээн асуудал боллоо. Энэ шүүхийн түвшинд ч юм уу бүтэн шийдэгдэхгүй байна аа.

Дээрээс нь авлигал дээр асуудал үүссэн хүмүүсийг өнгөрсөн хугацаанд нэлээдгүй зүйл боллоо. Хөрс суурийг нь бэлдэх нь зүйтэй юм биш үү гэж ярьж байна. Санал нэг байна. Сүүлийн үед бид нар эдийн засаг өслөө. Одоо эдийн засгийн өсөлт чинь хоосон тоо байгаад байгаа юм биш үү өргөхөөр оруулах нь зүйтэй юм биш үү гээд санал нэг байна. Гэхдээ гэхдээ тоо байхгүй байхад хүртээмж ярих боломжгүй байдаг аа.

Өнөөдөр авлигалтай хийх тэмцэл бүтэн үр дүнд хүрсэн үгүй зарим асуудал нь ингэсэн тэгсэн гэдэг асуудал ярьж байна гэдэг сайн дэвшил. Бид ерөөсөө авлигалтай холбоотой асуудлыг ярьдаггүй байсан юм шүү дээ. Сүүлийн нэг 3, 4 жил л энэ асуудлууд яригдаж, сонсгол хийгдэж, бүх нийтээрээ энэ авлигалтай холбоотой асуудлыг ярьж хэлж ингэж байгаа болохоос биш өмнө нь ийм зүйл ерөөсөө

яригддаггүй байсан. Тийм учраас Дашдаваа даргыг оруулж ирж байгаа шалтгаан ч тэр энэ байгууллагыг амь оруулсан. Энэ байгууллага амь орсон нь авлига гэдэг асуудал нийгмийн асуудал болсон. Бүх нийтээрээ бид нар Хөгжлийн банкнаас авхуулаад лиценз яаж авсан гээд олон асуудлуудыг Улсын Их Хурал ярьсан.

Эрх зүйн хувьд нь өөрчлөлт оруулсан. Тийм учраас энэ хийгдээд эхлүүлсэн ажлаа дуусгахад энэ үргэлжлүүлж ажиллах нь зүйтэй юм л гэдэг өнцгөөс миний хувьд оруулж ирж байгаа юм. Анх миний хувьд дэвшүүлэн гаргаж тавьж байсан байгалийн баялагтай холбоотой асуудал. Энэ өнгөрсөн гучаад жил дотор яагаад орлогын тэгш бус байдал үүсчихсэн бэ гэдэгтэй холбоотой асуудлаас би нэг алхам ч ухрахгүй. Энэ миний амьдралын философи болохоос биш би албан тушаал дээр ажил хийж байгаа зүйл огт биш.

Тийм учраас энэ дээр санаа зоволтгүй. Харин асуудлуудыг илүү хуулийн түвшинд яаж богино хугацааны шийдэл болгох вэ гэдэг нь л чухал байгаа болохоос биш явж ирсэн энэ буруу асуудлуудыг системтэйгээр засна засаж ч байгаа. Бас ч гэж нэлээдгүй үр дүн гарсан байгаа. Авлигалтай тэмцэх газар 2022 он гэхэд л 2.3 их наяд төгрөгийг буцаж улсад төвлөрүүлсэн.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: АТГ-ын даргаар томилогдож байгаа Дашдаваа танд амжилт хүсье. Таны дээр зөвхөн хууль л байх ёстой. Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Ерөнхий сайд хэн ч байсан гагцхүү хуулийн дор захирагдаж ажиллах ёстой. Та бол Улсын Их Хуралд ажлаа л тайлагнана. Танд хэн нэгэн нөлөөлөх ёсгүй Өнгөрсөн 6 жилийг би таныг сайн их хичээл зүтгэлтэй ажилласан гэж бодож байгаа. Энэ 6 жил амаргүй 6 жил байх болов уу гэж бодож байна.

Тийм учраас хэн нэгэн санхүүгийн эрх мэдлээ алдсан аль нэг компани, бүлэглэлд ажилладаг, тийм Улсын Их Хурлын гишүүн, тийм Засгийн газрын гишүүнүүд битгий бууж өгөөрэй. Гагцхүү хуулийн доор бүгд захирагдах ёстой шүү л гэдгийг захъя. Танд амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Жаргалсайхан: Ингээд Ерөнхий сайд анх удаагаа АТГ-ын даргыг санал болгож оруулж ирж байна. Олон аймгаар явлаа. Ард иргэд маань олон зүйлийг ярьж байна аа. Ер нь авлигатай тэмцэнэ гэдэг бол бас биднээс эхлэх ёстой юм байна гэдгийг энэ чуулганы танхимд, энэ гишүүддээ, удирдлагууддаа бас хэлэхийг хүсэж байна. Тэгээд АТГ-ын даргаас 2 асуулт асуух гэсэн юм. Энэ танхимд биднээс яг хүсэх ямар хүсэлт байна вэ? Одоо жишээ нь бидний хувьд бол Улсын Их Хурлын сонгууль гээд маш их том тоотой, босготой Сонгуулийн ерөнхий хорооноос бол том мөнгөн дүнг хүртэл хэлсэн байгаа шүү дээ. Тэгээд бид нар төрийн алба зарим нь хашиж байсан хүн байна. Зарим нь бизнес хийж байсан хүмүүс байна. Ер нь төрийн албанд ажиллаад жийп унаад л амьдрал ахуй нь эрс сайжраад л явж байгааг ард иргэд тэр тусмаа хөдөө орон нутагт бол харагдаж байдаг л даа ер нь тийм.

Гэтэл бид бүхэн өнөөдөр яг энэ заалнаас яг та бидэнд яг юу хандаж хэлмээр байна вэ? Жишээ нь энэ сонгуулийн мөнгөтэй холбоотой, энэ хуулийг өөрчлөхтэй

холбоотой юм уу? Нэг дэх асуудал. Энэ дээр ямар асуудал ямар боломжийг бид нарт гаргаж өгвөл би ажлаа сайжруулна гэдгийг та нэг хэлэх үг байна уу? Биднээс хүсэх хүсэлт юу байна вэ?

Нөгөө 2 дахь асуудал маань юу вэ гэхээр түрүүн хэлсэн үнэхээр энэ төрийн албанд ороод амьдрал ахуй нь эрс сайжраад юу гэдэг юм нэг хүнд цалин тавьж өгөөгүй, татвар төлж үзээгүй хүмүүс ингээд явж байгаа нь бол нийгэмд энэ ард иргэдэд маш муухай харагдаж байгаа байхгүй юу. Тэгээд тэр хүмүүстэй хариуцлага тооцохгүй жирийн хөдөөгийн саяын манай Увс аймагт гарсан ингээд 3 сумын Засаг дарга мөнгө төгрөг авч өгөлцөөгүй утасны ярианаас л ингээд л шууд шийтгэчихэж байгаа байхгүй юу. 4 жилийн хорих ялаар шийтгэчихсэн байх жишээний. Энэн дээр л ард иргэд дургүйцээд байгаа байхгүй юу. Энэ хууль чинь жирийн иргэдэд хатуу байна. Энэ төрийн өндөр албан тушаалтнууд энэ танхимд сууж байгаа хүмүүст үйлчлэхгүй байна аа. Энэнтэй холбоотой Алтангэрэлд сайдын оруулж ирж байгаа хууль бусаар орлого олсон хөрөнгөжсөн төрийн өндөр албан тушаалтнуудын хөрөнгийг хураана гэсэн энэ хуулийн төсөл явж байгаа. Та энэ дээр ямар саналтай байгаа вэ? Энийг батлагдвал дэмжиж ажиллах уу гэсэн ийм 2 асуулт байгаа юм.

Ерөнхий сайд бол Дашдаваа гэдэг хүнийг оруулж ирж байгаа нь бол давхар хариуцлага хүлээж байгаа. Тэгээд энэ Засгийн газарт Ардчилсан нам хамтарсан яах гэж хамтарсан бэ гэхээр бол энэ томоохон төслүүдийг явуулах мөн дээрээс нь энэ ТӨК-уд энэ улс төрд байгаа энэ авлигал энэ янз янзын зүйлүүдтэй тэмцэх гэж энийг засаж сайжруулах гэж орж ирсэн. Тэр ч үүднээсээ манай Хууль зүйн сайд бусад энэ томоохон салбарын сайдуудыг хийж байгаа. Мөн дээрээс нь АН-ууд бүтээмжийн менежерүүдийг тавьж байгаа. Нэг хүн тавьснаар бол юу гэдэг юм энэ асуудал сайжирчихгүй. Энэ хүмүүсээс орж ирж байгаа саналыг бид нар бол үндсэндээ бүлэг дээрээ мөн тэр чуулган дээрээ ажлыг сайжруулах дээр л голлож энэ хүмүүсийг тавьсан байгаа. Тэрнээс нэг ажилтай болгох гэж бол тавиагүй. Тэр ч утгаараа энэ манай энэ МАН-ын зарим гишүүд хэлж байх шиг байна л даа. Дөчхөн хүн тавьчихаад баахан улсууд тавьчихлаа. Төсөв зардал данхайчихлаа гэж яриад байгаа юм. Тэгэхэд бид нар өнөөдөр бол асар их хэмжээний алдагдалтай ажиллаж байгаа ТӨК-уд зөндөө байгаа шүү дээ. Энийг үр бүтээлтэй, үр ашигтай ажиллуулах гэж л тэр хүмүүсийг аваачиж байгаа шүү дээ. Салхи оруулах гэж өөр бас ямар бодол санаа уралдуулах гэж өөр өнцгөөс харах гэж ингэж тавьсан. Тийм учраас энэ хүмүүст боломжийг олгох дээр Ерөнхий сайд анхаарч ажиллахыг хэлэх гэсэн юм. Тэгээд энэ 2 асуулт дээр хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Дашдаваа дарга хариулт өгье.

З.Дашдаваа: Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя аа.

Ер нь яг ингээд Улсын Их Хурлаас хүсэх хүсэлт юу байна гэхээр өнөөдөр бидний ярь яригдаад байгаа Авлигын төсөөллийн индекс маань буучихсан байна аа. Бага байна. Маш их муу үр дүн үзүүлээ. Энэ авлигатай тэмцэх байгууллага болоод Монголын төр засагтай холбоотой байна гэсэн асуудлууд яригдаж байгаа. Тэгээд ерөөсөө энэ нөгөө эх сурвалж маань юу яриад байгаа вэ гэхээр Улсын Их Хурлын хууль тогтоомж ер нь тэгээд амьдралд нийцэж гарч байна уу? Монгол Улсын татварын орчин хэр байна аа? Монгол Улсын төсөв ер нь их зөв зарцуулагдаж байна уу? Түүнд тавих хяналт хэр байна аа? Бизнес хийх орчин ямар байна.? Гадаадын хөрөнгө оруулалт орж ирэхэд ямар орчинтой байна? Мөн энэ гадаадын хөрөнгө оруулалт оруулж орж ирэхээр энэ гардаг маргаанууд их он удаан жил ингээд Монгол

Улсын шүүхээр шийдэгдэхгүй байна гэдэг ийм л бидэнд үнэлгээн дээр асуудлууд, асуумжууд тавигдаад яваад байгаа юм.

Тийм учраас энэ Монгол Улсад өнөөдөр гаднын хөрөнгө оруулалтын асуудлаар бол энэ яаралтай Их Хурлаас иргэний эрх зүйн асуудлуудыг зохицуулж аль нэг талд нь шийдэх нэн шаардлагатай юм шиг байна лээ. Одоо ердөө явж байгаа гаднын хөрөнгө оруулалтуудын маргаан, дан эрүүгийн журмаар яваад байгаа юм.

Тэгээд энийг бид нар олон улсын арбитраар шийдүүлэх, олон улсын арбитрайн маргааныг манай улс хүлээн зөвшөөрөх, эсвэл оруулж ирэх энэ асуудлуудыг ингэснээр энэ гаднын хөрөнгө оруулалтын орчин сайжирч байна бизнесийн орчин сайжрах энэ талын зөвлөмжүүд нэлээн байгаа учраас энэ тал дээр манай Их Хурал ер нь онцгой анхаарах шаардлагатай юм уу л гэж АТГ-ын даргын хувьд бодож байна.

Дараагийн асуултад хариулахад ерөнхийдөө бол ер нь аливаа гэмт хэргийг их багахан үйлдлээ гэж ялгаж салгаж болохгүй ээ. Ер нь тэгээд гэм буруугийн асуудлыг шүүх шийдэж байгаа. Гэхдээ өнөөдөр сумын дарга байна уу, аймгийн дарга байна уу энэ тухайн Эрүүгийн хууль тогтоомжид заасан үйлдэл, эс үйлдлийг л хийсэн бол энэ хуулиар хуулийн хариуцлагыг хүлээх л ёстой.

Алтангэрэл сайдаас санаачилж байгаа хууль дээр бид нар тодорхой саналуудаа өгчихсөн байгаа. Тэгээд энэ хууль Их Хурал батлаад явал баталбал бид хэрэгжүүлээд л ажиллах л үүрэгтэй. Тэндээс их тодорхой ийм тийм гэсэн одоо өнөөдөр энд ярих боломжгүй байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж үг хэлье.

А.Ариунзаяа: Ерөнхий сайд Оюун-Эрдэнээс асуулт асууя. 2023 оны 3 сарын 7-ны Засгийн газрын хуралдаанаар гарсан шийдвэрийн талаар мэдээ мэдээлэл ч сайтуудаар байгаа. Засгийн газрын өнөөдрийн хуралдаанаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолыг баталсан.

Авлига албан тушаалын гэмт хэргийн улмаас улсад төвлөрүүлсэн орлого төрд хураагдсан хөрөнгийг эх, хүүхдийн эрүүл мэнд, хавдар, эрхтэн шилжүүлэн суулгахтай холбогдох эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах барилга барихад зарцуулах чиглэл баримтлан ажиллахыг Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгалан эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Сангийн сайд Б.Жавхлан, ХЗДХ-ийн сайд Х.Нямбаатар нарт үүрэг болголоо.

Мөн авлига албан тушаалын хэрэгт төрд хураагдсан барилга байгууламжид үнэлгээ хийж эмнэлгийн зориулалтаар ашиглах боломжийг судлан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрүүл мэндийн сайдад даалгалаа гэсэн ийм тогтоол 3 сарын 7 буюу 2 жилийн өмнө 2023 онд 3 сарын 7-нд гарсан байдаг юм аа. Хураагдсан мөнгийг аваад үзэх юм бол гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөлтийн тухайд 2022 онд 2.3 их наяд, 2023 онд 238.6 тэрбум, 2024 он гэхэд 240.9 тэрбум Монгол Улсдаа, гадаад улсад 2021-2024 онд 13.9 сая ам.долларын

үнэ бүхий хулгайлагдсан хөрөнгийг буцаан авчирч улсын орлого болгосон ийм мэдээлэл байгаа юм аа.

Сарын дараа буюу 2025 оны 5 сарын 8-нд хүүхдийн байгууллага байгуулагдсаны 100 жилийн ой болно. Эрхэм Ерөнхий сайд яг энэ бодлого дээрээ хэвээрээ байгаа юу? Авлига бол нийгмийн хорт хавдар мөн. Үүнээс улбаалж байгаа энэ иргэн улсын орлого болж төвлөрч орж ирж байгаа хөрөнгийг хүүхдэд нийгмийн бүтээн байгуулалтад зарцуулах боломж байгаа юу. Үүн дээрээ та шинэ кабинет, шинэ сайд нартаа үүрэг даалгаврыг өгөөд сарын дараа тодорхой хууль тогтоомжуудыг оруулж ирэх боломж байгаа юу, үгүй юу, энэ бодлого дээрээ хэвээрээ байна уу гэдгийг нэг лавлаж асууя аа.

Дашдаваа даргаас болохлоор авлигын индекс гэдгээр танай ажлыг дүгнэх нь буруу. Сая миний дурдсан хураагдсан хөрөнгө эргээд гадаадад зугтсан байгаа оргон зайлсан 34 хүнээс 11-ийг нь та хэд маань ямар ч байсан авчирсан байна. Тодорхой энэ ажлууд хийгдэж явж байгаа. Авлигын индексийн төсөөллөөр бол хүмүүс яах вэ дэлхийд энэ ТББ олон улсуудыг хооронд нь харьцуулаад байдаг. Тэгэхээр энэ олон улсад байгаа энэ дүр төрхөө ч гэсэн сайжруулахын тулд зөвхөн танайх гэлтгүй бүх нийтээрээ л ажиллах ёстой юм гэдгийг бол хүлээн зөвшөөрч ойлгож байгаа. Улсын Их Хурлын хувьд яг ямар хууль, тогтоомж батлагдах юм бол энэ үнэлгээнд эергээр нөлөөлөх вэ гэдгийг та энэ үнэлгээг харж байгаа хүний хувьд тулгамдаж байгаа асуудлуудыг мэдэж байгаа хүний хувьд яг ийм ийм хууль болоод бодлогууд нэн шаардлагатай орж ирэх юм бол дараа жилийн үнэлгээ бол сайжирна гэдгийг хэлээд өгөхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Ерөнхий сайдын хувьд АТГ-ын даргыг санал болгож байгаа ийм тохиолдол. Ингээд томилогдчихвол би бас АТГ дээр очиж ажиллана гэсэн ийм бодолтой байгаа. Би урьд нь нэг ч удаа очиж байгаагүй. Мөн АТГ-ын удирдлагуудтай би уулзаж ямар нэгэн байдлаар энэ асуудлыг ийм байдлаар бодлогын хувьд ч гэсэн ийм байдлаар ингэж хамтарч ажиллая гэдэг яриаг өрнүүлж байгаагүй ээ. Энэ бол зарчим гэж би хувьдаа бодсон. Зүгээр Засгийн газрын хувьд бол илүү эрх зүйн орчин талд нь, мөн иргэдийн мэдэх эрхийг хангах тал дээр нь цахимжилт тал дээр нь л илүү олон нийтийн анхаарлын төвд энэ авлигатай холбоотой асуудлуудыг оруулах ийм тал дээр нь л Засгийн газар ажилласан. Яах вэ авлигын төсөөллийн индекс буюу CPI гэдэг энэ аргачлал бол энэ олон нийтийн дунд байгаа төсөөлөл.

Тийм учраас Засгийн газраас одоо энэ бүх сангуудыг ил болгосон. Ингээд нүүрс хөгжлийн банк гээд бүх зээлүүдийг прокурорын зөвшөөрөлтэйгөөр ил болгосон. 2, 3 ч том жагсаал цуглаан болж парламент дээр 2, 3 ч түвшний том сонсгол болсон. Тэгээд энэ нь бол өөрөө авлигатай тэмцэх чиг үүрэгт туйлын чухал мөртөө төсөөллийг мэдээж олон улсын түвшинд ч бай, манай улсын хувьд ч бай нэмэгдүүлдэг. Энэ бол аль ч улсад байдаг л эрсдэл юм байна лээ.

Өнөөдөр ч гэсэн одоо бид бүгдийн мэдэж байгаа Элон Маск нэлээн л олон асуудлуудыг задалж байна тийм ээ. Энэ юу вэ гэхээр төсөөлөлд бол ийм ийм байгууллагууд ийм байсан юм байна гэдэг ойлголтыг өгнө. Тийм учраас персепшний хувьд бол одоо тодорхой хэмжээнд унана. Гэхдээ энэнээс айгаад ч юм уу эсвэл зөвхөн төсөөллөө ингээд эерэг байлгахын тулд байгаад байвал авлигалтай ерөөсөө тэнцэхгүй гэсэн үг. Энийг Трансперенси интернэйшнлийн удирдлагуудтай ч бид нар

юун дээр очиж уулзаж л байсан юм. Лауст очоод Швейцарт санаа битгий зовоорой хийх ажлаа хийгээд явах нь зүйтэй шүү. СРІ-аар бүх зүйл үнэлэгддэггүй юм гэдэг зүйлийг хэлдэг. Энэ хураагдсан хөрөнгүүд бол бас боломжийн. 2.3 их наяд, 2023 онд 238 тэрбум, 2024 онд 240 тэрбум, гаднаас авчирсан нь 13 сая доллар гэдэг бол бас боломжийн. Энэ санхүүг зарим асуудлыг нь шүүх дээр шийдвэрлэхээр ингээд өгчихсөн байгаа юм байна гэж миний хувьд ойлгосон. Миний байр суурь хэвээрээ байгаа. Энэ орлогыг үндэсний баялгийн сангаар дамжуулж хүүхэд гэр бүл ирээдүйн сайн сайхны төлөө ийм зүйл рүү зарцуулах нь зүйтэй юм аа.

Тэгэхгүй бол зөвхөн Сангийн яам аваад орлого төвлөрүүлчихлээр яг юу болоод байгаа нь мэдэгдэхгүй өнгөрнө өө гэдэг миний байр суурь хэвээрээ байгаа.

Д.Амарбаясгалан: Дашдаваа дарга хариулт өгье. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

З.Дашдаваа: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Хохирлын хувьд бол энэ 2 талтай байгаа юм.

Нэгдүгээрт бол хохирол зарим хэсэг нь Сангийн яам нь төвлөрч байгаа, зарим хэсэг нь тухайн хохирсон байгууллагад эргэж олгогддог байж байгаа. Хамгийн сүүлийн үе гэхэд бид нар СХД-т хураагдсан 72 га газрыг хавдрын эмнэлгийн газ зориулалтын газраар олгосон байна лээ. Энэ бол тодорхой хэмжээгээр нийгмийн хариуцлагын хүрээнд бас хийсэн ажлуудын нэг ээ. Ер нь ямар хууль дүрэм эхний ээлжид яаралтай батлах шаардлагатай байна гэдэг дээр ерөнхийдөө их олон давтамжтайгаар л ер нь жил болгон зөвлөмжид ордог нөгөө Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулиа гаргаач гэдэг л ийм батлаач гэсэн асуудлууд ер нь жилийн жилийн энэ зөвлөмж дээр энэ дурдагдаж байдаг юм аа.

Хариулт дууслаа.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Ерөнхий сайдын хүүхдэд зориулна гэдэг би шинэ даалгавар сонсчих шиг боллоо. Энэ авлигаас үүдсэн хохирлыг улсын төсөвт хураагдсан төвлөрүүлсэн мөнгийг баялгийн санд байршуулна гэдэг үүргийг та хэлж байх шиг байна тийм үү? Одоо бол гэмт хэргийн хохирогчдод гэдэг юм уу тусгайлсан санд төвлөрүүлээд явдаг нэг хэсэг байх шиг байна лээ. Ер нь хууль тогтоомжоороо баялгийн санд байршуулна гэдэг нь нэг өөр. Эргээд яг нөгөө 2023 оны 3 сарын 7-ны чиглэл бол арай өөр агуулгаар гарч байсан шиг санаад байх юм. Тэгэхээр яг та тодорхой үүргээ хэлэх юм бол Ерөнхий сайдын өгч байгаа үүрэг чиглэл Ерөнхий сайд нарын хувьд бол заавал биелүүлэх ёстой үүрэг гэж би ойлгодог.

Тэгэхээр энийгээ ч гэсэн яг тодорхой болгох юм бол ойрын хугацаанд шийдвэрлэх боломжтой юм шиг харагдаж байна аа. Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууж үг хэлье.

Х.Ганхуяг: Өглөөний мэндийг хүргэе. Надад яах вэ 2 асуулт байгаа юм. Тэгээд нэр дэвшигчийг дэмжиж байна. Туршлагатай тэгээд ажлаа юунаас яаж эхлэх вэ гэдгээ мэдэж байгаа. Үргэлжлүүлээд яаж хийх вэ гэдгээ мэдэж байгаа. Яах вэ авилгалын индексээр манай зарим нэг гишүүд нэлээн баалаад байх шиг байна л

даа. Энэ авилгалын индекс гэдэг маань ер нь эдийн засаг төрийн оролцоо хэр байгаагаас хамаарч индексийн л тоо гарч ирдэг юм л даа.

Өнөөдөр манай нийтдээ төрд ажиллаж байгаа хүний тоо болон ТӨК-удад ажиллаж байгаа хүний тоо үндсэндээ 350 мянган хүн болсон байна. Нийт Монгол Улсад байгаа идэвхтэй ажиллах насны иргэний 4 хүн тутмын нэг нь төрд ажиллаж байна 4 хүн тутмын нэг. Улсын төсөв болон ТӨК-удын төсөв гээд нийлэх юм бол 2 төгрөг тутмын нэг нь төрөөс хамааралтай, 2 төгрөг тутмын нэг нь. ТӨК-удын худалдан авалт улсын төсвөөр хийгдэж байгаа худалдан авалтаас 10 дахин их байгаа, 10 дахин. Ийм нөхцөл байдалд авлигал буурах ямар ч боломж байхгүй. Энэ өөрөө авлигалын хөрс юм. АТГ бол үр дагавартай нь л тэмцдэг газар. Тэгээд яах вэ 1 дүгээр асуулт бол үүнээс улбаалаад үндсэндээ 2.5 их наяд төгрөгийн хөрөнгийг хураасан гэж би сая АТГ-ын дарга болон Ерөнхий сайдын ярианаас ойлголоо. Тэгээд хөрөнгө хураана авлигачдын хөрөнгийг хураана гэдэг хуулийн төслийг Хууль зүйн сайд нь санаачлаад яваад байх юм. Энэ ямар учиртай юм? Би энийг АТГ-ын даргаас асуух гээд байгаа юм. Хурааж болохгүй нолиос нь хураачаад байдаг. Одоо тэгээд дахиад хураана гээд байгаа юм. Энэ нэг хуулиа уншаагүй юм уу эсвэл попроод байгаа юм уу энийг нэг их сайн ойлгохгүй байна. Энийг нэг тодорхой хэлж өгмөөр байна.

Хоёрдугаарт энэ төрийн өндөр албан тушаалтнуудын хэргийг АТГ шалгадаг л даа. Ерөнхийлөгч байхдаа байсан юм уу Ерөнхий сайд биш тэр сайд байхдаа байсан юм уу? Саяын сая сошиалаар явсан мэдээллээр ингээд харахад бол стратегийн ордод орохоор лицензийг зарчихсан оффшор 3, 4 дансаар дамжуулаад зарчихсан гэдэг мэдээллийг авлаа л даа. 50 сая төгрөгийг татвараас зугтаалгавал эрүүгийн хэрэг үүсдэг юм. Эрүүгийн хэрэг 50 сая төгрөг шүү. Оффшороор дамжуулна гэдэг маань үндсэндээ татвараас зугтаалгаж байгаа нэг хэлбэр. 250 сая доллароос үндсэндээ 70-аас 85 тэрбум төгрөгийн татварын асуудал яригдах ёстой. Энэ дээр бол эрх шилжүүлсний татвар, орлогын албан татвар. Нийтдээ энэ чинь бараг 300-аас 350 тэрбум төгрөгийн асуудал байгаа юм. Нийтдээ 30 сургууль барих, 640 хүүхдийн 30 сургууль барих асуудал байгаад байгаа юм л даа. Тэгээд энэ асуудлыг ер нь шалгасан юм уу, шалгаагүй юм уу би эсвэл энэ сошиал дээр явж байгаа мэдээлэлд итгэх юм уу, итгэхгүй юм уу. Яг үнэнээ хэлэхэд иргэд 2 хуваагдчихаад байгаад байгаа юм. Энэ дээр нэг тодорхой хариу авмаар байна. Шалгасан бол шалгасан шалгаагүй юм бол шалгаагүй.

Үндсэндээ бид нар нэг 50 сая төгрөгийн татварт ийм өртэй хүнийг, татвараас зайлсхийсэн хүнийг эрүүгийн хэрэг үүсгээд цусыг нь холж байгаа шүү дээ энэ бол.

Тэгээд бид нарын ярьж байгаа энэ хэвлэлээр яваад байгаа 300-аас 350 тэрбум төгрөгийн татварын асуудал байгаа. Татварын асуудал. Энэ нөгөө иргэдэд очих ёстой баялаг нь юм. Иргэдийн хүртэх ёстой баялаг нь татвараа л хүртдэг юм.

Д.Амарбаясгалан: Дашдаваа дарга хариулт өгье.

3.Дашдаваа: Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Энэ эрүүгийн хууль тогтоомжид бол Монгол Улсын Эрүүгийн хуульд үндэслэлгүй хөрөнгөжсөн гэсэн асуудал байгаа. Энэ нийтийн албан тушаалтны үндэслэлгүй хөрөнгөжсөн асуудлыг бол манай байгууллага өнөөдөр хуулийн хүрээнд харьяалан шалгаж байна. Алтангэрэл сайдаас өргөн барьж байгаа хуулийн

Үзэл баримтлалыг бол 2002 оноос хойш төрийн алба хашиж байсан хөрөнгөжсөн хүмүүсийн хөрөнгийг шалгана гээд ийм асуудал тавьж байгаа. Эндээс манайх улам үндэслэлгүй хөрөнгөжсөн гэдэг асуудал нь бол нийтийн албан тушаалтан гэдэг одоо албан тушаалаа хашиж байгаа иргэдийн асуудлыг манай байгууллага шалгаж байгаа. Энэ дээр мөн Алтангэрэл сайдаас өргөн барьж байгаа хууль дээр үндэслэлгүй хөрөнгөжсөн харьяаллын гэмт хэргийг энэ бусад хууль сахиулах байгууллагууд ингэж нэгдэж шалгаад ингээд улс даяар одоо арга хэмжээ гаргаж ажиллах нь зүйтэй юм гэсэн ийм санаа саналууд явж байгаа.

Яах вэ энэ хууль өнөөдөр бол мөрдөгдөж байгаа эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд энэ хуулийн үзэл санааг бид хэрэгжүүлээд явж байгаа учраас манай байгууллагын зүгээс бол дэмжих боломжгүй гэж гэдэг байр сууриа илэрхийлчихсэн байгаа. Энэ нэгэнт эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд шүүхээр хүн эцсийн гэм буруу нь тогтоогдсон тохиолдолд бусдын эд хөрөнгөд халдана. Өнөөдөр Монгол Улсад эд хөрөнгө хураах ял урьд нь 86 оны эрүүгийн хууль тогтоомжид байсан. Энэ нь эд хөрөнгө хураах ял юу вэ гэвэл ер нь эд хөрөнгө хураах ял гэж нэмэгдэл ялаар бол өөрийнх нь хууль ёсны олсон хувь ноогдох хөрөнгийг хураадаг байсан. 2015 оноос хэрэгжиж байгаа Эрүүгийн хууль тогтоомжоор бол энэ хувийн эд хөрөнгө хураах ял байхгүй. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төлүүлдэг ийм л асуудлууд асуудлын ийм ялгаатай юмнууд байгаа юм аа. Сая сүүлийн таны ярьдаг энэ татвар маргаантай холбоотой энэ хэвлэл мэдээллээр гараад байгаа асуудлыг бол шалгаж тодруулаад тодорхой хэмжээгээр танд тусгайлан хариу өгье.

Одоо яг энэ дээр хариу өгөх боломжгүй байна.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууна.

Ер нь өнөөдөр бид АТГ-ын ажилтай танилцаагүй, АТГ-ын даргыг томилох асуудлыг хэлэлцэж байгаа учраас гишүүд тухайлсан гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар асуулт асуух нь зохимжгүй зүйл гэдгийг бол онцолж хэлэх нь зүйтэй. Тэгээд бид даргын томилгооны асуудал ярьж байгаа. Мэндбаярын Мандхай гишүүн. Ер нь бол энэ олон улсын энэ судалгааны байгууллагын гаргадаг авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт бол яах вэ манай улсын хувьд урагшлахгүй байгаа нь мэдээж энэ судалгаанд оролцож байгаа оролцогчдын авлига их байгаа гэж төсөөлж байгаатай шууд хамааралтай. Гэхдээ товчхондоо бол манай нийгэм бүх зүйлийг дабль стандарт авлига байгаа гэж ер нь бодож үнэлж байгаа. Гэхдээ энэ байдал бидний хөгжлийн үзүүлэлт амьдралын чанар ч ч гэдэг юм уу цаашлаад одоо энэ харилцан итгэлцлийн асуудлыг илэрхийлж байгаа гэж бол хувьдаа үзэж байгаа.

Ер нь тэгэхдээ яах вэ энэ АТГ-ын тайланг харахад бол улсад учруулсан хор хохирлыг энэ 6 жилийн хугацаанд барагдуулсан тоон үзүүлэлт өссөн байгаа. Мөн энэ 5 ш ажиллагаа бас хэрэгжиж эхэлснээс хойш багагүй үр дүн гарсан гэж харагдаж байгаа. Гэхдээ нэг зүйлийг манай энэ аль АТГ мэдлэгжүүлэх мэдээллийг бас ойлгуулахгүй бол авлигалыг бууруулах ажил бол зөвхөн АТГ-ын ажил гэж буруу ойлгоод байдаг. Энэ өөрөө бол мэдээж хууль тогтоомж хатуу хэрэгждэг байх ил тод байх, бас нэг чухал асуудал бол энэ шүгэл үлээгчийн тухай хууль бас яаралтай батлуулж хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн энэ эдийн засгийн өсөлт гээд түрүүн гишүүд хэлж байсан. Эдийн засгийн өсөлт өөрөө сайжрах тусам энэ авлигын индекс өөрөө буурах бор боломж үүсдэг. Мөн одоо бид нарт тулгамдаад байгаа нэг асуудал бол энэ төрийн албан хаагчдын иргэдэд үзүүлж байгаа энэ хүнд суртлыг бууруулах, иргэдийг мэдлэгжүүлж, чадавхжуулах энэ ойлголтыг өгөхгүй бол ганцхан нэг

байгууллагын энэ асуудал юм шиг ингэж ярьж байгаа нь зарим гишүүд ч гэсэн яг тэгж ойлгоод яваад байгааг засаж залруулах хэрэгтэй. Тэгэхээр авлигаын хэрэг энэ нууц далд байдалд хийгддэг. Эрх бүхий албан тушаалтнуудтай холбогддог учраас энэ язгуур үндсийг таслан зогсооход зөвхөн энэ АТГ-ын нэг байгууллагын ажил биш юм аа.

Тэгэхээр түрүүний хэлснээр ер нь Засгийн газар яам, агентлаг, иргэний нийгмийн байгууллага, ТББ гээд л иргэд хүртэл энэ олон нийтийн энэ оролцоог хангаж байж яг энэ авлигатай тэмцэх асуудал буурах юм аа. Тийм учраас энэ одоо улируулан сонгох асуудлыг бол дэмжиж байгаа. Эхлүүлсэн ажлыг 6 жилийн хувьд хугацаанд юуг хийх ёстой хаанаас эхлэх ёстой, ямар дүрэм, журам, энэ хуулийг сайжруулснаар энэ ажил буурах ёстой вэ гэдэг ажлаа сайн ойлголцсон хүний хувьд өшөө цааш нь хэрэгжүүлж бэхжүүлэхэд онцгой анхаарах ийм хэрэгцээ байгаа учраас дахиж нэг шинэ хүн сольж дахиж тэр хүнийг ажилтайгаа танилцаж жигдрэх гэсээр байтал бид нарын авлигалын асуудал буурахгүй байх ийм эрсдэл байгаа учраас энэ улируулан сонгохыг миний зүгээс дэмжиж байгаа юм гэж хэлмээр байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Авлигыг дотор нь 2 том ангилж байгаа. Махан тэжээлтэн буюу өвсөн тэжээлтэн гээд онолын дагуу. Инээж байгаа хүмүүс ном дээрээс уншиж болно шүү. Онолын номон дээрээ махан тэжээлтэн гэдэг нь болохоороо томоохон албан тушаалтан их хэмжээний авлигын асуудал бий болгохыг махан тэжээлтэн гэж байгаа юм. Өвсөн тэжээлтэн гэдэг нь болохоороо бага хэмжээгээр бага албан тушаалтан, бага, дунд албан тушаалтнуудын жижгээр тэр авлигыг бий болгож байгаа тэр эргэх холбоог бий болгож байгаа зүйлийг хэлж байгаа. Тэр иргэдийн шүүмжлэл бол өвсөн тэжээлтэй авлигачдыг бол илрүүлээд байна. Махан тэжээлтэй энэ авлигын сүлжээг устгах дээр бол учир дутагдалтай байна гэдэг шүүмж 1 дүгээрт байгаа, нэг.

Хоёрдугаарт АТГ-ыг зарим үед хэдэн жилийн өмнө Авлигатай тэнцэх газар гэж хүртэл хэлж байсан. Улс төрийн давуу тал бий болгодог хэлмэгдүүлэлтийн махны машин боллоо гэсэн шүүмжлэлүүд маш их байдаг. Тэгээд энэ 2 иргэд олон нийтийн шүүмжлэлээс дүгнээд би Дашдаваа даргаас асуулт асуух гэж байгаа юм.

Нэгд Ерөнхий сайд таны нэрийг оруулж ирж байгаа юм байна. Тэгэхдээ энд яригдаж байгаа ихэнх зүйл дээр таныг дэмжиж байгаа өнцөг нь бол туршлагатай гэдэг асуудлаа ажлаа мэдэж ойлгож байгаа гэдэг өнцгийг гаргаад байгаа юм. Энэ бол хувь хүний асуудал. Таны АТГ-ыг цаашид үргэлжлүүлэн удирдах концепц юу юм бэ? Хувь хүний итгэл үнэмшил чинь юу юм бэ? Та өөрөө энэ АТГ-ыг үргэлжлүүлэн удирдах, дахиад энэ амжилтад хүргэх, авлигыг бууруулах, эрх зүйт нийгмийг төлөвшүүлэх хүний эрх, эрх чөлөөг илүү хангах энэ нийгмийн хорт хавдар болсон үзэгдлийг бодитойгоор бууруулах таны хувь хүний чинь итгэл үнэмшил юу юм бэ гэж асуух гэж байгаа юм.

Хоёрдугаарт энэ итгэл үнэмшлийг хэрэгжүүлэх концепц юу байна аа? Өөрөөр хэлбэл статистик тоон мэдээнүүдийг бид нар харж байгаа. Өмнөх уулзалтуудаар ч гэсэн авлигыг бууруулахад ОУБ-аас ирүүлсэн зөвлөмжүүдийг та бол хэлж байна лээ. Тэгэхээр энэ дээр бол Улсын Их Хурлын чуулган дээр нэгэнт протокол үйлдэж байгаа учраас та нэг тодорхой ийм хэмжих нэгжтэй хэмжиж болохуйц тийм зүйлийг

концепцыг хэлээч гэж хүсэх гэсэн юм. Дараад нь нэг зүйлийг сонсож хэлмээр байгаа юм аа.

Өвөл болоод хүйтэрдэг. Хүйтрэхээр яаж байна гэхлээр утаа гарна. Утаа гарахаар утааны асуудалтай иргэдийн маш их бухимдал болно. Сая 2 сарын 3, 4-нд утааны сонсгол болсон.

Ингээд анзаарч байхад бол дулаан оронгуут хүмүүс энэ утааны асуудлыг мартчихаж байгаа юм. Энэ дээр бол харагдахад сая өнгөрсөн 10 орчим жилийн хугацаанд 1.8 их наяд төгрөгийн зардлыг утааг бууруулах зорилгоор зарцуулсан авч 190 гаран тэрбум төгрөгийн хэрэг зөрчил одоогийн байдлаар мэдэгдээд байна гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр энэ утааны асуудлыг би зүгээр цаг зуурын шинж чанартай улирлын зовлон гэж ойлгож болохгүй. Хүний эрхийг ноцтойгоор зөрчсөн Монгол Улсын иргэний амьд явах эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд ноцтойгоор заналхийлж байгаа зүйл. Энийг зоригтойгоор далайцтайгаар шийдэж чадахгүй байгаагийн нэг нууц нь энд мөнгө угаалт явагддаг байж болзошгүй нөхцөл байдал.

Дээрээс нь янз бүрийн төсөл хөтөлбөрөөр далимдуулж татвар төлөгчдийн мөнгийг шамшигдуулдаг байж болзошгүй нөхцөл байдлууд байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол энэ зүгээр нэг төрлийн хэргийн дугаартай, хавтаст хэргийн дугаартай материал гэхээсээ илүүтэйгээр энэ бол нийгмийн зүй тогтол бөгөөд Монгол Улсын хүн амын талаас илүү хувь нь оршин амьдарч байгаа Улаанбаатар болон суурьшмал хотуудад тохиолдож байгаа асар том үндэсний аюулгүй байдлын гамшиг.

Д.Амарбаясгалан: Эрдэнэболд гишүүнд нэг нэмэлт нэг минут өгье.

С.Эрдэнэболд: Тэгэхээр нөгөө түрүүний хэлдэг нөгөө махан тэжээлтэй авлигын энэ сүлжээ маш том хэлбэр нь бол нэг талаасаа уур уурхайтай холбоотой байгаа ч гэсэн нөгөө талаасаа энэ утаатай холбоотой байна аа. Энэ дээр жишээлбэл ер нь ямар явц байгаа юм бэ? Зүй тогтол талаас нь би яг тодорхой хэрэг асуугаагүй зүй тогтол талаас нь хариулаач ээ.

Дүгнээд хэлэхэд 2 асуулт.

Нэгд таны өөрийн итгэл үнэмшил ингээд үргэлжлүүлээд ажиллахад хэр байна? Энэ дээр яг тодорхой хариулт.

Хоёрдугаарт бол таны энэ ажлаа үргэлжлүүлэх яг концепц юу юм бэ?

Гуравдугаарт нь саяын сүүлд хэлсэн асуулттай холбогдуулж та байр сууриа хэлээч гэсэн 3 асуулт байна аа.

Д.Амарбаясгалан: Дашдаваа дарга хариулт өгье.

З.Дашдаваа: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. АТГ байгуулагдаад 19 жил болж байгаа. Би энэ авлигатай тэмцэх байгууллагын 5 дахь дарга нь юм байгаа юм. Тэгээд энэ бүрэн эрхийн хугацааг гүйцээж байгаа би анхны дарга нь. Өмнөх дарга нар тодорхой хэмжээгээр цөөн жилээр ажиллаад ингээд ажлаа өгсөн.

Тэгээд энэ авлигатай тэмцэх байгууллага маань 10-аас жилдээ ажиллаж байгаа тодорхой туршлага хуримтлуулсан, тодорхой бас өөрийн гэсэн боловсон хүчинтэй болсон, өөрийн гэсэн туршлагатай болсон ийм байгууллага ерөнхийдөө өсөж бойжиж шинэ байгууллага бололцооны идэр насан дээрээ очиж байна уу гэсэн ийм бодолтой явдаг.

Тийм учраас би энэ хамт олонтой учраас би энэ байгууллагыг цаашдаа бол дараагийн 6 жил Ерөнхий сайдын тавьсан саналын дагуу хүлээж аваад энэ хамт олонтойгоо энэ асуудалтай ажиллахад бэлэн байна гэж үзсэн. Эндээс өөрийн туршлагаас гадна энэ байгууллага хамт олныхоо энэ туршлага энэ чадвар дээр тулгуурлаж энэ ажиллана гэсэн ийм бодолтой байна.

Миний яг үнэхээр яг дараагийн энэ 6 жилд юу хийх концепц юу байна гэхэд би ерөнхийдөө бол энэ бид бол дараагийн 6 жил хүнтэй тэмцэхээсээ илүү бид нар тогтолцоо руугаа нэг анхааръя гэж үзэж байгаа юм. Өнөөдөр энэ хуулиас давсан журмууд гаргаад ингээд энд тэнд хүнд суртал үүсгэдэг хуулиас давсан шийдвэрүүд гаргаад төрийн албан тушаалтнууд аливаа асуудлыг хүндрүүлдэг энэ асуудлуудыг өнөөдөр Улсын Их Хурал, Засгийн газартай хамтарч энэ чиглэлээр тодорхой ажлууд ахиц гаргаж ажиллана гэж бодож байгаа. Энэ дээр ч гэсэн эхний ажлууд явагдаж байгаа. Энэ журмуудыг цэгцлэх ажлуудыг л ХЗДХЯ-нд бүртгэлтэй журмууд байна, бүртгэлгүй журмууд байна.

Энэтэй тэмцэх чиглэлээр Их Хуралтай хамтарсан ажлын хэсгүүд гаргаад энэ ажлуудаа эхлэх гээд ингээд цэгцлээд ингээд явж байна. Энэ чиглэл рүү би эхний ээлжид тухайн хөрс суурь руугаа чиглэсэн ийм тэмцлийн ажлыг эхэлнэ гэж бодож байна. Тийм. Энэ иргэд олон нийт маань шүүмжилдэг. Яг таны яриад байгаа энэ махан идэштэн та нар жижгийг нь бариад байна. Нөгөө том загас барихгүй байна гэдэгтэй л агаар нэг.

Тийм учраас Эрүүгийн хууль тогтоомжоор бол ерөнхийдөө их бага хэрэг гэхгүй. Том жижиг албан тушаалтан гэхгүйгээр энэ эрүүгийн хууль тогтоомжид 22-ын бүлэгт заасан үйлдэл, эс үйлдлийг хийсэн хэн байгаа вэ? Тэр хуулийн дагуу болоод цээрлэлтээ хүлээж байх ёстой. Тэгээд ингээд ерөнхийдөө бол энэ чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тодорхой ахиц гаргаж, энэ нэг тодорхой энэ зохион байгуулалттай чиглэлд орсон гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр ажиллана гэж бодож байна. Тэгээд энэ дээр бол манай хамт олон нэлээн тодорхой туршлага хуримтлуулсан. Бас нэлээн суурь бааз сайтай болсон гэсэн ийм итгэл үнэмшилтэй байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа тодруулах минутаа авчихсан Эрдэнэболд дарга. Нэмээд авчихсан. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууж үг хэлье.

Ц.Мөнхбат: АТГ-ын даргаар ажиллаж байгаад үргэлжлүүлээд ажиллахаар болж байгаа Дашдаваа даргыг дэмжиж байгаа. Ер нь өнгөрсөн цаг хугацаанд хийж хэрэгжүүлж байгаа энэ ажил энэ авлигатай тэмцэх гээд эхлүүлсэн энэ үйл хэрэг үргэлжлээд явах ёстой. Ер нь энэ Монгол Улс энэ авлигын индексээрээ аль болохоор амжилт гаргаж байж улс орны хөгжлийн тухай асуудал ингээд дагаж яригдаж явдаг учраас шударга ёсны тухай асуудал бас энийг дагаж хөндөгддөг учраас би бол таныг үргэлжлүүлээд амжилттай сайн ажиллах болов уу л гэж бодож байгаа. Миний нэг хэлэх гээд байгаа зүйл бол хүний эрхийн мэдрэмжтэй ажиллах ёстой. Ялангуяа энэ авлигатай тэмцэх байгууллагын тэр мөрдөгчид, тэр ажиллаж

байгаа албан тушаалтнууд бол энэ тал дээр бол бас дээд зэргийн хариуцлагатай байх ёстой болов уу гэж боддог. Яах вэ ажлын чиг үүрэг энэ мөрдөн шалгах гүйцэтгэх ажиллагаа явуулах чиг үүрэг өөрөө ажлын онцлог бас зарим нэг өөр зүйлийг шаарддаг байхыг үгүйсгэхгүй.

Мэдээж энэ авлигатай тэмцэхийн тулд албан тушаалтнуудтай л энэ асуудал бол ингээд хөндөгдөөд явж байгааг ойлгож байгаа юм. Тэгээд аливаа нэг албан тушаалтнуудыг мөрдөн шалгах явцад бол мэдээж хэн нэгэн этгээдийн гомдол санал тэр сонирхол хүсэл дээр л тулгуурлаж л хийгддэг байх л даа. Гэхдээ энэ тал дээр ингээд хийгдээд явна гэдэг нь гэмт хэрэгтэн мөн гэсэн үг биш гэж ингэж би хувьдаа боддог юм.

Эцсийн дүндээ шүүхээр орж байж гэм буруутай нь тогтоогдож байж тухайн тэр холбогдсон этгээд нийтэд зарлагдах ёстой. Тэгэхгүйгээр мөрдөн шалгах ажиллагаа явагдах тэр цаг үеэс эхлээд л гэмт хэрэгтэн юм шиг нийгэмд зарлагддаг нь бол энэ хариуцлагагүй асуудал гэж ингэж бодож байна. Тухайн этгээд холбогдогч амьдралтай, гэр бүлтэй, нэр хүндтэй тэрийг бол энэ ХМХ-ээр олон нийтэд зарлаад тэр мэдээллийг санаатай болон санаандгүй байдлаар алдана гэдэг бол тухайн хувь албан тушаалтанд бол маш хариуцлагагүй асуудал гэж ингэж боддог.

Тэгэхээр зэрэг хойшдоо энэ мэдээллээ аль болохоор гаргахгүй байх тал дээр та сайн хичээж ажиллаарай гэж танаас хүсэх байна аа. Бас нэг зүйл бол одоо тэр төрийн албан хаагчид, ялангуяа мэргэжилтнүүд, дунд шатын албан тушаалтнуудаас тухайн холбогдогчтой холбоотой мэдүүлэг байцаалт тэр зүйлүүдийг авч байх шиг байгаа юм. Ингээд авснаараа тэрэн дээр дүгнэлт хийгээд бид нар одоо хэрэг бий болгодог, тэгээд тэр албан тушаалтнууд нөгөө нэг гэрчээр оролцож байгаа нөгөө доод тушаалаар ажиллаж байгаа тэр хүмүүсийн мэдүүлэг дээр үндэслэдэг учраас нөгөө улсууд бол яг үнэндээ энэ АТГ-ын тэр мөрдөгчдөөс айдаг эмээдэг янз янзын тулгамдсан тийм хариултуудыг өгдөг. Түүнээсээ болоод.

Д.Амарбаясгалан: Нэг минут нэмж өгье.

Ц.Мөнхбат: Түүнээсээ болоод өөрөөсөө зайлуулахын тулд аль нэг дээд албан тушаалтнаа гүтгэдэг тэр ийм байдлууд байгаа. Тэгэхээр энэ тал дээр би тэр гэрчийн мэдүүлэг өгч байгаа. Тэр төрийн албан хаагчдаас би зайлшгүй өмгөөлөгчтэйгөөр хэдийгээр эрх нь өмгөөлөгч авах үгүй нь тухайн хүнд байгаа ч гэсэн заавал өмгөөлөгчтэйгөөр гэрчийн мэдүүлэг байцаалт өгдөг байх л их чухал юм гэж хувь хүнийхээ хувьд боддог юм аа. Тэгээд энэ тал дээр та бодолцож ажиллахыг танд хүсье ээ. Тэгээд танд ажлын амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Мөнхбат гишүүн үг хэллээ. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Үүрийнтуяа: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Би асуулт асуухгүй үг хэлнэ. Трансперенси Интернэйшнал ОУБ-ын хийсэн судалгаагаар энэ авлигын төсөөллийн индексээр нэлээн дээгүүр дэлхийд эрэмбэлэгдэж байгаа улс орнуудын энэ авлигатай тэмцдэг байгууллагынх нь удирдлага их тогтвортой ажилладаг юм байна. Дунджаар нэг 10-аад жил. Энэ индексээр нэлээн сүүл мушгиж байгаа улс орнуудын авлигатай тэмцэх байгууллагын удирдлагууд маш ойр ойрхон солигддог ийм судалгаа гарчээ. Монгол Улс Авлигын тухай хуулийг анх баталсан цагаас хойш 11 жилийн дараа энэ авлигатай тэмцэх байгууллагаа байгуулж

ажилласан. Энэ байгууллага байгуулагдаад өнөөдөр 18, 19 жилийн нүүрийг үзэж байгаа юм. Эхний 12 жил 4 дарга ямар нэгэн шалтгаанаар солигдсон байдаг. Сүүлийн 6 жил Дашдаваа дарга бас үр дүнтэй ажиллаж байгаа гэж үзэж байгаа юм.

Бид ер нь Монгол Улс авлигатай тууштай тогтвортой тэмцэх тэмцэл л бидэнд чухал байгаа. Сүүлийн 5, 6 жил Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнэ сайд манлайлж энэ чиглэлээр тодорхой ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байгааг АТГ-ын хамт олон үр дүнтэй үр дүнг нь гаргаж яваа гэж боддог юм. Бид их том үр дүн хүсээд байгаа юм л даа. Манай нийгэмд 20, 30 жил бугшчихсан энэ авлигын суурь эдээгээ нэг 5 жилийн дотор шахаад гаргачих байсан юм шиг л үр дүнг нэхээд байгаа юм. Дийлдэхгүй эрх мэдэлтэй, мөнгөтэй, улс үндэстэн дамнаж амьдарсан ийм бүлэг этгээдүүдтэй болчихсон улс шүү дээ манайх. Маш урт гартай маш олон салаа мөчиртэй. Тэгэхээр энэ асуудалтай тэмцэхэд бид нарт тогтвортой бодлого, тогтвортой удирдлага, тогтвортой ажиллагаа хэрэгтэй л гэж ойлгож байна. АТГ-ын мөрдөн шалгах ажиллагааны үр дүнгээр ТӨК-удын санхүүгийн сахилга бат сайжирсан. Улс орон нутгийн төсөвт оруулдаг мөнгөн дүн нэмэгдсэн гэж тайлагнасан байна лээ. Би санал нэг байгаа. Би ТӨК-д удирдах албан тушаал эрхэлж байсан хүн. Энэ байгууллагын үйл ажиллагаанд шалгагдаж өгсөн зөвлөмжийнх нь дагуу үр дүнг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж байсан хүний хувьд би энэ хамт олон үр дүнтэй ажилласан гэдгийг хэлнэ. Харин бид нар нэлээн хурдтай илүү их үр дүнтэй ажиллаасай гэвэл АТГ-ынхаа бүтэц орон тоо, хөрөнгө хүч, энэ зардлын асуудал дээр нь анхаарах цаг болсон гэж харж байгаа.

Өнөөдөр магадгүй улс төрийн шийдэл гаргасан байх. Бараг 400 бүтээмжийн менежер, хяналтын менежер, төрийн өмчит 123 компани томилогдож байна гэж байгаа. 5-аас 6 сая төгрөгийн цалинтай хүмүүс. Тэгвэл энэ авлигатай тэмцэх асуудлынхаа үндсийг улс төрийн намууд улс төрчид бид өөрсдөө эхлээд манлайлаад явъя л даа. Энэ 400 ажилтныхаа 200-г нь ядаад АТГ орон тоотой цалинтай нь өгчихье л дөө. Тийм төсөв нь байгаа юм бол. Тэгэх юм бол харин тэр нэг ТӨК дээр нэг хүн хяналт тавих гэж нэг хүн бүтээмж дээшлүүлэх гэж очихоос чинь илүү их үр дүн авлигын индекс бууруулсан асуудлууд чинь харин гарч ирэх байх гэж ингэж бодож байгаа юм.

Тийм учраас АТГ прокурорын байгууллага, энэ цагдаагийн байгууллага, хууль хүчний байгууллагуудын үйл ажиллагааг бид аль болох улс төрөөс ангид байлгаж тогтвортой урт хугацаандаа үргэлжлүүлж байж энэ зорьсон зорилго том зорилтын үр дүн хэрэгжинэ гэж ингэж бодож байгаа гэдэг саналаа бол илэрхийлж байна аа.

Ингээд Дашдаваа даргад амжилт хүсье. Энэ авлигатай тэмцэх тэмцэлд АТГ биш авлигын эсрэг бүх байгууллага бүх хууль тогтоомждоо энэ заалтаа бид нар оруулж өгч, бүх байгууллага, бүх албан тушаалтан санаачилж байж энэний үр дүнд хүрэх ёстой шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үүрийнтуяа гишүүн үг хэллээ.

12 цаг 30 минутад санал хураалт явагдана. Гишүүдэд урьдчилж мэдээлэл хүргүүлээрэй. Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе ээ. АТГ-ын даргаар үргэлжлүүлэн ажиллахаар нэр дэвшиж орж ирж байгаа Дашдаваа даргыг дэмжиж

байгаа Дашдаваа даргын багийг бас дэмжиж байгаа. Яагаад дэмжиж байгаа юм бэ гэвэл сая манай гишүүн хэлж байна. Энэ Трансперенси интернэйшнл буюу энэ авлигалын индекс гээд байгаа. Энэ индексийг өндөр гардаг сайн гардаг орнуудын хувьд энэ АТГ-ынх нь дарга удирдлагууд нь их тогтвортой ажилладаг юм байна лээ. Монгол дээр ч гэсэн энэ жишээ тодорхой харагдаж байгаа. Дашдаваа дарга сүүлийн 6 жил ажиллах хугацаанд өмнөх дарга нарынхаа хийж байсан ажилтай нь харьцуулаад үзэхэд бол ажлын ахиц нэлээн өндөр байгаа өндөр байгаа. АТГ ирж байгаа энэ иргэдийн өгч байгаа энэ гомдол мэдээллийн тоо 10, 20 дахин өссөн. 2023, 2024 оны АТГ-ынх нь дотоод үйл ажиллагааных нь тайланг нь веб сайт руу нь ороод иргэд орж үзэж болно. Энэ дээр тодорхой мэдээллүүдээ нээлттэй тавьчихсан байна лээ. Жилдээ 4, 5 мянган өргөдөл, гомдол ирж байна. Өнгөрсөн 2024 он гэхэд 1863 хэрэг дээр мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулсан. Энэ нь бол 2019 онтой харьцуулахад 43 хувиар өссөн гээд илрүүлж байгаа энэ гэмт хэрэг нь гэмт хэрэг хохирлынх нь дүн гэхэд жил болгон ингээд тодорхой хэмжээгээр өндөр үр дүнтэй үзүүлэлттэй яваад байгаа юм. Энэ АТГ-ын төсөв нь жилдээ нэг 40 орчим тэрбум төгрөг мөртөө 2024 оны байдлаар жишээлбэл 240 тэрбум төгрөгийг авлигалын хэргийг илрүүлж энэний үр дүнд хохирлыг барагдуулсан. 2022 он гэхэд 2.3 их наядаар барагдуулсан гэх мэтчилэн ийм ажлын үзүүлэлтүүд байгаад байгаа юм аа.

Манай энэ гишүүд болон иргэд юу хийгээд байна гэхээр авлигалтай авлигалын индекстэй ингэж Авлигалтай тэмцэх газрын ажлыг ингэж дүгнэж үзээд байгаа юм, холбож үзээд байгаа юм. Энэ дээр би нэг зөв мэдээллийг өгөх нь зөв болов уу гэж ингэж бодож байна.

Нийтдээ 13 хөндлөнгийн байгууллагын үнэлгээнүүдийг нийлүүлж Авлигалтай тэмцэх газрын энэ авлигалын CPI буюу авлигалын урьдчилсан индекс буюу индексийг гаргадаг. Энэ 13 байгууллага дотор нөгөө нэг бид нарын дунд яригдаад байдаг энэ ардчиллын олон талт байгууллагын үнэлгээ гээд Шведийн их сургуулийн дэргэдэх ийм үнэлгээ улс орнуудыг хооронд нь харьцуулдаг ийм үнэлгээний нэг байгууллага. Энэ байгууллагын үнэлгээ жишээлбэл энэ 13 байгууллагын нэг байх жишээтэй. Энэ үнэлгээ нь энэ байгууллагууд үнэлгээгээ хийхдээ 2 янзаар хийж байгаа. Нэгд нь олон улсын экспертүүдийн үнэлгээгээр хийгдэж байгаа юм.

Хоёрдугаарт нь бизнес эрхлэгчдээс нь санал асуулга авч байгаа юм. Тэгээд олон улсын экспертүүд нь үнэлгээгээ хийхдээ яадаг вэ гэхээр зэрэг тухайн орон дотор явж байгаа нийгэмд явж байгаа хэрэг маргааны асуудлууд, энэ цахим орчинд явж байгаа асуудлууд, энэ нь хэрхэн шийдэгдэж байгаа юм гэх мэтчилэн энэ Улсын Их Хурлын Улсын Их Хурал дээр хийх гэж байгаа сонсгол түүний хэрэг маргаан нь хэр зэрэг явж байгаа юм гэдэг ийм асуудлууд нь эргээд энэ үнэлгээнд нөлөөлж байгаа.

Нөгөө талаасаа бизнес эрхлэгчдээс авч байгаа саналууд нөлөөлнө. Энэ дотор төрийн Засгийн газрын зүгээс энэ Засгийн газрын агентлагуудын зүгээс ажлаа сайжруулах шаардлагатай. Ийм үзүүлэлтүүд явж байгаа. Тухайлбал төрийн байгууллагаас олгодог энэ зөвшөөрлийн асуудлууд байгаа. Энэ нь хэр зэрэг ил тод нээлттэй байгаад байгаа юм. Төрийн албан хаагчид өөрсдөө энэ эрх мэдлээ хэр зэрэг ашиглаж байгаа юм. Энэ нь нээлттэй болж чадсан юм уу? Төрийн албан хаагчдын субъектив хамаарлын бууруулж чадсан юм уу гэдэгтэй холбоотой. Өөрөөр хэлбэл Засгийн газрын үйл ажиллагаа бусад энэ үйл ажиллагаануудаа сайжруулахгүй бол энэ үнэлгээнд нөлөөлөх ийм зүйл байгаа юм. Тендерийн

худалдан авалтын асуудал, төсвийн худалдан авалтаас гадна төрийн өмчит ААН-үүдийн худалдан авалтын асуудал.

Нөгөө Эрдэнэс Тавантолгой компани нь төмөр зам барьчихдаг. Энэ дээрээ ямар журмаар энэ компаниудыгаа сонгож явуулж байгаа юм бэ гэдэг ийм асуудлууд чиг эргээд энэ үнэлгээнд чинь нөлөөлөөд байгаа юм аа. Тийм учраас эдгээр үнэлгээнүүд дээр энэ зөвхөн АТГ гэхээс гадна энэ.

Д.Амарбаясгалан: Нэмэлт нэг минут.

Б.Заяабал: Засгийн газрын үйл ажиллагаа бас энэ дээр тодорхой үүрэг рольтой гэдгийг энэ дээр хэлэх нь зүйтэй. Төрийн албан хаагчдын ерөөсөө энэ эрх мэдэл албан тушаалаа ашиглаж байгааг чинь ерөөсөө л авлигалын хэрэг гээд байгаа. Гэтэл өнөөдөр Монгол Улсад энэ орлогын тэгш бус байдлын үзүүлэлт буюу Жи нэг коэффициент дэлхийн банкны гаргадаг үзүүлэлтээр Монгол Улс 195 орноос 116-д явж байгаа юм. Төрийн албан хаагчдын цалин нь өнөөдөр бас яг тийм амьжиргааны хангалттай түвшинд байна уу гэвэл тийм үзүүлэлтийг хангаж чадахгүй байна аа.

Тийм учраас би энэ дээр санал хэлэх гээд байгаа юм. АТГ энэ дээрээ цаашдаа энэ авлигыг бууруулах, урьдчилсан сэргийлэхтэй холбоотой, одоо бол үнэлгээ хийдэг төрийн байгууллагуудын дунд үнэлгээ хийгээд өндөр үнэлгээ гарсан газрууд дээр сонгож АТГ урьдчилсан сэргийлэх ажил сургалтуудыг хийдэг.

Энэ дээрээсээ нэмээд бас энэ төрийн албан хаагчдын цалин, тухайлбал яг хэдэн төгрөг байвал авлигад эергээр нөлөөлөх юм бэ гэдэгтэй холбоотой судалгаа хийж Засгийн газарт санал ирүүлэхийг би хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт нь.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Лхагвын Мөнхбаатар гишүүн асуулт асууж үг хэлье.

Л.Мөнхбаатар: Ерөнхий сайд өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд АТГ-ын даргыг улируулан томилох томилуулах саналаа оруулж ирж байна. Өчигдөр Улсын Их Хурлын бүтцийн байгууллагууд, ХЗБХ-оор орж дэмжигдсэн. Өнөөдөр нэгдсэн чуулганаар хэлэлцэж байгаа. Ер нь авлигатай тэмцэх асуудалд энэ 2 гол хүчин зүйл байдаг. Нэг нь улс төрийн хүсэл зоригийн асуудал байгаа юм. Нөгөөдөх нь энэ авлигатай тэмцэх байгууллагын түүний багийн туршлага, түүний ур чадвартай холбоотой байдаг. Улс төрийн хүсэл зоригийн хувьд эрх баригчдын хувьд энэ чиглэлээр багагүй зүйлүүдийг хийж хэрэгжүүлж байгааг хэлэх хэрэгтэй. Эрүүгийн хууль тогтоомжид тодорхой өөрчлөлт оруулж авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг чангатгах ажлыг удаа дараа хийсэн.

Энэ өөрчлөлтөөр авлигын хэрэгт торгох ял оногдуулахаа больсон. Зөвхөн хорих ял оногдуулдаг 5-аас 12 жилийн ялтай түүнээс гадна улс төрийн нөлөө бүхий этгээдүүд буюу ярьдаг өндөр албан тушаалтнуудад бүүр 12-оос 20 жилийн ял буюу хүний амь насыг хөнөөсөнтэй дүйцэхүйц хэмжээний ийм өндөр ялыг хүртэл оногдуулах ийм өөрчлөлтүүдийг хийсэн байгаа. Энэ бол ингээд хэрэгжээд явж байна.

Түүнчлэн мөн одоо ял наймаалцах энэ асуудлуудыг байхгүй болгосон. Түүнтэй холбоотой олон өөрчлөлтүүдийг ингээд хийгээд явж байгаа. Бусад эрх зүйн олон шинэчлэлүүдийг хийгээд энэ хүсэл зоригийг энд хэрэгжүүлээд явж байна 5 ш ажиллагаа гээд олон авлигатай тэмцэх ажлуудыг хийж хэрэгжүүлж байгаа ийм ажлууд байна. Түүнээс гадна авлигатай тэмцэх байгууллага бол бас Дашдаваагийн удирдаж байгаа энэ байгууллага түүний баг нэлээн туршлагажиж энэ чиглэлээрээ сайн ажиллаж байна. Гадаад дотоодын байгууллагуудтай нэлээн сайн хамтран ажиллаж байгаа. Энэ чиглэлээр хийж байгаа ажлын үр дүн тайлантай нь Их Хурлын гишүүд бүгд танилцаж байгаа. Энэ дотроос нь би нэг зүйлийг нэг онцолж ярьж гэж бодож байгаа олон ажлууд л байна.

Ер нь нэг талаасаа авлигачдад ял шийтгэл оногдуулах нь тодорхой. Түүнээс гадна түүний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэлгүй хөрөнгөжсөн энэ гэм хорыг нөхөн төлүүлэх асуудал хамгийн чухал байдаг. Энэ бол өөрөө төрд нийгэмд учруулсан их томоохон хохирлууд байдаг учраас энэ дээр нэлээн ахиц гарсан байгаад байгаа юм. 2019 онд 11 тэрбум байсан бол одоо өнгөрсөн онд 240 тэрбум байна. Нийтдээ 2.9 тэрбум төгрөгийн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлсэн. Энэ дотор нөгөө үндэслэлгүй хөрөнгөжсөн тохиолдолд эд хөрөнгийг нь хураах ял ч гэсэн энэ тоон дотор ороод явж байгаа гэсэн үг.

Бид ямар ч байсан энэ чиглэлээр тодорхой хэмжээнд үр дүнтэй ажиллаад энэ хуулийн боломжийг ашиглаж байна гэж гэж ойлгож байгаа. Энэ чухал өөрчлөлт сайн ажиллаж байна гэж би ойлгож байгаа. Энэ өөрчлөлт бол 2015 онд орсон өөрчлөлт. Тухайн үед Хууль зүйн сайд байсан энэ Тэмүүжин байхдаа оруулсан санагдаж байна. Энэ үндэслэлгүйгээр хөрөнгөжих Нийтийн албан тушаалтан үндэслэлгүйгээр хөрөнгөжөөд хөрөнгө орлогын их хэмжээгээр нэмэгдсэн түүнийгээ нотолж чадахгүй бол ил нотолж чадаагүй тэр хөрөнгө орлогыг нь хураадаг ийм зохицуулалттай болсон. Энэ бол хангалттай сайн зохицуулалт байгаа. Үүнийгээ харин сайн хэрэгжүүлэх хэрэгтэй нуугдмал эд хөрөнгийг олж илрүүлэх түүнийгээ тогтоогоод явах бүрэн боломжтой.

Харин сүүлийн үед харин хөрөнгийг компаничилж хураах тухай хуулийн төслийг ярьдаг бүр оруулж ирсэн байгаа. Энэ болохгүй. Хүнд байдаг үндсэн эрх бол хувийн өмчтэй байх хэрэг байгаа. Үндсэн хуулиар олгогдсон эрх. Хувийн өмчтэй байх энэ үндсэн хүний эрхэд огт халдаж болохгүй. Энэ турхирсан хүний эрхэд халдаж байгаа ноцтой зүйл болно. Компаничилж хүний нэр зааж, албан тушаал зааж, он зааж болохгүй.

Д.Амарбаясгалан: Мөнхбаатар гишүүнд нэг минут нэмж өгье.

Л.Мөнхбаатар: Тийм учраас энэ асуудал шүүхийн холбогдох хуулийн байгууллагаар тогтоогдож шүүхээр гэм буруу нь тогтоогдож байж энэ түүнийг дагалдаж энэ хөрөнгө хураах асуудал нь яригддаг зүйл ээ. Түүнээс биш ийм кампаничилж шийддэг зүйл биш шүү. Хэрвээ ингээд явах юм бол тодорхой хэсэг нь алга ташна. Түүний дараа аймаг, суман дээрээ очно. Сүүлдээ сумын эмнэлгийн эмч сургуулийн багш нарын хөрөнгийг хураах тухай болоод явна. Ийм гашуун түүх бидэнд бий.

Тийм учраас ийм хүний хувийн үндсэн эрх рүү халдсан зүйлүүдэд ерөөсөө халдахгүй байх ёстой. Энд их болгоомжтой хандаж байх ёстой шүү гэдгийг хэлэх гэсэн юм. Ингээд АТГ-ын даргыг улируулан ажиллуулах нь өөрийн хуримтлуулсан

энэ туршлага түүний баг хамт олон цаашид хийж хэрэгжүүлэх энэ ажилд нь бол улс төрийн дэмжлэг хэрэгтэй. Дээр нь энэ багийн ажиллагаагаа сайжруулах туршлагаа нэмэгдүүлж.

Д.Амарбаясгалан: Лхагвын Мөнхбаатар гишүүн үг хэллээ. Дамбын Батлут гишүүн асуулт асууж, үг хэлье ээ.

Д.Батлут: АТГ-ын даргыг томилох асуудал хурал дээр орж ирж байна. Дашдаваа даргыг бол дэмжиж байна аа. Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх баялагтаа эзэн байх тухай уриалгыг гаргаж, Монгол Улсын Засгийн газар энэ уриалгыг манлайлж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Манай хойд бүс дээр олон гишүүд сонгогдож ажиллаж байгаа манай Баттулга гишүүн маань Эрдэнэтэд очиж уулзахдаа байгалийн баялгаасаа иргэд хувь хишиг хүртэх ёстой гэж ярьж явсан байна лээ. Сонгуулийн үеэр бас 10 саяын хэрэглээний зээл авсан айл өрхүүдийн хэрэглээний зээлийг тэглэнэ гэсэн яриаг ч гэсэн гаргаж байсан. Тэгээд бодоод байсан чинь эх үүсвэр нь тодорхой байсан юм байна гэж хараад байна л даа. Хэрвээ айл өрх бүрийн 10 саяын хэрэглээний зээлийг тэглэж төсөвт тавина гэвэл Монгол Улсын төсөв барахгүй. Харин эх үүсвэр нь тодорхой байсан учраас ярьж байсан юм байна гэж ойлголоо. Төгрөг нуурын ордыг 250 сая доллароор заржээ.

Тэгээд одоогийн ханшаар үржүүлэх юм бол энэ нь өөрөө нэг 830 тэрбум төгрөг болж байгаа юм. Манай хойд бүс 80 гаран мянган айл өрхтэй яг үнэн байсан юм байна. Би тэр үедээ худлаа л байна даа гэж бодож байсан. Одоо бол үнэн итгэл үнэмшилтэй болж эхэлж байна. Тэгээд энэ айл өрхийн хэрэглээний зээлийг хэзээ тэглэх юм бол? Тэглээсэй гэж хүсэж байгаа. Бас нэхэж ажиллана гэж би бодож байна. Ер нь энэ уул уурхайтай холбоотой асуудал олон асуудлууд байна. Татварын асуудлууд ч үүснэ энэ дээр. Тэгэхээр манай АТГ-ын дарга энэ тал дээр онцгой анхаарч ажиллах хэрэгтэй цаашдаа. Би бол одоо Баттулга гишүүнээсээ хэрэглээний зээлээ тэглэж өгөөрэй 10 саяын. Яг хойд бүс дээрээ 80 гаран мянган өрхийн хэрэглээний зээлийг тэглэх гээд бүүр бэлдчихсэн байсан юм байна гэж ойлголоо. Талархаж байна иргэд сонгогчдынхоо өмнөөс. Тэгээд үүнийг нэхэж ажиллана. Тэгээд АТГ-ын дарга таныг нэг хүн томилуулсан байж болно. Тэгэхдээ та нийтийн төлөө ажиллах ёстой амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батлут гишүүн үг хэллээ. Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн асуулт асууж үг хэлье.

П.Мөнхтулга: Авлигатай тэмцэнэ гэдэг бол маш өндөр албан тушаалтай, бүлэглэсэн боловсролтой, хуулийн багтай ийм том хүчтэй тэмцэнэ ээ. Монгол Улс төрийн албан хаагч 226 мянга, ТӨК-д ажилладаг дахиад 60, 70 мянга. Ингээд 300 мянган хүмүүсийн хам хүрээнд 65 мөрдөгчтэй орон нутагт 21 аймгийн засаг захиргаа түүний агентлагууд гээд тэнд 8 мөрдөгчтэй ажилладаг гэж өчигдөр бүлэг дээр ярьж байна лээ.

Тэгэхээр ингээд нэг холбогдогчийг аваад байцаахаар өгөгч авагч гэсэн ингээд 2 тал байгаа. Зуучлагч, хамжигч, дэмжигч гээд 5, 6 талуудыг жаран тавхан мөрдөгчөөр 300 мянган төрийн албан хаагчийн хам хүрээнд ажиллана гэдэг бол яг ингээд тоог нь бодоход л АТГ энэний ард гарахад хэцүү. Тэгэхээр миний санал болгоод байгаа юм юу вэ гэхээр ер нь ингээд авлигатай тэмцээд үр дүнтэй ажилласан орнуудын жишгийг харахлаар өгөгчийг ялаас чөлөөлдөг өгөгч хэрвээ үнэхээр хэргээ хүлээгээд нотлох баримтаа гаргаж тавих юм бол өгөгчийг ялаас

чөлөөлдөг. Тэгээд ирэхлээр яах вэ гэхээр төрийн албан хаагч нь авахаасаа айдаг. АТГ бол 2 хүн хоёулаа ял авах гээд байгаа учраас хоёулаа хэргээ нуучихдаг. Тэгээд тэр том хүчтэй ийм цөөхөн бүрэлдэхүүнтэй ажиллаад манайх хэргээ илрүүлж чадахгүй ингээд л овоороод байгаа юм. Тэгэхээр юу вэ гэхээр АТГ-ын даргад нэг соён гэгээрүүлэх үүрэг байдаг чиглэл байдаг. Тэнд судалгааны баг байх ёстой. Тэрүүгээрээ энэ хуулийн хүрээнд энэ өгөгчийг чөлөөлөх өөрсдөөсөө энэ ачааллыг бууруулах хэргийн илрэлтийг нэмэгдүүлэх тал дээр судалгаа хийж Улсын Их Хуралд тайлагнаж өгөөч ээ.

Тэгээд холбогдох хуулиудад нь өөрчлөлт оруулаад энэ өгөгч өөрөө хүлээн зөвшөөрөөд хэргээс чөлөөлөгддөг байх юм бол авагчийг байнга бид нар дотроос нь илрүүлж чадна аа. Хэргийн илрэлт бол ерөөсөө 50 хувиар нэмэгдэнэ. Холбогч шалгах ёстой хүн нь 50 хувиар хасагдаж энэ холбогдогч яг бид нар байгаа онож чадна л гэсэн. Энийг хэлэх гээд байгаа юм. Энэ маань тэгээд олон улсуудад зөв жишээ болж явдаг юм байна аа.

Хоёрт нь та ингээд 12 жил, ингээд 2 бүлгийн хурлыг харахлаар хоёулаа ер нь дэмжихсэн дүнтэй гарсан. Ингээд цаашаа үргэлжлээд ажиллах байх. 12 жил ажиллаж байна. Энэ бол нэг ди кэйд гэж ярьдаг хулгана жилээс дараагийн хулгана жил хүртэл. Энэ 12 жилийн энэ дараагийн ажиллах 6 жил дээр нэг алга эргүүлэх юм шиг сайхан өөрчлөлт хийгээч, түүхэнд үлдээч ээ. Түүхэнд алтан үсгээр бичигдээч ээ. Ийм өөрчлөлтийг хүлээж байгаа. Тэгэхийн тулд энэ авлигатай тэмцэж байгаа өмнөх 6 жилийн туршлагаа ашиглаад энэ дээр суурилсан эрх зүйн орчны бүрэн реформ маягийн юмыг хийе гэдэг ийм саналыг дэвшүүлж байна.

Тэгээд холбогдох хуулиудыг нь судлаад тэр түрүүний хэлээд байгаа өгөгч өөрөө хэргээ хүлээгээд ингэх юм бол ялаас нь чөлөөлдөг энэ бодлого руу оръё гэсэн ийм саналтай байна аа. Тэгээд танд амжилт хүсье ээ. Бас минут дуусаагүй байна. Хэвлэл мэдээллээр улс төрждөггүй чинь их зөв шүү. Хэргийг шүүхэд шүүхэд л эцсийн шийдвэр гарч байгаа. Амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Мөнхтулга гишүүн үг хэллээ. Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууж үг хэлье ээ. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Дашдаваа даргад бол ингээд 6 жил ажилласан байна. Цаашдаа бол үргэлжлүүлэн ажиллана гэж харж байна. Амжилт хүсье.

Ганц 2 асуудал асуулт асуух гэсэн юм. Авлигатай тэмцэх байгууллага бол байгууллагын мөрдөгчид тухайлбал нөгөө Хөгжлийн банкны хэргийг шалгахад нэг мөрдөн байцаагч 200 мянган хавтас хэрэг бүрдүүлж нэлээн нүсэр ажил болдог. Тэгэхээр шүүх дээр очихлоороо болохлоор 60 орчим 30 хувь нь бол ингээд хэрэгсэхгүй болоод байна. Тэгэхээр энэ ер нь яагаад ийм болоод байна гээд таны бодож байгаа бодол юу байна аа?

Нэгдүгээрт прокурорын мэргэжлийн ур чадвар муу байна уу эс үгүй бол танай боочихсон хэргийг улсын яллагч тааруу харж шийдэж байна уу. Эс үгүй бол хууль тогтоомжийн зохицуулалт муу байна уу? Эс үгүй бол хэрэглэгчид ойлгомжгүй байдлаас болж байна уу? Ер нь шүүхийн хараат бус байдал энд алдагдаад байна уу? Ер нь прокуроруудын та Ерөнхий прокурортой яаж цаашдаа 6 жилд хамтарч ажиллая гэж бодож байна энэ дээрээ анхаарч ажиллана уу гэж хүсэж байна аа.

Д.Амарбаясгалан: Дашдаваа дарга хариулъя.

З.Энхнасан: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Авлига албан тушаалын гэмт хэрэг өөрөө бас нэлээн ажиллагааг шаарддаг. Гадаад дотоодын эрх зүйн туслалцаа харилцаа гээд ингээд нотлох баримт бүрдүүлэх цуглуулах энэ үйл ажиллагаа нэлээн төвөгтэй ээдрээтэй явдаг ийм ажлаа. Тэгээд энэ дээр бид ямар ч байсан ямарваа нэгэн байдлаар прокурорын байгууллагатайгаа нягт хамтран ажилладаг аа. Өнөөдөр манай байгууллагын мөрдөн байцаах албыг бол Улсын прокурорын Нийслэлийн прокурорын газрын 1 дүгээр хэлтэс хариуцан хяналт тавьж ажилладаг. Ингээд бид ерөнхийдөө бол тэр хэлтсийн прокурорууд маань тодорхой хэмжээгээр энэ авлига албан тушаалын гэмт хэргийг мөрдөх хянах чиглэл дээр бол мэргэшсэн энэ чиглэлийн хүмүүс байгаа. Бид ч гэсэн аливаа гадна дотнын төсөл хөтөлбөрүүд дээр нь сургалтуудад бол нийслэлийн прокурорын газрын тусгай манайх хариуцдаг прокурорууд болон ерөнхийдөө манай хэргүүд очдог чингэлтэй одоогоор Зүүн бүсийн шүүхийн шүүгч нарыг сургалтад хамруулдаг.

Тийм учраас энэ юу юугүй энэ хэрэг төвөг маань очоод шүүх дээр очоод цагаадах асуудал харьцангуй гайгүй. Ганц нэг тохиолдлууд бий. Энэ дээр бас хууль тогтоомжийн зөрүүтэй байдал шүүгч энэ дээр ямарваа нэгэн бид нар тайлбар хэлэх боломжгүй. Энэ шүүхийн хараат бус байдал. Тэгээд энэ дээрээ бол прокурор мөрдөх байгууллагууд бол бололцооны хэрээр мөрдөж нотолж л шүүхэд өгч байгаа. Тэгээд энийг бол эцсийн шийдвэрийг шүүх гаргаж байгаа. Тэгээд энэ дээр яг хэрэг цагаадаад асуудал нэг талдаа гараад байгаа асуудал харьцангуй бага байгаа гэж хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Чинбүрэн: Гишүүддээ энэ өглөө мэнд хүргэе ээ. Өнгөрсөн парламент өнгөрсөн хамгийн отгон чуулганаараа бид Эмийн түр хорооны нээлттэй сонсголыг сонссон. Эмийн түр хороог намайг ахалж ажиллаж байхад нэгдмэл ашиг сонирхолтой этгээд гэдэг хуулийн заалтад 260 гаруй хүний нэрс холбогдож эдгээр улсууд шийдвэр гаргах түвшинд нөлөөлж оролцсон уу, оролцоогүй юу гэдгийг би АТГ-т хүлээлгэн өгч энийг шалгаж өгөөрэй гэж өгсөн. Хариу аваагүй байгаа.

Тэгэхээр энэ асуудал ямар шатад явж байгаа талаар Дашдаваа дарга нэг хариулт өгөөч. Ер нь тэгээд энэ 260 гаруй хүмүүсийн нэрсийг энэ хуулийн заалттай нь уяад харахлаар ямар нэгэн хамааралгүй олон олон хүмүүс энд орсон. Зүгээр миний АТГ-т өгдөг нь эдгээр улсуудын нэр гарсан улсуудыг цагаатгах энэ хамаагүй шүү. Зүгээр нэгдмэл ашиг сонирхолтой гэдэг хуулийн заалт нь өөрөө их маш их өргөн утгатай байдаг. Харин яг шийдвэр гаргахад Хүний эмийн зөвлөлд ажилласан уу, тухайн компаниудын үйл ажиллагааг дэмжсэн үү, тэр шийдвэр гарахад би ашиг сонирхлын зөрчилтэй гээд тухайн хурлаас өөрөө би энэ санал хураалтад оролцохгүй энэ тэр гэж хэлж өгч чадсан уу гэдэг асуудлыг л тодруулах гэж би АТГ өгч байсан.

Тэгэхээр энэний явц ямар байна вэ. Би эмийн түр хороо ажиллаад Засгийн газарт бол тогтоол гаргаж 10 хэдэн шийдвэрлэх асуудлуудыг үүрэг даалгавар өгсөн. Өнгөрсөн намрын чуулганаар хэлэлцэх ёстой байсан асуудлаа оруулж ирээгүй. Өнөөдөр бид Нийгмийн бодлогын байнгын хороогоороо тайлангаа 50 гэдэг

шаардлагыг би дөнгөж өчигдөр ЭМЯ эрүүл мэндийн сайдад хэллээ. Тэгэхээр энэ процессыг та нэг дэлгэрүүлж хэлж өгөөч?

Д.Амарбаясгалан: Дашдаваа дарга хариулт өгье.

3.Дашдаваа: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя аа.

Энэ Монгол Улсад Засгийн газрын харьяанд агентлаг эмийн эмийн мэргэжлийн хэрэгсэлд тавих хяналт тавих ийм агентлаг байгуулагдсан. Энд манай байгууллага чиг үүргийнхээ хүрээнд иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу бид энэ шалгалт хийгээд энэ тодорхой ажлууд зохион байгуулагдсан. Үүний дараа эмийн сонсгол явагдсан. Ингээд ерөнхийдөө бол ер нь энэ эмийн салбар гэдэг маань ерөнхийд энэ нэг бидэнд мэргэжлийн онцлог юм байна лээ. Ерөөсөө л энэ нөгөө нэг сургууль төгссөн, нэг анги төгссөн энэ хүмүүс ер нь тэр салбартаа л ажилладаг. Энэ өөр тийм мэргэжлийн боловсон хүчний хувьд бол тодорхой нэг хэсэг бүлэг нэг үеийн хүмүүсийн дунд л энэ асуудлууд явж байдаг юм байна лээ. Бид ямар ч гэсэн энэ эхнээсээ манай хяналт шалгалтын хэлтэс бол тодорхой нөгөө хамаарал юуг нь үзээд хариунуудыг нь бол ЭМЯ болон эмийн энэ агентлагт өгөөд явж байгаа гэж ингэж л хэлэх байна.

Д.Амарбаясгалан: Чинбүрэн гишүүн тодруулж асууя.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр Дашдаваа дарга энэ дээр нэг хэдүүлээ нэг бүүр нэг ажил болгож ажилламаар байгаа юм. Шийдвэр гаргах тэр Хүний эмийн зөвлөлийн хурал болоод аль нэг эмийг хөнгөлөлттэй эмийн жагсаалтад оруулах гэж байгаа бол өө би энэ компанид хамааралтай учраас би санал өгөхгүй гэдэг ийм соёлыг сургах энэ ажил дээр хэдүүлээ сайн ажиллаж, энэ ашиг сонирхлын зөрчлөө илэрхийлээд тэгээд гарын үсэг зурж байгаа шүү дээ. Энэ хуралд энэ тэр орохдоо. Тэгэхдээ бүүр зориудаар тэр өөрийнхөө компанийнхаа бүтээгдэхүүнүүдийг ажиллаж байсан компанийнхаа бүтээгдэхүүнүүдийг улайм цайм дэмжээд орсон ийм тохиолдлууд Эмийн түр хорооны тэр нотлох баримт дотор орсон. Харин энд ямар ч хамааралгүй хэрнээ нөгөө нэгдмэл ашиг сонирхол гэдэг утгаараа ямар нэгэн ашиг сонирхол байхгүй ч гэсэн нэр нь холбогдоод тэрэнд эмзэглэсэн олон олон эрүүл мэндийн салбарын ажилтнууд байгаа.

Тэгэхээр энийг нэг юугаар нь ус, сүүгээр нь ялгаад тавьчихмаар байгаа юм. Энэ дээр та нэг анхаарч ажиллаарай гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууж үг хэлье ээ.

Н.Номтойбаяр: 3 асуулт байна. Ер нь гишүүдийн асууж байгаа асуулт АТГ-ын дарга дэд даргын томилгоо гэхээр нэг л зүйлийг бүгдээрээ л дотроо бодож гаднаа асуудаг. Улс төрөөс хэр үл хамааралтай байх вэ гээд. Тэгээд энэ үүднээс нь 3 асуулт асуух гэсэн юм.

Нэгдүгээрт, өөр дээрээ сайн мэдэхийн хувьд жишээ авъя. 2019 оны 11 сарын 22-ны өдөр улсад 3.9 тэрбум төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулсан гээд намайг сэжигтнээр татаж байсан. Яах вэ шалгагдах ёстой юм шалгагдана биз. Тэгээд дуудсан цагт нь очоод л байцаалт мэдүүлгийг нь өгөөд л явсан. Тэгээд 3.9 тэрбум төгрөгийн хохирол учраагүй нь тогтоогдсон. Хохирол учрах ч үндэс ердөөсөө

байгаагүй. Төсвийн тухай хуулиар бүх юм шийдэгдээд л явж байсан. Тухайлбал 2019 оны 2017 оны төсвийн тухай хуулиар. Тэгээд хэрэг нь хэрэгсэхгүй болж байгаа юм байна гэдэг ойлголт тухайн үед хяналтын прокурор байсан Мөнхбат гэж хүнээс албан бичгээр авч байсан. Гэтэл 2020 оны 4 сарын 27-нд бие дааж нэр дэвшихээр болонгуут 4 сарын 29-нийх нь 12 цаг 31 минутад намайг эрүүгийн хэрэгт яллагчаар татах шинээр тогтоол үйлдээд дуудсан.

Тэгсэн яасан бэ гэхээр банкаар дамжуулж хүү тооцоогүй гээд. Тодорхой яривал нөгөө Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэ ажилгүйдлийг бууруулах халамжаас хөдөлмөр эрхлэлт рүү шилжүүлэх зорилготой олгодог санхүүгийн дэмжлэг. Тэрийг банкаар дамжуулж хүү тооцоогүй гээд. Хуульд банкаар дамжуулж хүү тооцдог ямар ч эрх зүйн зохицуулалт байдаггүй. Тэгээд би Төсвийн тухай хуулиа аваад ирье. Маргааш мэдүүлгээ өгье өө гэсэн чинь маргааш нь шууд яллах дүгнэлт үйлдчихсэн. 24 цагийн дотор. Надаас ердөөсөө тайлбар мэдүүлэг аваагүй. Нотлох баримтаа шалгуулах Үндсэн хуулиар олгогдсон эрхийг минь олгоогүй. Ингээд чирээд явчихсан. Энэ хүртэл бол таны удирдлага дор ажиллаж байсан одоо ч ажиллаж байгаа Нямдагва гэж мөрдөн байцаагч энэ бүгдийг хийж байсан.

Тэгэхээр энэнтэй холбогдуулаад асуухад ийм зүйл ер нь байж болдог юм уу? Та хувь хүнийхээ үүднээс ч тэр энэ хариуцлагатай албан тушаал дээр 6 жил ажилласан хүний хувьд ч тэр ер нь юу гэж дүгнэж байгаа юм?

Хоёрдугаарт 2022 оны 12 сарын 13-нд нүүрсний хулгайч гээд Халтмаагийн Баттулга тэргүүтэй 17 хүнийг зарласан. Хариуцлагатайгаар зарласан АТГ-аас. Энэ юу болсон.

Гуравдугаарт өнөөдөр 126 Улсын Их Хурлын гишүүд байна. Энд ямарваа нэгэн байдлаар шууд болон харилцан хамаарал бү бүхий этгээдээрээ шалгагдаж байгаа хэдэн нөхдүүд байгаа юм. Энийг би яагаад асуугаад байна гэхээр санал хураалтад бие даасан байдлаар Их Хурлын гишүүнийхээ өргөсөн тангаргийн хүрээнд санал хураалтад оролцох гээд байна уу үгүй юу гэдэг дээр би эргэлзээд байна. Энэ 3 асуултдаа тодорхой хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Дашдаваа дарга хариулт өгье.

3.Дашдаваа: Номтойбаяр гишүүний асуултад хариулъя. Өмнө нь шалгагдаад ингээд шүүхээр ороод шийтгэгдсэн асуудал дээр бол миний хувьд хууль сахиулах байгууллагын сахиулах болоод Авлигатай тэмцэх байгууллагын даргын хувьд дүгнэж хэлэх зохимжгүй, нэг.

Хоёрдугаарт эрүүгийн хэрэгт яллагдагчаар татах ялын дүгнэлт үйлдэх эрх бол авлигатай тэмцэх хууль сахиулах байгууллагад мөрдөх байгууллагад байдаггүй ээ. 2022 оны 10 сарын 13-нд нийтдээ арван хэдэн хүнийг зарласан байгаа. Энэ нь бол өмнө нь эрхэлж байсан ажил алба болон өмнө нь хийж байсан бизнес үйл ажиллагаатай холбоотойгоор Эрдэнэс Тавантолгой компанитай ямар нэгэн байдлаар хамааралтай байна. Энэ хүмүүсийг ингээд шалгах шаардлагатай байна гэсэн ийм мэдээллийг хийсэн. Энэ хүрээнд одоо мөрдөн байцаалтын болон хэрэг бүртгэлтийн 44 хэрэг үргэлжлээд шалгагдаад явж байна. Эхнээсээ 17 хэрэг шүүхээр ороод шийдэгдсэн байна.

Ямар нэгэн байдлаар шалгагдаж байгаа 126 гишүүн дотор байна уу гэсэн энэ дээр энэ хариулах боломжгүй байна. Танд би эргээд шүүгээд ингээд танилцуулж болох байх.

Д.Амарбаясгалан: Номтойбаяр гишүүн тодруулж асууя.

Н.Номтойбаяр: Эхний асуулт нөгөө надтай холбоотой. Эцсийн дүндээ явж явж Дээд шүүх хэрэгсэхгүй болгож шийдсэн. Өөрөөр хэлбэл анхнаасаа хэрэг үүсгэсэн байдал, яллах дүгнэлт үйлдсэн байдал, анхан болон нийслэлийн давж заалдах шатын шүүхийн бүх энэ хуулийн дагуу явсан процессууд, хууль бус байна. Энэ бол гэмт хэргийн бүрэлдэхүүн ч алга гээд хэрэгсэхгүй болгочихсон. Та бол энийг маш сайн мэдэж байгаа. Тэгэхээр өөртөө дүгнэлт хийгээрэй.

Хоёрдугаарт одоо нүүрсний 2 дугаар анги нээгдчихээд байна л даа. Засгийн газрын зүгээс Төгрөг нуур Халтмаагийн Баттулгатай холбоотой асуудлуудыг яриад байна. Энийг ингээд харахад татвараас зайлсхийсэн, мэдээлэлд ойрхон байдлаа ашигласан, мөнгө угаасан, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн маш олон асуудлууд энд харагдаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Түрүүн үндсэндээ байр сууриа илэрхийлчихсэн л дээ. Хэвлэлээр явж байгаатай холбоотой асуудалтай холбогдуулж. Дашдаваа дарга хариулт өгье.

3.Дашдаваа: Энэ чинь ямар асуулт билээ.

Д.Амарбаясгалан: Засгийн газраас энэ Төгрөг нуурын ордтой холбоотой асуудал ярьж байна шалгах юм уу л гээд л тэгж байна л даа.

3.Дашдаваа: Үгүй энэ хэвлэл мэдээллээр гарч байгаа асуудлыг шалгаж л тодорхой шалгалт хийж байж л энэ чинь тайлагнаж л ярих байх.

Д.Амарбаясгалан: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Тэмүүжин: АТГ-ын дарга улиран томилогдох гэж байх шиг байна. Тэгээд мэдээж хэрэг олон нийтийн дунд бол 2024 оны сонгуулийн дараа бол томоохон өөрчлөлтүүд гарна гэсэн хүлээлттэй байсан. Энэ өөрчлөлтүүдийн нэг хэсэг нь ч гэсэн ер нь тодорхой албан тушаалтнууд дээр ч гэсэн хөдөлгөөн гарах байх гэдэг хүлээлттэй байсан. Засгийн газраас Ерөнхий сайдаас үргэлжлүүлэн ажиллуулахаар оруулж ирж байх шиг байна. Мэдээж хэрэг хөшигний ард тодорхой эрх, институт, эрх мэдэл хуваарилалтын байгаа албан тушаалтнуудын статус кво эвдэгдэх вий гэдэг болгоомжлол ийм сонголт руу орж ирж байгааг үгүйсгэхгүй ээ.

Авлигалтай тэмцэнэ гэдэг өөрөө бас энэ ганц энэ байгууллагын ч ажил биш. Тэгээд өнөөдөр би Ерөнхий сайд байсан. Ерөнхий сайдад бүр хэлэх үг байсан юм. 2024 оны сонгуулиар системийн авлига Монгол Улсад гаарсан тухай Ерөнхий сайд нэг бус удаа хэлсэн. Үнэхээр энэ тогтолцооны авлига Монгол Улсад байгаа бол бид АТГ-ыг үсний машин шиг ашиглах зохимжгүй. Өнгөрсөн хугацаанд яг л үсний машин шиг ашиглаж байгаа. Авлига, ургадаг хөрс, авлига ургаж байгаа тэр толгойг нь өөрчлөх тухай биш ургасан үсэн дээр нь л машиндаа л суугаад байгаа. Албан тушаалтнууд ээлж даргаараа шорон руу яваад л ачигдаад л байгаа. АТГ-ын ажлын

үзүүлэлтийн нэг болж харагдаад өнөөдөр маш олон гишүүд магтан дуулж байх шиг байна. Хэн ч очсон авлигач болдог, хулгай хийж, авлига авч чаддаг энэ тогтолцоог өөрчлөхгүйгээр ямар ч сайн дарга тэнд очоод энэ байгууллагыг хэчнээн олон төсөв мөнгөөр тордоод нэмэр байхгүй.

Үнэхээр тогтолцооны авлигатай тэмцье гэж бодож байгаа бол зоригтой том өөрчлөлтүүд хийх хэрэгтэй. Авлигаас ангижрах ерөөсөө хоёрхон л арга байгаа шүү дээ.

Нэгдүгээрт төвлөрсөн эрх мэдлийг задал. Засгийн газар дотор байгаа байгууллагын даргад овоорчихсон байгаа. Нэг байгууллага дээр очоод бараг хувьчлагдаад авагдчихсан юм шиг. Энэ чиг үүргийг нь минийх гээд хувьдаа бодчихсон байгаа. Тэр эрх мэдлийг задлах ёстой шүү дээ. Оновчлох ёстой шүү дээ. Энэ ажлаа Засгийн газар хийхгүй байна, хүлээгээд байдаг. Харагдахгүй байна.

Хоёрт нь эрх мэдлийг задалж байгаа бол харилцан хяналтад оруулах ёстой шүү дээ. Харилцан хяналтад орох тогтолцоо чинь ерөөсөө ажиллахгүй байна. Хууль тогтоох гүйцэтгэх шүүхийнхээ хэмжээнд ч ажиллахгүй байна. Засгийн газрын дотоодод байгаа агентлагуудын дундаж ажиллахгүй байна.

Би бол Амарбаясгалан даргад зориулж үг хэлмээр байна. Парламент үнэхээр энэ тогтолцооны авлигатай зоригтой тэмцье гэж байгаа бол импич хийдэг эрх мэдлээ авах ёстой. Албан тушаалтнуудын статус квогоор томилогдож болно. Ард нь асуудал үүсвэл парламент томилсон хүнээ буцаагаад хариуцлага тооцдог огцруулдаг эрх мэдэлтэйгээ болох ёстой шүү. Энэ Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг хүмүүс чинь огт хариуцдаггүй юм шиг хариуцлагагүй ажиллаж байна шүү. Импичменийхээ энэ механизмыг бид эхлүүлье ээ. Тэгэхгүй бол сонгогдсон авторитаризм Монголд ажиллаад эхэллээ. Сонгуулийн үр дүнгээр юу ч өөрчлөгддөггүй. Ядаж 126 гишүүнтэй Улсын Их Хурал энэ өөрчлөлтийг хийж эхэлье.

Дараа нь оновчлох АТГ-ын эрх мэдлийг ч оновчилмоор байна. Парламентын хяналтыг ч оновчилмоор байна, Засгийн газрын дотоод бүтцийг ч оновчилмоор байна. Оновчгүй бүх юмны чинь ард.

Д.Амарбаясгалан: Тэмүүжин гишүүн үг хэллээ.

Тэгээд энэ авлигатай тэмцэх үйл ажиллагаанд Их Хурал онцгойлон манлайлж ажиллана гэдэг ийм зорилгыг тавиад байгаа. Өнгөрсөн оны 11 дүгээр сард АТГ дээр Улсын Их Хурлын дарга, Байнгын хороодын дарга, гишүүдийн хамт очиж ажилласан. Тэгээд бид яг авлигатай тэмцэх суурь нөхцөлийг нь бүрэн хангалттай бий болгож өгөхийн тулд хууль эрх зүйн орчиндоо томоохон шинэчлэл хийх шаардлага байна гэж үзээд байгаа юм. Яг саяын Тэмүүжин гишүүний хэлж байгаа үнэн л дээ.

Авлига авах нөхцөл нь байгаад байгаа үед хэн ч очсон л өртөж байгаа. Тэгэхээр тэр нөхцөлийг арилгахын тулд бид хуульд томоохон өөрчлөлт хийх ёстой л гэж үзэж ажиллаад байна. Өнөөдөр Монгол Улсад хэрэгжиж байгаа хууль, хууль дагаж гарсан журам гэдэг нэг 2 том ойлголт байгаад байдаг. 900-аад хуультай, 3 мянга гаран журамтай. Нэг ёсондоо хууль дээдлэх зарчим доор бид ажиллаж амьдрах ёстой байтал. Өнөөдөр журам дээдлэх зарчим дээр бид оччихсон байна л

гэж үзэж байгаа юм. Сүүлийн 14 жилийн хугацаанд журам тоо нь 4 дахин нэмэгдсэн энэ үзүүлэлттэй явж байна.

Тэгэхээр эндээс эхлээд бид энэ нөхцөлийг арилгах хуулиас давсан журмаар үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын үйл ажиллагааг таслан цогцлоох Хууль зүйн яаманд бүртгэлгүй байгаа олон 100 журмыг хүчингүй болгох гээд энэ олон ажлыг Их Хурлын түвшинд бид зайлшгүй хийх шаардлагатай. Өнөөдөр бид энэ Хууль тогтоомжийн хуулиар энэ асуудлыг цэгцлэх эхний алхмаа хийж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр гишүүд идэвхтэй оролцож асуудлыг нэг талд нь ойлгож дэмжиж ажиллах нь зүйтэй юм гэж ингэж үзэж байгаа.

Батын Батбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Алга байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн сайд алга байна. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууж, үг хэлье ээ.

Б.Жаргалан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе 2024 онд Бүгд найрамдахчуудын хүрээлэнгээс гаргасан олон нийтийн санал бодлын судалгаанд Монгол Улсад хамгийн тулгамдсан асуудал юу вэ гэдэг дээр нийт оролцогчдын 31 хувь нь үнийн өсөлт гэж хариулсан байна, 30 хувь нь ажилгүйдэл гэж хариулсан байна. Тэгээд 26 хувь нь авлига гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл бид нарын бусад яриад байгаа энэ зам, замын түгжрэл Улаанбаатар хотын утаа гэх мэтчилэн энэ хүмүүсийн амьдралын чанарт нөлөөлж байгаа зүйлүүдээс илүү ихээр энэ авлигын асуудалд иргэд санаа зовж байна аа. Тэгээд өнгөрсөн 30 жил 30 гаруй жилийн хугацаанд бол энэ авлига гэдэг бол Монгол Улсын хөгжлийг хойш нь татсан эдийн засгийн өсөлтийг сааруулсан Монголчуудын бүтээмжийг бууруулсан ийм чөдөр тушаа болчихоод байна тэгээд өнгөрсөн хугацаанд бид нар энэ дээр ерөөсөө хангалттай ахиц дэвшил гаргаж чадсангүй ээ. Тэгээд ийм авлига өндөр байгаад байгаа учраас энэ нийгэм тэр аяараа авлигад идэгдчихсэн байгаад байгаа учраас залуучуудын мөрөөдөл үгүй болж байна аа.

Монгол Улсад шударгаар хөдөлмөр эрхлээд, аж ахуй эрхлээд, бизнес эрхлээд амжилтад орж амжилтад хүрч чадахгүй байна гэсэн тийм итгэл үнэмшилтэй болчихлоо. Тэгээд хүмүүс мөрөөдөлгүй болж байгаа учраас гадагшаа гарахыг илүүд үзэж байна аа. Тэгээд төрд л орохгүй бол ямар ч боломж бололцоо байдаггүй, ашиг орлого нь нэмэгддэггүй. Ерөөсөө хувийн хэвшлийн орон зай энэ улсад байхгүй болчихсон ийм нөхцөлд та бид нар ажиллаж байгаа шүү дээ. Тэгээд энэ 126 гишүүнтэй шинэ парламент бүрэлдсэний хамгийн чухал анхаарвал зохилтой асуудал энэ хуулийн засаглалыг бэхжүүлэх, шударга ёсыг тогтоох, энэ нийгэмд энэ авлига гэдэг асуудлыг бүрмөсөн алга болгох ийм л зорилт хэдүүлээ дэвшүүлж ажилламаар байна аа.

Тэгээд өнөөдөр энэ гишүүдийн хэлж байгаа үгүүдийг нэлээн сонслоо. Тэгээд бас нэг зарим талаар урам хугарч байна шүү нөхөд өө. Энэ төсөөллийн индекс бол төсөөллийнх л байдаг юм аа. Авлигатай сайн тэмцээд байгаа учраас төсөөлөл нь нэмэгдээд байгаа юм ч гэж байх шиг. Тэгээд авлигатай тэмцэх ажил бол зөвхөн АТГ-ын ажил биш бид бүгдийн ажил ч гэж байх шиг. Тэгээд маш сайн туршлага хуримтлуулсан баг бүрэлдэхүүн байгаа энээ тэрээ гээд л янз бүрийн л юм яриад байх юм. Гэхдээ хамгийн гол нь бид нарт ер нь энэ Улсын Их Хуралд ч тэр, Засгийн газар ч тэр, энэ АТГ-т ч тэр энэ авлигыг устгаж чадна гэсэн итгэл үнэмшил байгаа эсэхэд бол ерөөсөө эргэлзээ төрж байна.

Тэгэхээр үнэхээр яг бид нар ийм итгэл үнэмшлээ дор бүрнээ өөрсдөдөө нэг юм бий болгож байж тэгж байж ингээд энэ нийгэмд эерэг өөрчлөлт гаргах юм аа. Тэгэхээр яг тэр чиглэл рүү ажиллаж чадна гэж манай нэр дэвшигч итгэл төгс хэлж чадах уу гэдгийг танаас асуумаар байна аа? Яагаад вэ гэхлээр бид нар зүгээр нэг ийм юу гэдэг юм өдөр тутмын ажлаа аргацаасан байдлаар энэ асуудалд хандмааргүй байна аа. Бүр яг ингээд тогтолцооны шинж чанартай өөрчлөлтүүдийг хиймээр байна. Тэгээд хэдий богино ч гэсэндээ үлдэж байгаа энэ парламентын бүрэн эрхийн 3 жилийн хугацаанд бол энэ авлигатай тэмцэх чиглэлээр бид нар бүүр маш дорвитой өөрчлөлт гаргачхаад тэгээд дараа нь иргэддээ очоод тайлагнамаар байна аа.

Яагаад гэхээр бид ард иргэдийн төлөөлөл болоод энд сууж байгаа. Тэгээд яг энэ чиглэлээр бид нар бол нэг тайлагнах ийм үүрэгтэй. Бид нар тийм мандатыг авсан хүмүүс байж байгаа. Тэгэхээр яг та одоо үнэхээр энэ Их Хуралтай энэ Засгийн газартай хамтарч ажиллаад энэ авлигыг бүр мөсөн үгүй хийх чиглэлээр ямар дорвитой ажил хэрэгжүүлэх вэ гэдэг дээр гол нь тэр итгэл үнэмшил байгаа эсэх дээр л танаас хариулт авмаар байна аа? Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дашдаваа дарга хариулт өгье.

3.Дашдаваа: Жаргалан гишүүний асуултад хариулъя аа. Ер нь Монгол Улсад анх ер нь 2000 оноос эхэлж авлига гэдэг асуудлыг ер нь ярьж эхэлсэн юм байна лээ. Тэгээд 2004 онд Монгол Улс НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод нэгдэн ороод тэгээд 2004-2006 оны хооронд энэ авлигатай тэмцэх байгууллага гэдгийг яаж байгуулах вэ, хаанаас олж, аль загвараар явах вэ гэдэг судалгаануудыг хийгээд тэгээд 2006 онд энэ Хонгконгийн авлигатай тэмцэх байгууллагын загвараар АТГ-ыг байгуулсан юм билээ. Ингээд 2006 онд байгуулагдаад АТГ 2007 оноос хойш үйл ажиллагаагаа явуулаад ингээд энэ жил 18, 19 дэх жилдээ орж байна. Энэ байгууллагыг би 6 жилд удирдаж ажиллаж байна. Энэ хугацаанд авлигатай тэмцэх байгууллага бол олон бэрхшээл янз бүрийн асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд ч гэсэн эрх хэмжээг нь хумих ажлууд хийгдэж байсан. Зарим тохиолдолд ч энэ төсөв хөрөнгө нь танайх эд нар гээд тухайн тухайн улс төрийнхөө юутай тохиролцохгүй ийм асуудлууд үүсэж ажиллаж байсан юм байна лээ. Би бол аваад зургаа дахь жилдээ ажиллаж байна.

Ирэх 6 жил юуг төлөвлөж байгаа вэ гэвэл 1 дүгээрт энэ тогтолцооны өөрчлөлтийг хийе ээ. Зөвхөн хүнтэйгээ тэмцээд авлига аваад байгаа албан тушаалтнуудаа илрүүлээд цааш нь хийгээд байхаасаа илүү энэ тэнд суудал дээр очоод байгаа, очоод ингээд хэрэгт өөрөө одоо мэдсэн бараг зарим нь мэдээгүй ороод байгаа шүү дээ. Энэ чинь өнөөдөр Монгол Улсад хөгжиж байгаа орон. Тийм учраас бүтээн байгуулалт төрийн, нийгмийн салбарын чиглэлийн бүтээн байгуулалт маш ихээр явагддаг тойроод зөндөө тендерүүд явагддаг. ТӨК-удыг нь тойроод хувийн хэвшлийн тендерүүд бүгд явагддаг. Тэгээд энэ бүхнээс бодоод энэ Зөвшөөрлийн хуулиуд, Тендерийн хуулиуд эд нарыг боловсронгуй болгох чиглэлээр энэ тогтолцооныхоо энэ хууль эрх зүйн чиглэлд энэ Засгийн газар Улсын Их Хуралтайгаа ингээд санал санаачилга солилцоод ингээд хамтран ажиллаад явна гэсэн ийм ийм л бодолтой байна даа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: 2 гишүүний дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирье. Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууж, үг хэлнэ ээ.

Б.Мөнхсоёл: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр өчигдөр бас нөгөө намын бүлгүүд, ХҮН намын зөвлөлөөр энэ асуудал орсон учраас товчхон хэлье гэж бодож байна. 1 дүгээрт авлига нь өөрөө зөвхөн юу гэдэг юм нэг хэсэг улс төрчид ч юм уу тухайн асуудалд холбогдсон хүмүүст хамаатай асуудал биш. Тухайн улсад авлига их тусмаа эдийн засгийн өсөлт муу буюу өөрөөр хэл хэлэх юм бол хүний хөгжлийн индекстэй маш их ийм урвуу хамааралтай, нийгэмд тэр даяар нь маш өргөн хэмжээний сөрөг үр дагавар үзүүлдэг ийм том асуудал аа.

Тэгэхээр ийм чухал асуудал дээр 126 гишүүн бид хүн бүр маш анхааралтай хандаж оролцох ёстой гэж үзэж байгаа юм аа. Тэгэхээр авлигын талаарх олон улсын маш олон индексүүд байдаг. Одоо өнөөдөр бид нар ч гэсэн авлигын төсөөллийн индексийн талаар ярилцаад байна. Яагаад энэ индекс чухал вэ гэхээр энэ нь өөрөө 13 төрлийн тайлангийн үр дүн дээр гарч ирдэг. Энэ дотор улс төрчдөд итгэх итгэлийн асуудал хүртэл ордог. Төсвийн зарцуулалтын асуудал хүртэл ордог. Тухайн бодлого боловсруулж байгаа хууль эрх зүйн орчинд шийд тэр гаргаж байгаа байдал процесс нь ил тод байж чадаж байна уу, иргэдийн оролцоо байна уу гэдгийг ч хардаг гээд. Энэ 13 тайлан, тэрэн дотроо маш олон үзүүлэлтүүд энэ индекст ордог юм аа. Тэгээд энэ индексийг манай Авлигатай тэв тэмцэх газар харж бусдад энэ авлигын талаарх төсөөлөл болон нөхцөл байдлын талаар мэдээлэл өгч байгаа бол индексээ сайн судлаад иргэдэд болон энэ улс төрчдөд ч гэсэн маш сайн мэдээлэл мэдлэг өгөх хэрэгтэй гэж 1 дүгээрт үзэж байгаа. Яагаад гэвэл АТГ-ын нэг үүрэг нь урьдчилан сэргийлэх байхгүй юу. Урьдчилан сэргийлэх буюу авлигаас зайлсхийх. Авлига гэж юу юм олон улсын түвшинд тэр олон улсуудыг яагаад жагсаагаад зэрэглээд байгаа юм, дотор нь ямар үзүүлэлт байгааг хараасай ойлгоосой гэж 1 дүгээрт хүсэж байгаа юм аа.

Хоёрдугаарт энэ авлига нь эдийн засаг болон бизнесийн орчинд маш их сөрөг нөлөөтэйгөөс гадна энэ өмнөх гишүүд Жаргалан гишүүнтэй санал нийлж байна. Залуучуудыгаа бид нар гадагшаа алдаад байна аа. Залуучуудад ажлын байр угаас жижиг зах зээлтэй ховор. Дээр нь нэмээд улс төрийн нам улс төрчдийг дагахгүй бол ажлын байргүй. Ер нь ирээдүй дээ итгэх итгэлгүй болгоод байна. Угаасаа бид нар мэдэж байгаа энэ их улс төржилттэй энэ нийгэмд төрд ажиллах чадамжтай хүмүүс маш их ховордсон. Хүний нөөцийн асуудал зөвхөн бизнесийн секторт биш төрд байна. Сайн чадамжтай хүмүүсээ бид нар ажилд авч чадахгүй байна. Зөвхөн цалингийн асуудал биш нэр хүндийн асуудал эрсдэлийн асуудлууд байгаа шүү. Энэ учраас бид нар залуучуудаа гадагшаа алдаад байна аа.

Гуравдугаарт бас нэг тоо баримт дурдахад Дэлхийн банк энэ чиглэлээр судалгаанууд хийдэг. 2030 он гэхэд бид нар ядууралтай тэмцэнэ гээд дэлхий даяараа 160 хэдэн улс нийлээд гарын үсгээ зурчихсан ийм тунхаглал байна. Гэтэл 2030 онд дуусгах тэр ядуурлыг байхгүй болгоход хамгийн сөрөг нөлөөлж байгаа нь энэ авлига өөрөө байна аа. Олон улсын түвшинд дотоодын нийт улсуудын нийт ДНБ-ний 2 хувь нь авлигад явж байна гэж ийм тооцоо гаргасан. Энэ бодит байдал дээр энэ тооцоо 2 хувь чинь бүүр үүнээс өндөр дүнтэй байх магадлалтай гэдэг ийм тооцоолол судалгаа гарчихсан байгаа юм аа. Монгол Улсын хувьд болохоор Азийн сан гэх мэт байгууллагууд бизнес дэх авлига, ер нь бизнесийн орчинд сөрөг нөлөөлж байгаа энэ авлигыг судалсан тоонууд маш их байдаг.

Тэгэхээр энэ санал хураах гээд гишүүд ороод ирснийг далимдуулаад уриалахад 126 гишүүн бид энэ анхны 126 гээд маш их ярьж байгаа. Энэ 126-гийн

түүхэнд үлдэх гол гавьяа нь энэ авлигатай тэмцэж чадвал энэ гол гавьяа бахархал болж үлдэнэ шүү гэдгийг бас.

Д.Амарбаясгалан: Мөнхсоёл гишүүн үг хэллээ. Энхбатын Болормаа гишүүн асуулт асууж үг хэлье.

А.Болормаа: Ингээд өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайд АТГ-ын даргыг улираан томилох асуудлыг оруулж ирж байна. Гишүүдийн асууж байгаа асуулт болон хэлж байгаа үгнээс анзаарч харахад АТГ-ын үйл ажиллагаанд сэтгэл ханамж өндөр гэхээсээ илүүтэйгээр Ерөнхий сайдын авлигатай тэмцэх хийж байгаа үйл ажиллагааг дэмжиж энэ томилгооны асуудлыг онцгойлон дэмжиж байна гэж харж байна. Миний хувьд асуух асуулт онцгойлон яг хөдөө орон нутагтаа улсын хэмжээний томоохон авлигын хэргүүдийг сая нэлээн олон талаас нь ярилаа. Тэгвэл хөдөө орон нутагт дунд шатад явагдаж байгаа энэ авлига мөн түүнтэй уялдсан хүнд сурталтай асуудалтай хэрхэн тэмцэж байгаа вэ? Би яг Засаг даргаар 2 жил ажиллахад бараг л АТГ-ын ажилтан шиг ер нь бол хөдөө орон нутагт ажилласан. Тэр хугацаанд ямар АТГ-ын ажилтан нь өөрөө бараг авлига хээл хахууль авч байгаа ийм хэмжээний гомдол сонсдог. Би аливаа нэг хүний асуудал ярих гэсэндээ биш. Гэтэл энэ эргээд хөдөө орон нутаг ямар жижигхэн газар билээ нөгөө яриад байгаа авлигын төсөөлөл юм уу энэ нийгэмд байгаа авлигал багасаж байна, буурч байна гэдэг ойлголтыг төрүүлэхийн эсрэгээрээ өө АТГ нь өөрөө ийм байна шүү дээ гэдэг ийм мэдрэмжийг төрүүлдэг. Энэ гомдлыг ч би гаргаж байсан.

Одоо миний ажиллаж байсан Ховд аймгийн хөрш зэргэлдээ жишээлбэл Говь-Алтай аймаг байна. Мөн олон төрийн албан хаагчид гомдол гаргаж байсан. Тантай шууд танил найз нөхдийн ч гэсэн асуудлыг ярьж ингэж гомдол гаргадаг тэр аймагт бол АТГ-ын үйл ажиллагаа ингээд Улаанбаатар хотод ингээд дарга танилаар юмаа шийдчихдэг юм уу гэдэг ийм хэмжээний би олон иргэд болон төрийн албан хаагчдаас энэ асуудлыг гомдол сонсож байсан. Би зөвхөн 2 аймгийн л жишээ өөрийнх юм мэдэхийг ярьж байгаа юм шүү.

Тэгэхээр бусад 21 аймагт энэ орон нутгийн түвшинд зөвхөн Улаанбаатар хотод энэ авлигын асуудал байх биш шүү дээ. Орон нутгийн түвшинд хэрхэн энэ авлигатай тэмцэх ажлын үйл ажиллагаа өрнөж байна вэ? Цаашдаа та бүхэн энэ хүний нөөцөө сэлгэх асуудлыг яагаад хийхгүй байна. Уул нь хуульдаа нэг албан тушаалдаа хэр удах гэдгээс авхуулаад зүйлсүүд байдаг. Гэтэл хөдөө орон нутагт байгаа чадвартай боловсон хүчнээ явуулж чадаж байна уу, сэлгэж чадаж байна уу гэдэг энэ асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Дашдаваа дарга хариулт өгье.

3.Дашдаваа: Болормаа гишүүний асуултад хариулъя. Манай авлигатай тэмцэх байгууллага орон нутгийн мэдээллийг бол 110 хуудсаараа дамжуулж бол хөрөнгө орлого болон хяналт шалгалтын чиглэлийн үйл ажиллагааг гомдол гаргаад эндээс бол томилолтоор хүмүүс ажиллуулж ингэж шийдвэрлэдэг байгаа. Эрүүгийн хэрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр бол Ховд, Увс, Баян-Өлгийг хариуцсан албан тушаалтан ажилладаг. Өнөөдөр Ховд аймагт бол өнгөрсөн онд 34 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Энэ мөрдөн байцаагчийн энэ таны ярьж байгаагаар ур чадвар удаан ажилласан зэргээс шалтгаалаад аливаа асуудлыг удаашруулсан байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ бид бол ер нь нэг 2 жилээс илүүгээр томилолтоор ер нь

ажиллуулахгүй байгаа ер нь сэлгээд л явдаг. Тийм учраас бол энэ таны хэлж байгаа санал дээр анхааръя.

Говь-Алтай аймагт бол өнгөрсөн жил 29 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан байна. Говь-Алтай аймгийг мөрдөн байцаагч Говь-Алтай, Завхан, Баянхонгор гэсэн чиглэлээр ингээд ажилладаг юм. 3 аймаг хариуцан ажилладаг юм. Цаашдаа би таны хэлсэн дээр анхааръя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

Танхимд 80 гаруй гишүүд байна уу. Ирцэд бүртгэлтэй 112 гишүүн байгаа. Байнгын хорооны саналаар “АТГ-ын даргыг улируулан томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт,

83 гишүүн дэмжиж, 74.1 хувиар санал дэмжигдлээ.

Дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх гишүүд Мэндбаярын Мандхай, Батжаргал гишүүн, Дэлгэрсайхан, Ганхүлэг, Мөнхтуяа, Бямбасүрэн гэсэн 6 гишүүн дэмжсэнээр протоколд нэмж тэмдэглүүлье. Тэгэхээр 89 гишүүн саналыг дэмжсэн байна.

Ингээд тогтоолын төсөл батлагдлаа. Байж байгаарай Туваан, Алтангэрэл гэсэн гишүүд дэмжсэнээр санал өглөө.

Би тогтоолын төслийг Ерөнхий сайд дэмжсэнээр санал өгсөнд тооцъё. ингээд 92 гишүүн дэмжсэн байна тогтоолыг. Номин гишүүн. Хоцорч орж ирчхээд та хэд маань ингээд дэг зөрчөөд байх юм тиймээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол, АТГ-ын даргыг улируулан томилох тухай, Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.АТГ-ын даргаар Зандраагийн Дашдавааг улируулан томилсугай.

2.Энэ тогтоолыг 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн тогтоолын төслийг уншиж танилцууллаа.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дашдаваа даргад ажлын амжилт хүсье. Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд АТГ-ын даргыг улируулан томилж байгаатай холбогдуулан олон саналыг

илэрхийллээ. Тэгээд гишүүдийн хэлсэн саналыг та бүхэн бодож ажилдаа ажил хэрэг болгож хэрэгжүүлж ажиллах ийм шаардлагатай гэж үзэж байна.

Ерөнхийдөө гишүүдийн зүгээс авлигатай тэмцэх үйл ажиллагааг ул суурьтайгаар хэрэгжүүлэх, ёстой, үүнийг нь Улсын Их Хурал дэмжиж ажиллах шаардлагатай гэдэг байдлаар бол асуудлыг бол өргөн хүрээгээр хэллээ. Тэгэхээр одоо энэ ажлыг хэрэгжүүлэхийн үүднээс АТГ өөрийн бүтэц бүрэлдэхүүн ажиллах нөхцөлтэй холбоотой асуудлуудыг Улсын Их Хуралд танилцуулж ажиллаж байх ийм шаардлага бол байгаа гэж ингэж харж байна. Гантөмөр дарга аа АТГ-ын даргад хандаж үг хэлж байна. Тэгэхээр нөхцөл байдлаа сайжруулж бүтэц бүрэлдэхүүнтэй холбоотой асуудлуудыг тодорхой төсөл хэрэгжүүлэх зорилгоор магадгүй шаардлагатай үед нь нэмдэг бусад үед нь багасгадаг хэлбэрээр ч ажиллах нөхцөлүүд байх боломжтой гэж үзэж байгаа. Нөгөө талаасаа авлигатай тэмцэх хуулийн дагуу АТГ-ын зүгээс хуулиудад болон энэ хуулиас давсан журмуудтай холбоотой асуудлаар өөрсдөө санал боловсруулж хүчингүй болгуулах авлига үүсгэх нөхцөлийг бий болгож байгаа төрийн шийдвэрүүдийг хүчингүй болгуулах саналуудыг эрчимтэйгээр оруулж ирж Улсын Их Хурлаар шийдвэрлүүлж ажиллах ийм үүрэг, чиглэлийг танд өгье.

Улсын Их Хурлын Тамгын газар, АТГ, Хүний эрхийн Комисс хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа. Энэ ажлыг бас өшөө илүү эрчимжүүлж бодитой ажил хэрэг болгох тал дээр анхаарч ажиллахыг танд хүсэж байна.

Ингээд Улсын Их Хурлын зүгээс мэдээж өдөр тутамд АТГ-ын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах боломжгүй. Ажиллах нөхцөлийг чинь бүрэн дэмжиж ажиллах чиглэл дээр анхаарч ажиллана гэдгийг та бүхэнд хэлье ээ. Ажлын өндөр амжилтыг хүсье.

12.19 цагт

Дараагийн асуудалд оръё. **Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.**

ҮХЦ-ийн дүгнэлтийг ҮХЦ-ийн гишүүн Эрдэнээгийн Энхтуяа танилцуулна аа. Индэрт урьж байна.

Э.Энхтуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 2 дугаар дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

Монгол Улсын ҮХЦ-ийн дунд суудлын хуралдааныг ҮХЦ-ийн дарга Г.Баясгалан даргалж, ҮХЦ-ийн гишүүн Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Энхтуяа, Р.Батрагчаа нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан ҮХЦ-ийн хуралдааны танхимд нээлттэй хийлээ.

ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн О.Баясгалан болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нар оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Шүүхийн тухай хууль шинэчилсэн найруулгын 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30 түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 4, 5 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 51 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Далдугаар зүйлийн нэг дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

ҮХЦ-ийн 2025 оны 2 дугаар дүгнэлт нь нийт 20 нүүр түүний үндэслэх хэсэг нь дангаараа 11 нүүр болсон учраас та бүхэнд дүгнэлтийн үндэслэх хэсгийг товчилж, тогтоох хэсгийг бүхэлд нь уншиж сонсоё.

Үндэслэл Шүүх эрх мэдэл нь хүний эрх эрх чөлөөг хуулиар хамгаалсан хувийн болон нийтийн ашиг сонирхлыг аливаа хууль бус халдлагаас хамгаалах, хөндөгдсөн эрхийг сэргээх эрх хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд Үндсэн хуульд шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэхээр заасан. Шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдал бол шүүх эрх мэдлийг шударгаар хэрэгжүүлэх баталгаа болдог. Шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлын зарчим нь аливаа хүн, хуулийн этгээд, эрх, эрх чөлөө, хууль ёсны, ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд хандах шударгаар шүүлгэх үндсэн эрхийг хангах суурь нөхцөл юм.

Өөрөөр хэлбэл энэхүү зарчим нь эдлэх эрх ямба давуу байдлыг биш харин ардчилсан нийгмийн шударга ёсны тогтолцоо, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой бөгөөд Үндсэн хуульт ёс, Үндсэн хуулиар бэхжүүлсэн төрийн эрх мэдэлд хуваарилах, харилцан хяналт, тэнцэлтэй байх үзэл баримтлалын тулгуур юм аа.

Монгол Улсын Үндсэн хуульд хүн бүр эрх бүхий бие даасан тал үл харсан шүүхээр эрх тэгш байх үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх хэрэгтэй гэсэн суурь зарчмыг тусгаж зүй бус нөлөөллөөс хамгаалах баталгааг бий болгосон. Үндсэн хуулиар баталгаажсан шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлыг хангах хууль зүй, эдийн засаг, нийгэм болон бусад баталгааг төрөөс бүрдүүлэх үүрэгтэй. Энэ хүрээнд шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулсан, дордуулсан хууль тогтоомж, эрх зүйн бусад акт гаргахыг хориглоно.

Монгол Улс Үндсэн хуульдаа шүүгчийг хуулиар тогтоосон тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүртэл нь хугацаагүй томилох түүнчлэн бүрэн эрхээ хуулийн дагуу зохих ёсоор гүйцэтгэж байгаа бол огцруулахыг хориглох үзэл баримтлалыг тусгаж шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулсан.

Өөрөөр хэлбэл зөвхөн Үндсэн хуулиар хамгаалсан шүүгчийн хараат бус байдлын зарчимд нийцсэн үндэслэл журмаар шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгохоор заасан болно.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль энэ хууль бусад хуулиар баталгаажуулна гэж заасан бөгөөд уг зүйлийн 42.3.1 дэх заалтад Үндсэн хууль

болон энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хязгаарлах, түдгэлзүүлэх, дуусгавар болгохыг хориглосон бөгөөд 42.3.3 дахь заалтад шүүгч хугацаагүй томилогдож захиргааны болон гуравдагч этгээдийн санаачилгаар чөлөөлөгдөхгүй огцрохгүй гэж тусгажээ.

Мөн хуулийн шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох талаарх харилцааг зохицуулсан 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт шүүгч хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн эсвэл шүүгчээр 25 жил ажилласан бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдөж болно гэж заасан. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн маргаан бүхий зохицуулалтад 30 жил шүүгчээр ажилласнаар 60 нас хүрээгүй байсан ч шууд тэтгэвэрт гаргахаар хуульчилсан нь агуулгын хувьд шүүгчийг тодорхой хугацаагаар томилох буюу шүүгчийн бүрэн эрхийн хугацаа 30 жил байх утгыг илэрхийлж байна аа.

Ийнхүү шүүгчийг тодорхой хугацаагаар томилох агуулгыг ердийн хуульд тусгасан нь Үндсэн хуулиар баталгаажсан шүүгчийн хараат бус байдлын гол бүрдэл болох шүүгчийг тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүртэл нь хугацаагүй томилох зарчимд нийцээгүй байна аа.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 47.6 дахь хэсгийн маргаан бүхий зохицуулалт нь мөн хуулийн зарим хэсэг заалттай зөрчилдөж, хууль, хэрэглээний уялдаагүй байдал үүсгэж шүүгчийн эрх зүйн байдал, нийгэм, эдийн засгийн баталгааг дордуулах нөхцөлийг бүрдүүлж эрх зүйн тодорхой байдлыг бий болгосон байна аа.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийг шинэчлэн найруулж батлахдаа хууль тогтоогч, шүүхийн хараат бус шүүхийн бие даасан байдлыг хангах зорилт тавьсан гэж үзэж болно. Гэсэн хэдий ч дээрх хуулийн 47.6 дахь хэсгийн маргаан бүхий зохицуулалтад тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрээгүй байхад нь шууд тэтгэвэрт гарах нөхцөл шаардлагыг нийтлэг заалтаас өөрөөр тогтоож түүнчлэн шүүхийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг бус ажиллах жилийн дээд хязгаарыг тогтоосон агуулгатай байгаа нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн зорилт болон тус хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхойлсон агуулгад нийцээгүй байна аа.

Мөн ийнхүү хуульчилснаар 25-аас 29 насандаа томилогдсон шүүгч нарыг ажилласан жил шүүгчээр томилогдсон насаар нь ялгаварлан шууд тэтгэвэрт гаргаж бүрэн эрхийн хугацааг эрт дуусгавар болох хууль зүйн нөхцөлийг бүрдүүлж, ижил эрх зүйн байдалтай, адил чиг үүрэг хэрэгжүүлж байгаа шүүгч нарт зохих үндэслэлгүйгээр тэгш бус нөхцөлийг тогтоосон тохирсон байх зарчмын гол шалгуур болох хууль ёсны зорилгодоо хүрэхэд зайлшгүй тэнцвэртэй байх шалгуурт нийцэхгүй байна аа.

Энэ нь Үндсэн хуулиар баталгаажсан шударга, ёс, хууль дээдлэх, эрх тэгш байх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд нийцээгүй байна аа. Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт ҮХЦ-ийн шийдвэр буцаж үйлчлэх хүрээг тодорхойлсон байна.

ҮХЦ-ийн энэ дүгнэлт гарсан цагаасаа хойш үйлчлэх бөгөөд буцаж үйлчлэхгүй үр дагавартайг тэмдэглэж байна.

Монгол Улсын үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн нэг дэх заалт, ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон Монгол Улсын үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30 түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Шударга ёс хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 14 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна, мөн зүйлийн 2 дахь хэсэгт хүнийг насаар нь ялгаварлан гадуурхаж үл болно, 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт төрөөс нийгэм хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна, 51 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Үндсэн хууль, Шүүхийн тухай хуульд заасан үндэслэл шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах эсвэл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатын шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно. Далдугаар зүйлийн нэг дэх хэсэгт Үндсэн хуульд хууль бүрнээ нийцсэн байвал зохино гэснийг тус тус зөрчсөн байна.

2.Энэхүү дүгнэлтийн нэг дэх хэсэгт заасан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх заалтад хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхтэй, мөн зүйлийн 5 дахь заалтад өндөр наслах тохиолдолд тусламж авах эрхтэй гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

3.Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30 түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэж заасныг ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Г.Баясгалан, гишүүд Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Э.Энхтуяа, Р.Батрагчаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: ҮХЦ-ийн дүгнэлтийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан уншиж танилцуулна аа. Индэрт урьж байна.

Э.Бат-Амгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 2 дугаар дүгнэлтийг 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2025 оны 3 дугаар сарын 24, 4 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдааны үеэр Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяраас Байнгын хорооны гишүүд ҮХЦ-ийн дүгнэлтийн талаар асуулт асууж, хариул авсан болно.

ХЗБХ-ны хуралдаанаар ҮХЦ-ийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг Монгол Улсын Шүүхийн тухай хуульд заасан тэтгэврийн насны зохицуулалт нь Хөдөлмөрийн тухай хуультай нийцэж байгаа эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно, Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 3 дугаар сараас хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш уг хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх талаар нийт 10 гаруй маргаан үүсгэж тухай бүр Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажилласан бөгөөд тэдгээр бүх маргаан нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн Үндсэн хууль зөрчөөгүй гэдэг дүгнэлт гарч шүүхийн шинэтгэл тодорхой хугацаагаар амилах боломжийг бий болгож ирсэн талаар, Монгол Улсын Их Хурал тэр дундаа Хууль зүйн байнгын хороо шүүх эрх мэдлийг бэхжүүлэх, шүүгчийн нийгэм, эдийн засгийн баталгааг хангах, томилогдсон этгээдээс хараат бус байх, шүүгч, шүүгчдээсээ хараат бус байх шүүхийн дотоод ардчиллыг бэхжүүлэх зэрэг тодорхой шинэтгэлүүдийг үе шаттай хийж, хууль тогтоогчийн зүгээс бодитой хариуцлагатай дэмжлэгүүдийг хууль тогтоомж батлах замаар хэрэгжүүлж ирсэн бөгөөд цаашид мөн анхаарах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг шүүгчийн тэтгэвэрт гарах насыг тогтоохдоо шүүгчид сонголт байхаар зохицуулахаар зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Монгол Улсын Шүүхийн тухай хуульд шүүгчийн тэтгэврийн насыг тогтоох үндэслэлтэй холбогдох судалгаа шинжилгээнд суурилж тусгасан талаар, мөн өндөр насны тэтгэврээ тогтоолгосон туршлагатай шүүгч нар Шүүхийн дэргэдэх судалгааны академи болон арбитрын ажиллагаанд үргэлжлүүлэн ажиллах боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд Улсын Их Хурлын гишүүд аливаа асуудалд судалгаанд суурилсан баримтаар нотлогдсон зүйлийн талаар уг үзэл бодлоо илэрхийлж байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч холбогдох өөрчлөлтийг хийх нь зүйтэй талаар тус тус үг хэлсэн болно оо.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэрт тогтоолгоно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт шударга ёс хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 14 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байна. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт хүнийг насаар нь ангилан ялгаварлан гадуурхаж үл болно, 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт төрөөс нийгэм хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна, 51 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Үндсэн хууль Шүүхийн тухай хуульд заасан үндэслэл шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах эсвэл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно, 70 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Үндсэн хуульд хууль бүрнээ нийцсэн байвал зохино гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 2 дугаар дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Бат-Амгалан гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье өө. 3 гишүүнээр тасаллаа. Цэцийн дүгнэлт дээр чөлөөтэй. Дарааллаараа Сандагийн Бямбацогт сайд асуулт асууж, үг хэлнэ ээ.

С.Бямбацогт: ҮХЦ-ийн дунд суудлын хуралдааны дүгнэлт орж ирж байна аа. Тэгээд манай Улсын Их Хурлын гишүүд бас нэлээн анхааралтай хандаж баймаар байгаа юм. Түрүүн Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хязгаарласан Цэцийн дүгнэлтийг бид нар хүлээгээд авчихсан. Уул нь Их Хурлын гишүүдийн бүрэн эрх 4 жилийн хугацаатай, түрүүн цэцийн дүгнэлт хүлээж авсан нь бидний бүрэн эрх 3.6 жилийн хугацаатай болчихсон. Энэ удаагийн дүгнэлтийг би хүлээж авах нь зүйтэй юм байна гэж харж байгаа. Шүүгчийн настай шүүгчийн, бүрэн эрхтэй холбоотой асуудал. Шударга үнэнийг дэнсэлдэг. Хараат бус бие даасан үйл ажиллагаа явуулах ёстой. Шүүгч маань хараат бус байх бололцоо боломжийг нь бүрдүүлэх тал дээр энэ цэцийн дүгнэлт үүнтэй холбоотой байгаа. 2019 онд бид нар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Тэр үед үндсэндээ нийгмийн сэтгэл зүй ард иргэд бол энэ шүүх шударга биш болчихлоо шүүгч нар хараат болчихлоо. Ерөөсөө л дохио зангаагаар ажилладаг болчихлоо. Ийм үед шүүхэд итгэх итгэл алга, шударга ёс Монгол Улсад алга гэдэг байсан.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, цагдаа нь хүнээс хамааралтай, хяналт тавих прокурор нь хамааралтай, тэр шударга үнэнийг дэнслэх шүүгч нь хамааралтай ийм хонгил угсарчихсан байна. Энэ хонгилыг л нураая устгая гэж 2019 онд Үндсэн хуулийн өөрчлөлт хийсэн. Үүгээрээ шүүхийн бие даасан, хараат бус, эдийн засгийн хувьд улс төрийн хувьд, эрх зүйн хувьд хараат бус байхыг Үндсэн хуулиар бид хийсэн. Шүүгчийн бие даасан улс төрчтэй хамааралгүй байх энэ бүх бололцоо Үндсэн хуульдаа хийсэн. Энэ хүрээндээ 2021 онд энэ Шүүхийн тухай багц хуулийг баталсан. Олон сайн зүйлүүд хийсэн. Шүүхийн сахилгын хороо шинээр байгуулагдсан. Шүүгч нарын ёс зүй сахилга хууль зөрчиж байгаа асуудал энд шийдэгддэг болсон. Шүүхийг хэрхэн яаж сонгож, шалгаруулж, томилж ажиллуулах вэ Шүүхийн ерөнхий зөвлөл хараат бусаар ажиллах бололцоотой болсон. Дээд шүүх, давах шатны шүүх, анхан шатны шүүх хоорондоо хараат бус шүүгч нар дотроо бие биеэсээ хараат бус ажиллах бололцоо боломжийг бүрдүүлсэн.

Энэ дунд хийсэн нэг ажил бол энэ шүүгчийн настай холбоотой асуудал байгаад байгаа юм. Сая гарч байгаа тэр ажилласан жилээр нь ялгаварлаж байна. Насаар нь ялгаварлаж байна. 30 жил ажилласан хүнийг тэтгэвэртээ гар гэж шууд гаргадаг, 55 нас хүрсэн шүүгчийг шууд тэтгэвэрт нь хөөж гаргадаг ийм хуулийг бид нар хийчихсэн. Тэгэхээр давуу талтай олон зүйл байгаа. Энэ тал дотор бас нэг явсан нэг сул тал тийм үү алдаатай зүйл нь бол энэ шүүгчийг насаар нь ялгаварлаж байгаа, ажилласан жилээр нь ялгаварлаж байгаа байдал юм байна гэж би харж байгаа.

Энийг бас ҮХЦ-д олон удаа хандсан юм байна. Цэц дүгнэлтийг хүлээж аваад энэ бас зөв юм байна гэж оруулж ирж байна. Энийг би хүлээж авах нь зүйтэй гэж үзэж байгаа. Яагаад гэвэл тэр шүүгч олон жил ажилласнаараа мэдлэгтэй, чадвартай, туршлагатай байснаараа өнөөдөр ялгаварлагдах ёсгүй. Хараат бус ажиллах бие дааж шийдвэр гаргах бололцоо боломжийг нь шүүхийн тухай хуулиар бүгдийг нь бүрдүүлээд өгчихсөн. Үнэхээр шударга ёсыг тогтоож чадаж байгаа бол тэр бусад иргэдтэй адилхан Монгол Улсын Үндсэн хуульд заасан бусад Төрийн албаны хуульд заасан тэтгэвэрт гарах дээд насныхаа хэмжээ, хязгаартаа хүрэх ёстой. Үнэхээр 60 нас хүрээд өөрсдөө тэтгэвэртээ гаръя гэж байгаа бол гарах бололцоо нь нээлттэй байх ёстой. Ийм байдлаар энэ ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээж аваад холбогдох хуульдаа өөрчлөлт оруулаад явах нь зүйтэй гэж би бодож байгаа. Яг үүнтэй адилхан бусад хуулиудад төрийн албан хаагч нар төрийн тусгай албаныхныг тийм үү насаар нь ялгаварласан, хязгаарласан, ажилласан жил туршлагаар нь тийм үү мэдлэг чадвараар нь тийм ялгаварласан ийм заалтууд байдаг бид нар энийг давхард нь харж үзэх ёстой.

Миний одоо санаж байгаагаар Прокурорын тухай хуульд бид нар прокуроруудыг 60 нас гээд оруулчихсан санагдаж байна. Өөр иймэрхүү хуулиуд юу байна. Манай ХЗБХ энэ дээр судалгаа хийсэн байдаг болов уу? Мэдээлэл өгөөч? Хариулт авахыг хүсэж байна. Иймэрхүү дагалдаж бусад хуулиуддаа нэмэлт, өөрчлөлт оруулж энэ насаар нь ажилласан жилээр нь, туршлагаар нь, мэдлэг чадвараар нь ялгадаг байдлыг бид нар таслан зогсоож нэг цэгцлэх нь зөв байх аа.

Үг хэллээ. Цогтбаатар гишүүн хариулт өгье.

Д.Цогтбаатар: Яг Бямбацогт гишүүний асууж байгаа энэ асуулт аягүй чухал асуулт. Хэд хэдэн газар ийм зөрөөтэй. ҮХЦ Монголд мөрдөгдөх нэг зарчмыг батлаад өгч байна шүү дээ. Тэгээд энийг би дагуулаад юу ХЗБХ-ндөө яг энэ үүргийг өгсөн байгаа. Бусад ямар байгууллагууд дээр энэ зөрчил бид нарын мэдэж байгаагаар хэд хэд дээр байгаа юм. Тэгэхээр энийг жигдэлж оруулж ирж хууль жигд мөрдөгдөх ёстой. Түүнээс ялгаварласан байдалтайгаар өөр өөр төрийн нэг л тогтолцоонд өөр өөр байгууллагад өөр өөр журам үйлчлэх ёсгүй шүү гэсэн үүднээс би тийм чиглэл өгчихсөн байж байгаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өглөө. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

А.Ариунзаяа: ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргаж гомдол ирүүлсэн О.Баясгалан танд би талархлаа дэвшүүлэх гэсэн юм аа. Нэг салбар дээр энэ ялгаварлан гадуурхсантай нэгэн адилаар яг энэ тэтгэврийн нас болоод бусад нөхцөл дээр нь 10 салбар байгууллага дээр тусгайлсан нөхцөл явж байгаа. Тэгэхээр үүнийг бол нэг зарчмаар бусад байгууллагуудыг ч гэсэн цэгцлэх зүйтэй гэдгийг бол Цогтбаатар дарга сая хэллээ. Яахын аргагүй Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар зохицуулагдаж байгаагаас гадна салбар салбарын тухайн үеийн хүчтэй сайд нар, тухайн үеийн хүчтэй салбараа хамгаалж байгаа шийдвэр гаргагчид өөр өөртөө давуу байдал үүсгэж өөрчлөлтүүдийг хийсэн байдаг. Энэ бол эргээд төсвийн татаасаар зохицуулагдаж эргээд л татвар төлөгчдийн мөнгөөр дамжиж тухайн салбараас тэтгэвэрт гарч байгаа хүмүүст давуу байдлыг үүсгэж байгаа.

Ийм учраас үндсэн хуулийн дунд суудлын шийдвэрээр гаргасан Үндсэн хууль Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгштэй

байна гэдэг агуулгаар Нийгмийн даатгалын багц хуулийн энэ шинэчлэлийг оруулж ирэх гэж байгаа бол бусад салбарын дагасан салбарын хуулиудыг хүчингүй болгох шинээр бүгдэд хууль ижил тэгш үйлчилдэг байх тал дээр нь бол анхаарах нь зүйтэй. Өмнө гарсан байгаа хуулиуд дээр бид яагаад ч юм тухайн салбарыг ярихаас эмээгээд асуудал үүсчих вий, гал гарчих вий гэдэг байдлаар энийг ярихаас эмээдэг. Гэтэл цаана чинь салбарууд 55 байтугай, 45 насанд тэтгэвэрт гарч байна. Шимтгэл төлөх төлөхгүй асуудал байна. Ердийн хүмүүс цалингийн дунджийн 45 хувиар тогтоолгож байхад зарим салбар 80 хувиар тогтоолгогдож байна аа. Энэ бол шударга бус аа. Ийм учраас аливаа нийгмийн хамгаалал тухайн салбартаа байж болно. Тэгэхдээ үүнийг нийгмийн даатгалын салбарт биш өөр өөрсдийнхөө салбарынхаа тэтгэвэр тэтгэмжийнхээ тусгайлсан сангаараа гэдэг юм уу энэ бодлогуудаа явуулсан нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байна аа.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийг баталсан. Хөдөлмөрийн тухай хууль дээр ажилтан өөрөө л хүсэлт гаргаагүй бол ажил олгогч шахаж тэтгэвэрт нь гаргах боломжгүй болсон. Ингэснээрээ үүнийг бол бид нар анхаарах ёстой. 4 хүүхэд гаргасан эмэгтэйчүүд бол 50 настайдаа тэтгэврээ тогтоолгох эрх нь бол үүссэн байгаа. Монгол Улсын хүний амьдралын чанар дундаж наслалт ер нь нэмэгдэж байгаа, шүүгчдийн хувьд биднийг битгий хязгаарлаад бид нар ажилламаар байна гэдэгтэй нэгэн адил ажиллах хүсэлтэй байгаа хүмүүс маш олон байгаа. Гэвчиг яах вэ эрт тэтгэвэрт гарч байгаа хүмүүсийн дараагийн бас нэг хуулийн өөрчлөлтийг энд ярьсан нь зүйтэй болов уу гэж бодож байна дашрамд.

Тухайн байгууллага өмчийн хэлбэр үл хамаараад 50-аас дээш ажилтантай бол 2 хувьд нь тэтгэвэртээ гарсан ахмадыг заавал ажиллуулах хууль гарсан байгаа шүү, 50-аас дээш ажилтантай байгууллага бүр. Өмчийн хэлбэр үл хамаараад ахмадыг ажиллуулах үүргийг хүлээж байгаа. Ингээд тэтгэврээ нийгмийн даатгалын сангаас тэтгэврээ тогтоолгосон тэтгэвэр авч байгаа иргэнийг ажиллуулж байгаа бол тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлөхгүй байж болно.

Ажилтан 7.5 хувь, ажил олгогч 7.5 хувь шимтгэлийг төлөхгүй буюу ачаалал өндөр байгаа гэж ярьж байгаа энэ цаг үед нэг туршлагатай, мэдлэгтэй, тогтвор суурьшилтай, мэргэжлийн энэ хүмүүсийг ажиллуулах гарц гаргалгаа ААН байгууллагуудад байна шүү гэдгийг хэлье.

Иргэн Баясгаланд дахиад 10 сар байгаа юм байна гэдгийг анхаарч үзэж бид ч гэсэн энэ хуулиуд дээрээ анхаарч бүгд хуулийн өмнө эрх тэгш байх асуудлыг мөрдөхийг уриалж байна гэх юм уу хүсэж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Лхагвын Мөнхбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Л.Мөнхбаатар: Шүүхийн тухай хуулийн холбогдох зүйл заалт Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн дүгнэлтийг Цэц гаргасан байна. Энд бол ийм л зүйл байна л даа. Шүүгчийн настай холбоотой зүйл заалт байгаад байгаа.

Ер нь бол Төрийн албаны тухай хуульдаа төрийн алба хаших насны дээд хязгаарыг 65 гээд заачихсан байгаа. Шүүгчийн хувьд нэг онцлог байгаа юм. Үндсэн хууль болон холбогдох хуульд зааснаар бол шүүгч өөрөө 25 нас барс хүрч байж шүүгч болдог ийм зохицуулалттай. Дээд шүүхийн шүүгчээр ажиллахаар бүүр 10-аас доошгүй жил ажилласан байх ийм шаардлагыг тавьдаг ийм тусгай шаардлагатай. 35 нас хүрч байж шүүгч Дээд шүүхэд ажиллах ийм эрх нэмэгддэг ийм тусгай

шаардлагууд ингээд тавигддаг. Ингэхээр жирийн иргэн бол 21, 22-той ажиллаад явахад 25, ингээд зарим иргэн 30 наснаасаа ингээд шүүгчээр ажиллах ийм боломж нь нээгдэх нь байна шүү дээ. Энэ тусгай шаардлагуудад тавигдаад явдаг. Гэтэл одоо 30 жил ажилласан энэ 55 нас хүрсэн иргэнийг ингээд тэтгэвэр тогтоолгоно гээд ингээд хатуу заасан байгаад байгаа. Хамгийн гол нь гэтэл бусад хуулиудад яаж заасан бэ гэхээр Прокурорын хуульд 60 нас гэж заасан боловч өөрөө хүсвэл тэтгэвэр тогтоолгож болохоор заачихсан.

Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн хуульд бол мөн өөрөө хүсвэл тэтгэвэр тэтгэмжээ тогтоолгох боломжтойгоор энийг заачихсан байгаад байгаа юм. Өөрөө хүсвэл гэдэг ийм үгнүүд байгаад байгаа юм. ҮХЦ-д мөн 65 нас хүрсэн бол өөрөө хүсвэл өөрөө хүсвэл гэдэг үгнүүд заавал байгаад байгаа юм. Тогтоолгож болно гэдэг ийм заалттай. Гэтэл Шүүхийн тухай хуулийн энэ 47.6 дээр бол шүүгчээр 30 жил, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэрт тогтоолгоно гээд заачихсан. Тэгэхээр яг энэ заалтынхаа дагуу яг энэ насанд хүрчихсэн тохиолдолд 30 жил ажилласан тохиолдолд тэтгэвэрт шууд гарчхаж байгаа юм. Тэр өдрөө тэтгэвэрт гарч байна гэсэн үг. Тэгэхээр энэ өөрөө энэ Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчиж байна гэж байгаа юм. Энэ үндэслэлтэй байна. Тийм учраас энийг Үндсэн хуулийг зөрчиж байна гэж үзээд ҮХЦ-ийн шийдвэрийг хүлээж аваад холбогдох хуулиа засаад явах нь зүйтэй. Тийм ингэж үзэж байна. Ийм байр суурьтай байгаагаа хэлье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалтыг хойшлуулъя.

12.46 цагт

Дараагийн асуудалд оръё.

Хууль, тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн ХЗБХ-ны дарга Дамдины Цогтбаатар танилцуулна аа. Индэрт урьж байна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгон 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. 70 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Үндсэн хууль, хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэж, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.5 дахь зорилт дийг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шатад нэг хүний

эрхийг хангасан бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоо бэхжиж үр нөлөө дээшилнэ гэж тус тус заасан.

Үндсэн хуульд 2023 онд оруулсан өөрчлөлтийн дагуу 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан 126 гишүүнтэй парламент шинэ тутам бүрдэж улмаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэгт заасны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын Их Хурал 2024-өөс 2028 оны стратеги төлөвлөгөө батлаад байна аа.

Тус стратеги төлөвлөгөөний нэгдэх зорилтод хүн төвт хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санааг төгөлдөржүүлэхээр заасан бөгөөд хууль тогтоомж болон хууль тогтоомжийн төслийг боловсруулах, төлөвлөх, өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих тайлагнах, бүх үе шатад хүн төвт үзэл санаанд суурилсан хүний эрх, эрх чөлөөг хангаж хамгаалсан байх зарчим шаардлагыг тэргүүн эрэмбэд тавих зорилгыг дэвшүүлсэн. Тэгвэл энэхүү зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс суурь нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлан боловсруулах хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж буй Хууль, тогтоомжийн тухай хуульд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах явдал болно оо.

Иймд Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 72 дугаар захирамжаар Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ХЗБХ-ны дарга Цогтбаатараар ахлуулан нийт 16 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Улмаар Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар нарын 9 гишүүн санаачлан боловсруулсан Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна аа. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 6 зүйлтэй бөгөөд хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан тусгасан.

Үүнд:

1.Хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх хүрээнд хуулийн төслийн хүний эрхийн нийцлийг тодорхой аргачлалаар үнэлдэг болох, Хуулиар хүний эрхийг хязгаарлах нөхцөлд тавигдах шалгуурыг хуульчлах бөгөөд үүнд гагцхүү хуулиар хязгаарлах. Үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах, зорилгод нийцсэн байх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн байх, ялгаварлан гадуурхаагүй, жендерийн мэдрэмжтэй байх, тохирсон арга хэмжээ, хэлбэр ашигласан эсэхийг дүгнэж, энэ шаардлагыг хангаагүй тохиолдолд төслийг өргөн мэдүүлэхийн өмнөх шатад буцаах зохицуулалт тусгав.

Хууль тогтоомжийн хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг илүү өргөн хүрээнд буюу төсөв эдийн засагт үзүүлэх нөлөөлөл хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг тооцохоор тусгалаа. Улсын Их Хурлын гишүүний санаачлан боловсруулж буй хууль тогтоомжийн төсөлд

Улсын Их Хурлын Тамгын газар эс үгүй бол судалгаа шинжилгээний байгууллага судлаач зардлын тооцоог хийхээр тусгав.

Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах тохиолдолд тухайн төсөл нь анх батлагдсан хууль болон дагалдаж буй хуулийн төслийнхөө үзэл баримтлал агуулгад нийцсэн байх шаардлагыг төсөлд тусгалаа.

Хууль тогтоох онцгой бүрэн эрхийг Улсын Их Хуралд хадгалах хүрээнд түүний хязгаарласан аливаа зохицуулалтыг засаж залруулахаас гадна захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх олгосон хуулийн төслийн зохицуулалтад тавих шаардлагыг өндөрсгөж зөвхөн хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авах зорилгоор хуулиар тусгайлан эрх олгосон тохиолдолд гаргадаг байхаар хязгаарлахаар тусгав.

2.Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах хүрээнд холбогдох төрийн байгууллага, иргэд, олон нийтээс хууль төсөлд өгсөн саналыг товъёг тухайн саналыг хуулийн төсөлд тусгасан эс тусгасан талаарх нэг бүрчилсэн тайлбар, үндэслэлийг хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад тусгадаг байх шаардлагыг тусгалаа.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, legalinfo.mn цахим хуудсыг хууль тогтоомжийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэхэд төвлөрсөн цахим систем хэлбэрээр ашиглах хөгжүүлэхээр тусгав. Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх зохицуулалт бүхий хуулийн төсөлд Улсын Дээд шүүх, Улсын Ерөнхий прокурор, ХЭҮК-ын саналыг заавал авсан байхаар зохицууллаа.

Иргэд олон нийтээс ирүүлсэн саналыг төсөлд тусгасан, эс тусгасан талаарх тайлбарыг хууль тогтоомжийн төслийн танилцуулгад нэг бүрчлэн оруулдаг байх, уг шаардлага хангагдсан эсэхийг өргөн мэдүүлэхээр ирүүлсэн төслийн бүрдүүлбэрийг хянах хүрээнд нягтлан үздэг байх, шаардлага хангуулахаар буцаах зохицуулалтыг тусгав.

3.Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар болон Улсын Их Хуралд ажлаас шууд хариуцан тайлагнадаг холбогдох байгууллага хэрэгжүүлэхдээ Улсын Их Хурлын болон Улсын Их Хуралд ажлаас шууд хариуцан тайлагнадаг байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг зохицуулж буй хууль тогтоомжид хийдэг байхаар бусад хууль тогтоомжийн биелэлтийн үр дагавар үнэлгээг Засгийн газраар үүрэг болгосны дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр тусгав. 5 ба түүнээс дээш жил дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийг шинэчилсэн найруулга, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд биелэлтийн үр дагаврын үнэлгээг хийж хуульд заасны дагуу үнэлгээний үр дүнг хэлэлцүүлсэн байх шаардлагыг тусгав.

Ажлын хэсэг ажлын дэд хэсгээс Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шатад гадаад улс орнуудын хууль, тогтоомжийн харьцуулсан судалгаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэн МУИС-ийн Хууль зүйн сургууль Монголын хуульчдын холбоо, Хууль зүйн үндэсний зэрэг

байгууллагаар Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу гүйцэтгүүлсэн болно. Уг хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын DParliament.mn цахим хуудаст олон нийтэд нээлттэй байршуулж төслийн зүйл, хэсэг, заалт бүрээр саналаа гаргах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна аа.

Энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Та бүхнийг уг хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслүүдийн талаарх ХЗБХ-ны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүнээс 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг ХЗБХ 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч уг хуулийн төсөлд хууль Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан бөгөөд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээг судалгаа, шинжилгээний байгууллага, судлаачаар хараат бусаар гүйцэтгүүлэх, хуулийн төслийн хүний эрхийн нийцлийг тодорхой аргачлалаар үнэлэх, хуулиар хүний эрхийг хязгаарлах нөхцөлд тавигдах шалгуурыг хуульчлах. Үүнд гагцхүү хуулиар хязгаарлах үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгод нийцсэн байх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн ялгаварлан гадуурхаагүй, жендерийн мэдрэмжтэй тохирсон арга хэлбэр ашигласан эсэхийг дүгнэж энэ шаардлагыг хангаагүй тохиолдолд төслийг өргөн мэдүүлэхийн өмнө буцаах зэрэг зохицуулалтыг тусган боловсруулсан байна аа.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчим хэм хэмжээний агуулгад аливаа хууль тогтоомжийн төслүүдийг нийцүүлэх суурь нөхцөл сайжран Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх хууль зүйн баталгаа бэхжиж, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчил арилж, хэм хэмжээ тогтоосон захиргааны бусад хэм хэмжээний акт, дүрэм, журмыг батлах асуудал цэгцрэх, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах үйл ажиллагааны чанар, үр өгөөж нэмэгдэж, үг үсэг, утга найруулга, нэр, томьёоны алдаагүй төсөл

боловсруулах боломж бүрдэж хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний ач холбогдол нэмэгдэж, судалгаа, үнэлгээний үндсэн дээр шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл бүрдэнэ гэж хууль санаачлагч үзсэн байна аа. Хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад нийт 113 сая 849 мянга 208 төгрөгийн зардал үүсэх ба иргэн болон хуулийн этгээдэд шууд болон шууд бусаар үүрэг бий болгосон заалт тусгагдаагүй буюу зохицуулалтууд нь бүхэлдээ төрийн байгууллагын үүрэгт хамааралтай байх тул иргэн болон хуулийн этгээдэд зардал үүсэхгүй гэж үзжээ.

Хуулийн төслийг DParliament.mn цахим хуудаст байршуулж иргэд олон нийтийн санал авч байгаа болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хуулийн төсөлд захиргааны хэмжээний акт батлах эрх олгосон хуулийн төслийн зохицуулалтад тавигдах ёсгүй шаардлагуудыг тусгасан талаар, Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтад хамаарах хамаарах асуудлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөлд тусгасан эсэх талаар байр сууриа илэрхийлж үг хэллээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна гэж заасны дагуу санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжээгүй бөгөөд хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулан өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. ингээд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Дамдины Цогтбаатар нарын 9 гишүүн 1 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн. Тэгээд хэлэлцэх эсэх асуудал хэлэлцэгдэж байна.

Ажлын хэсгийг танилцуулъя. Тайванхүүгийн Алтангэрэл Улсын Их Хурлын даргын зөвлөх, Наранчулууны Отгончимэг Улсын Их Хурлын даргын зөвлөх,

Чулуунбаатарын Дондогмаа Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга, Ганхуягийн Агар-Эрдэнэ Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Нийт уг асуудлыг хэлэлцэх эсэхийг нь 150 минутын хугацаанд хэлэлцэхээр байгаа. 15 гишүүн асуулт асуухаар нэр ирүүлсэн байна. Нэр ингээд орсон байгаа.

13 цаг болсон учраас үдээс өмнөх чуулганы хуралдааныг өндөрлүүлье.

14 цагаас хурал үргэлжилнэ.

ЗАВСАРЛАГА

Д.Амарбаясгалан: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаа эхлүүлье. Ирсэн нэрсийн дарааллаар Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Баярлалаа. Хууль тогтоомжийн тухай хууль уг нь их чухал хууль байгаа юм аа. Мэдээж энэ асуудал дээр бас сайжруулж боловсронгуй болгох зүйлүүд байгаа боловч өнөөдрийн өргөн барьсан энэ төслийг дэмжих боломжгүй байна. Учир нь энэ Хууль тогтоомжийн тухай хуульд тусгагдах бус илүү захиргааны ерөнхий хуульд тусгагдах асуудлууд ийшээ орж ирсэн байгаа. Энэ нь ч цаашдаа эрх зүйн гажуудал үүсэх нэлээн томоохон суурь, үр дагавартай зүйлүүд орж ирсэн байна аа. Би энийг гишүүдийг анхаараасай гэж хүсэж байгаа юм.

Жишээ нь одоо Хууль тогтоомжийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 1 дүгээр зүйл дээр байгаа 27.¹.2 дахь хэсгийг би уншиж өгье бүтнээр нь. Захиргааны хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтад дараах асуудлыг тусгахгүй.

Энэ бүр ингээд хатуу хуульчилж байгаа. Тусгахгүй гээд. Тусгахгүй байж болно гэж хэлээгүй, тусгахгүй гээд. Энэ дээр юу хэлж байна гэхээр Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх чөлөөг хязгаарлах гэж байгаа юм. Яах вэ зүгээр хязгаарлах гэдэг үгийг бид нар тоо, хэмжээ, нас шалгуур тавьж хязгаарлах асуудлууд яригдана аа. Тэгэхдээ энэний цаана маш олон үр дагаврууд гарна.

Жишээ нь одоо Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу иргэд эрүүл мэндээ хамгаалах эрхтэй. Тэгэхдээ эмийн зохистой хэрэглээ гэж байдаг учраас жороор олгох эмийг захиргааны хэмжээний актаар холбогдох байгуулан баталдаг. Жишээ нь энэ бол агаарын чанарыг сайжруулах бүс байна гээд энэ дээр түүхий нүүрс түлэхгүй гэдэг бүсийг тогтоож өгдөг ИТХ-аас энэ захиргааны хэмжээний акт байхгүй юу. Энд тодорхой иргэдийн эрх ашиг бас хязгаарлагдаж байдаг. Тэгэхдээ нийтлэг эрх ашгаараа бүх иргэдийнхээ сайн сайхны төлөө байдаг байхгүй юу.

Тэгэхээр ийм зүйлүүдийг ингээд шууд муйхраар буюу хатуу ингээд хийчих юм бол энэ хуулиараа ерөөсөө өдөр тутмын уян хатан байх иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байдаг юм уу ер нь эрх мэдлийг бас задалж тодорхой эрх шилжүүлэх энэ солилцоонууд үндсэндээ зогсох гэж байна. Тэгээд би зүгээр нэг зүйлийг л хэлье л дээ.

Дээрээс нь хэд хэдэн жишээг зүгээр хэлж болно. Хэдүүлээ замын хөдөлгөөний дүрэм, замын хөдөлгөөний дүрэм гэдэг бол захиргааны хэмжээний акт. Бас дандаа иргэдийн эрхийг хязгаарлана. Ингэвэл та явна ингэвэл та хязгаарлагдана гээд.

Дугаарын хязгаарлалт байна. Яндангүй бүс нүүрс түлэхгүй байх шийдвэр ч гэдэг юм уу хотод адуу мал бэлчээхгүй байх тухай шийдвэрийг хүртэл иргэдийн өмчтэй байх эрхийг хязгаарлаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ асуудлууд чинь ингээд шийдэгдэхээ болих нь ээ. Энэ дээрээ ямар байр суурьтай байгаа юм бол? Би бас эндээс хариулаасай гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт орон нутгийн том эрх мэдлийг ерөнхийдөө төвлөрүүлэх гэж байна аа. Бид эрх мэдлийг орон нутагт өгнө өө гэж ярьдаг мөртөө саяын тэр 27.² дахь заалтаар захиргааны хэмжээний актад батлах эрх олгосон зохицуулалтад дараах асуудлыг тусгахгүй буюу албан татвар төлбөр хураамж тогтоосон харилцааг гэгчхэж байгаа юм. Тэгэхээр чинь өнөөдөр 21 аймаг нийслэлийн авто зам ашигласны төлбөр, хог хаягдлын хураамжийн хэмжээ, эргээд газрын төлбөр зам ашигласны төлбөр гэх мэт маш олон. Энд улсын тэмдэгтийн хураамжаас эхлээд төлбөр хураамж буюу татварын бүрдэл хэсэг болсон энэ зүйлүүдийг иргэдийн төлөөлөгч, Засгийн газар, Засгийн газрын гишүүд ерөнхийдөө батлах эрх нь байхгүй болж байна. Уг нь зарим зүйл амьдрал дээр амьдрал баян учраас уян хатан хандах ёстой байдаг аа. Бид эрх мэдлийг харин Засгийн газартаа шилжүүлэх үү, иргэдийн хуралд шилжүүлэх үү, холбогдох сайд нь шилжүүлэх үү гэдэг зүйлээ л бодно.

Тэгэхээр өнөөдөр малын хөлийн татварыг жишээ нь энэ хуулиар тогтоох орон нутагт тогтоох боломжгүй болох юм бол 330 сумын малын хөлийн татварыг бид нар Улсын Их Хурал дээр яриад суух нь байна шүү дээ. Өөрөө энэ заалтын цаана дахиад жороор орох эмийн жагсаалтыг бид нар Улсын Их Хурал яриад суух нь болж байгаа байхгүй юу. Ийм л зүйл рүү өнөөдөр энэ асуудлуудыг ингэж хэлбийж ороод ирсэн байна.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр Сайнзориг гишүүний асуултад Цогтбаатар дарга хариулах уу? Цогтбаатар гишүүн хариулт өгье.

Д.Цогтбаатар: Энд тийм асуудал ерөөсөө байхгүй байгаа. Би өчигдөр тэр хуулийн үзэл баримтлалаа үзээч ээ. Хуулийн үзэл баримтлал энэ текстийг чинь нийлүүлээд тайлбарлана гээд нэг,

Хоёрт энэ хууль чинь зөвхөн урдах яг хууль боловсруулах энэ процесстой л холбоотой болохоос биш, цаад Үндсэн хууль, Татварын хууль, Засаг захиргааны нэгжийн тухай хуулиар аль хэдийн хуваарилагдчихсан эрхийг ерөөсөө оролдоогүй. Та өөрөө энийг хамгийн сайн мэдэж байгаа.

Ингээд хүмүүс тэгдэг л дээ. Хууль харахлаараа нэг зүйл харангуутаа бусад хууль байхгүй зөвхөн энэ үйлчлэх юм шиг. Тэгтэл энэ аль хэдийн хуваарилагдсан энэ зохицуулалтууд чинь бид нар өөрчлөх боломжгүй шүү дээ. Үндсэн хуулийг яаж ж өөрчлөх юм. Тэгээд орон нутагт чинь энэ юу чинь аль хэдийн шилжчихсэн. Та малын хөлийн татвар яриад байна. Малын хөлийн татвар чинь Улсын Их Хурлаас

тогтоож өгөөд 0-200 мянга билүү тэгээд орон нутгийн ИТХ-даа хэдийг яг тухайн газраа тогтоохыг нь шилжүүлээд өгчихсөн байгаа байхгүй юу. Харин одоо энэ заалт чинь юуг зохицуулаад байгаа гэхлээр орон нутгийн энэ ИТХ-д өгчихсөн энэ эрхээ цаашаа харин журам дамжуулж өгөхдөө хувь хүн буюу тэр Сумын Засаг дарга дүүргийн Засаг дарга юм уу энэ хүмүүст тэр иргэдээс мөнгө авах эрх тийм зохицуулалтуудыг оруулж өгч болохгүй шүү л гэдгийг нь хааж өгч байгаа байхгүй юу.

Өөрөөр хэлбэл энэ хуульд байж байгаа заалтуудыг чинь илүү crystallize consolidation гэж ярьдаг шүү дээ. Тэр болж өгч байгаа болохоос бид нар байгаа хуулийг өөрчилж чадахгүй шүү дээ. Энэ хуулийг дагаж тэр засаг захиргааны эрх мэдэлтэй холбогдолтой юу ч орж ирээгүй. Энэ бүгд чинь оролдогдохгүй шүү дээ. Тэгээд өшөө энэ дээр нэг зүйл хэлмээр байна Сайнзориг гишүүн ээ. Яг үнэнийг хэлэхэд байна шүү дээ энэ заалтыг 2023 онд Хууль зүйн яам боловсруулж байсан юм байна лээ. Танай Хууль зүйн яамнаас авсан юун дотор бичиг баримт дотор энэ заалт чинь явж байгаа байхгүй юу. Энэ байна танайхаас авсан. Тэгээд энд 2023 онд танайх боловсруулж байсан юмыг манай ажлын хэсэг танайхаас мэдээж санал авна шүү дээ. Тэгэхэд энд бүр яг би танд үгээр нь уншаад өгье.

29.² танай яамны юу шүү. Дараах асуудлыг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулахаар хуулийн төсөлд эрх олгосон заалт тусгахгүй гэснээ 29.^{2.1} Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зохицуулсан, хариуцлага оногдуулсан татвар тогтоосон харилцаа гэж байгаа байхгүй юу. Тэгээд танай юунд л байсан юм байна лээ. Тэгээд манайхан энд оруулсан. Үнэхээр энэ хуулийн зохицуулалт нь журмаар иргэдээс мөнгө аваад энэ чинь хамгийн хүнд юм чинь дунд доод шатдаа журам ингэж гаргаж байгаад өөрсдөө иргэдэд хүндрэл хүнд суртал үүсгээд байгаа энийг нь л болиулж өгье гэж байгаа шүү дээ. Өөр юм байхгүй байгаа.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Наадахыг чинь Хууль зүйн яамнаас авсан гэж чи мэдэхгүй байна.

Хоёрдугаарт Цогоо дарга хуулиа уншъя хэдүүлээ энэ захиргааны хэмжээний актын эрх шилжүүлэх асуудлыг повер оф делигэйшнийг бусад этгээд шилжүүлдэггүй байхгүй юу. Тухайн институцийг иргэдийн хурал өөрөө л эдэлдэг. Би энэ 27.^{1.2}-ыг чинь хэлээд байна шүү дээ. Асуудлыг тусгахгүй гэххээд татвар хураамжийн төлбөрийг тогтоосон харилцаа гэдэг чинь цаашдаа бүх гарах харилцаанууд дээр орон нутагт тогтоож болдог татвар хураамжуудыг бүгдийг нь өөрчлөх гээд байна. Улсын тэмдэгтийн хураамжийг бид нар шинэчлэх юм бол энэ дээр бүгдийг нь а, б-гүй бичих гээд байна. Малын хөлийн татвар чинь шинэчлэх юм бол бүгд энэ хуульд нийцүүлж өөрчлөх гээд байгаа байхгүй юу.

Хоёрдугаарт гишүүдэд би энэ 29.5-ыг хараасай гэж бодож байгаа юм. Тухайн жилийн Төсвийн хуулийг дагалдуулан бусад хууль тогтоомжийн төсөлд өргөн мэдүүлэх тохиолдолд төслөөр зөвхөн төсөв санхүүгийн харилцааг зохицуулна гэж байгаа юм. Хүүхдийн хоол тэжээлийн асуудлыг 5 хүртэлх ангид өгч байхад 10 дугаар анги хүртэл өгье өө гээд гэх юм бол дагаад тэр Хоол үйлдвэрлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулж болохооргүй болгочхож байгаа байхгүй юу. Энэ Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг чинь ингээд хязгаарлаад байж болох юм уу? Тэгэхээр энэ зүйлүүд дээрээ.

Д.Амарбаясгалан: Цогтбаатар гишүүн нэмж хариулъя.

Д.Цогтбаатар: Одоо та их гоё юм ярьж байгаа байхгүй юу. Наад эрх чинь аль хэдийн шилжчихсэн энэ ингээд хэрэгжээд явж байгаа. Энийг хэн ч өөрчилж чадахгүй. Гэтэл амьдрал дээрээ танай яамны хийсэн судалгаагаар чинь танайх ярьсан шүү дээ. Танайх харин тийм тийм учраас та улайм цайм ингээд би юу гэж ингээд худлаа би энд баримт бариад сууж байна шүү дээ. Юу гэж өөдөөс чинь харж сууж байгаад Хууль зүйн яамнаас арай худлаа байлгүй дээ гээд та над руу ингэж ярьж болохгүй шүү дээ. Энэ дээр чинь танайхаас авсан бичгээ л бид нар гаргаад ярьж байна. Нөгөө талаас танай яаман дээр энэ улсад чинь юу журам зохицуулдаг болчихжээ гэдэг асуудал танай дээр гарсан байхгүй юу. Яагаад гэвэл таны ярьж байгаа энүүгээр чинь аль хэдийн тэр дунд доод шатанд чинь хүмүүс өчнөөн журам гаргаад шүүх дээр очоод ялагдсан журмууд ч энд байж байна.

Угаасаа эрх зүйн үндэсгүй. Тэгээд тийм журмуудыг л цаашаа гаргахгүй байх тухай ярьж байгаа байхгүй юу. Түүнээс тэр бусдын эрх рүү халдах боломж ч үгүй. Энд хуулийн зорилго ч ерөөсөө тийм биш байгаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Тодруулж асууя.

П.Сайнзориг: Гишүүд төсвөө батлах эрхгүй боллоо. Яг Засгийн газрын орж ирснээр нь батлахаас өөр замгүй боллоо. Дагалдуулаад өөр хуулийн төслүүд орж ирэх боломжгүй боллоо. Энэ чинь төсвийн хэмнэлтийг хийе гээд нэг хууль хийж болно. Төсвийн орлогыг нэмэгдүүлье гээд бусад хуулиудад өөрчлөлт оруулж болох юмыг энүүгээр хаачхаж байгаа юм Цогоо дарга аа. Би зүгээр тантай чалленж хийгээд байгаа юм биш. Энэ зүйлүүдийг засаж болох юм уу гээд байгаа юм.

Хоёрдугаарт дараа дараагийн орон нутагт шилжих эрх мэдлүүдийн чинь хууль шинэчлэхдээ нэмэлт, өөрчлөлт оруулахдаа бүгдийг нь авах гээд байна гэдэг зүйлийг л хэлж байгаа юм аа. Энэ бол журамтай тэмцэх биш Монгол Улсын хууль зүйн тогтолцоог тэр чигт нь нураах ийм хуулийн төсөл орж ирж байгаа шүү. Энийг ерөөсөө гишүүд дэмжиж болохгүй гэдэг зүйлийг би хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн нэг зүйлийг зөв ойлгох хэрэгтэй. Хэт их субъектив асуудал ярих шаардлага бол бага гэж бодож байна. Яагаад гэхээр Монгол Улсад өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 920 орчим хууль яг одоогийн байдлаар бүртгэлтэй байна. 3500 орчим журам байна. Тэрний нэг 2800 орчим нь Хууль зүйн яаманд бүртгэлтэй, бусад нь бүртгэлгүйгээр бүүр хэрэгжиж байгаа юм. Тэрний цаана тоологдоогүй одоо хэчнээн ч журам хаана хэрэгжиж байгаа гэдэг бол эрсдэл болчхож байгаа юм.

Тэгэхээр зүгээр энэ хуулиар засах гэж үзэж байгаа нэг зүйл юу юм бэ гэхээр нэгдүгээрт аливаа төрлийн хэм хэмжээг тогтоох асуудлыг Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүд энийг эцэслэн шийддэг байх ёстой. Хуулиар журам батлуулах эрхээ авчихсан гэж баахан журам энд тэнд гаргаж хэрэгжүүлж байгаа. Гэтэл нөгөө гарч ирсэн журам нь хуулийнхаа агуулга хүрээнээс давсан эрхийг хэрэгжүүлэхээр гаргаад батлаад хэрэгжүүлж байгаа тохиолдлууд байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ бүгдийг засаж залруулъя гэдэг энэ зорилгоор Улсын Их Хурлын гишүүд санаачлаад Хууль тогтоомжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга гаргаж ирсэн.

Харин өнөөдөр хэлэлцэх эсэх асуудлаа шийдчихээд таны ярьж байгаа энэ асуудлуудыг үгүйсгэж байгаа зүйл бүрэн үгүйсгээд байгаа зүйл байхгүй. Харин хэлэлцэх эсэх шийдэгдсэний дараа ажлын хэсэг байгуулагдаад та бүхэн мэргэжлийн хуульчид өөрсдөө энэ ажлын хэсэгтээ ороод сайн ажиллах ёстой. Энд болохгүй гээд бүгдийг нь хааж болохгүй.

Хоёрдож уян хатан байх ёстой гэдэг асуудлыг та хөндөж байгаа юм. Өнгөрсөн цаг хугацаанд ер нь уян хатан байлгая, хууль ер нь жоохон ерөнхий байя гэсэн асуудлаар хандаад ирчихсэн байтал чинь энэ олон мянган журам гарч хүнд суртал авлига гээч зүйл цэцэглэх энэ нөхцөлийг бол үүсгээд байна гэж харагдаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бүгдийгээ хэлэлцүүлгийнхээ шатад засаж залруулаад яриад ажлын хэсэг дээрээ шийдээд явах боломжтой гэдэг талаас нь харахыг хүсье.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Яах вэ тэгээд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал. Ер нь бол яах вэ нэлээн олон асуудлууд яг энэ хууль тогтоомжтой холбоо бүхий асуудлаас үүдэлтэй. Ялангуяа ААН-үүдийн эдийн засгийн хувьд хохирдог хохирлууд их байгаа. Тэгэхээр энэ харилцааг үнэхээр энэ нэмэлт, өөрчлөлтөөр шийдэж чадаж байгаа бол маш сайн. Би БОАЖ-ын сайдаар ажиллаж байхдаа энэ хуулиудын байгаль орчны салбарын 33 хууль дээр бид нар судалгаа хийлгээд үзэхэд давхардал нь 97, зөрчил нь 179, хийдэл нь 335 гарч байсан. Тэгээд энэ өөрөө ямар харилцаан дээр оччихоод байна гэхээр та хэд маань өөрсдөө мэдэж байгаа шүү дээ. Давхардлын сөрөг нөлөө байгаа. Бид нар энэ хууль эрх зүйн орчин дээр эрх зүйн тодорхойгүй байдлыг бид нар давхардлаар үүсгэж өгч байгаа. Хийдлийн хувьд ч гэсэн мөн адилхан энэ зохицуулалтгүй орон зай үүсээд, зөрчлийн хувьд ч гэсэн хууль хооронд зөрчилдөөнтэй заалттай хэрэглээн дээр хүндрэл учраад явж байгаа. Тэгэхээр эхний асуулт нь бол энэ харилцааны асуудлуудыг үнэхээр өнөөдрийн нэмэлт, өөрчлөлтөөр шийдэж өгч чадах уу?

Хоёрдугаар асуулт нь бол хууль тогтоомжийн хувийн эрхтэй буюу иргэд олон нийтээр чөлөөтэй танилцуулах боломжтой байх ёстой гэдэг энэ зүйл заалтыг барьж байх шиг байна. Гэтэл өөрөө Хууль тогтоомжийн тухай хуулийн маань нэмэлт, өөрчлөлт яг энэ шаардлагуудаа хангаж оруулж ирж чадаж байгаа юу? ААН-үүдээс тодорхой хэмжээний саналуудыг авах нь зүйтэй юм шиг санагдаж байгаа.

Дагалдаж байгаа хуулиуд гээд нэг юм орж ирдэг. Баахан хууль дагалдаад ороод ирдэг. Тэгээд тэр дагалдаж байгаа хуулиудын үзэл баримтлал нь өөрөө ямар түвшинд байгаа вэ? Дагалдах хуулиудын төслүүд дээр тавигдах шаардлагууд ямар түвшинд тавигдахаар гэдэг дээр би нэг санал авчихмаар байгаа юм. Ер нь бол тэгээд өнгөрсөн хугацаанд энэ Хууль тогтоомжийн тухай хууль ялангуяа энэ өнгөрсөн хугацаанд хуульд нийцээгүй журмуудын асуудал нийтээр дагаж мөрдөх журмуудын асуудал одоо Засгийн газар дээр харахад бол бас нэлээн хууль дүрэм журмуудыг хууль дагасан журмуудыг цэгцлэх гээд яваад байх шиг байна. Гэхдээ энэ дотор хариуцлага хүлээж байгаа албан тушаалтнууд байгаа юм уу? Сая Улсын Их Хурлын дарга ч гэсэн сая хэлж байна л даа. Захиргааны хэм хэмжээний актын хүрээнд 3500 гаран. Гэтэл 2800 нь бүртгэгдчихсэн. Цаана ахиад 700 байгаа байх.

Зүгээр л одоо байгаа тоо. Тэгтэл энэ дээр бид нар жишээлбэл тухайн шийдвэр гаргаж байгаа холбогдох албан тушаалтнууд яг өнөөдрийг хүртэл хүртэл ний нуугүй хэлэхэд хариуцлага хүлээхгүй л яваад байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр бид нар яах юм. Эндээс чинь улбаатай эдийн засаг болон тодорхой үл ойлголцлын асуудлууд, үүсээд байгаа харилцаа үүсээд байгаа асуудлууд байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ асуудлууд яг шийдвэрлэгдэх бүрэн боломжтой юу гэдгийг би асуух гэж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дамдины Цогтбаатар гишүүн хариулт өгье.

Д.Цогтбаатар: Энд яг одоо ААН-үүд энэ бол байна шүү дээ ААН-үүд энгийн иргэдийн эрх ашгаа л үнэхээр бодсон хууль. Одоо энэ хуулийн хамгийн анхны, өөрийн логик санаа суурийн суурь санаа энэ чинь дараа нь хуулиа хэрэглэхэд хэрэглэгдэх суурь ойлголт байхгүй юу. Тийм учраас зүгээр би нэг ийм суурь санаа гээд яриад байгаа юм биш шүү. Шүүх дээр очоод хууль хэрэглэхэд үзэл санааг нь заавал гол авч үзэж байгаа байхгүй юу. Текст хэрэглэхийн хажуугаар. Тэгэхээр тэрэн дээр чинь тэр хүн рүү чиглэсэн иргэн рүү чиглэсэн ААН байгууллагууд руу чиглэсэн ямар нэгэн эрхээ хэтрүүлээд гаргачихсан байгаа журмуудыг хүчингүй болгох тухай яриад байна шүү дээ.

Тэгэхээр үнэхээр хүнд суртал юуг бий болгодог вэ гэхээр нээрээ ингээд л яваад очихлоор манайх тийм журамтай, иргэд тэрийг нь ийм эрх угаасаа байсан уу үгүй юу гэдгийг нь мэдэхгүй журам харахлаар журам байдаг тэрийг нь дагаж мөрдөөд л явдаг тэр нь аягүй их хүндрэл үүсгээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг нь бид нар хөнгөлж өгөх гэж оруулж ирж байгаа юм. Энэ нөгөө чөлөөтэй танилцах эрхийн бололцоог хангасан уу гэж. Яг нэгэнт ийм хууль оруулж ирж байгаа болохлоор бид нар энийгээ барих гэж Хуульчдын холбоо энэ зөндөө олон иргэд эд нартай манай энэ ажлын хэсгийнхэн бүүр цаг гаргаж нэлээн уулзаж ажилласан. Тэгээд тэрэн дээрээ бол танилцуулга эд нар дээр энэ юмнууд нь байж байгаа. Дагалдаж орж ирж байгаа хуулиудын үзэл баримтлал яг үнэн. Ер нь бол түрүүн яг юу яаж байна лээ.

Бид нар ингээд гишүүдийн эрх рүү халдаагүй эсрэгээрээ гишүүдэд харин энэ зөндөө олон хууль дээр хууль санаачлах эрхийг нь хаачихсан байгаа юмнуудыг харин нээж өгч байгаа шүү, нэг.

Хоёрдугаарт энэ нээрээ хууль дагалдаж орж ирээд аягүй олон анхдагч хуулийнхаа үзэл баримтлалаас зөрчигдсөн юмнууд ороод ирдэг. Тэгээд энийг болиулах гэж хийж байгаа. Одоо тэр үүднээсээ энэ хуулиа ч гэсэн бид нар оруулахдаа тэр үзэл баримтлалтайгаа бол нийцүүлж мэдээж чек хийж байж оруулж ирж байгаа. Хүний хариуцлага бол бид нар хууль л гаргаж байна шүү дээ. Тэгээд энэний дагуу бол зөндөө олон хууль тогтоомжууд тэнд 700-аас 800 Хууль зүйн яаманд бүртгэлгүй журмууд явж байгаа байхгүй юу. Эд нар чинь бол мэдээж хүчингүй болох үр дагавар гарч л таараа. Тэгээд хүний хариуцлагын тухайд бол энэ хуулийн зорилго биш тиймээ. Тэрэн дээр бол харин энэнээс хойш тэр эрх мэдлээ хэтрүүлсэн тийм журам гарахгүй л болж байгаа юм. Тэр бол тусдаа асуудал. Энэ хуулиар зохицуулаагүй.

Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Энэ Хууль тогтоомжийн тухай хууль энгийн мөртөө бас их олон үр дагавартай ийм л хуулийн асуудал хэлэлцэгдэж байна. Энэн дээр ганц 2 өнцгүүд байгаа нь жишээ нь түрүүн яригдаж байна.

Нэгдүгээрт нь яаралтай горимоор хууль өргөн барина гээд. Уг нь бол эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой урьдчилан тооцоолох нөхцөл боломжгүй нөхцөл байдал дээр яаралтайгаар хялбаршуулсан байдлаар хууль өргөн барина гэдэг. Ингээд тоо харахаар сүүлийн жилүүдэд 2016 оноос хойш гэхэд 68 хуулийг яаралтай горимоор өргөн барьсан байна лээ. Тэгэхээр хууль санаачлагчаас яг одоо яаралтай горимоор өргөн барьсан гэж байгаа энэ 68 хууль үнэхээр тийм урьдчилан тооцоолох боломжгүй нь тэр шаардлага хангасан нь хэд байсан юм. Энэ яг Засгийн газраас яаралтай горимоор сүүлийн үед чинь бүр маш их л юм л бол яаралтай горимоор л гэдэг болчихлоо. Ямар ч олон нийтийн хэлэлцүүлэггүй, Санаа бодолгүй, хуулийн иж бүрдэлгүйгээр л ороод ирчихдэг. Тэгэхээр энэн дээр та нэг тоог хэлээч. Энийг яаж энд өргөн барьж байгаа хуулиар яаж хязгаарлаж, яаж үзэл санааны хүрээнд аваачих гэж байгаа юм. Урьдчилан тооцоолох боломжгүй гэдэг тэр нөхцөл байдлуудыг яаж харж байгаа вэ.

Хоёрдугаарт нь хууль дагалдуулж орж ирдэг. Би энэн дээр нэг түрүүн нэг тоонууд харсан.

2022 оны улсын төсвийг 110 хууль жишээ нь дагалдаж орж ирээд 98 нь батлагдаад гарч ирсэн байна лээ. Та бод доо. Төсвийн хуулийг 110 хууль дагалдаж орж ирдэг. Жишээ нь энэ хуулиудыг харах юм бол Төсвийн хуулийг дагаад Татварын хууль ороод ирдэг. Татварын хувь хэмжээнд Татварын хууль ороод ирдэг. Төсвийн хуулийг дагаад Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой 2 хууль ороод ирдэг. Бүр Төсвийн хуулийг дагалдаад төсвийн тогтвортой байдлыг нь өөрөөс нь том хуулийг нь Төсвийн хуулийг нь дагуулж орж ирээд өөрчлөөд алх цохиод гаргачихдаг. Яг энэн дээр одоо энэ таны өргөн барьж байгаа танай гишүүдийн өргөн барьж байгаа энэ хууль дээр ямар өөрчлөлт, энийг яаж хязгаарлах юм? Жишээ нь одоо тэр нийслэлийн ч билүү хуулиуд орж ирж байсан. Газрын харилцааг зохицуулсан айхтар том том заалтууд дагалдаж орж ирээд л цуг гарчихдаг. Энэ өөрөө ингээд яг Улсын Их Хурлын хууль тогтоох, хуулийг үндсэндээ олон нийтийн санаа бодол, мэргэжилтнүүдийн санаа бодол, хуулийн иж бүрдэл, цаг хугацаа олон олон зүйл аль нь ч байхгүй. Ингээд нэг ийм цоорхойнууд энийг анхаарч байгаа байх бодвол. Өргөн барьж байгаа хууль дээр та эдгээрийг яаж зохицуулъя гэж ер нь нэг ийм үзэл баримтлалаас гачихгүй мачихгүй гээд нэг ийм ердийн үгний хүрээнд бол угаасаа тэр бол тэгээд л хамаагүй тойроод л явчихдаг шүү дээ.

Тодорхой зүйл, заалт, гарц гаргалгаа, арга шийдэл энэ дээр байна уу?

Д.Амарбаясгалан: Цогтбаатар дарга хариулт өгье.

Д.Цогтбаатар: Яг таны ярьж байгаа энэ заалтуудыг л ерөөсөө үзэл санаатай өөрчлөлтүүд орж ирж байгаа юм. Юу гэвэл одоо жишээлбэл та тэр яаралтай горимоор гэдгийг яагаад бид нар энэ дээр тусгаж байна гэхээр тийм хууль бол орж ирнэ шүү дээ. Энийг эрс цөөлж өгөх үүднээс энийгээ энд оруулж зөвхөн ийм яаралтай үнэхээр ийм үндэсний аюулгүй байдалтай холбоотой тэгээд энэ цаг

хугацаанд шахагдчихсан даруй авахгүй болохгүй байх ийм арга хэмжээнүүд онцгой нөхцөлд л болохоос бусад юманд бол одоо ийм тайлбар байхгүй болчихсон. Тэгэхээр таны хэлж байгаагаар тийм тайлбарын шаардлага хангахгүй байгаа хуулиудыг бол ийм богино хугацаагаар шахаж оруулж ирэх угаасаа нөгөө өөрөө тавигдаж байгаа шалгууруудаараа хангах боломжгүй болчихож байгаа байхгүй юу. Тэгээд тэрүүгээрээ боломжгүй болж байгаа. Энэ яг тоон дээр бол манайхан харин 68 хууль орж ирсэн ч билүү тэр тоонуудыг нь манай ажлын хэсгийнхэн хэлээд өгөөрэй. Энэ дагалдаж орж ирсэн хуулиуд яг Цогтгэрэл гишүүн бас өөрөө ч санаж байгаа байх. Энэ төсөв хэлэлцэж байхад түрүүний парламентад хамгийн их юм ярьж байсан хүн бол би.

Дагалдаж орж ирж байгаа хуулиуд чинь хууль эрх зүйн орчныг чинь өөрчлөөд байна аа. Тэгээд дараа нь бид нар гаднын хөрөнгө оруулагчдад очоод манай хуулийн орчин тогтвортой гээд жил болгон юу төсвөө дагаад маш олон хууль тэгээд бүүр эдийн засгийн хуулиуд байхгүй юу энэ чинь орж ирээд. Хуулийн орчин чинь өөрчлөгдөөд бүүр анхдагч хууль хяналтын хууль байх аа. Анхдагч хууль дагаж орж ирээд батлагдаж байсан юу байгаа байхгүй юу тохиолдол. Тэгэхээр энэ бүгдийг чинь тийм яг тийм анхдагч хууль орж ирээд гарч байсан шүү дээ. Одоо тэр бүгдийг чинь нөгөө шалгуурууд тавьж өгөөд энэ дээрээ орох боломжгүй болж байгаа. Харин тэртээ тэргүй гэхдээ төсвийн сая тэр хэн гишүүний ярьж байгаа юун дээр нэг ийм юм байгаа юм аа. Төсвийн хууль дагаж орж ирж байхад бид нар нэг л шалгуур тавьж байгаа юм. Зөвхөн санхүүгийн зохицуулалт бүхий ийм л юм дагаж орж ирнэ шүү. Тэгэхгүй бол нөгөө хууль нь өөрөө шал өөр үзэл агуулгатай юмнууд орж ирээд байдаг ийм юм байхгүй шүү л гэдгийг хийж өгч байгаа юм.

Тэгээд манай ажлын хэсгийнхэн тэр тоон дээр нэмээд хариулчих уу?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 10 дугаар микрофон Отгончимэг зөвлөх хариулт өгье.

Н.Отгончимэг: Гишүүний асуултад хариулъя. Яаралтай горимоор энэ зохицуулалт бол 2016 онд орж ирээд энэ хугацаанд бол 74 хууль намрын чуулганыг оруулах юм бол энэ 74 хууль энэ горимоор хэлэлцсэн байсан. Энэ статистик харахад бол сүүлийн чуулганаар 2020-2024 оны Их Хурлын үед бол 2.4 дахин нэмэгдсэн байгаа. Тэгэхээр энэ статистикийг үндэслээд яаралтай горимоор хууль хэлэлцүүлэхэд бол нэгэнт Улсын Их Хурлын дэгийн хууль дээр тодорхой барьер нь бол дээшилсэн байгаа. Нийт гишүүдийн саналаар шийддэг болсон яаралтай горимоор хэлэлцэх үү үгүй юү гэдэг. Харин агуулгын хувьд бүрдлийн хувьд бол бид нар энэ төсөл дээр нэг заалт нэмж өгсөн. Тэр нь цаашид яаралтай горимоор хэлэлцэхээр орж ирж байгаа энэ хуулиуд бол хэрэгцээ шаардлагын тандан судалгаагаа заавал хийж орж байх ёстой гэдэг ийм шаардлага нэмэгдсэн байж байгаа.

Д.Амарбаясгалан: Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Сая жишээ нь яаралтай горимоор орж ирэх асуудал орж ирдэг асуудал хууль дагалдуулдаг гээд бид нар 2 тусдаа 2 юмыг сая яриад л асуулт хариулт болчихлоо л доо. Жишээ нь энэний цаана дахиад гардаг асуудал чинь яаралтай горимоор мөртөө баахан хууль дагуулаад оруулчихдаг. Энэ 2-ыг чинь ингээд нэг зүйл болгоод. Яаралтай горимоор тэгээд 20, 30 хууль суурь хуулиудыг дагуулаад л оруулчихдаг. Энэ цонхууд жишээ нь бүр дахиад ингээд л давхар

аюултай ийм л нөхцөл байдлууд үүсчхэж байгаа юм. Тэгэхээр цааш цаашдаа ингээд харилцах эсэх нь дэмжигдээд явсан үедээ анхаарна биз.

Яг энэ хуулийн асуудал дээр гэхэд нэлээн хуульчдыг оролцуулсан тэр Их Хурлын ажлын хэсгээс гадна дэд ажлын хэсэгт мэргэжлийн хүмүүсийг сайн оролцуулж ярилцвал илүү тийм зөв зүйтэй байх. Янз бүрийн манай бүлгийн зөвлөхүүдээс ч гэсэн энэн дээр тодорхой маш олон саналууд ингэж хэлж байгаа зүйлүүд их гардаг. Тэгэхээр дэд ажлын хэсэг дээрээ анхаарч мэргэжилтнүүдийг хамруулж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Энэ яаралтай горимоор өргөн барьж байгаа хуулийн төсөл яг энэ Цогтгэрэл гишүүний хэлээд байгаа их чухал юм байгаад байгаа юм тиймээ? Энэ хууль дээр бид засаж авахгүй бол. Яаралтайгаар өргөн барьчихдаг. Их Хурал хэлэлцэхгүй гээд шийдчихлээ гэхэд бид нөгөө бүрдэл бүрэн хангагдаагүй хэлэлцүүлэг хийгдээгүй хуулийн төслийг хэлэлцээд явчхаж байгаа байхгүй юу. Яаралтайгаар хэлэлцвэл тэр нь болоод явчихдаг нэг ийм хийдэл маягтай зүйл бол бодитой бий болчихсон байна лээ. Тэгэхээр энийг засах нь зөв өө гэж. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Амьдралд яг ингээд тохиолдсон явдлаас Цогтбаатар гишүүнд санал болгож хариулт авах гээд байгаа юм. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга өмнөх Засгийн газар дээр боловсруулагдаад өмнөх Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх байж байгаад одоо энэ 126-тай парламентад орж ирээд бид нар ажиллаж байгаа. Гэтэл энийг бид дахиад иргэдийн дунд хэлэлцүүлэг хийгээд санал авмаар байдаг. Гэтэл Засгийн газрын зүгээс тэгэх шаардлагагүй гэж үзээд байдаг. Улсын Их Хурлын зүгээс бид энийг хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзээд байдаг. Энэ чинь нэг парламент нэг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусаад, дахиад шинэ концепцтой, шинэ Засгийн газар шинэ мөрийн хөтөлбөртэй тийм үү Улсын Их Хурал гараад ирж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ нөгөө Хууль тогтоомжийн тухай хууль дээр олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй гэдэг зохицуулалт байна 38.8, 38.9, 38.12 дугаар зүйл дээр. Энийг ингээд харахаар ийм тохиолдолд хэлэлцүүлэг хийж болох ч юм шиг болохгүй ч юм шиг. Ерөөсөө зохицуулаагүй юм байна л даа. Тэгэхээр энэ чинь нөгөө нэг ингээд маргаан үүсээд аль нэг ашиг сонирхлоор ч юм уу аль нэг тал руугаа тайлбарлаад явчих магадлал үүсэх вий гэж бодоод та туршлагатай парламентч хүн учраас энийг эргэж хараад зохицуулах боломж байдаг болов уу гэдэг санал гаргаж байна аа.

Энэ цааш цаашдын парламент цааш цаашдын Засгийн газарт тохиолдож болохуйц зүйл болчихоод байна л даа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цогтбаатар гишүүн хариулт өгье.

Д.Цогтбаатар: Тийм. Таны яг хэлэлцэж байгаа хууль дээр та яг л зөв хэллээ. Бид нарын энэ оруулж ирж байгаа юу энэ олон нийтийн хэлэлцүүлэг эд нарыг чинь харин бүр явуулах, заавал тэр нөгөө бүрдүүлбэр хэсэгт оруулж өгч байгаа юм. Онцгой зарим тохиолдолд оруулахгүй бүр аягүй ойлгомжтой тийм хуулиуд дээр л болохгүй болохоос бусад дээр нь бүр эсрэгээрээ дандаа олон нийтийн санал асуулга дээр суурилах гээд байгаа юм. Харин зүгээр яг таны хууль дээр эргэж энэ нөгөө хууль маань батлагдаад л тэрнээсээ хойш үйлчлэх учраас эргэж үйлчлэх

боломжгүй. Наадах чинь угаасаа өөрийнхөө байгаа хуулиараа л явж байгаа болохоор нэг тийм юу байгаа. Гэхдээ та бас ярьж байгаад ер нь зүгээр олон нийтийн санал асуулга шууд авч болохгүй гэхэд өөр тэгвэл ди парламент эд нараар ч юм уу тийм боломж байна уу үгүй юу? Тэрийг тэгэхдээ цаг хугацааныхаа юуг нөгөө хязгаарыг бодоод хийж болох л байлгүй. Би тэгж л бодож байна.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Цогтбаатар гишүүн ээ биш, ийм байхгүй юу. Одоо үнэхээр ингээд олон нийтээр хэлэлцүүлэх боломж нь хангагдчихсан байгаа. Зүгээр өмнөх парламент, өмнөх Засгийн газрын үед хэлэлцүүлчихсэн хууль дараагийн парламент руу уламжилж ирж байгаа байхгүй юу даа. Тэгэнгүүт энэ парламент энэ Засгийн газар чинь өөр мөрийн хөтөлбөртэй. Нэг парламент нэг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусчихсан. Дараагийнх руу өвлөж ирж байгаа хуулийг дараагийн парламент дараагийн Засгийн газар дахиад хэлэлцүүлэгт оруулах нь зүйтэй гэдгийг л зохицуулж өгөх боломжийг тусгаж өгөөч л гэж би хэлээд байгаа юм.

Тэрнээс одоо бол нээлттэй байгаа шүү дээ. Өмнө нь хэлэлцүүлэг хийчихсэн хууль дараагийн парламентад шилжиж байгаа. Засгийн газарт шилжиж байгааг яриад байгаа байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Мөнхбаясгалан гишүүн ээ нэг ч тийм хууль байхгүй шүү дээ. Хуулийн төсөл. Өмнөх парламент дээр өргөн баригдчихсан хэлэлцүүлгийн шатад явж байсан бүх төслүүдийг буцаачихсан. Одоо энэ парламент дээр бүгд дахиж өргөн баригдаж л орж ирж байгаа. Бүрдлээ хангана, хэлэлцүүлгээ хийнэ. Хууль нь Хууль тогтоомжийн хуулиараа тавигдах шаардлагаа хангасан нь өргөн баригдаад л явж байгаа байхгүй юу. Тэгэхдээ энэ Мөнхбаясгалан гишүүний хэлээд байгаа саналыг. Отгончимэг зөвлөх нэг хариулт өгөөдөхье. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Н.Отгончимэг: Мөнхбаясгалан Баясгалан гишүүний асуултыг зүгээр зөв ойлгосон уу үгүй юу. Ямар ч байсан өмнө нь тэр өргөн баригдсан хуульд авагдсан олон нийтийн саналыг одоо ахиж хавсаргаж болох уу үгүй юу гэдэг асуудал яригдаж байх шиг байна гэж ойлголоо. 38.1 дээр нэг чухал заалт орсон байж байгаа. Яг энэ хуулийн төсөл дээр. Одоо байгаа хуулиар бол хууль санаачлагч сайтдаа цахимаар байршуулчхаад санал ирэхгүй бол цахим хэлэлцүүлэг хийсэн гээд ямар нэг саналгүйгээр өргөн мэдүүлэх боломж байгаа. Үүнийг бол хэлбэр төдий олон нийтийн харилцааг хангаж байна гэж үзээд 38.1 дээр тухайн хуулийн төслөөр эрх ашиг нь хөндөгдөж байгаа иргэд дээр цахим хэлэлцүүлэг хийхгүй уулзалт, ярилцлага, хэлэлцүүлгийг заавал хийнэ гэдэг байдлаар ингээд ийм хэлбэрээр бол даалгасан ийм заалт орсон байж байгаа.

Тэгэхээр магадгүй энэ хууль.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Улсын Их Хурлын даргын дэвшүүлсэн парламентын 3 төгөлдөршил бидний хамтдаа баталсан Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөний дагуу Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт энэ өөрчлөлт хуулийг ХЗБХ-ны дарга Цогтбаатар Улсын Их Хурлын даргын хуулийн зөвлөх Отгончимэг нарын

хүмүүс оруулж ирж байгаад зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Гэхдээ надаа нэг санаа тавих нэг 4 асуудал байгаад байна аа.

Нэг нь болохоор хуулийн 27.2.3-д буюу албан татвар төлбөр хураамж тогтоосон харилцааг зөвхөн хуулиар буюу Улсын Их Хурлаар л зохицуулна гэдэг заалт маань хэрэгжих боломжтой юу үгүй юу? Бүх хураамж, бүх төлбөр, бүх татварыг Улсын Их Хурлаар хэлэлцэнэ гэхлээр эргээд нөгөө бусад цаг хугацааны хувьд ч тэр ер нь бодитой биелэх боломжтой юу үгүй юу? Төсөв дагаж орж ирж байгаа хуулиудыг хяз тусгаарлаж байгаа нь яах вэ цаашид бидний хувьд Ковид шиг ийм онцгой нөхцөл байдал битгий үүсээсэй гэдэг үүднээс магадгүй зогсоож болно. Гэхдээ онцгой нөхцөл үүслээ гэхэд яалт ч үгүй төсвийг дагуулаад орж ирж байгаа онцгой хуулиуд байдаг. Энэ маань эргээд хэрэгжих, хэрэгжихгүй, буцаад чөдөр тушаа болчих вий гэсэн ийм болгоомжлол байна.

Гурав дахь нь болохлоор энэ анхдагч болон салбарын хуулиудыг Засгийн газрын санал Засгийн газар ер нь энийгээ л хариуцна гэдэг байсан маань эргээд 126 гишүүнтэй болчихсон. Гишүүн болгон салбарын асуудлыг өргөн барьж болдог ярьдаг болох нь өөрөө эргээд эрсдэл үүсгэдэг юм гэдгийг онцолж хэлэх гэсэн юм.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль дээр аливаа Ерөнхийлөгчөөс Улсын Их Хурлын гишүүдээс өргөн барьсан байгаа хууль тогтоомж дээр Засгийн газар санал, дүгнэлтийг гаргадаг. Хэрэвзээ дэмжээгүй бол дэмжээгүй энэ саналаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд 10 минутын дотор хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн танилцуулна гээд орчихсон байгаа.

Тэгэхээр аливаа хууль Улсын Их Хурлын гишүүн байна уу, Ерөнхийлөгч байна уу, орж ирж байгаа, санаачилсан хуулийг хэлэлцэх эсэх тэр процесс дээр хэрэвзээ Засгийн газар дэмжээгүй бол заавал 10 минутын хугацаанд энэ асуудлыг сонсдог баймаар байна аа. Яагаад гэвэл яалт ч үгүй татвар гэдэг юм уу халамж гэдэг юм уу, тэтгэврийн энэ асуудал гэдэг юм уу тухайлсан асуудлууд дээр яахын аргагүй салбарын санал бол маш чухал байдаг. Энэ бол эргээд системийн хэмжээнд догдлол үүсгэх хэмжээний хуулиуд ч гэсэн урьд өмнө нь Засгийн газар дэмжээгүй ч гэсэн гишүүдийн хамтын шийдвэрээр өөрчлөлт ороод явж байсан тохиолдлууд маш их байгаа.

Эцэст нь бас нэг миний санаа зовоод байгаа асуудал болохоор энэ хууль хэрэгжихгүй байгаа дээр бид нар яах вэ? Монголын хууль 3 хоногт гэдэг энэ хэллэг бол миний ойлголтоор анх хууль батлагдангуут өртөөчлөн Монгол Улсын бүх өнцөгт хүрдэг байсан, 3 хоногт багтаагаад хүрдэг байсан гэж бараг Чингис хааны үеийн л тийм хэллэг байдаг гэж ойлгодог. Гэтэл одоо бол хууль гаргалаа гуравхан хоног хэрэгжээд л байхгүй хэрэгжилт нь байдаггүй гэдэг ийм ойлголттой болчихоод байна шүү дээ. Тэгэхээр яг энэ хууль хэрэгжүүлэхгүй байгаа хуулийн хэрэгжилтийг бид нар хяналаа гэхэд зүгээр хэрэгжүүлэх чиглэл өгөөд л орхичихдог. Гэтэл тэр хууль яагаад хэрэгжихгүй байна вэ заалт нь угаасаа буруу байна уу эс үгүй бол хэн нэгэн одоо шийдвэр гаргаж байгаа тэр субъект нь өөрөө хүсэхгүй байгаад мэдсээр байж байж хуулийг хэрэгжүүлэхгүй байна уу гэдэг нь өөр асуудал болчихож байгаа юм аа. Хамгийн наад захын жишээ ойрд би яриад байгаа Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль. Олон жил хэрэгжиж байгаа. Тухайн хуулийн 5.4 дээр 2 жилд нэг удаа тогтооно гэж байгаа. Тухайн хуулийн 7.2-т 1 сарын 1-ээс хэрэгжүүлнэ мөрдөнө гэж байгаа. Энэ хууль яах вэ тэгж байгаад өөрчилчихнө шүү дээ. Энэ Хөдөлмөр нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хорооны гаргасан шийдвэрээ гээд

4 сарын 1-ээс 3 жил дараалан нэмж байна. Энэ зөвхөн цалин хөлсний асуудал биш. ЭМД-ын шимтгэл сайн дурын НДШ, гадаад ажилтны төлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэн аж ахуйн төлбөр ордог.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Энэ хууль хэрэгжих үү энэ чинь зарим юу нь энэ төлбөр тооцоон дээр л хүмүүс ингээд асуугаад байна л даа. Энэ хууль хэрэгжилгүй яах вэ. Энэ хэрэгжих боломжтой энэ яг хэрэгжиж байгаа хууль шүү дээ. Угаасаа хэрэгжиж байгаа хууль. Бид нар нэмээд илүү боловсронгуй болгоод л оруулж ирж байгаа. Энэ дээр тэр нөгөө энэ төлбөр тооцооны тухай асуудал дээр би түрүүн нөгөө хариулчихсан. Угаасаа эрхийн хуваарилалт бол аль хэдийн хийгдчихсэн. Энэ хууль хийгээгүй. Энэ бол зүгээр нарийвчилж өгч байгаа болохоос биш энэ чинь Засаг захиргааны нэгжийн тухай хууль, Үндсэн хууль эд нараараа, Татварын тухай хууль эд нараараа хийгдчихсэн байж байгаа зүйл. Энэ дээрээ харин тухайн байгууллага энийг хэрэгжүүлэхдээ эрхээ нөгөө хуулиар эрхийг нь аль хэдийн шилжүүлээд өгчихсөн байхад тэрийг цаашаа журам гаргаад шилжүүлэхдээ тэр эрх нь эрх нь хүрэхгүй угаасаа хуулиар заагаагүй хүнд шилжүүлж болохгүй шүү л гэдэг юм ярьж байгаа юм.

Тэгэхээр энэ иргэн эсрэгээрээ харин энэ нь хэрэгжээд явах ёстой бөгөөд ингэж байж тэр хүнд суртал арилгах боломж гарна аа. Энэ салбарын гишүүн болгон юу яах вэ салбар болгон дээр гишүүн болгон санал ингээд юу хууль гаргах боломж чинь хүндрүүлэх юм биш үү гээд. Яах вэ гэхдээ Үндсэн хуулиараа Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газар, Ерөнхийлөгч хууль өргөн барих юутай байгаа шүү дээ. Бүрэн эрхтэй. Тэрийг бол бид нар ямар нэгэн байдлаар энэ хуулиар л лав хязгаарлах боломж байхгүй. Энэ нөгөө тэр татвар биш юун дээр бол хууль хэрэгжихгүй байгаа дээр харин яг одоо жишээлбэл 1 далайлтаар бүх юмыг шийдэхгүй. Гэхдээ энэ хууль хуулийн хэрэгжилтэд аягүй нэмэр болно. Яагаад гэвэл энэ хуулийг оруулж ирэхээсээ өмнө нөгөө экс пост судалгаануудаа хийж заавал тэр бүрдүүлбэрт нь энэ орох ёстой. Тэгээд энэ хууль хэрэгжвэл ямар ямар үр дагавар гарах вэ? Эдийн засгийн ямар юу үр дагаврууд гарах вэ ААН-үүдэд ямар ачаалал ирэх вэ аүртэл энэ юмнуудаа судалгаануудаа хийж байж оруулж ирэх ёстой учраас энэ хуулиа бид нар өөрөөр хэлбэл тийм болж байгаа учраас энэ хууль бодитоор ингээд хэрэгжээд явах боломжтой гэж бодож байна.

Манай ажлын хэсгээс өшөө нэмж хариулах юм байвал хариулчхаарай.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу? Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Н.Отгончимэг: 2 зүйл тодруулж нэмье.

Нэгдүгээрт хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой хэсэг багц заалт орж байгаа. Хууль тогтоомжийн хууль дээр хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхийг бол эзэнгүй орхисон байж байгаа. Энийг бол 3 субъектэд хуваарилж ингэж зааж өгч байгаа.

1 дүгээрт Улсын Их Хурал бол Их Хурал болон Дэгийн хуультай холбоотой асуудлаа өөрсдөө үнэлнэ. Харьяа байгууллагууд нь холбогдох хуулиудаа үнэлнэ. Эрүү, иргэн, захиргааны процессын хуулийг бол Хууль зүйн үндэсний хүрээлэн үнэлнэ. Үүнээс бусдыг бол Засгийн газар хэрэгжилтийг нь үнэлж тухайн судалгаагаа

5 жил тутам легал инфо дээр тавьж байх ёстой гэдэг маш нарийн ийм тодорхой заалт орж ирж байгаа.

Дараа нь журамтай холбоотой заалт орж ирнэ. Ер нь журам батлах эрх олгосон энэ заалтууд зарим тохиолдолд хэрэгжихгүй байна. Батлах гэсэн хугацаанд нь батлахгүй байна. Энэнтэй холбогдуулаад хэрвээ журам батлах.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Н.Отгончимэг: Журам батлах буюу захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон энэ заалт хуульд байгаа тохиолдолд хуулиа дагуулж тухайн заалтыг дагаж мөрдөх журмын хуульд заавал оруулж ирэх ёстой. Тухайн журмыг ямар хугацаанд баталсан байх ёстой юм бэ гэдгийг нь бол зааж өгнө өө гэдгийг бол тусгасан байж байгаа.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Зарим зүйлийг сонсоход бол Цогтбаатар даргын санааг дэмжмээр санагдаж байгаа. Тэгэхдээ яах вэ би нэг тодруулах гээд 2, 3 зүйл асуух гээд байгаа юм. Захиргааны хэм хэмжээний акт буюу энэ журмуудыг юу гэхлээр Захиргааны ерөнхий хуулиар уг нь зохицуулдаг. Яагаад хууль тогтоомжийн хуулиар энийг оролдох болсон юм бэ гэдгийг нэг асуучихмаар байна. Мөн үүнтэй улбаалаад энэ Захиргааны ерөнхий хуулийг Засгийн газар санаачлах эрхийг нь яагаад хаасан юм гэдэг 2 дугаар асуулт байна.

Мөн өмнө нь нөгөө хэвлэл мэдээлэл дээр гараад байсан мэдээллээр ингээд үндэслэх юм бол нийтдээ нэг 850 журам одоо хэм хэмжээгээ даваад гэх юм уу хуулиар эрхээ аваагүй мөртөө хэрэгжүүлчихсэн журмууд байгаад байна гээд байгаа юм. Тэгээд үүнээс гарсан хор уршгийн судалгаа ер нь байгаа юу? Эдийн засагт учруулсан хор уршиг байдаг юм уу, хүнд суртлын нэмэгдүүлсэн байдаг юм уу, авлигалын индексийг нэмэгдүүлсэн байдаг юм уу? Энэ нэг хор уршгийн судалгааг нь нэг харж байгаад цөмөөрөө яг энэ хуулиа нэгэнт явуулахаар бол энийг нь хэлэлцүүлгийн явцад ярилцах зүйлүүд байгаад байгаа юм. Яагаад тэгж байна гэхээр 2022 онд Зөвшөөрлийн хуулийг батлахад ч тэр, 2021 онд банкны хуулийг батлахад ч тэр эд нар энэ журмуудын асуудлыг тухайн хуулиудад ерөөсөө Зөвшөөрлийн хуультай холбоотой зөвхөн шалгуур шаардлага дээр л журам гаргаж болно шүү. Бусад бүх журмуудаа та нар хүчингүй болгоно шүү гээд 2.2 удаа тогтоол гарсан байдаг Улсын Их Хурлын тогтоол. 69 дүгээр тогтоол, нөгөөдөх нь хэддүгээр тогтоол байлаа даа?

Тэгээд тэр журмуудаа цуцлахгүй явсаар байгаад үндсэндээ 2025 оны 1, 2 дугаар сард цуцалж байгаа байхгүй юу. Тэгээд тэр бол үндсэндээ нөгөө хуулийг хэрэгжүүлэхгүй байх нөгөө гарын үсгээ авч үлдэх ийм санаа санаачилга яваад байдаг юм. Тэгээд хуулийг хэрэгжүүлэхгүй байгаа сайд нар дээр ямар ч арга хэмжээ олдоггүй. Тэр одоо тэр нэг эрхээ аваагүй 850 журмаар ямар хор уршиг яах юм.

Дээрээс нь одоо эрхээ аваагүй байгаа мөртөө тэр журмаа цуцлахгүй байгаа сайд нар дээр ямар арга хэмжээ авах юм. Энийг маш тодорхой оруулж өгөхгүй бол бол улс төрч нар дээр очоод л хуулийг хэрэгжүүлэх боломжгүй болдог хариуцлага тооцох боломжгүй болдог. Тэр тусмаа сайд нар дээр зөвхөн Ерөнхий сайд л хариуцлага тооцох биш бид нар энчээ зүгээр хэлээд л байдаг, хэлээд л байдаг

Улсын Их Хурлын хоёрын хоёр тогтоол. Их Хурлын дарга аа бүр хоёрын хоёр тогтоол гаргаж байгаа шүү дээ. Энэ журмуудаа та нар цуцлаач ээ. 2 удаа тогтоол гарлаа гээд. Тэгээд энийг бүр 2, 3 жилийн дараа цуцалж байгаа байхгүй юу? Тэгээд иймэрхүү асуудлуудыг хэрхэн яаж зохицуулж байгаа юм? Энийг нэг тодруулчихмаар байна. Мөн жил болгон баталдаг төсвийн хууль байдаг юм уу хөгжлийн төлөвлөгөө байдаг юм уу? Энэ хуулиудыг дагаж орж ирэх хуулиудын хэм хэмжээг бас нэг тодорхой зааж өгөхгүй бол Төсвийн хууль орж ирж байхад Засгийн газрын бүтэц орж ирдэг янз янзын асуудлууд их орж ирдэг. Магадгүй Төсвийн хууль орж ирж байхад зөвхөн Татварын хуулийг хөндөнө ч гэдэг юм уу нэг иймэрхүү гаргалгаанууд дээрээ хэр ажилласан бэ? Энэ нэг 4 асуулт дээрээ нэг тодруулчихаад дахиад тодруулж болзошгүй ээ.

Д.Амарбаясгалан: Цогтбаатар гишүүн хариулт өгье.

Д.Цогтбаатар: Энэ дээр яагаад яг энэ хууль дээр орж ирж байгаа гэхээр энэ хууль нөгөө өөрөө Хууль тогтоомжийн тухай хууль болохоор хууль боловсруулж байх үед энэ захиргааны актуудын асуудал ямар хэмжээнд орж байна бид нар яг тэр хэмжээнд нь л ерөөсөө явж байгаа юм. Тэгээд хамгийн гол нь энэ чинь нөгөө Хууль тогтоомжийн хууль болохлоор хуулиар юуг зохицуулах вэ, хуулиар юуг зохицуулах вэ гэдгийгээ бид нар тодотгож өгөхгүй бол нөгөө өөрөө сая ярьж байна шүү дээ. 800 хэдэн журам хуулиар хуулиас өөр юмаар зохицуулж болохгүй харьцаануудыг зохицуулчихсан байж байгаа байхгүй юу. Та ч тэрийг мэдээгүй. Тэнд зүгээр дунд шатын дарга нар өөрсдөдөө эрх олгоод шийдчихсэн тийм журмууд чинь яваад байна шүү дээ. Тэгэхээр өөрийн эрхгүй энэ хуулийг ярьж байхад тэр хэн хэмжээндээ орж ирсэн тэр хэмжээнд нь л бид нар оруулж өгч байгаа. Энэ тэгээд байгаа хуулиудтайгаа нийцэж байгаа тэр хуулиуд дээрээ суурилж оруулж ирж байгаа байхгүй юу. 850 хуулийн хор уршгийн талаар гэвэл манайхан энэ дээр хариулна биз. Би зүгээр танд хамгийн энгийн л жишээ энэ авлигатай тэмцэх юу чинь олон улсын рейтинг чинь Трансперенси интернэйшнлийнх арагшаа явчихсан байгаа биз? Шууд нөлөөний. Яагаад гэвэл ямар ч хуулиар заагдаагүй эрхийг дарга нар доороо авчихсан. Тэгээд тэнд чинь жинхэнэ авлига хүнд суртлын өөрөөр хэлбэл хүнд суртлыг үүсгэнэ хүнд суртал нь өөрөө авлига өгөх зайлшгүй шаардлагыг бий болгочхож байгаа байхгүй юу.

Тийм учраас би зүгээр шууд одоо хариулахад бол жишээлбэл энэ индекс бол яг энэний үр дагавар. Зөвшөөрлийн энэ хууль та түрүүн ярьж байна. Яг таны энэ та Зөвшөөрлийн хуулийг гаргахдаа аль болох л энэ хүнд суртлыг цөөлөх гээд байна шүү дээ. Тэгэхээр хүнд суртлын цөөлнө гэхэд ганцхан Зөвшөөрлийн хуулиар шийдэхгүй байгаа байхгүй юу. Энэ нийгэмд чинь өчнөөн олон өөр харьцаа, энэ Захиргааны хуулиуд, өшөө бид нар хүнд суртлыг шийдэхийн тулд Төсвийн хууль, төрийн өмчит ААН-үүдийн тухай хууль гээд зөндөө юм хийж байж энэ шийдэгдэнэ.

Тэгэхгүй бол нэг хуулиар энэ нийгмийн ийм том асуудал шийдэгдэхгүй. Энэ тэгэхдээ хувь нэмрээ оруулна. Яагаад гэвэл нөгөө хүнд суртлын аппаратыг чинь шалгуурыг нь өндөрсгөж өгөөд хүнд сурталтнуудын амьдралыг хүнд сурталтай болгож өгч байгаа байхгүй юу. Тэгж байж л энийг юу арай иргэдэд очих ачааллыг хөнгөлөх тийм зорилго байгаа юм. Тэр төсвийг дагаж орж ирж байгаа хуулиуд аягүй удаж байж та түрүүн тэр Зөвшөөрлийн хууль дээр ч гэсэн өөр юу өөрчлөгдөж байна гээд. Яг үнэн ийм хэцүү байхгүй юу. Одоо энийг хийгээд ч бид нар зүгээр орхичихвол өөрчлөгдөхгүй шүү дээ. Яагаад гэвэл дунд шатын албан тушаалтнуудад ашиггүй байхгүй юу.

Тийм учраас 2025 оны энэ хуулийг дагаад нэг орж ирж байгаа юу чинь Засгийн газар 2025 оны намрын чуулганд багтаад билүү юу тайлан тавих ёстой энүүгээр, энэ зөвшөөрлийн.

Д.Амарбаясгалан: Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: Нөгөө юун дээрээ танаас хариу авч чадсангүй. Захиргааны ерөнхий хуулийн санаачлагчаас яагаад Засгийн газраас санаачилж байж болохыг хассан бэ гэдэг л тайлбарыг авчихмаар байна. Тэрэн дээр ямар шалтгаан байна?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 10 дугаар микрофон Отгончимэг зөвлөх хариулт өгье.

Н.Отгончимэг: Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч хэд хэдэн хуулийн төслийг санаачилж болохгүйгээр оруулсан байдаг Улсын Их Хурлын тухай хууль болон Хууль тогтоомжийн хуульд энэ бол эрүү, иргэн, захиргааны хуулийн шинэчилсэн найруулга анхдагч хууль байвал санаачилж болохгүй гэж түүнчлэн өмчтэй холбоотой хуулийг мөн шинэчилсэн найруулга анхдагч хуулийг санаачилж болохгүй гэж ийм хязгаарлалттай. Энэ хязгаарлалтаас 2-ыг нь бол больж байгаа. Тэр нь бол захиргааны эрх зүйн салбарын хууль байж байгаа. Ажлын хэсэг дээр ярьж байгаа захиргааны эрх зүй бол өөрөө нийтийн эрх зүйн харилцаа юм аа.

Энэ бол захирах захирагдах шинжтэй байдаг ийм зарчмын өөр харилцаа байна. Энийг бол ганцхан Засгийн газарт энэ хуулийг боловсронгуй болгох сайжруулах асуудлыг нь өгчхөж болохгүй юм байна. Тэгэхээр энийг тухайлбал Захиргааны ерөнхий хуулийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгох энэ анхдагч болон шинэчилсэн найруулгыг бол Улсын Их Хурлын гишүүн нь ч, Ерөнхийлөгч нь ч эдлэх ийм боломжтой юм байна гэдэг үндсэн дээрээс харилцааных нь онцлогоос хамаарч ингэж нээж өгч байгаа.

Д.Амарбаясгалан: Ганхуяг гишүүний асуултад яах вэ би зүгээр нэг санаа хэлэх гэсэн юм. Санаа ч юу байх вэ. Үндсэн хуулиараа хууль тогтоох байгууллага нь Их хурал. Хууль тогтоогч нь Их Хурлын гишүүд байж байгаа шүү дээ. Гэтэл энэ захиргааны хэм хэмжээг чинь бүх түвшинд энэ эрхийг нь давуулж анхан болон дунд шатад аваачиж хүний эрхийн зөрчил үүсгэх нөхцөлүүдийг гаргаад байгаа учраас гэж байгаа юм. Тэгээд тэр өндөр хөгжилтэй улс орнуудын жишгийг аваад үзэхэд ч гэсэн яагаад авлига эрс багасдаг, яавал энэ хүнд суртал арилдаг вэ гэдэг асуудал нь яг л энэ журамтай холбоотой, хуулийн хэрэгжилттэй холбоотой, энэ 2-ын зохистой харьцаатай холбоотой асуудал үүсээд байгаа юм.

Манай нэг сул тал бол хууль нь иж бүрэн зохицуулалтаа өөрөө бүрэн хийж чадахгүй байгаад байна, сул байна гэдэг зүйл ойлгогдож байна шүү дээ. Түрүүн Ариунзаяа гишүүн яагаад хууль хэрэгжихгүй байна гэж асуугаад байгаа юм. Хууль хэт ерөнхий учраас хэрэгжихэд хүндрэл үүсэж байна. Орон нутгаар яваад ард иргэддээ энэ хуулийн талын хэлэлцүүлгүүдийг хийгээд яриад үзэхээр хуулиа ер нь ойлгохгүй байгаад байгаа юм. Хэт ерөнхий учраас тэрийг яаж хэрэглэхээ мэдэхгүй байгаад байна. Тэгэхээр эдгээр асуудлуудыг нь илүү нарийвчилж, хүндээ ээлтэй, үзэл баримтлалтай тийм хууль болгох нь зөв юм гэж харж байгаа юм. Ахиад одоо Улсын Их Хурлын гишүүн эс үгүй бол Засгийн газар 2-ын хууль санаачлахтай холбоотой 2 ийм үзэл баримтлал дээр том ялгаа гарч ирж байгаа юм. Засгийн

газраас боловсруулж орж ирж баригдаж байгаа хуулиудын дийлэнх нь мэдээж хэрэг төрийн ажлыг явуулах зорилготойгоор.

Улсын Их Хурлын гишүүдийн санаачилж байгаа хууль нь үзэл баримтлалын хүрээнд илүү их хүний эрхийг хамгаалах чиглэл рүү чиглэж болж байгаа юм. Тэгэхээр энэ бүгд дээр энэ Улсын Их Хурлын гишүүн их хэмжээгээр хууль санаачлах эрхээ хязгаарлуулчихсан байгаа энэ тэр нөхцөл бол хүнд байна аа.

Тэгэхээр Улсын Их Хурал Улсын Их Хурлын гишүүд энэ хүний эрхийг хамгаалсан үзэл баримтлалтай хуулийн орчныг бий болгож өгье. Хууль нь өөрөө иж бүрэн зохицуулалтаа хийж чаддаг болгоё. Тэгэхгүйгээр Улсын Их Хурал дээр нэг ёсондоо бол жоохон залхуурах маягтай байна шүү дээ. Хуулиа хэлэлцэж байгаад л жоохон нарийвчилсан зохицуулалт ороод ирэхээр тусгай журмаар зохицуулна гэж заачхаад яваад байдаг. Энэ харилцаа чинь өөрөө нийгэмд хүнд суртлын нөгөө авлига авах үндсийг бий болгоод байгаа учраас хууль нарийвчилсан зохицуулалтаа өөрөө хийж чаддаг болъё л гэдэг асуудал.

Ахиад энэ хууль тогтоомжийн хуулиар нэг зүйлийг хийж өгч байгаа нь хуулийн цаг хугацааны хоцрогдлыг арилгадаг болъё. Жишээлбэл Өмнөд Солонгос улс 3 жил тутамд хуулийн цаг хугацааны хоцрогдлыг арилгаж байна. Манайх бол хууль тогтоомжийн хуулиар 5 жил тутамд хийж болно гээд заачихсан. Гэтэл өнөөдөр 1997 онд батлагдсан Дампуурлын тухай хууль өнөөдрийг хүртэл шинэчлэгдээгүй байна. 2002 онд батлагдсан Иргэний хууль өнөөдрийг хүртэл шинэчлэгдээгүй байна. 2015 онд батлагдсан Тамхины тухай хууль өнөөдрийг хүртэл шинэчлэгдээгүй.

Ингээд электрон тамхины хэрэглээ чинь тамхи юм уу, электрон бараа юм уу гэдэг ойлголттой болчихсон явж байна. Одоо энэ цахилгаан дугуй скүүтрийн харилцаа. Өнөөдөр авто зам дээр 100км цагийн хурдтай цахилгаан дугуйг насанд хүрээгүй хүүхэд унаад л замын хөдөлгөөнд оролцоод л явж байгаа юм. Аваар осол болбол хэн буруутах вэ. Насанд хүрээгүй учраас тэр дугуйг унаж явсан хүүхэд буруутах юм уу? Эс үгүй бол тэр мөргөсөн жолооч хариуцлага хүлээх юм уу. Яг энэ хууль өөрөө цаг хугацаанаасаа хоцрогдчихсон байгаа нөхцөлөөс чинь болоод л иргэд амь нас, эрүүл мэнд, тиймээ эд хөрөнгө, эрх чөлөө гээд их олон зүйлээрээ хохироод байгаа учраас Хууль тогтоомжийн хууль энийг засъя аа, хууль илүү сайн болъё, нарийвчилсан зохицуулалттай байя, иргэдэд ойлгомжтой байя л гэдэг ийм л үзэл санаан дээр энэ асуудал явагдаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Надад нэг асуулт байна.

Асуултаа асуухаасаа өмнө нэг 2, 3 жишээ хэлэх нь зөв байх. Бид нар ардчилсан нийгмийн хамгийн гол шинжийн нэг бол иргэд. Бодлого шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн санал тусдаг байх, оролцдог байх тэр дундаа утга учиртай хариу үйлдэлтэйгээр оролцдог байх хэрэгтэй.

Бид нар бол иргэдийг оролцуулж байгаа нэртэй, хэлэлцүүлэг хийж байгаа нэртэй, саналыг нь авч байгаа нэртэй ингээд л орхичихдог. Захын нэг хуульч бол үнэхээр энэ хууль тогтоомжийн хуулийн зарим зохицуулалтууд үнэхээр хангалтгүй байна, мэргэжлийн түвшинд боловсруулагдахгүй байна, маш олон судалгаа гарсан шүү дээ.

Тэгээд байхад манай ХЗБХ энэ асуудлыг унагачхаж байгаа нь би хувьдаа жаахан гайхаж байна. Тэгээд яг энэ оролцоотой холбоотой асуулт асууя. Тэгээд одоо жишээ нь хамгийн сүүлд ХАА-н даатгалын тухай анхдагч хуулийн ажлын хэсэг сая байгуулагдсан. Тэгэхдээ бас л нэг зайлшгүй хэрэгцээ шаардлагаар байгуулагдсан. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль орж ирэхдээ малчдыг заавал энэ даатгалд даатгуулсан байх ёстой гэдэг ийм заалт дагалдаж орж ирсэн. Тэгээд гишүүд энийг энэ юу болоод байгаа юм бэ? Яахаараа ингэх ёстой юм бэ? Ер нь энэ даатгалын асуудлыг эргэж харах ёстой юм байна гээд ингээд шинээр ажлын хэсэг байгуулагдсан. Тэгээд ажлын хэсэг байгуулагдаад хамгийн анхны хурлаа хийсэн чинь даатгалын компаниудын эрх ашгийг хамгаалдаг холбоо төрийн бус байгууллагууд ороод ирчихсэн. Нөгөө малчдын төлөөлөл тариаланчдын төлөөлөлд ерөөсөө энэ мэдээлэл очоогүй. Тэгээд бид нар ингээд бодлого шийдвэр гаргахдаа оролцоог нь хангалаа гээд яг нөгөө эрх ашиг нь хөндөгдөөд байгаа хүмүүсийнхээ утга учиртай оролцоог бид нар ерөөсөө хангаж чадахгүй байгаа.

Тэгэхээр энэ бол бид нарын хувьд яг энэ ардчиллыг хамгаалах, бодлого шийдвэр гаргах, энэ иргэдийн өмнө хүлээж байгаа итгэлийн асуудал гээд асар том үнэт зүйлийг агуулах ийм хууль гэж энэ хуулийг харж байгаа. Тийм учраас яг энэ иргэдийн бодит оролцоог хангах тал дээр энэ хуульд ямар ахиц дэвшил гарч байгаа вэ ямар зохицуулалт орж байгаа вэ гэдэг дээр маш тодорхой хариулт хэлээч ээ.

Хоёрдугаарт энэ хүний эрхийн хязгаарлалт гэдгийг манайхан яг нэг өөрийнхөө арьс махан дээр нэг их сайн ойлгохгүй байх шиг байна. Биеийн тамир спортын тухай хууль гэж байгаа. Тэр хууль дээр нэг сонирхолтой заалт байгаа. Спортын тамирчид дасгалжуулагчид бүгдээрээ улс төрийн үзэл баримтлалаа төвийг сахисан байдлаар төвийг сахисан улс төрийн үзэл баримтлалаа илэрхийлнэ гэж байгаа. Улс төрийн үзэл баримтлал төвийг сахина гээд заалт байгаа. Тэгээд одоо нөгөө боксчин бөх бүгдээрээ улс төрийн үзэл баримтлалаа илэрхийлэхгүй юм байна л даа. Энэ чинь өөрөө хүний улс төрийн эрхийн хязгаарлалт байхгүй юу даа.

Тэгэхээр хуульд ийм заалт орж ирж байгаа чинь өөрөө ардчиллын хамгийн том аюул. Тэгэхээр ийм заалтууд орж ирэхээс хамгаалж мэргэжлийн институтууд орж ирэх энэ үүд хаалгыг энэ хууль нээж байгаа. ХЭҮК энэ дээр дүгнэлт гаргадаг байгаач. УЕП дүгнэлт гаргадаг байгаач ээ. Улсын дээд шүүх дүгнэлт гаргадаг байгаач ээ. Энэ хууль тогтоомжийн хүний эрх хязгаарлаад байгаа заалтууд болж байна уу, болохгүй байна уу? Процессын энэ ажиллагаанд энэ мэргэжлийн байгууллагууд нь орж ирээд энэ хүний эрхтэй холбоотой дүгнэлт гаргадаг болооч гэдэг ийм заалтууд орж ирээд байгаа юм.

Тэгэхээр энэ мэт асуудал чинь өөрөө энэ ардчилалд хамгийн чухал ийм амин сүнс ийм асуултууд байгаа. Тэгэхээр яг энэ иргэдийн оролцоон дээр маш тодорхой хариултыг ажлын хэсгийнхэн хэлээч. Яг утга учиртай жинхэнэ оролцоог хангасан ийм заалтууд орж ирж чадаж байгаа юу? Одоо цаашид хууль санаачлагчид хэлбэрийн төдий байх энэ зүйлийг бид нар хааж чадах уу гэдэг ийм асуулт асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Дамдины Цогтбаатар гишүүн хариулт өгье.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүн яг энэ асуудлуудыг л шийдэх гэж энэ хууль дээр ажлын хэсэг ажилласан. Одоо жишээлбэл өнөөдөр ингээд хууль өргөн барьж байхад нээрээ энэ хэлэлцүүлгийн аягүй олон юм чинь хэлэлцүүлсэн гэдэг

тиктэй. Тийм, тэгээд л болоо. Онлайнд тавилаа, тэгээд л тэнд респонс байсан уу, үгүй юу, тэрийгээ сурталчлахгүй. Тэгээд дараа нь яасан юм, тавьсан шүү дээ гээд нөгөө тавьсан тавьсан хүн нь тэнд нэг их орж хүмүүс интеракшин хийсэн юм эд нар байхгүй ингээд л нэг шалгуур даваад л явчхаж байгаа байхгүй юу. Одоо энэ чинь бүүр яг бодит уулзалтууд хүмүүстэй хийх ёстой. Манайхан энэ дээрээ нэмээд өгөөрэй. Ийм ийм заалтууд орж байгаа. Эс үгүй бол зарим заалт дээр бүүр яг эрх ашиг нь хөндөгдөж байгаа тэр юу тоглогчдын саналыг заавал тусгасан байх ёстой.

Энэ нөгөө бүрдүүлбэр хэсэгт чинь тэгэхгүй бол хүлээж авахгүй болчхоод байна шүү дээ. Нөгөө тикүүд чинь бүгд бүрдэж байж л юу Их Хурал хүлээж авах юм чинь тэр нь жишээлбэл хүлээж авагдахгүй болчхож байна гэдэг чинь тэрийгээ заавал хийж байж л орж ирэхгүй болохгүй болж байна гэсэн үг. Өшөө яг өөрийн чинь саяын хэлдэг энд нөгөө яагаад хүний эрхийн асуудлыг энд тусгаж өгөөд байна гэхлээр Спортын хууль дээр яг ийм заалт дээр байж л байгаа байхгүй юу. Тэгээд манай энэ хэд өө ёстой ямар ч асуудалгүй хүний эрхийн хууль аягүй ойлгомжтой, үгүй хүмүүс чинь хүний эрхийг зөрчиж байгаагаа мэдэхгүй тэр хуульд парламентаар орж ирээд бүүр батлагдаад гараад явчихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм юмнуудыг чинь л тэр хүний эрхийн шалгуур үзүүлэлтүүдийг заавал давдаг байхын тулд прокуророос, шүүхээс, хүний эрхийн комиссоос заавал дээр нь нөгөө дүгнэлт энэ авдаг болохоор оруулж байгаа. Өөр нэг энд нэг заалт одоо юу байж байгаа юм. Одоо энд хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх, 18.1.2 шиг үйлчлэх хүрээнд хамрах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагааны үүсэх зардлыг тооцох.

Энэ бол аягүй эерэг. Өөрөөр хэлбэл тэр өөрийнхөө л мөнгийг төсөвт яаж нөлөөлөх вэ гээд иргэдийн амьдралын мөнгө тэнд ямар ачаалал очих хэнд ч сонин биш байгаад байдаг байсан бол одоо иргэдэд ямар зардал наадах чинь гарах юм бэ гэдэг юу заавал орж байгаа. Өөрөөр хэлбэл тэр төсвийн үр нөлөө заавал орж байгаагийн хажуугаар таны гаргасан шийдвэр иргэнд яаж нөлөөлөх гээд байна. Та тэр төсөөллийг гаргаж ир гэдэг шалгуурыг энд оруулаад ирчихсэн байж байгаа 18.1.2.

Тэгээд манай ажлын хэсгийнхэн нэмээд хариулна биз.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон Алтангэрэл зөвлөх хариулъя.

Т.Алтангэрэл: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр манай Үндсэн хуулийн язгуур үзэл баримтлал бол хүний эрхийг хамгаалах, хүний эрхийг дээдлэх, эрхэмлэх ийм суурь үзэл баримтлалтай байгаа. Тэгэхээр энэ үзэл баримтлал нь өөрөө хууль боловсруулах үйл ажиллагаанд яаж хэрхэн хэрэгжих вэ гэдэг талаас нь энэ Хууль тогтоомжийн тухай хууль бол үндсэндээ шинэчлэлт нь хийгдсэн гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл анх удаа аливаа хуулийг боловсруулахдаа ямар арга зүйгээр хүний эрхэд нөлөөлөх байдлыг нь авч үзэх юм бэ гэдэг талаараа энэ хуульдаа энэ арга зүйг нь нарийвчилж тусгаж өгч байгаагаараа энэ хууль зөвхөн Монгол Улсад төдийгүй, дэлхийтэй шинэлэг, ийм зохицуулалтын хувьд зохицуулалт юм гэж үзэж байгаа. Яагаад гэхээр энэ судалгааг одоо энэ хуулийн боловсруулалтыг хийж байхад бид нар олон улсын туршлагыг харж байсан. Тэгээд яг энэ хуульдаа тусгаж хууль болгоны төслийг урьдчилсан байдлаар хүний эрхийг зөрч бичиж байна уу? Үгүй юу.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Т.Алтангэрэл: Хязгаарлалт байна уу, үгүй юу. Хэрвээ хүний эрхийг хязгаарлах зайлшгүй шаардлагатай нөхцөлд тэр нь тохирсон хамгийн бага хэлбэрээр байна уу, үгүй юу гэдэг шалгуурыг хуулийн төсөл болгонд ингэж заалт бүрээр нь хянах ийм нөхцөл шинээр бий болж байгаа. Энүүгээрээ энэ хууль маш шинэлэг ийм зохицуулалт гэж хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Энэ маш чухал сэдэв хөндчихөж байгаа юм. Нөгөө түрүүн Ариунзаяа гишүүн асуугаад байсан шүү дээ. Хууль яагаад бүрэн хэрэгжихгүй байна вэ гэж. Тэгэхээр нөгөө хуулиа гаргахдаа эрх ашиг нь хөндөгдөж байгаа бүх талын оролцоог хангаагүй учраас хууль өөрөө амьдралд нийцэхгүй байгаад байгаа тал үүсэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хууль тогтоомжийн хууль батлагдсанаараа бүх эрх ашиг нь хөндөгдөж байгаа талуудын оролцоог хангасан хэлэлцүүлгийг зохион байгуулах. Сая Цогтбаатар гишүүн хэлж байна. Тэр битгий хэл тэр салбарыг төлөөлж байгаа мэргэжлийн төрийн бус байгууллагууд нь өөрсдийн саналыг чөлөөтэй илэрхийлэх, оролцоогоо бүрэн хангах, дээрээс нь олон нийтэд ил тод байх хэлэлцүүлгийн бүх шатад нь бүх талын оролцоо бүрэн хангагдаж байх гэдэг ийм шаардлагуудад тавигдаад ирэхээрээ энэ хууль бол илүү чанартай болно гэж. Мэдээж өргөн барих процесс бол жоохон хүндэрнэ. Гэхдээ бид энэ нийгмийн харилцааг зохицуулах гэж байгаа энэ чухал зүйлийг илүү өргөн хүрээний хэлэлцүүлэгтэй магадгүй тодорхой хүнд сурталтайгаар процесст дамжуулж байж хэлэлцэж баталж чаддаг л болчихвол Монголын хууль чанартай болно оо, хууль нь хэрэгждэг болно оо л гэж байгаа юм.

Одоо Засгийн газар дээр ч гэсэн энэ асуудал байнга хөндөгддөг шүү дээ. Нөгөө төрийн бодлого шийдвэр тогтворгүй байна. Нэг өглөө босоод ирэхэд нэг асуудал шийдэгдчихдэг. Нэг өглөө босоод ирэхэд нэг бодлого өөрчлөгдчихдөг. Энэнээс болоод Монголчуудад нэг том зовлон биш шүү дээ. Урт хугацаанд ажил амьдралаа төлөвлөж чаддаггүй. Бизнес хийе нөгөөдхийгөө 10 жил, 5 жилээр бодож төлөвлөх ямар ч боломжгүй.

Одоо хамгийн сүүлийн жишээ байна шүү дээ. Махны экспортыг өмнөх жил нээгээд л энэ жил хаагаад л явчхаж байгаа жишээ байхгүй юу? Тэгэхээр чинь нөгөө бизнес хийж байгаа, худалдаж байгаа, худалдан авч байгаа тал ажлаа урт хугацаанд төлөвлөх ямар ч боломжгүй нөхцөлөөр л хангаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид илүү чанартай хуультай болох энэ зорилго руугаа энэ өөрчлөлт орж ирж байгаа гэж ингэж тайлбарлая.

Би бас нөгөө энэ ажлын хэсгийн хуралд их оролцсон учраас зарим нэмэлт хариулт өгөөд байгаа шүү зөв ойлгоорой. Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя. Баярлалаа.

Ж.Батжаргал: Энэ хууль өөрөө нэлээн ач холбогдолтой гол хууль л даа.

Улсын Их Хурал үнэхээрийн л хууль тогтоох эрх мэдлийг хадгалдаг юм бол Улсын Их Хурлаар хэлэлцэгдэх гэж байгаа хуулийн төслийн боловсруулалтад тавигдах шаардлага нэг үгээр хэлбэл, стандарт, техникийн зохицуулалтыг нь зааж өгсөн хууль байхгүй юу. Тийм учраас энэ хуульд бид нэлээн их ач холбогдол өгч

энийг илүү боловсронгуй болгох ёстой би зүгээр үзэл баримтлалынх нь хувьд дэмжээд хэлэлцүүлгийн түвшинд илүү сайжруулж гаргах талаас нь анхаарах ёстой юм болов уу гэсэн ийм бодол байна.

Хуулийн төслийг дагуулж тодорхой хуулийн төслүүд өргөн барьдаг. Тэрэнд гажиг бий юу гэвэл бий. Угтаа үзэл баримтлалд нь нийцэж гарах ёстой хуулийн төслийг дагуулаад өнөө малгай хуулийнх нь өөрчлөлтийг өргөн барьчихдаг байхгүй юу. Одоо төсөв дээр их тодорхой харагддаг. Төсвийн тусгай шаардлага буюу төсвийн хүрээний мэдэгдлээ төсвөө дагуулаад өргөн барьчихдаг нэг ийм гажиг асуудал үүсдэг. Дээр нь анхдагч гэдэг юм уу шинэчилсэн найруулга дагуулаад өргөн барьчихсан юмнууд байдаг.

Тэгэхээр энийг бид хаах ёстой. Зөвхөн тэр нэг төсвийн, тухайн жилийн төсөв, төсвийн тодотголыг дагуулж өргөн барьж байгаа хууль нь зөвхөн төсөв санхүүгийн харилцаа зохицуулна гэдгээр энэ хаагдахгүй. Тийм учраас энийг бид хэлэлцүүлгийн түвшинд нэлээн онцгой анхаарч энэ гажгийг засах талаас нь бодох ёстой юм гэж хэлмээр байна.

Энэ тал дээр ямар бодол байна гэж.

Хоёр дахь зүйл захиргааны хэм хэмжээ тогтоох эрх олгохдоо ийм зүйлийг хангасан байна, ийм зүйлийг тусгахгүй байна гээд 27 дээр хэдүүлээ оруулжээ. тэгээд тэр 27.2 дээр нь татвар хураамж төлбөртэй холбоотой юм ороод ирж байгаа юм аа. Бид бүхэн чинь бол нэгдсэн улс. Татвар төсвийн бодлого нэгдсэн байна гэж хэлээд Ерөнхий хууль, Татварын ерөнхий хуульд ороогүй татварын нэр төрөл гаргахыг хориглочихсон юм. Зөвхөн олгосон эрх хэмжээ дотор хязгаар дотор багтааж тогтоох эрхийг нь нутгийн өөрөө удирдах байгууллага холбогдох байгууллагуудад өгдөг юм аа. Гэтэл бид хэдийн энд орчхоод байгаа чинь тэрийгээ давхар хаачаад байгаа юм шиг ийм заалт болчихжээ. Үгүй ээ уншаад үзэхээр тийм юм харагдаад болж өгөхгүй байна. Тэгэхээр энийг зөв талаас нь харах ёстой энэ дээр ямар байр суурь байна вэ гэж.

Гурав дахь зүйл. Захиргааны хэмжээ тогтоох эрх олгож болно. Бүгдийг хуулиар зохицуулж чадахгүй. Яг үнэнийг хэлэхэд. Амьдрал өөрөө үргэлжилж л байгаа бол дандаа шинэ юмтай гэдэг юм уу нүүр тулж байдаг. Тэр болгоныг зөв зохицуулахад бид нар энэ хууль тогтоомж гэдэг хэллэгээрээ буюу дүрмийн засаг гэдэг хэллэгээрээ явагдах ёстой. Тэгэхээр нэгдсэн сан гэж байна аа тэр захиргааны хэмжээ тогтоосон актуудыг бүртгэдэг. Тэрийг манай Хууль зүйн яам өөрийнхөө онцгой мэдэлд нь байлгаж авч байгаа. Тэнд хуулиас давтсан журам яагаад бүртгээд байгаа юм бэ? Яагаад тэнд энэ юмнуудыг журмуудыг бүртгүүлэхгүй байгаа юм бэ? Хэрэвзээ бүртгүүлээгүй бол түүнээс гарах хохирол, үр дагаврыг тухайн гаргасан нөхөр хариуцахаар ийм юутай шүү. Тэгэхээр энэ дээр одоо харин энэ байгууллагуудаа чангатгах талын юмыг давхар хэдүүлээ яаж бодох ёстой юм бэ?

Д.Амарбаясгалан: Батжаргал гишүүнд нэг минут нэмж өгье.

Ж.Батжаргал: Бодох ёстой гэж. Дараагийн нэг миний хэлмээр байгаа санаа. Дагуулаад авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоол санаачилсан байна. 1.2 дахь заалтаараа 2025 оны намрын чуулганаас өмнө тэр 27-д заагдсан шалгуур шаардлагыг хангуулж, хуулиудын нэмэлт, өөрчлөлтийг оруулж ир гээд хэлчихжээ.

Ер нь хэчнээн хууль энүүгээр өөрчлөлт орж ирнэ гэж тооцоологдсон юм байна уу, амжих юм уу? Энэ чинь ер нь нэлээн өргөн ажил болох юм биш үү гэсэн ийм бодол байна. Энэ дээр ямар юм байна вэ гэж.

Дараагийн нэг гол зүйл бол энэ хууль нийгэм, эдийн засгийнхаа амьдралыг урагшлуулдаг нийцсэн байх тухай л ойлголт л доо. Тэгэхээр хууль амьдралд хэрхэн нийцэж байна гэдэг дээр үнэлгээ хийдэг тухай асуудал. Бид хяналт шинжилгээ үнэлгээг 5 жил тутамд хийхээр орсон боловч энэ олигтой явж өгөхгүй байгаад байгаа юм аа. Энэ биелэлтийг нь гаргаад байгаа байгууллагууд энэ хууль амьдралд ингэж нийцэж байна.

Д.Амарбаясгалан: Цогтбаатар гишүүн хариулт өгье.

Д.Цогтбаатар: Батжаргал гишүүний ярьж байгаа юунуудтай санал нэг байна. Тэгээд энэ үнэхээр энэ хууль боловсруулах стандартыг л боловсруулж байгаа. Тэгээд энэ маань өөрөө сайн байж байж дараа нь хууль чанартай гарах тухай асуудал яригдана. Эцсийн дүндээ энэ чинь энд ингээд л батлагдаад л гараад л 3 сая хүний аж амьдралыг зохицуулаад эхэлж байгаа тэр дүрмүүдийг тэр нормуудыг л бид нар шингээсэн хуулийг энд гаргаад байгаа болохлоор энэ анхдагч стандарт үнэхээр сайн байх ёстой. Энэ дээр бол би тантай санал нэг байна. Тэгэх гэж л энийг уг нь оруулж ирж байгаа юм. Нэмэлт өөрчлөлтийг. Тэгж оруулж ирэхдээ угаасаа Үндсэн хуульд хүн төвтэй гэж байгаа болохлоор тэр нөгөө хүний эрхэд илүү нийцүүлэх гээд л оруулж ирээд байгаа юм л даа.

Энэ төсвийг дагах хуульд нээрээ дагуулаад одоо бол энэ энд орж ирж байгаа нь нөгөө анхдагч хууль эд нар оруулаад ирдгийг чинь л болиулах гээд. Одоо төсвийг дагаж орж ирж байгаа бол тэр төсвийн өөрчлөлттэйгөө л холбоотой юм. Түүнээс хуулийн бүүр үзэл агуулгыг юм уу эс үгүй бол анхдагч хууль оруулаад ирж болохгүй гэдэг энэ юуг санааг л энэ хуульдаа тусгаж өгч байгаа юм. Таны тэр түрүүн нөгөө татварын юун дээр та яг орон нутагт ажиллаж байсан хүн. Одоо энд чинь Батжаргал гишүүнээ ингэж яаж байгаа шүү дээ. Ер нь яг хуульд байгаа юмнуудаа л энэ чинь нөгөө бусад хуулиа өөрчилж чадахгүй. Тодотгогдож л өгч байгаа юм. Юу гэвэл захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх олгох олгосон хуулийн төслийн зохицуулалт тавигдах шаардлага гээд. Энэ дээрээ тэгэхээр захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх олгоно гэдэг чинь нэг этгээд эрхтэй байгаад, тэр эрхээ дамжуулах гээд байна шүү дээ.

Тэр эрхтэй этгээд чинь аль хэдийн Үндсэн хууль юугаараа засаг захиргааны нэгжийн хуулиараа орон нутгийн юу иргэдийн төлөөлөгчдийн хурал чинь энэ эрх нь аль хэдийн авчихсан байж байгаа байхгүй юу. Харин энэнийхээ хүрээнд аливаа нэгэн энэ татвар, хураамжтай холбоотой ийм шийдвэр гаргаж байгаа бол хамтын тэр байгууллагаасаа нөгөө хүн рүү шилжүүлэхгүй шүү. Тэр чинь өнөөдөр хуулийнхаа дагуу та нар өөрсдөө л гаргана шүү. Тэрийг хэрэгжүүлэх тэр журам юмнуудаа гаргаж болно. Түүнээс та өөрөө сая хэлж байна шүү дээ. Жишээлбэл татвар гэдэг чинь төрийн бүрэн эрхийн асуудал. Энэ татварын өөр хэлбэрийг орлогын албан татвар юм уу, юу нэмэгдсэн өртгийн албан татвар эд нарыг чинь Улсын Их Хурал тогтооно уу гэхээс угаасаа хуулиар өөр хэн ч тогтоож болохгүй. Тэгээд тэр юмнуудыг л энд илүү тодотгоод заагаад өгчихсөн байгаад байгаа юм аа. Харамсалтай нь бид нар хэчнээн ийм хуультай ч цаана чинь зөндөө тэр хуулиуд гараад ямар сайндаа журам хүртэл Засгийн газрын журам очоод шүүх дээр очоод

ялагдсан байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энийг л бид нар юу тусгая гээд байгаа юм.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Энэ нөгөө хуулийг яагаад бүртгэж аваад байгаа юм бэ гээд бүртгэж авч болохгүй шүү дээ. Тэр хэм хэмжээ давсан хуулийг нээрээ л бүртгэж авч болохгүй. Тэгээд одоо хэдүүлээ төрдөө итгэе л дээ. Хууль зүйн яам бүртгэж авахгүй байгаа учраас л цаанаа 800 хэдэн бүртгэгдээгүй дүрэм журам явж гарч ирж байгаа байх гэж би бодож байгаа. Яагаад гэвэл Хууль зүйн яамыг бүртгэхгүйг мэдээд тийм журмаа гаргачихсан амьдрал дээрээ мөрдөөд хэрэгжүүлээд яваад байна л гэсэн үг л дээ.

Тэгэхээр одоо харин энэ таны нөгөө нэг асуудал. Одоо энэ хууль гарснаар тэр 2025 оны намрын чуулган гэхэд оруулж ирэх ёстой гэж байгаа. Амжуулах гээд л үзэх ёстой байх. Тэгэхдээ нээрээ л таны хэлж байгаагаар 800 хэдэн журам хүчингүй болгоход цаана хэчнээн хуульд асуудал гарах вэ? Энэ бол өөрөө том асуудал шүү энийгээ бол хэлэлцүүлгийн явцад та ч гэсэн саналаа хэлээрэй. Хэдүүлээ энийгээ бодитоор харах нь зөв байх.

Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Г.Агар-Эрдэнэ: Батжаргал гишүүний асуултад зарим статистик мэдээлэл нэмж өгье. Одоогоор бид нарт ХЗДХЯ-аас ирүүлсэн мэдээллээр бол эрх олгосон заалт бүхий хууль 315, мөн хуулиар эрх олгосон заалт бол 2403 байна гэдэг ийм мэдээлэл өгсөн байгаа. Ингээд ХЗДХЯ-ан дээр яг улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний акт бол өнгөрсөн 2024 онд 2560 гар байсан бол одоо энэ оны 2 дугаар сарын байдлаар бол энэ тоо нэмэгдсэн байгаа. 2868 гэсэн ийм тоо байгаа. Энэ дотроо сайдын тушаал, Засаг даргын захирамж, ИТХ-ын шийдвэр Улсын Их Хурлаас томилогдсон байгууллагын удирдлагын шийдвэр гэх мэтээр эрх олгогдсон субъектүүдийн баталсан хэм хэмжээний актын тоо бол ийм байдалтай байна гэж гарсан байгаа.

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Өдрийн мэнд. Энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үзэл баримтлалынх нь хувьд дэмжиж байгаа юм аа. Яг энэ Үндсэн хуулийн суурь суурь зарчим, хүний эрх, эрх чөлөө, Үндсэн хуулиар олгогдсон эрхийг ингээд хангуулж дараа дараагийн хууль тогтоомжууд боловсруулагдаж гарах ёстой. Ингээд энийг бол дэмжиж байгаа. Тэгэхдээ дотроос нь нэг ганц нэг асуулт асуучихмаар байгаа юм. Хууль санаачлагч сууж байгаа болохоор 41.4 дээр Улсын Их Хурлын Тамгын газрын судалгааны хүрээлэнгээс хууль, тогтоомжийн төслийг хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж дүгнэлт гаргана гэж байгаа юм.

Тэгэхээр энэ манай Их Хурал чинь өөрөө бас ХЗБХ-той, Хүний эрхийн дэд хороотой байдаг. Тэгэхээр энэ ер нь зарчмын юу зөв юм уу буруу юм уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт ер нь энэ манай энэ Тамгын газрынхан судалгааны хүрээлэнгийнхэн яг тэр танилцуулга, материал судалгаагаар нь хангаж өгөөд тэгээд Хүний эрхийн дэд хороо нь хурлаа хийгээд тэгээд тэрэн дээрээс дүгнэлт боловсруулбал яадаг юм? Энэ дээр би Цогтбаатар даргаас асуулт асуучихъя гэж

бодож байгаа юм. Энэ дээр ямар судалгаа хийж ямар үндэслэлээр энэ заалтыг оруулж ирсэн юм бэ? Нэгд.

Бид түрүүн бас Их Хурлын Тамгын газартай холбоотой олон юман дээр дүгнэлт гаргаад ирэхээр сүүлдээ нөгөө дүгнэх субъектүүд нэмэгдээд байх тусам асуудал ингээд Их Хурлын гишүүдэд хүртэл мэдээллүүд их зөрөөтэй орж ирээд байгаа ийм хандлагууд гарч ирээд байгаа юм. Тэгэхээр энэн дээр ер нь ямар үндэслэлээр энэ заалтыг оруулж ирсэн юм бэ? Яагаад гэвэл энэ чинь мэргэжлийн чиг үүргийн Байнгын хороо байна.

Дээрээс нь Хүний эрхийн дэд хороо байна. Эндээс дүгнэлт гараад оруулж ирэх бололцоо байсан уу, байгаагүй юу.

Д.Амарбаясгалан: Энэ Очирбат гишүүн энэ юм хэллээ. Нэг нь хуулийн төслийг өргөн барих процесс дээр хийгдэж байгаа зүйл. Хүний эрхийн зөрчил үүсгэж байгаа эсэх дээр үнэлгээ өгөх асуудал. Таны ярьж байгаа бол хуулийн төсөл өргөн баригдаад Улсын Их Хуралд орж ирээд Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо гээд яг дотоод нөгөө бүтцийн дагуу явах процесс. Ийм ялгаа байгаад байгаа юм. Цогтбаатар дарга нэмж хариулах уу? Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Энэ дээр нэг ач холбогдол нь ийм байгаа юм аа, гишүүн ээ нөгөө ХЗБХ, Хүний эрхийн дэд хороо чинь өргөн барьчихсан төслөө өөрсдөө өөрийнхөө хэлэлцэх гэж байгаа юмыг өөрөө судлаад өөрөө өөртөө барих болчихоод байна л даа. Тэгэхээр энийг чинь нөгөө бүрдүүлбэр нь заавал судалгааны академик шинж чанартай судалгаа хийгдэх хэрэгтэй болоод байна шүү дээ. Тэгтэл нөгөө манай Байнгын хороо, Дэд хороо чинь улс төрийн байгууллага байхгүй юу? Бид нар яаж ч хичээгээд тэнд хэчнээн академич суугаад энэ бол улс төрийн л шийдвэр гарна. Тэгтэл энэ хүрээлэнгийн судалгаа чинь бол нөгөө илүү академик чанартай судалгаагаа хийх ёстой. Тийм ч функцтэй төсөвтэй байж байгаа болохлоор ингэж оруулсан байгаа байх гэж би ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Тодруулж асууя Очирбат гишүүн.

Г.Очирбат: Яах вэ зүгээр орж ирээд нэг дүгнэлт боловсруулна гэххээд байгаа юм. Тэгээд дүгнээд Тамгын газар дээрээс өргөн барьсан хуулийн төслүүдийг энэ нь хүний эрхийг хангасан байна, энэ нь хангаагүй байна гээд ингээд нэг ийм юм үүсэх вий дээ. Яагаад гэвэл энэ чинь бүүр заалт болоод ороод ирчихсэн байгаа шүү. Тэгээд дараа нь ярихдаа бид ингээд Тамгын газрын гаргасан дүгнэлт дээр үндэслээд гээд ингээд орж ирж байгаа хуулийн төслүүдийг гацаадаг. Хүний эрхийг хангаагүй байна гэдэг нэг ийм юмнууд болох вий дээ л гэж зүгээр санаа зовж байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү сайд алга байна. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууя.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Би Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг шинэчлэх ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байна. Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсэг. Энэ хүрээнд бол яг одоо байгаа Хууль тогтоомжийн хуулийг маш хатуу мөрдөж ажиллаж байгаа. Тэгээд энэ хууль хууль тогтоомжийн хуулийг ялангуяа Улсын Их Хурлын гишүүн хүн үндсэн үүргээ буюу хууль боловсруулах тэр орчныг бүрдүүлэх.

Түүнээс гадна Улсын Их Хурлаас дэвшүүлсэн иж бүрэн зохицуулалттай, хүний эрхийг дээдэлсэн, цаг хугацаатай нийцсэн, цаг үетэй нийцсэн ийм хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх гэсэн энэ стратегийг биелүүлэхийн тулд энэ хуулийг шинэчлэхээс аргагүй ийм байдалтай байсан гэж ойлгож байгаа. Үүнтэй холбоотойгоор нэг ийм 3 асуултыг асууя гэж бодож байна, 4 асуултыг.

Нэгдүгээрт нь, Улсын Их Хурлын иж бүрэн зохицуулалттай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх гэдэг стратеги зорилтын хүрээнд бол хуулийн бичвэр огцом өөрчлөгдөхөөр ийм дүр төрх харагдаж байгаа. Манай өмнө нь боловсруулж байсан хуулиуд бол ерөнхийдөө маш ерөнхий юм байна лээ. Маш товчхон маш ерөнхий. Үүнээс болоод яаж байна гэхээр нөгөө бодит амьдралд маш олон журам бий болж байгаа.

Тухайлбал манай Эрчим хүчний тухай хууль гээд тэгэхэд ерөөсөө төрийн байгууллагын эрх үүрэг, тусгай зөвшөөрөл, үнэ тариф гэсэн зургаахан бүлэгтэй, арван наймхан хуудастай. Тэгсэн хэр нь дулаан цахилгаан гээд бүхэл бүтэн 2 том салбарын харилцааг зохицуулдаг ийм хууль. Ийм ерөнхий хуультай байснаас болоод өнөөдөр яаж байна гэхээр 800 гаран журмаар энэ 2 салбар харилцаагаа зохицуулж байна. Тэгэхээр энэ журмуудын буруу биш юм аа. Энэ бол яалт ч үгүй амьдралаас ургаад 2 хүн хоорондоо харилцаж л байгаа харилцааныхаа хэм хэмжээг цагаан дээр хараар буулгахаас л аргагүй.

Тэгэхээр хууль дээр нь зохицуулж өгөөгүй болохоор амьдрал дээр энэ олон журам бий болчихоод байна аа. Энэ чинь энэ салбарыг ямар хууль эрх зүйн орчны хувьд тогтворгүй гэдгийг харуулаад байгаа юм. Гэтэл манайхтай яг ижил төстэй өөрөөр хэлбэл хэрэглэгчээ дулаанаар, цахилгаанаар хангах ийм асуудалтай. Казакстан улс, Эстони, Унгар, Дани, Герман гээд энэ улсуудыг нарийвчилж судлаад үзэхэд энэ улсууд бие даасан дулаан цахилгааны хуультай. Дулааны хууль нь гээд тэгэхэд чинь дор хаяж 5-аас 10 бүлэгтэй, 40-өөс 50 хуудастай. Цахилгааны хууль нь гэхэд чинь дор хаяж 10-аас 20 бүлэгтэй 100-аас 200 хуудастай. Өөрөөр хэлбэл энэ орнууд өнөөдөр бид нар журмаар зохицуулаад байгаа тэр харилцааг хуулиараа зохицуулж байна аа. Тэгж байж нөгөө тогтвортой хууль эрх зүйн орчныг бүрдүүлж байна аа.

Тэгэхээр энэ хүрээнд нөгөө бид нарын энэ хаврын чуулганаар өргөн барих гээд байгаа дулааны, цахилгааны хууль маань өмнө нь бичигдэж байсан хуулиудаас маш огцом өөрчлөгдсөн тийм хууль орж ирэх юм. Процессын зохицуулалттай, маш их техникийн зохицуулалттай. Тэгэхээр нөгөө гишүүд маань өмнө нь хэзээ ч уншиж байгаагүй ийм олон хуудастай, ийм нарийн зохицуулалттай юм ороод ирэхээр нөгөө шил нь татаад уначих вий дээ гэж маш их санаа зовж байгаа.

Тийм учраас өөрөөр хэлбэл энэ хуулийг энэ хууль тогтоомжийн хуулийг шинэчлэхдээ өөрөөр хэлбэл хуулийн бичвэр ингэж огцом өөрчлөгдөж байгаа асуудал дээр яаж хуулийн зохицуулалт дээр тусгалд тусгаж орж ирсэн бэ гэдэг 1 дүгээр асуулт байгаа. Энэ бол бид нарын бүүр маш их олон удаа ярихаас аргагүй ийм асуудал байгаад байгаа.

Хоёрдугаар асуудал болохоор ерөнхийдөө энэ хууль дээр шинэчилж байгаа хууль дээр хуулийн хэрэгжилтийн зардлын тооцоо гээд хийдэг. Тэгэхээр энийг одоо Тамгын газар хийнэ гэж заалт орж ирж байгаа юм байна. Тэгэхээр энэ тооцоог хийх чадамж Тамгын газарт байгаа юу? Энэ тооцоог ямар хугацаанд хийх вэ? Ялангуяа

бид нарын боловсруулж байгаа дулаан цахилгааны хууль, ялангуяа Цахилгааны хууль дээр бид нар цахилгаан эрчим хүчний зах зээлийг либералчлах маш нарийн зохицуулалттай ийм хууль оруулж ирэхээр төлөвлөж байгаа юм.

Тэгэхээр нөгөө хэрэгжилтийн зардлын тооцоог гаргахын тулд.

Д.Амарбаясгалан: Нэмэлт нэг минут өгье.

М.Энхцэцэг: Тэгэхээр зардлын тооцоог хийхийн тулд энэ зохицуулалтуудыг нэлээн сайн ойлгох шаардлага үүснэ. Тэгэхээр энэ хугацааг ямар хугацаатай хийх вэ чадамж байгаа юу гэдэг асуулт байна.

Дараагийнх нь болохоор ерөнхийдөө хууль энэ хуучин хуулийн төсөл дээр бол олон нийтээс санал авах гэсэн зохицуулалт байсан. Тэгэхээр энэ хууль дээр болохоор энэ олон нийтийн санал асуух дээр ямар зохицуулалтууд өөрчлөгдөж орж ирсэн бэ гэж. Мөн хуучин Хууль тогтоомжийн хууль дээр хүн хуулиа боловсруулаад дууслаа гэхээр тэр дууссанаас хойш маш их давхардсан үүрэг зорилго нь ойлгомжгүй бараг 11 шат дамжлага байдаг юм байна лээ.

Тэгэхээр энийг илүү тодорхой болгох, илүү зорилго хугацааг нь тодорхой болгохоор ямар сайжруулалтыг хуульдаа хийж байгаа вэ гэсэн ийм 4 асуулт байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Би эхний хэсэгт нь юу яачихъя манайхан энэ техникийн юмнуудаа хариулаад явчихъя даа. Яг та яагаад энэ хууль орж ирж байгааг бүүр аягүй сайн яг салбарынхаа юун дээр харин ёстой хэлээд өглөө. 4 хуудас хуультай. Тэгээд дараа нь хэчнээн журамтай. Тэгтэл энэ чинь ямар нарийн зохицуулалттай салбар билээ? Их Британийнх чинь Энержи акт гээд байдаг байх аа? Ингээд тэр хуулиуд чинь аягүй нарийн зохицуулалттай байж байдаг. Тэгтэл манайд бол журам гэхлээрээ тэр журмыг чинь эрх зүйн үр дагавар дараа нь хариуцлага тооцох гэхэд хүртэл өөр болчхож байгаа байхгүй юу. Тэгээд ийм болохоор л энийг илүү хуульдаа акцент өгч хуулиар заавал зохицуулах юмнуудаа хуулиар л зохицуулъя аа. Түүнээс түрүүн Их Хурлын дарга яг л бодит Монголын амьдралын үнэнийг л хэлчихлээ л дээ. Тэгээд л амарчлаад энийг журмаар зохицуулна, журмаар зохицуулна гээд ингээд явчихаар дараа нь ийм олон журам гараад ирчихсэн байгаа байхгүй юу.

Тэгээд тэр журам чинь харин энэ чинь сайн ч бай, муу ч бай 76 гишүүн тал талаасаа сайндаж муудаж байгаад нэг юм гаргах чинь өөр. Тэгэхэд чинь тэнд бол зөвхөн мэргэжилтнүүд бид нар мэдэж байна гэж суугаад нөгөө хэрэглэгчийн эрх ашиг аягүй бага тусгагдаад. Яагаад гэвэл тэд нар чинь тэгэх ч үүрэггүй юм чинь. Яг өөрийнхөө нийлүүлэгчийн зүгээс харж байгаад хийчхэж байгаа байхгүй юу.

Тийм учраас хэрэглэгчийн гомдол хүлээж авах энэ асуудлууд эд нар чинь салбарт хэцүү байгаад байгаа нь энэнтэй л холбоотой байгаа юм. Тэгээд манайхан үлдсэн асуултуудад нь хариулаад явчих уу?

Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Г.Агар-Эрдэнэ: Гишүүний асуултад дэлгэрүүлж хариулъя. Төсөл дээр бол зардлын тооцоог Улсын Хурлын гишүүний ялангуяа Улсын хурлын гишүүн санаачилсан хууль тогтоомжийн төсөл Улсын Хурлын Тамгын газар эс үгүй бол судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач хийнэ гэж заасан байгаа. Тэгээд бид нар бол энэ хуулийн төслийг боловсруулж байх шатад бас өмнөх хууль тогтоомжийн хувийн хэргүүдтэй бүгдтэй нь танилцаж зардлын тооцоо ер нь хэр зэрэг чанартай хийж байна вэ гэдэг дээр иргэд олон нийтийн саналыг ч авч судлаачдынхаа байр суурийг ч сонссон. 30 хуулийн хувийн хэрэгтэй танилцахад бол зардлын тооцоо бол энэ манай хууль тогтоомжийн тухай хуульд заасан энэ шаардлагад төдийлөн нийцэж хийгдэхгүй байна гэдэг судалгаа гарсан байгаа.

Тийм учраас цаашид бол Улсын Их Хурлын Тамгын газар өөрөө гишүүдийн санаачилсан хууль тогтоомжийн төсөлд зардлын тооцоог хийдэг байх нь бусад улс орнуудын туршлагаас хараад үзэх юм бол зөв зүйтэй юм байна гэдэг саналыг гаргасан байгаа. Австралийн холбооны улс болон бусад улсуудад тухайн парламентын ажлын алба нь энэ зардлын тооцоог.

Д.Амарбаясгалан: Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгаад мэндчилье.

Хууль тогтоомжийн тухай хууль өөрөө хууль тогтоогчдын үндсэндээ гарын авлага, ажлын гарын авлага нь. Энэ их чухал хууль. Аливаа зүйлийг хэм хэмжээгээр нь бид нар тогтоохгүй бол тэрнээс гарч болох үр дагаврыг бид заримдаа нийгмийн бүхий л хүрээнд биеэрээ амсдаг гэдгийг бол бид мэдэж байгаа байх.

Хөрөнгө оруулагчдын хамгийн их гомдолдог тэрнээс гадна шүүмжилдэг зүйл бол хууль ер нь бол манайд ер нь тогтвортой байдаггүй, залгамж чанараа хадгалдаггүй, уламжлалаа хадгалдаггүй хад хадгалаагүйгээс болоод манай жишээ нь бизнесийн хүрээнд бол бизнес хийгээд хөрөнгө оруулалт хийхэд их хүндрэлтэй байна гэдэг. Энийг бол бүх салбарын хүрээнд ярьж болно оо. Энэ үүднээс нь сая бид 2024 оны 11 сарын 15-нд Улсын Их Хурлын цаашдын 4 жилийн стратегийг баталсан. Энэ стратеги дээр бидний гол хэлэлцэж ярилцсан зүйл бол цаашдаа хууль боловсруулах энэ үйл ажиллагааг маш нарийвчилсан процедуртайгаар нь жишээ нь боловсронгуй болгох ёстой юм байна гэдэг ойлголтод хүрсэн. Энэ үүднээс нь аваад үзэх юм бол энэ хуулийг бол бид боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай учраас өнөөдөр ингээд хэлэлцээд явж байгаа нь зүйтэй гэж үзэж байгаа юм аа.

Тэгэхээр энийг бол зарчмын хувьд дэмжиж байна. Энийг бол Их Хурлын жишээ нь танхимаас бид бүгдээрээ энэ хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явах ёстой шүү гэдэг талаас нь саналаа илэрхийлж байна.

Гурван асуулт байна аа. 1 дүгээр асуудал бол маш чухал мэдээж энэ зохицуулалт байж байгаа. Урьд нь байсан. Гэхдээ энийг бол их тийм нарийвчилж оруулж ирж байна. Улсын Их Хурлын гишүүний санаачлан боловсруулж буй хууль тогтоомжийн төсөлд Улсын Их Хурлын Тамгын газар, эсхүл судалгаа шинжилгээний байгууллага судлаач зардлын тооцоо хийнэ гэсэн байгаа юм. Энэ өөрөө их чухал. Тамгын газар бол яах вэ ойлгомжтой байх.

Хэрвээ судалгаа шинжилгээний байгууллага юм уу судлаачаар зардлын тооцоо хийлгүүлэх бол энэ зардал хаанаас гарах вэ? Энийг та бүхэн яаж зохицуулж бодож байгаа вэ? 1 дүгээр асуулт.

Хоёр дахь зүйл их чухал. Урьд нь бол яах вэ нэг заалтаар бол тодорхойлчихсон байсан юм байгаа юм. Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар бусад улсын эрх зүйн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгааг хийнэ гэсэн. Тэгээд энийгээ их нарийвчилчихсан байгаа юм. Үндэсний эрх зүйн тогтолцоо, уламжлал, онцлог гээд. Тэгээд яах вэ ингээд их нарийвчилчихсан байна. Бүр зарчмыг нь нарийвчлаад судлах зүйлийн хүрээг нь ингээд нарийвчилчихсан байна л даа.

Тэгэхээр энэ дан ганц эрх зүйн тогтолцооных нь уламжлал тогтолцооны хүрээнд ингээд судалгаа хийнэ гэдэг байдлаар ингээд нарийвчилж байгаа зэрэг бусад хэлбэрийн судалгааны хүрээнд бол хязгаарлагдчих юм биш үү? Энийг ерөнхийгөөр нь байж байвал зөв биш үү гэсэн нэг ийм асуулт байна.

Гурав дахь зүйл. Сая Их Хурлын дарга ч гэсэн хэлж байна. Манайд бол ингээд хууль бол өөрөө тогтвортой байдаггүй нэг шалтгаан нь бол хуульд нэмэлт оруулахдаа хуулийн үзэл баримтлалаас тэс ондоо. Бүр тэрийгээ тэс эсэргүүцсэн байдлаар шинэ үзэл баримтлал гаргаад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулчихдаг. Тэгээд ирэхээр зэрэг уг нь бол нийгмийн харилцааг зохицуулах гэж байсан нийгмийн өөрчлөлтийг авчрах гэж байсан тэр хууль бол үндсэндээ үйлчлэхгүй байна гэсэн үг. Үйлчилсэн бол буцаад асуудал болж байгаа юм. Тэгэхээр энэтэй холбоотой тухайлсан заалт орж ирсэн байна л даа. Хуульд өөрчлөлт оруулах тухай, хуулийн төсөл боловсруулах тохиолдолд тухайн төсөл нь анх батлагдсан хууль болон дагалдаж буй хуулийн төслийнхөө үзэл баримтлал агуулгад нийцсэн байх шаардлагатай гэсэн байгаа юм. Энэ маш чухал зөв. Та бүхэн энэ яг судалгаа хийж байх үед манайд ямаршуу хэчнээн хуульд энэнээс болоод үзэл баримтлал нь зөрчигдсөн, тэрнээс дагалдсан, бэрхшээлүүд гарсан тухай судалгааны үр дүн гарсан юм бэ гэсэн нэг ийм асуулт байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цогтбаатар гишүүн хариулах уу?

Д.Цогтбаатар: Энэ Улсын Их Хурлын Тамгын газар эс үгүй бол судалгааны нөгөө Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Судалгаа, шинжилгээний хүрээлэн хийнэ гээд. Энэ орж ирж байгаа судалгаа шинжилгээн дээр суурилсан нөгөө .. бест гэдэг энэ зарчмаараа бид нар хуульд хандах ёстой гэсэн энэ үүднээсээ энийг оруулж ирсэн байгаа. Зүгээр энэ дээр санхүүжилтийн хувьд гишүүнээ нөгөө гишүүн хууль боловсруулахад өөрт нь цаанаас нь санхүүжилт байж байгаа шүү дээ. Тэгээд тэр санхүүжилтээ энд зарцуулах боломжтой. Энэ дээр зүгээр яах вэ аягүй олон гишүүдийн зүгээр амьдрал дээр харахад манайхан нэмээд хариулаарай. Хууль санаачлаад явж байхад энэ судалгааны хүрээлэнгүүд амар биш юм байна лээ. Дуугарах үнэ нь хэцүү юм байна лээ шүү бас. Үнэндээ одоо бол бас Монголд энэ судалгааны хүрээлэнгүүд чинь том том дуугардаг болчихсон юм байна лээ. Ингээд бодоод үзэхлээр манайхан энд нөгөө Тамгын газрын дэргэдэх юугаа оруулаад байгаа нь төсөвтэйгөө харьцуулж тооцож тэгээд бүүр ингээд боломжгүй бол энийгээ ашиглах энэ юугаа бодолцож энийгээ оруулсан байх.

Харьцуулсан энэ судалгаа ерөнхий байвал яах вэ гэдэг дээр энэ чинь нөгөө хууль юм чинь ер нь л нарийвчилсан л зохицуулж байгаа юмнууд маань

нарийвчилсан хууль болохлоор нарийвчлал өндөртэй л байвал зүгээр байх гэж би бодож байна. Энэ тэгэхдээ миний л бодол. Юун дээр харин энэ нэмэлт хуультайгаа зөрчилтэй гэдэг дээр манайхан хариул даа. Энэ дээр надад бол мэдээлэл байхгүй байна. Нөгөө яг тоо баримт нь.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгөх үү? Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Н.Отгончимэг: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Юун дээр 13.2.6 дээр хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тандан судлахад бол харьцуулсан судалгаа хийж болж байгаа. Хэрвээ хийе гээд шийдээд хийсэн тохиолдолд тодорхой мэдээллийг хавсаргаж өгөх хэрэгтэй байна гэдэг энэ заалт 13.2.6-гаар орж байгаа. Энэ заалттай орсон шалтгаан бол судалгаа хийж үзсэн. 1992 онд батлагдсан Үндсэн хуулийг дагаж гарсан органик хуулиуд гэж нэрлэдэг. Хүчин чадлын хувьд Үндсэн хуульд заачихсан тодорхой нэр бүхий хуулиуд дээр судалгаа хийж үзсэн. Тэгэхэд ердөө бараг ганцхан хуульд 1993 оны Шүүхийн тухай хуульд тэр нь байсан, харьцуулсан судалгаа хийсэн. Товчхон тэрийгээ бол тодорхой хэмжээгээр протокол байдлаар тэмдэглэж үлдсэн байдаг. 2021 оны Шүүхийн хууль одоо хэрэгжиж байгаа.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Н.Отгончимэг: Бүр энэ 2021 оны Шүүхийн хуульд нь гэхэд харьцуулсан судалгаа нь байхгүй хавсаргаагүй байж байдаг. Тэгээд яагаад энийг оруулсан бэ гэхлээр хэрвээ сонгоод харьцуулсан судалгаа хийсэн тохиолдолд ямар харьцуулалт хийсэн юм? Ямар дүгнэлтэд хүрсэн юм? Алийг нь авсан юм? Яагаад авсан юм? Эрх зүйн бүлгийнхээ онцлогийг харгалзсан уу? Өөрийнхөө эрх зүйн тогтолцооны уламжлалт онцлогийг бас харгалзсан уу. Чиг хандлага нь юу гэдэг ийм асуудлыг тусгасан Байгаа. энэ үг хэллэг нэр томъёоны хувьд бол 1998 онд батлагдсан эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр гэж байдаг. Энэнээс урган гарч авсан нэр томъёо байж байгаа.

Д.Амарбаясгалан: Зулпхар гишүүн тодруулж асууя.

С.Зулпхар: Би зүгээр саналаа л хэлчихье тодруулах байдалтай. Тэр зардлын тооцоог бол бүрэн жишээ нь сайшааж байна аа. Угаасаа урьд нь яах вэ, хийж байсан хуулиудаар. Гэхдээ яах вэ энэ чинь амаргүй ажил. Үнэхээрийн таны одоо жишээ нь Цогтбаатар гишүүний хэлдэгчлэн ямар хууль жишээ нь санаачилж, ямар хууль батлуулах гэж байгаагаас шалтгаалаад тэрэнтэй уялдсан зардлын тооцоолол хийгдэнэ. Тэрэнтэй уялдсан ажилбар явагдана. Тэрийг дагасан тооцоолол явагдах юм. Тооцоо зардал гарна гэсэн үг. Тэгэхээр энэ бол бид чинь зарим хууль дээр бол төсөв дэх нөлөөллийг нь тооцно. Зарим хууль дээр бол эдийн засаг дахь нөлөөллийг нь тооцно. Зарим хууль дээр бол тухайлсан салбар дахь нөлөөллийг нь тооцно.

Тодорхой хуулиуд дээр бол нийгмийн тодорхой хүрээнд үйлчлэх явцад ямар зардал гарах юм бэ иргэнээс гэх гэх мэтчилэн энэ тооцоолол хийгдэнэ. Тэгэхээр зөвхөн одоо жишээ нь дан ганц гишүүнд олгогдсон тэр зардлаар бид энийг бол тооцоолол хийнэ гэж бодох юм бол энэ их тийм нэг талдаа их өрөөсгөл амаргүй болох байх аа. Тэгэхлээр энийг бол.

Д.Амарбаясгалан: Дашдоржийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: 3 асуулт асууя.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн уучлаарай.

Д.Энхтүвшин: 1 дүгээрт нь болохоор энэ хууль байгаа. Тэгэхдээ хуулиа бид нар хэрэгжүүлэхгүй байгаа. Тэгэхээр энэ чиглэлээр энэ хууль маань өөрөө процессын шинжтэй хууль байгаа. Тэгээд энэ хэрэгжүүлэхгүй байгаа дээр ямар хэмжээний одоо юу гэдэг юм уу бусад субъектүүдээр хянадаг тийм боломжуудыг нээсэн юм бэ? Тухайлбал өнөөдөр бид нар Уул уурхайн биржийн тухай хуулийг хэлэлцэхээр сая зөвшөөрч байна. Тэгээд энэ дээр жишээлбэл ингээд харахаар хууль зүйн энэ асуудлуудыг оруулж ирж байгаа нь хууль зүйн бүрдэл хангаж байгаа талаар Засгийн газраас оруулж ирж байгаа тэгэхдээ Засгийн газар нь өөрөө саналаа өгч байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр харангуут ХЗДХЯ-аас энэ жишээлбэл хууль нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг нийцсэн байна гэсэн дүгнэлтийг 3 сарын 26-нд гаргасан байгаа юм.

Тэгэхээр өөрөөр хэлбэл олон нийтийн саналыг тодорхой хэмжээгээр авчихсан байх шаардлагыг жишээлбэл зөрчөөд аваагүй байгаа юм. Гэхдээ энийг веб сайт дээр болохоор 27-нд нь өөрөөр хэлбэл Хууль зүйн сайд шаардлага нийцсэн байна гэсний дараа нь өгчхөж байгаа юм. Түрүүн Улсын Их Хурлын дарга бас хэлсэн. Энэ хэлэлцэж амжаагүй учраас Эдийн засгийн байнгын хороо дээр хэлэлцээрэй гэх мэтчилнээр. Ингээд хууль байгаа мөртөө бид нар хэрэгжүүлэхгүй байгаад тэгэхээр жишээлбэл энэ чиглэлээр ялангуяа энэ Хууль тогтоомжийн хууль бол бид нар хууль засаглах эрхтэн дархтан биш. Хууль засаглах нь чухал учраас энийг мөрддөг байх. Энэ чиглэлээр ямаршуу хаалтууд хийсэн бэ гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт нь бас л яг энэ нөгөө дагалдах хуультай холбоотой заалт. 40.1 дээр одоо жишээлбэл яг тодорхой болон 40 дүгээр бүлэг дээр хууль тогтоомжийн бүрдүүлбэр заасан байгаа. Тэрэн дээр болохоор 40.1 дээр өөрчлөлт орсон юм байхгүй харагдаад байна л даа. Зөвхөн дагалдах хуулийг нэмж хуулийн төслийг оруулж ирнэ ээ. Тэгэхээр яг энэ дээр өөрчлөлт ороогүй болохоор дахиад дагалдах хуулиуд дээр өөрчлөлт нөгөө бүрдүүлбэр хангах, олон нийтийн саналыг авах гэдэг юмнууд орхигдох вий.

Дээр нь хууль тогтоох явцад бас нэг ийм хуудуутай ч гэдэг юм уу гэнэтийн юмнууд орж магадгүй. Хууль зөрчсөн зүйл орж магадгүй заалтууд харахаар, жишээлбэл зарчмын зөрүүтэй санал гарахад хууль хэлэлцүүлж байх явцад тэр зарчмын зөрүүтэй санал дээр асуулт асуух эрх байдаггүй юм билээ. Тэгэхээр өөрөөр хэлбэл дэмжсэн дэмжээгүй гээд тэгэхээр Байнгын хорооны цөөн хэдэн гишүүдийн хүрээгээр ингээд зарим нэг хуулийн өөрчлөлтүүд орох ийм магадлалтай байгаа.

Дараачийнх нь болохоор гуравдугаарх нь 5 жил болсон 5 ба түүнээс дээш дагаж мөрдөж байгаа хуулиуд дээр нэмэлт, өөрчлөлт оруулахаар бол үр дагаврын үнэлгээ хийнэ гэсэн байгаа юм. Одоо жишээлбэл өргөн баригдсан хэлэлцэх эсэхийг нь шийдэх гээд бид нар хүлээгдэж байгаа өнөө маргаашгүй ярих гэж байгаа Хүний эрх эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 7 хууль жишээлбэл дагалдан орж ирж байгаа. Тэгээд эд нар бүгдээрээ 5-аас дээш болчихсон гэх мэтчилнээр. Энэ хууль батлагдангуут тодорхой

хэмжээгээр энэ хууль хэлэлцэх асуудлууд нэлээн жигдэртлээ цаг хугацаа орох шинжтэй харагдаж байна. Тэгэхээр энэ талаар та хэзээнээс энэ үйл ажиллагаа, хууль тогтоох үйл ажиллагаанд саад учруулахаар байна уу? Тэгээд энэ хэзээнээс жигдрэхээр байна гэсэн ийм багцаа тооцоо хийсэн бэ? Бодитой байдалдаа ямаршуу тооцоо судалгаа хийсэн бэ гэсэн ийм 3 асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цогтбаатар гишүүн хариулт өгье.

Д.Цогтбаатар: Хууль хэрэгжүүлэх энэ нөгөө хуулийн хэрэгжилтэд энэ хууль хувь нэмэр оруулна аа. Яагаад гэвэл нөгөө хэрэгжих ёстой хууль чинь өөрөө чанаржиж гарч ирнэ гэсэн үг. Одоо жишээлбэл чанаргүй Ерөнхий хуулиуд болохоор өөрөө хэрэгжихэд амьдрал дээр хүндрэлтэй байгаад хэрэгжилт нь сүүлдээ журам руугаа шилжиж явчхаад байна шүү дээ. Тэгэхээр эхнээсээ хууль чанаржина гэдэг хэрэгжих магадлал нь өндөрсөж байна гэсэн үг. Хэрэгжилтийг хариуцлага тооцдог механизм бол энэ хууль биш. Нөгөө бусад өөр хуулиараа, жишээлбэл Их Хурал бид нар хяналтын хуультай шүү дээ. Тэрнийхээ дагуу хуулийн хэрэгжилтээ жишээлбэл Их Хурал энэнийхээ дагуу хянаад явдаг.

Тэгэхээр тэрэн дээрээ бас өөр хуулиудаар энэ нь зохицуулагдаад явж байгаа. Гэхдээ энэ хууль бол хэрэгжилтэд нөлөөлнө. Яагаад гэвэл эхнээсээ хуулийн чанар нь өөрөө сайжирч байгаа юм.

Дагалдах хуулиуд дээр манайхан ард хариулчих байх.

Хоёрдугаар асуудал энэ зарчмын нөгөө зөрүүтэй санал. Энэ асуудал дээр бол гишүүнээ ийм л байгаа. Энэ чинь нөгөө Дэгийн хуулиараа зохицуулагдаад явж байгаа болохоор энэ хууль өөрөө Дэгийн хуулийг өөрчлөхгүй учраас энэ тэрэнтэй бол нэг их энэ дээр ямар нэгэн юу байхгүй зохицуулалт байхгүй байгаа. Зохицуулах ч нөгөө өөрийнх нь юу биш, хуулийн асуудал биш хүрээний асуудал биш. Тэгээд одоо энэ өргөн барьчихсан байгаа хуулийн 5 жил болсон хуулиуд тэгээд энэ хүний эрхийн өргөн барьчихсан байгаа хуулиуд дээр яах вэ энэ хууль маань эргэж үйлчлэхгүй. Гэхдээ яг бодит амьдрал дээр гишүүнээ нэг ийм л юм байдаг юм. Яг хууль ийм асуудал орж ирээд л нэгэнт яригдаад л эхэлж байгаа бол хэлэлцэж байгаа хүмүүсийн сэтгэлгээ өөрчлөгдчихдөг. Эндээ хандах хандлага өөрөө аягүй хариуцлагатай болоод эхэлнэ.

Тэр хэмжээгээрээ энэ гараагүй хэлэлцэгдээд явж байхдаа л хүмүүс жишээлбэл энэ дагалдан орж ирж байгаа хуулиудынхаа дагуу аягүй олон юм өөрчлөгдчих гээд байдаг шүү. Үзэл агуулгатайгаа зөрчилдсөн юм орж ирдэг шүү гээд л ингээд хүмүүс илүү анхааралтай нөгөө хуулиуддаа хандах тэр боломж үүсэж байгаа юм. Тэгээд манайхан ардаас нэмээд хариулах уу?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон Алтангэрэл зөвлөх хариулъя.

Т.Алтангэрэл: Энхтүвшин гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье гэж бодож байна.

Тэгэхээр хүний эрхийн зөрчил бол яаж хууль гаргаад баталсных нь дараа хүний эрхийн зөрчлийг арилгах нь өөрөө асар их зардалтай байдаг. Хэрвээ энийг яг хуулийн төслийн түвшинд нь хүний эрхийн зөрчлийг хязгаарлаж хязгаарлаж байгаа

заалтыг илүү нарийвчилсан аргачлалаар үнэхээр шаардлагатай хязгаарлалт байна уу, үгүй юу гэдэг энэ аргачлалаар нь хянаад явах юм бол хүний эрхийн зөрчил гарах нь эрс багасна. Энэ утгаараа хүний эрхийн хэрэгжилт хангалтгүй байна гэж байгаа өнөөгийн энэ шүүмжлэлд энэ бодитой хэрэгжилтийн хувьд бол давуу байдлыг авчирна гэж ингэж судлаачийн хувьд харж байна.

Хоёрдугаарт нь журам багасах ёстой. Энийг бол энэ хуулиар гол онцолж байгаа зүйл байгаа. Тэгэхээр журам багасна гэдэг маань илүү хуульчлагдана гэсэн үг. Тэгэхээр процесс нь өөрөө илүү их.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Т.Алтангэрэл: Хуульчлагдах учраас энд хариуцлагын хувьд бол нэлээн өөр, зарчмын хувьд ялгаатайгаар өөрөөр хэлбэл хуулийг зөрчих нь нэг өөр асуудал болно. Журам зөрчих нь бас нэг өөр байдаг тийм ээ. Тэгэхээр энэ талаасаа бол нэгэнтээ хуульчлагдсан процессыг төрийн албан хаагч зөрчих нөхцөл нь бол их багасна гэж бодож байгаа. Энэ утгаараа бас хуулийн хэрэгжилтэд бол бодитой хувь нэмэр оруулж чадна аа.

Д.Амарбаясгалан: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: 5 ба түүнээс жил дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийг шинэчлэн өөрчлөхөөр бол үнэлгээ хийчихсэн байна гэж байгаа шүү дээ. Яах вэ энэ нь зүгээр нөгөө нэг хууль тогтоох үйл ажиллагаанд тодорхой хэмжээний яг энэ хууль батлагдсаны дараа тодорхой хэмжээгээр нөлөөлөх байх. Тэгэхээр энэ жишээлбэл хугацаанд ямаршуу байдлаар зохицуулах вэ. Тэгэхээр ер нь бол бүх үнэлгээ ийм хурдан хийж чадахгүй, хүчин чадлын хувьд ч гэсэн хангалттай биш учраас яаж нөлөөлөх вэ? Тэгэхээр тодорхой хэмжээгээр энэ хууль тогтоох үйл ажиллагаанд нөлөөлж үнэлгээ хийсэн л зөвхөн хуулиудыг дагалдах байна уу, өргөн барьсан байна уу ингэж явах нь ээ. Тэгэхээр ямаршуу байдлаар нөлөөлнө гэж бодож байгаа гэж. Тэрийг илүү тодруулж асууя.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгье. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Н.Отгончимэг: Хуулийн төслийн 51.5-д яг тийм заалт орсон байгаа. Цаашид яг энэ хууль хэрэгжихгүй байгаатай холбогдуулаад хэрэгжилтэд нь хяналт тавих энэ зохицуулалтыг чангатгах хэрэгтэй байна гэдэг энэ хэлэлцүүлгийн шатын саналууд гарсан юм. Тэгээд цаашид 5 ба түүнээс дээш жил болсон энэ хуулийг өөрчлөх нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хэрэгжилтийг нь үнэлж байх ёстой. Түүнийгээ бас хэлэлцүүлж байх ёстой гэдэг ийм заалт орж ирж байгаа. Энэ хувь нэмэр болох байх. Хуулийн хэрэгжилт дээр анхаарал хандуулахад. Энэ хуулийн мэдээж ийм шаардлага нь өндөрсөж байгаа гэсэн үг. Яг тийм.

Энэ хуулийг бол дагаж мөрдөх хугацааг нь ердийн журмаар хууль санаачлагч бол өргөн мэдүүлсэн байгаа. Өөрөөр хэлбэл ердийн журмаар хэрэгжээд явах байгаа. Магадгүй хэлэлцүүлгийн шатад бас энэ дээр санал гарвал ингээд.

Д.Амарбаясгалан: Энхтүвшин гишүүн дахин тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Би яг хариултаа авч чадсангүй. Яг энэ хууль тогтоох үйл ажиллагаанд нөлөөлөх юм шиг санагдаад байгаа байхгүй юу. Үнэлгээ хийгдээгүй учраас бүгдээрэнг нь үнэлгээ хийж байж 5-аас дээш жил болсон мөрдөгдөж байгаа хуулиуд дээр үнэлгээ хийх хэрэгтэй болчхож байна. Тэгэхээр үнэлгээ хийхийг нь хүлээнэ гэхээр тодорхой хэмжээгээр хууль тогтоох үйл ажиллагаа саатахаар байгаа байх. Саяын таны яг та сая төгсгөлд нь халти хэлж байгаад дутуу үлдээчих шиг боллоо. Тодорхой хэмжээнд хэрэгжилт дээр нь ийм зохицуулалтууд байна уу эсвэл өөр хууль тогтоомж энэ хууль тогтоох үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр удаашрах үйл ажил ажиллагааг яаж зохицуулах вэ? Эсвэл цөөн хууль жишээлбэл зөвхөн үнэлгээ хийгдсэн хуулиудыг л өргөн барина гэсэн үг үү? Энэ талаар л илүү мэдээлэл авах гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Н.Отгонжаргал: Тодруулаад хариулъя. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа энэ хуульд 51.3 гэж заалт байгаа юм. Энэ заалт бол яг одоо хатуу 5 жил гэж заагаагүй. Түүнээс наана хэрэгжилтийг нь үнэлж болно гэдэг ийм зохицуулалт байгаа. Гэхдээ цаад талын хугацаа нь 5 жил шүү. Монгол Улсад байж байгаа энэ бүх хуулиуд 5 жил болох юм бол заавал хэрэгжилтийн үр дагаврыг нь үнэлдэг байгаа. Тэрнээс наана болно.

Одоо яах вэ байж байгаа хуулиараа бол заавал хэрэгжилтийг нь үнэлэх ёстой байж байгаа. Гагцхүү энэ заалтаа л бид нар хэрэгжүүлэх ёстой.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Өнгөрсөн намар бид нар нэлээн олон удаагийн төсвийн хэлэлцүүлэг төсвийн тодотголын хэлэлцүүлэг хийсэн. Тэр хүрээнд бол бас нэлээн олон асуудлууд гарсан. Тэгээд яах вэ би бол юу гэж ойлгож байсан бэ гэхлээр тухайн үед гарсан асуудлуудыг засаж залруулах шугамаар энэ Хууль тогтоомжийн хууль тэгээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль зэрэг хуулиуддаа нэг мөр өөрчлөлт оруулах зорилгоор ажлын хэсэг гарсан гэж ойлгосон. Гэтэл яах вэ яг энэ удаад зөвхөн Хууль тогтоомжийн тухай хуульд бол өөрчлөлт оруулахаар оруулж ирж байгаа юм байна. Тэгээд тухайн үед яригдаж байсан асуудал юу вэ гэхлээр энэ Төсвийн тухай хуулийг дагалдуулаад баахан янз бүрийн холбогдолтой холбогдолгүй хуулийн төслүүд оруулж ирээд хамт батлаад байна. Тэрэн дээр нь ингээд хэлэлцүүлэг олигтой явахгүй байна гэсэн нэг зүйл яригдаж байсан. Мөн яаралтайгаар маш олон хууль тогтоомжууд орж ирээд байна аа. Энэ дээр бол олон нийтийн хэлэлцүүлэг явахгүй байгаад байна. Тухайн хуулийн төслийг нь шүүсийг нь шахаж чадахгүй байна гэдэг асуудлууд яригдсан. Мөн дэгтэй холбоотой бас нэг цаг хугацаатай холбоотой ч гэсэндээ зөндөө олон асуудлууд байсан.

Тэгээд яах вэ тэр асуудлуудын зарим нэгийг нь энэ хуулийн төсөлд тусгасан байна. Тэгэхдээ нөгөө талаасаа бол яах вэ тунхагийн шинж чанартай зүйлүүд нэлээн олон харагдаж байна. Хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль зүйн баталгааг бүрдүүлэх гэх зэргээр ер нь бол энэ нөгөө хүний эрхтэй холбоотой олон заалтуудыг оруулж өгсөн боловчиг зарим нь үнэлгээ хийхэд магадгүй хүндрэлтэй тийм зүйлүүд ч байх шиг байна. Тэгэхээр сая Энхтүвшин гишүүний асуугаад байгаа асуулт нь бол ер нь энэ хууль батлагдсанаар хууль санаачлагчийн хувьд аливаа хуулийн төслийг

санаачлах тэр процесс хэр удаашралттай болох вэ, хэр хөнгөн шуурхай байх боломжтой вэ гэдэг асуудлыг л асуугаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр яах вэ ингээд ийм санаа нь зөв боловчиг ингээд янз бүрийн тийм одоо нөгөө нэг шаардлагуудыг тавьчихаар ач холбогдолтой ач холбогдолгүй маш их хэмжээний цаас үйлдвэрлэгдээд тэр нь зарим талаар зүгээр хүнд суртал болоод тэгээд ингээд энэ хууль санаачлах тэр үйл явцыг удаашруулж байгаа бас нэг хэлбэр болж магадгүй гэсэн нэг тийм болгоомжлол гишүүдэд байх шиг байна.

Тэгэхээр тэрийг бас анхаарч авч үзээрэй. Тэгээд уул нь нэг мөр саяын нөгөө дурдсан Дэгийн тухай хуультайгаа ер нь ингээд нэг ийм багцаар нь нэг асуудлыг авч хэлэлцүүлээд ороод ирвэл сайн байсан гэж харж байна. Тэгээд нэг асуулт юу вэ гэхлээр энэ Хууль тогтоомжийн тухай хуульд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ гэж байгаа юм уу? Тэрэн дээр нь яг ямар асуудлууд хөндөгдөж байгаа юм. Саяын яригдаад байгаа энэ нөгөө судалгаа, шинжилгээ, үнэлгээнүүд нь хэр үр өгөөжтэй байсан юм бэ гээд. Тийм үнэлгээ ер нь энэ хууль дээр өмнө нь хийгдсэн үү. Тэр талаар хариулт өгнө үү.

Тэгээд сая Байнгын хороон дээр бол нэг сонин санал хураалт явчихсан юм байна шүү дээ. Яг энэ хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтөө бол хэлэлцэхийг нь дэмжээгүй хэр нь дагалдаж орж ирсэн хуулиудыг нь хэлэлцэхийг нь дэмжчихсэн юм байна шүү дээ. Гэх мэтчилэн бид нарт энэ нөгөө дэгтэй холбоотой асуудлууд их байгаа гэж харагдаж байгаа. Тэгэхээр энэ саяын Байнгын хорооны санал дээр ямар хууль зүйн гаргалгаа байгаа юм бэ.

Д.Амарбаясгалан: Цогтбаатар дарга хариулт өгье.

Д.Цогтбаатар: Энэ манай ажлын хэсэг бол яг энэ энэ хуулийг л өөрчлөх гэсэн ажлын хэсэг байсан болохоор бид нар үнэхээр Лэгийн хууль руу энэ дээр ороогүй. Гэхдээ Дэгийн хууль дээр бол өөрчлөх юмнууд бий бий. Тэрэн дээр бол санал нэг байна. Энэ хүний эрхийн асуудлаар зарим асуудал нь тунхаг чанартай гээд тэгж байна. Хэрэв тийм зүйл заалтууд байгаа бол Жаргалан гишүүн бид нар сонсоод тэр тунхаг шинж чанартайг бодит үйл хэрэгжих болгох тал дээр нь бид нар ажиллаж болно шүү. Тэр саналыг хэлэлцүүлэг одоо энэ чинь нөгөө хэлэлцэх эсэхээ л ярьж байгаа болохоос хэлэлцээд эхлэхлээрээ бид нар энэ доторх агуулга руугаа ороод явахад бид нар нээлттэй байгаа.

Яагаад гэвэл энэ чинь хэлэлцүүлж байж л энэ машин дундуур орж байж л энэ хууль сайжирч гарч ирнэ. Түүнээс хэлэлцэх шаардлагагүй төгс юм хууль хэзээ ч хэн ч өргөн барьж байгаагүй тийм юм байдаг бол парламент байгаад ч хэрэггүй шүү дээ.

Тэгэхээр бид нар бол хэлэлцүүлээд явах явцдаа юмыг сайжруулаад явж болно. Тийм тунхаг чанартай юм нээрээ хүний эрхийн асуудал дээр байж болохгүй. Тэрийг нь бол оруулахад бэлэн байна аа. Хэрэгжилтийн үр дагаврын тухай гэвэл гишүүнээ нэг ийм л юм байна. Яг одоо ингээд бодит байдал дээр байна шүү дээ. Энэ хуулийн одоо өнөөдөр хэрэгжиж байгаа хуулийн хэрэгжилтийн үр дагавар гэвэл 800 хаана ч бүртгэгдээгүй, хэний ч зөвшөөрөлгүй журам явж байна. Одоо таны сонгогчдын амьдралыг өдөр болгон хүндрүүлээд явж байгаа хүнд сурталтнуудын хаалт бамбай болчихсон хүний амьдралыг цаг хугацааг нь очроор хүндрүүлээд тэрийгээ өө бид нар ийм журамтай шүү дээ гээд хүн өөдөөс нь юу ч ярих боломжгүй. Тэр нь ямар их хуулийн эх сурвалжаас үүсэж гарч ирээд ийм журам явж байгааг

иргэд мэдэхгүй шүү дээ тэр болгон. Тэгээд 800 хэд байгаа байхгүй юу. Зөвхөн бүртгэлгүй нь шүү дээ. Тэгэхээр энэ нөгөө Хууль тогтоомжийн хуулийн хэрэгжилтийн хамгийн бодит жишээ энэ байна гэж харж байгаа юм аа. Тэгээд энэ үр дагаврыг л бид нар арилгах ёстой л гэж бодож байгаа юм.

Тэгээд манайхан нэмж хариулаарай.

Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон Алтангэрэл зөвлөх.

Т.Алтангэрэл: Их хурлын гишүүн Жаргалангийн асуултад нэмж тодруулга өгье. Энэ хуулийн төслийн 41.4 дээр орж ирж байгаа гол өөрчлөлт нь юу вэ гэхээр орж ирсэн хуулийн төсөл нь өөрөө хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээгээ тодорхой хуульд заасан аргачлалынх нь дагуу хийгдсэн байх ёстой. Энийгээ хийсэн байна уу, үгүй юу гэдгийг 5 хоногийн дотор дүгнэлт гаргана л гэж байгаа юм. Тэгэхээр энд бол яг нөгөө хууль тогтоох процесст тийм жинтэй хоцрох ийм нөхцөл бол үүсэхгүй гэж үзэж байгаа юм аа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хууль тогтоолын төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлнэ. 1 дүгээр индэрт урьж байна.

П.Сайнзориг: Баярлалаа. Өнөөдөр Хууль тогтоомжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж байна. Тэгээд энэ дээр нэг зүйлийг олон нийтэд маш буруугаар өгч байна. Захиргааны ерөнхий хуулийн 59.1 дээр угаасаа захиргааны хэмжээний акт гаргахын тулд хуулиар эрх авсан байдаг. Хуулиар эрх аваагүй 800 журмын асуудал ерөөсөө Хууль тогтоомжийн хууль байтугай Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэлд хамаагүй. Энэ асуудлыг ХЗДХЯ Засгийн газраас зүгээр самналт хийгээд хүчингүй болгох, хүчингүй болгоогүй хүмүүстэй нь сахилгын арга хэмжээ авах ажил албан тушаал дээр нь ярих ёстой юм. Ийм журмаар үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал үзүүлээд байвал тэрийг захиргааны шүүхэд хандах ёстой юм.

Засгийн газар дээр ийм журмууд байвал Засгийн газрыг Цэцэд өгөх ёстой байхгүй юу? Энэ хуулиар эрх олгосон заалтыг томьёолохдоо яах вэ гэж асуудлыг ярьж байгаа болохоос биш огтоосоо эрх аваагүй заалтын тухай шийдэх гэж байгаа юм шиг олон нийтэд ингэж төөрөгдөл мэдээллүүдийг өгч байгаа нь өөрөө эргээд буруу байгаа юм аа.

Би дээрээс нь ганц зүйлийг хэлмээр байна. Сая хүний эрхийн нөлөөллийн шалгуур үзүүлэлтийг хийнэ гэж байгаа боловч энийг чинь хийж байгаа байхгүй юу. Төслийн үр нөлөөг буюу төсөл боловсруулсны дараа Үндсэн хуульд нийцэж байгаа тэр хүний эрхийг хангаж байна уу гэдгийг чинь үздэг юм аа. Энийгээ бид нар сайжруулах асуудал байгаа болохоос биш цоо шинэ юм хийх гэж байгаа юм шиг олон нийтэд худлаа хэлээд дээрээс нь ХЭҮК, Дээд шүүхээс санал авдаг болж байна. Дэлхийд байхгүй жишиг гэж байгаа юм.

Өнөөдөр ХЭҮК-ын тухай хуулиа эргүүлээд хараарай. 7.1.2, 7.1.3 дээрээ комисс хууль тогтоомж болон захиргааны шийдвэрийн төсөл дээр санал өгнө. Олон улсын гэрээг соёрхон батлах гэж байж санал өгч хүний эрхийн шалгуур үзүүлэлтийг хангаж байна уу гэдгийг чинь аль хэзээ хийчихсэн байхгүй юу. Яагаад ингээд худлаа яриад ажлын хэсгээс ингээд тайлбар хэлээд байгаа юм бэ?

Хоёрдугаарт энэ дээр би ганц л зүйлийг хэлье. Орон нутагт энэ татвар хураамжийг Улсын Их Хурлын баталсан дээд доод хязгаарын хүрээнд баталдаг юм. Зам ашигласны хураамжийг баталдаг юм аа. Малын хөлийн татварыг баталдаг юм, хогийн хураамжийг баталдаг юм аа. Энэ эрх мэдлүүдийг нь өнөөдөр Улсын Их Хурал дээр ярьдаг болъё гээд сууж байгаа нь харамсалтай байна. Энэ хууль батлагдсан тохиолдолд бүх энэ дүрэм журмуудыг энд нийцүүлэх арга хэмжээ буюу эрх зүйн асуудал гажуудалд үүснэ ээ.

Төсвийн хууль дээрээ дагаад одоо өнөөдөр би зүгээр жишээг авъя. Маш энгийнээр. 5 дугаар анги хүртэлх хүүхдүүд дээр үдийн хоол өгч байгаа. Энийг 10 дугаар анги дуусах, 12 дугаар ангийг дуустал өгье өө гээд тэгэх юм бол бид нар хоол үйлдвэрлэлийн хууль дээр өөрчлөлт оруулна шүү дээ. Тэгэхээр энэ хуулиар чинь өөрчлөлт оруулж болохгүй гээд хэлчхэж байгаа байхгүй юу. Үгүй та нар хар л даа энийгээ хар. Одоо жишээ нь Номин сайдын жишээг авъя. Номин сайдын 18.3 тэрбумыг хасуулсан ваучер олгож байсан. Энийг хасахад эргээд бид нар Соёлын бүтээлч үйл ажиллагааны тухай хуулиас тэр эрхийн бичиг олгоно гэдэг заалтыг хасах байхгүй юу. Гэтэл энэ хуулийн чинь орж ирж байгаа 29.5-аар чинь зөвхөн төсөв санхүүгийн зохицуулалт гээд хэлчхэж байгаа юм. Дахиад маргаан орж ирж болох юм уу, болохгүй юм уу энэ тэр гээд ийм зүйл рүү ингээд явлаа.

Хоёрдугаарт 27.¹.2-ын нэг дээр байгаа Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх чөлөөг хязгаарлаж байгаа асуудлаар эрх олгосон заалт тусгаж болохгүй гэж байгаа юм. Би энэ дээр ганц л жишээг хэлье. Өнөөдөр эрүүл мэндээ хамгаалах Үндсэн хуулийн эрх байж байгаа. Энэ эрхийг нь зохистой хэмжээнд хамгийн багаар хязгаарлах асуудлыг ярих ёстой. Ийм хязгаарлалт байхын тулд жороор олгодог эмийн жагсаалтыг баталдаг юм аа. Эсвэл энэ жороор олгох эмийн жагсаалтыг Улсын Их Хурал ярих гээд байгаа юм уу энэ дээр. Өнөөдөр Улаанбаатар хотын агаарын чанарын бүс буюу түүхий нүүрс түлэхгүй бүсчлэлийг яндангүй бүсийг иргэдийн хурал тогтоодог юм аа. Энэ чинь дахиад хүний эрхийн хязгаарлалт цаана нь явж байдаг байхгүй юу. Энийг хамгийн зохистой түвшинд л багаар байлгах нь Улсын Их Хурал энийгээ шийдээд энийг Засгийн газар тогтоох юм байна, иргэдийн хурал тогтоох юм байна гэж энийгээ хууль батлахдаа ньуанстай бодож өгөх ёстой болохоос биш ийм зүйлүүдийг ерөөсөө огтоосоо гаргаж болохгүй гээд сууж байгаа нь Монголын юу гэдэг юм энэ амьдралын бүх зүйлүүд чинь зогсоно шүү.

Хууль тогтоомжийн жижиг гацалтаас болоод сүүлдээ нийгмийн амьдрал дээр чинь маш олон сөрөг үзэгдлүүд гарчих вий дээ гэдэг л энэ болгоомжлолууд.

Д.Амарбаясгалан: Тэгээд Сайнзориг гишүүн энэ хэлэлцэх эсэх асуудал шийдэгдсэний дараа тэгээд ажлын хэсэгт ороод өөрийнхөө энэ хөндөж байгаа асуудлууд дээр байр сууриа илэрхийлээд чөлөөтэй явах боломж байгаа. Бүх зүйл болж байгаа бол заавал өөрчлөх гээд байх шаардлагагүй шүү дээ. Болохгүй зүйл маш их байгаа учраас бидэнд өөрчлөлт хэрэгтэй, сайжруулалт хэрэгтэй. Зүгээр байгаагаараа бүх юм хангагдаад иргэд нь хүнд сурталд өртөхгүй авлига нь газар авахгүй байгаа бол бид энэнчээ өнөөдөр хууль журмын зохист харьцааг хангая гээд

сууж байх шаардлага байхгүй байхгүй юу. Болохгүй байгаад байгаа зүйлээ сайжруулъя гэдэг агуулга явж байгаа гэж.

Бямбацогт сайд үг хэлье 1 дүгээр индрээс.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая аа. Би дэмжиж хэлэх гэж байгаа юм. Бид нар хэт туйлшраад байж болохгүй байх, эс үгүй бол дэмжинэ, эс үгүй бол дэмжихгүй гээд. Одоо хуулийг хэлэлцэх эсэхийг дэмжих санал хураалт явах гэж байгаа. Дэмжихгүй гэчих юм бол бас олон сайжруулах, засах, өөрчлөх шаардлагатай олон зүйлүүд сайжрахгүй, өөрчлөгдөхгүй, хэвээр үлдэж магадгүй. Тийм болохоор хэлэлцэхийг нь дэмжихээд ажлын хэсэг байгуулаад манай Сайнзориг гишүүд нарын хүмүүс эсэргүүцэж байгаа хүмүүс ороод болохгүй буруу заалтууд санаанууд орж ирсэн бол тэрийг нь түүж хаяад, сайныг нь цааш нь хөгжүүлээд явах ёстой байх аа. Яагаад ингэж хэлж байгаа юм бэ гэхээр энд нэг зарчим байгаа юм.

4.1-д 1.1 дэх заалт. Хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль зүйн баталгааг бүрдүүлэх гээд. Энэ зайлшгүй хууль болгоны үзэл баримтлал сууж байх ёстой энэ шалгуур шаардлага заавал байх ёстой. Энэ үүднээсээ энэ явах ёстой гэж үзэж байгаа. Үндэсний аюулгүй байдал бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалахад зайлшгүй шаардлага бүхий байх гээд нэмэлт шаардлагууд тавигдаж байгаа. Энэ зайлшгүй бас байх ёстой байх.

Өнөөдөр бид нар ингээд юу гэдэг юм нийгмийн сэтгэл зүйг дагаад хууль санаачилдаг баталдаг. Үүнийх нь сөрөг үр дагаврууд их гардаг. Дараад нь үүнийгээ засах гэж бөөн юм болдог. Иймэрхүү цөөнгүй жишээ байж байгаа. Эс үгүй бол өөрчилдөггүй. Хэн нэг нь захиалгын асуудал үүсдэг. Тухайлах юм бол хуурамч шатахууны тухай хууль. Хуурамч шатахуун хийгээд олон мянган иргэд олон 100 саяын үнэтэй хөрөнгөөр хохирсон. Энийг Улсын Их Хурал дээр хязгаарласан хориглосон харамсалтай нь ҮХЦ дээр очоод боссон. Одоо өнөөдөр ингээд хуурамч шатахуун хэрэглэх бололцоотой болчихсон явж байгаа. Энийг ч Улсын Их Хурал шийдэж чадахгүй л явж байна. Олон нийтэд таалагдах гээд хууль санаачилдаг. Нэмэгдсэн өртгийн албан татварыг 5 хувь болгоно гээд. 5 хувь болох юм бол үндсэндээ Монгол Улсын төсвийн орлого бүрдэхгүй. Төсвийн орлого бүрдэхгүй бол цалин, тэтгэвэр, хүүхдийн мөнгөө өгч чадах уу чадахгүй юу асуудал үүснэ. Сая бас бид нар ярьж эхэллээ.

Хүн амын орлогын ХХОАТ-ыг нэг хувь болгох. Энийг бид нар шатлалтай тогтооё гэж ярьж байгаа юм. 5 хувь Улаанбаатарт, 3 хувь хөдөөд аймгийн төвд, нэг хувь хөдөө суманд гэдэг ч юм уу. Тэгэхгүй бол улс даяар нэг хувь болчих юм бол дахиад л сөрөг үр дагавартай. Иймэрхүү юмнуудыг бид нар нэг тал талаас нь хардаг баймаар байгаа юм. Энэ хуулийн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноороо иймэрхүү юмнууд харах бололцоо боломж бүрдэх юм байна гэж харж байгаа.

Өнөөдөр Монгол Улс 437 хуультай. Энэ хууль нь 2403 заалттай байна гэж байгаа. Үүнээс тэгвэл давсан 2500 журамтай. Үүнээс давсан. Хуулиас давсан журмаараа өнөөдөр ард иргэдийг хүнд суртал учруулдаг, чирэгдүүлдэг. Төрийн албан хаагч нар өөрсдийн давуу байдал бий болгож, шан харамж, авлигал авах нөхцөл бүрддэг.

Тийм болохоор энэ асуудлыг бас энэ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оролцоод шийднэ гэж харж байгаа. Сая бид нар Засгийн газрын тайлан хэлэлцсэн. Анх удаагаа 5 жилийн төлөвлөгөө. 1990 оноос хойш 30 жилийн хугацаанд анх удаагаа 5 жилийн төлөвлөгөө хэлэлцсэн. 4 жилийн мөрийн хөтөлбөр гэдгийг нь хэлэлцсэн. Нэг жилийнхээ тайланг хэлэлцсэн. Энэ дээр олон давхардал байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд Улсын Их Хурлын Тамгын газарт хяналт тавина, ЗГХЭГ-т хяналт тавина аа. Үндэсний аудитын газарт хянаана. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар хянаана гээд олон давхардалтай алийг нь хянах юм? Бодлогын хяналт, нийслэлийн хяналт, гүйцэтгэлийн хяналт, санхүүгийн хяналт гээд олон хяналтууд байж байгаа. Энэ дээр аль нь тодорхой биш. Нөгөө хэмжиж чадахгүй, хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй. Хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй. Энэ асуудлыг бид нар шийдэх ёстой байж байна. Ийм давхардал байж байна. Энийг энэ хуулиар оруулж ярилцаад шийдэх ёстой болов уу гэж бодож байгаа юм.

Хийдлийн асуудал. Алсын хараа-2050 гээд урт хугацааны хөгжлийн бодлогоо бид баталчихсан. 8 зорилт хөтөлбөр батлаагүй байж байгаа. Энэ 8 зорилт хөтөлбөр баталмаар байна. Энийг энэ хуулиар зохицуулмаар байна. Улсын Их Хурал энэ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль зөрчсөн.

Д.Амарбаясгалан: Бямбацогт гишүүнд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжихгүйг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

6 гишүүн дэмжсэн байна.

Ингээд Хууль тогтоомжийн тухай хуулийг хэлэлцэхийг дэмжсэн санал гарлаа гэсэн үг. Нийт хэдэн гишүүн байна аа? Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд байгаа. 3 санал байна.

Бямбацогт гишүүн горимын санал гаргая.

С.Бямбацогт: Энэ нэг жоохон юу байна арай болохгүй байх аа. Гишүүд нөгөө өглөөний ирцэд 112 гишүүн байгаа. Танхимд бол 40 хүрэхгүй гишүүн байх шиг байна. Одоо ингээд хураасан санал болгон бол үндсэндээ эсрэг гарна. Сая бид нар яг ийм сургамж өнгөрсөн 7 хоногт болсон.

Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороон дээр дэмжсэн бүх саналууд Улсын Их Хурал дээр гишүүдийн ирц цөөхөн байснаас болоод бүгд боссон. Үүнээсээ болоод Улсын Их Хурлын гишүүд нөгөө бүрэн эрхийг хязгаарлах эрх нь хязгаарлагдсан. 4 жилийн хугацаанд тангараг өргөөд дараагийн гишүүн тангараг өргөснөөр Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх дуусгавар болдог. Гэтэл бид нар Цэцийн дүгнэлтийг хүлээж аваад 3 жил 6 сарын хугацаатайд Их хурлын гишүүн болчихсон. Энэ юунаас болсон бэ гэхээр үндсэндээ цөөхөн гишүүд сууж байгаад цөөхөн гишүүд саналаа өгсөн. Үүнээс болоод тэр мэргэжлийн Байнгын хороод энэ ТББХ, ХЗБХ-ны дэмжсэн санал Их Хурал дээр унасан. Одоо яг түүнтэй адилхан энэ маш чухал хуулийн төсөл. Үүнийг дагах олон хуулиудын төсөл яг ийм цөөн гишүүдээс болоод унах нь ээ.

Тийм болохоор гишүүдийн ирцийг бүрдүүлж олонх саналаа өгөх боломжтой болсон үед нь санал хураалт явуулж өгөөч Их хурлын дарга аа. Тэгэхгүй бол бүх саналууд бүгд унана аа.

Д.Амарбаясгалан: Горимын саналыг хүлээж аваад санал хураалтыг үлдсэн санал хураалтуудыг хойшлууллаа.

16.00 цагт

Дараагийн асуудалд оръё. [Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.](#)

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, ХЗДХ-ийн сайд Оюунсайханы Алтангэрэл танилцуулна аа. Индэрт урьж байна.

О.Алтангэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Алсын хараа-2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын хүн төвтэй үйл ажиллагааны үзэл баримтлал, Улсын Их Хурлын 2023 оны 114 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Хүний эрх эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхээр танилцуулж байна аа.

Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц, хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэлүүд, түүнчлэн Хүний эрх, дэвшилтэт бодлогын хүрээлэн ТББ-аас хийсэн Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал, тулгамдсан асуудал, шийдэл сэдэвт тойм судалгааны зөвлөмжүүдийг үндэслэн дараах хуулийн төслүүдийг боловсруулаад байна аа.

1.Нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцааны төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх. Өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг энэ чиглэлд уялдуулан зохицуулах замаар Монгол Улсын иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах зохицуулалт бүхий Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

2.Хуульчийн хувьд бусдаас хөлс авахгүйгээр нийтийн тусын тулд болон нийгмийн эмзэг хэсгийн эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ, эрх зүйн иргэний боловсролыг дэмжих зорилготой үйл ажиллагааг буюу нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг Хууль зүйн туслалцааны тухай хуультай уялдуулах зохицуулалт бүхий Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Эрүү шүүлт тулгах хүний хүчээр алга болох гэмт хэргийн шинжийг олон улсын гэрээ, конвенц, зөвлөмжид нийцүүлэн тодорхой болгох зорилгоор боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

4.Баривчлах шийтгэлийг оногдуулахгүй байх этгээдийн хүрээ хязгаарыг иргэдийн зүй ёсны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх хуулийн тусгай ангид заасан зөрчил үйлдсэн этгээд оногдуулах баривчлах шийтгэлийг цөөрүүлэх Улсын Их Хурлаас баталсан зарим хуультай холбогдуулан зөрчилд тооцох үйлдлүүдийг шинээр тусгах зэрэг зохицуулалт бүхий Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

5.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдлыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон шүүх, прокурор эрх бүхий албан тушаалтнууд бий болдог хүндрэл чирэгдлийг багасгах, цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх, зарим төрлийн хэргийн харьяаллын алдааг засах зохицуулалт бүхий Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

6.Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдөр буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө зөрчил үйлдсэн хүн хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэл хэвээр үйлчлэхээр заасан зохицуулалтыг өөрчилж биелэгдээгүй байгаа зөрчлийг хүчингүйд тооцох зохицуулалт бүхий Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

7.Монгол Улсын иргэнийг Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх журмыг боловсронгуй болгох, Хилийн хориг тавих эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоог хангах, Сайдын тушаалаар зохицуулж байсан хүүхдийг хилээр нэвтрүүлэх журмыг хуулиар зохицуулах зорилгоор боловсруулсан Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

8.Албаны нууцын тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох албаны нууцын хүрээ хязгаарыг багасгах. Байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцад хамруулж байгаа зохицуулалтыг эргэн харах. Иргэдийн мэдээлэл авах эрхийг хязгаарлаж байгааг арилгах зорилгоор боловсруулсан Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

9.Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хараат бус байдлыг хангах, Иргэний нийгмийн болон мэргэжлийн байгууллагын бодит оролцоог хангах, тэдгээрийг нээлттэй сонгон шалгаруулалтаар томилох зохицуулалтыг бий болгох зорилгоор боловсруулсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

10.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх бүхий хуульчдад олон улсын гэрээ конвенцын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, уг асуудлыг хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт тус хөшүүрэг бий болгох зохицуулалт бүхий Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

11.Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулах шаардлагад хүний эрхийг хангах шалгуур бий болгох зохицуулалт бүхий Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хуулийн төсөл батлагдсанаар олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүрэг тэдгээрийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмж хүний эрхийн үндэсний байгууллага төрийн бус байгууллагуудын санал эрх бүхий байгууллагаас Засгийн газарт даалгасан арга хэмжээ, хууль тогтоомжид хүний эрхтэй холбоотой зөрчил дутагдлыг засахад тодорхой ахиц дэвшил гарна гэж үзэж байгаа. Иймд хуулийн төсөл төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хуулийн төсөлд үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүний эрхийг олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх зорилгын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрүүдэн шүүх гэмт хэргийн шинжийг олон улсын конвенцод нийцүүлэн өргөжүүлэх, өмгөөлөгчдийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг энэ чиглэлд уялдуулан зохицуулах замаар иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, баривчлах шийтгэлийг оногдуулахгүй байх этгээдийн хүрээ хязгаарыг иргэдийн зүй ёсны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх. Хуулийн тусгай ангид заасан зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулах баривчлах шийтгэлийг цөөрүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх, зарим төрлийн хэргийн харьяаллын алдааг засах, Монгол Улсын иргэнийг улсын хилээр гаргах эрхийг түдгэлзүүлэх журмыг боловсронгуй болгох, Хилийн хориг тавих эрх бүхий байгууллагын уялдаа холбоог хангах, насанд хүрээгүй хүүхдийг хилээр нэвтрүүлэх журмыг хуулиар зохицуулах, албаны нууцын тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлж Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах шаардлагад хүний эрхийг хангах шалгуур бий болгох зэрэг зохицуулалтыг тусган боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад томоохон дэвшил авчрах боломжтой болж, цаашид хүний эрх, эрх чөлөөг хангах,

хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хөхүүлэн дэмжихэд чиглэсэн бусад хууль тогтоомжийн төслийг тодорхой төлөвлөлт үе шаттайгаар боловсруулах нөхцөл бүрдэх бөгөөд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад зардал үүсэхгүй гэж төсөл санаачлагч үзсэн байна аа.

Хуулийн төслийг dparliament.mn цахим хуудаст байршуулж иргэд олон нийтээс санал авч байгаа болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг багц хуулийн төсөл нь нэг үзэл баримтлалтай байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтаар зөрчилдөж байгаа эсэх талаар, хуулийн төсөл дэх Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан өмгөөлөгчийн нийтэд тустай үйл ажиллагаа хууль зүйн мэргэжлийн туслалцааг үнэ төлбөргүй хийх зохицуулалт нь оновчтой эсэх талаар, хүний нэр төрийг доромжлон харьцахыг Эрүүгийн хуульд гэмт хэрэг орон нэмж тусгаж байгаатай холбогдуулан Зөрчлийн хууль тогтоомжийн хүрээнд оногдуулсан торгууль шийтгэлийг чөлөөлөх асуудлын зардлын талаар, Монгол Улсын иргэн гадаадын хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан томилгоотой холбоотой зохицуулалтын үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг багц хуулийн төсөл дэх Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан төрийн болон албаны нууцын ангилал, зааг ялгааг хэрхэн тодорхойлсон талаар, үүнтэй холбоотой хууль санаачлагчийн хийсэн судалгааны талаар асуулт асууж хариулт авлаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа талаар байр сууриа илэрхийлж, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хуулийн төслийн агуулгын хувьд дэмжиж байгаа хэдий ч Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа аль нэг ерөнхий хуулийн үзэл баримтлалыг боловсруулан өргөн мэдүүлэх шаардлагыг хангаагүй талаар, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох эх сурвалжийн талаар талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зохицуулалтуудыг тусган багц хуулийн төсөл хэлэлцэж байгааг хангахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагын талаар, Засгийн газраас өргөн мэдүүлсэн эдгээр багц хуулийн төслийн жишгээр цаашид хүний эрхтэй холбоотой бүх хуулиудыг багцлан оруулж ирэх жишиг тогтох эрсдэлийг тооцож анхаарах нь зүйтэй гэж тус тус үг хэллээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна гэж заасны дагуу санал хураалт явуулахад Байнгын хороонд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бөгөөд Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуулийн төсөл болох Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл ХЗДХ-ийн сайд, Батзэвгийн Энхболд ХЭҮК-ын гишүүн, Нэргүйн Мягмар ХЗДХЯ-ны ТНБД, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Цоодолын Батболд УЕП-ын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Ичинноровын Баатархүү ГИХГ-ын Захиргаа удирдлагын газрын дарга, Баатарсүрэнгийн Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Доржхүүгийн Сандаг ШШГЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Батсүхийн Батдэлгэр ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны дэд дарга, Төмөртоогогийн Эрдэнэлхагва ЦЕГ-ын хэрэг бүртгэх албаны зөрчлийн хэрэг бүртгэлд мэргэжил арга зүйн хэлтсийн дарга, Отгоны Сувд-Эрдэнэ ХХЕГ-ын ХХЕГ Шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга, хурандаа, Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд ХЗДХЯ-ны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Лхагвын Данзанноров Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч, өмгөөлөгч, Алагаагийн Амарсайхан Хууль зүйн туслалцааны төвийн мэргэжил арга зүйн хэлтсийн дарга, Олзвойн Мандах ХЗДХЯ-ны Нийтийн эрх зүйн хэлтсийн шинжээч, Шолтойн Маяа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Ирсэн ирцийн дарааллаар Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууна. Алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой энэ зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг агуулгын хувьд бүгдийг нь дэмжиж байгаа. Эдгээр хуулийн төсөлд тусгагдсан энэ асуудлууд нь яг цаг үеэ олсон. ер нь бол зайлшгүй тодотгоод энэ хуулийг батлах зайлшгүй шаардлага байгаа юм. ХЗДХЯ-ан дээр ч гэсэн нэлээд цаг хугацааг өнгөрөөчихлөө. Өмнө ч гэсэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд шинэ дэгийн хуулиар буцсан байгаа. Тэгээд Алтангэрэл сайд энийг шуурхай оруулж ирж байгааг зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгэхдээ 1 зүйл байгаа юм дарга аа. Энийг цаашдаа нөгөө Уянгахишиг гишүүн нэг үгэн дээрээ хэлсэн.

Энэ Хууль тогтоомжийн хуулийн 14.4 дээр хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэгт хамт хэлэлцүүлэхээ багцлан боловсруулж өргөн мэдүүлж болно гэж заасан. Ингээд багцлан мэдүүлж байгаа бол хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа Ерөнхий хуулийг дагаж анхдагч хуулийн төсөл болон шинэчлэн найруулах нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг дагалдуулж болно гэсэн. Тэгэхээр энэ хуулийн үзэл баримтлал маань зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэхихээр аль хуульд хувийн хэрэг нь орох нь мэдэгдэхээ бичээд байгаа юм.

Тэгэхээр уг нь бол ингээд Хууль зүйн туслалцааны тухай хуулиа малгайлаад хууль зүйн туслалцааны хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ч гэдэг юм уу ингээд үзэл баримтлалаа тодорхойлоод ороод ирвэл энэ хуулийн хувийн хэргийн хувьд их зөв болох байсан юм аа. Тэгээд ийм зүйлүүдийг нэг цаашдаа Улсын Их Хурлын яг өргөн мэдүүлэгтээ зөв болгож авахгүй болохгүй бол бас болохгүй. Тэгэхдээ энэ дээр бол нэг их тийм аймаар хуулийг хэлэлцэхгүй байх тийм эрсдэл үүсээгүй гэж үзэж байгаа. Тийм учраас энэ хуулийн төслийг зарчмын хувьд хэлэлцээд явъя гэдэг зүйлийг дэмжиж байгаа гэдэг зүйлийг хэлмээр байна.

Тэгээд Алтангэрэл сайдаас хоёрхон зүйлийг л асууя гэж бодож байгаа юм. Өмгөөллийн хууль дээр бодлогын хувьд зүгээр сайд ямар байр суурьтай байна? Иргэн захиргаагаар мэргэшсэн хүмүүс чинь яг томилолтын өмгөөлөгч буюу эрүүгийн хэрэг дээр ерөнхийдөө хийхэд их хүндрэлтэй байдаг. Тэгэхээр тэр хүмүүс яг мэргэшээгүй салбараасаа хүний эрхийг хамгаалж бас мөрдөн байцаах ажиллагаанд оролцоно гэдэг их төвөгтэй. Тэгэхээр иргэн захиргааны чиглэлээр ч гэдэг юм уу мэргэшсэн хүмүүс нь хураамж төлөх байдлаараа нийтэд тустай үйл ажиллагаагаа хааж болох уу? Тэр орж ирсэн хураамжаар нь буцаагаад яг эрүүгийн чиглэлээр мэргэшсэн өмгөөлөгчдийг авч ажиллуулж хүний эрхийг илүү их чанартай хангах чиглэлд ийм өөрчлөлтийг Өмгөөллийн тухай хууль дээр ингээд тусгаж болох уу? Энэ дээр та ямар байр суурьтай байдаг вэ гэдэг зүйлийг 1 дүгээрт хариултыг авъя гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт яах вэ зүгээр энэ харилцаа холбоо болон зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын хуулийг буцаачхаад байгаа. Тэгэхээр уг нь эдгээр асуудлаас харилцаа холбоог нь буцаалаа гэхэд уг нь тэр дагаж мөрдөх журмын хуулийг ингэж босгож ирээд хэлэлцээд явчихмаар байгаа юм л даа. Тэгээд таны байр суурь ямар байгаа вэ Алтангэрэл сайд. Энийг ингээд хууль санаачлагчид нь буцаах нь ямар үр дагавартай байна? Энийг Улсын Их Хурлаас дэмжиж босгож ирээд уг нь хэлэлцээд явбал зөв зүйл үү? Нийгэмд тулчхаад байгаа асуудал байгаа.

Тэгэхээр энэ дээр та бас нэг тодорхой байр сууриа хэлээч гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Би Өмгөөллийн тухай хууль дээр Сайнзориг гишүүнтэй санал нийлж байна аа. Ер нь өнгөрсөн жилүүдэд манай өмгөөлөгч нар хуучин хуулийн эрх зүйн орчинд жилдээ 2 удаа үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа үзүүлдэг байсан. Ноднингийн 7 дугаар сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн хуулийн дагуу ХЗДХ-ийн сайд журам батлаад энэ үйл ажиллагаа явж байгаа. Тэгэхээр энэ үеийн үед яг энэ пробоны үйл ажиллагаатай холбоотой зүйл дээр нэн ялангуяа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгч нарын мэдлэг туршлагын асуудал хөндөгдөж байсан. Хэдийгээр сургуульд бүгдээр хуулийн сургуульд бүгдээр адилхан заалгаж байгаа боловч яг практик дээр гараад ирэхээрээ иргэний чиглэлээр явдаг, захиргааны чиглэлээр явдаг, энүүгээрээ дагнадаг, эрүүгийн процесст оролцдоггүй хүмүүс байдаг аа. Тэгээд ер нь бол энэ хуулийн төслийг боловсруулахдаа Монголын өмгөөлөгчдийн холбооноос санал авсан. Тэгээд яг хуулийн төсөл яригдаж байгаатай холбоотойгоор дахиад хэлэлцүүлэг зохион байгуулъя гээд Монголын өмгөөлөгчтэй холбоотой хамтраад 4 дүгээр сарын 9-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгуулахаар ярьж байна. Одоо хэдүүлээ энэ хуулийнхаа хүрээнд ер нь энэ төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлж байгаа хуульчийн нийтэд тустай үйл ажиллагааны хүрээ хязгаар ямар байх юм. Ямар цар хүрээг хамрах юм, хуульчид яаж оролцох юм гэдгийг нэг сайн цэгцлэх ёстой. Энэ дээр бол Сайнзориг гишүүнтэй санал нэг байна.

Харилцаа холбооны тухай хууль болоод тэр зөрчлийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудыг дэмжихгүйгээр буцаасан. Зөрчилтэй холбоотой нэг л асуудал байгаад байгаа юм. 2017 оноос өмнөх зөрчлүүд өнөөдөр ингээд иргэдийн мэдээлэл дээр гараад яваад байдаг. Давхардсан тоогоор 200 гаруй мянган зөрчил байгаа. Тэгээд энэ болохоор шинэ Зөрчлийн хуулиараа зарим нэгэн зөрчилд тооцогдохгүй болчихсон, оногдуулах торгууль шийтгэл нь багасчихсан. Үгүй тэгээд энэнээс хойш Эрүүгийн өршөөлийн хууль батлаад өршөөчихсөн хэрнээ, одоогоос энэ 8 жилийн өмнөх энэ асуудлаар нь иргэдийн нөгөө өөр дээр нь бүртгэлтэй зөрчилтэй гэсэн ийм мэдээлэл явуулаад байгаа юм. Тэгээд энийг нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, цаг хугацааны хувьд өнгөрчихсөн, маш олон иргэдэд энэ нэн ялангуяа хөдөө орон нутгийн иргэдэд дарамттай ийм нэг араас нь дагаад яваад байдаг нэг ийм статистик болчихоод байгаа юм аа.

Тэгэхээр бүгдээрээ хууль зүйн зарчмаа бодъё. Эрүүгийн хэрэгтэй хүмүүсийг бид нар өршөөчихсөн. Тийм байж байж 2017 оны Зөрчлийн хуулиар энэ торгууль төлбөрийг ингээд нэхээд явдаг нь утгагүй байна аа. Дээрээс нь эдгээрийн чинь зарим нэг хэсэг нь одоо байхгүй болчихсон. Зөрчилд тооцогдохоо больчихсон. Энэ чинь хуулийн зарчим шүү дээ. Тэгээд 70 гаруй мянга нь энэ оногдуулж байгаа шийтгэлийн хэмжээ нь багасчихсан.

Ийм байгаа учраас Их Хурлын эрхэм гишүүдийг яг энэ хуулийн төслийг хэлэлцэх талаас нь дэмжиж өгөөсэй гэсэн ийм хүсэлтэй байгаа.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Тэгэхээр би нөгөө Алтангэрэл сайд яг бодит үнэнийг л хэлж байгаа юм. Энэ Зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын хуулийг гишүүд маань нэг кнопдоо хүрэхгүйгээр босгоод ирээч. 2017 оноос өмнөх юм байгаад

байгаа юм. 1993 он Захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад хуулиудаар оногдуулчихсан байсан зөрчлүүд, зарим нь ч ингээд биелэгдээгүй ийм зүйлүүд ингээд түүх үүсчихсэн байдаг. Уг асуудлыг бас нэг шийдье гээд тэгсэн. Тухайн үедээ дэмжлэг аваагүй юм. Тэгээд энэ зүйлүүдийг нэг цэгцлээд бас нэг иргэддээ энэ ойлгомжтой хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд нь нэг шийдчихмээр байгаа юм аа. Тэгээд энэ нөгөө Зөрчлийн тухай хуулийнхаа ерөнхий анги дээр заасан зарчимтай бол зөрчилдөхгүй. Эрх зүйн байдлыг нь дээрдүүлж байгаа учраас энийг босгож ирээд хэлэлцээд ингээд шийдчихэд бол ямар нэгэн байдлаар иргэдийн эрхийг зөрчөөд байх зүйл байхгүй. Харин зүгээр дордуулж байгаа байвал болохгүй гэдэг энэ зарчимтай нийцэхгүй. Тэгээд ХЗБХ-н дээр энэ дордож байна гэдэг үндэслэлийг дурдаж байгаад дэмжихгүй.

Д.Амарбаясгалан: Доржзодовын Энхтуяа гишүүн асуулт асууя.

Д.Энхтуяа: Хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байна. Тэгэхээр энэ хууль хэлэлцэгдсэнээр хохирогчийн аюулгүй байдал, нийгмийн эмзэг бүлгийнхэнд одоо хууль зүйн туслалцаа үзүүлэх албадан эмчлэх гэх мэт маш чухал чухал өөрчлөлтүүд орох юм байна гэсэн ийм үүднээс би дэмжиж байна аа.

Тэгэхээр хүний эрх эрх чөлөө бол хаана их зөрчигдөөд байна вэ гэхээр өнөөдрийн яг бодит байдал дээр бол гэрч болон хохирогч болсон хүмүүс дахин гэрч хохирогч болсныхоо хүчинд гэх юм уу энд нэмж хохирдог ийм асуудал өнөөдөр энэ амьдрал дээр байна аа. Тэгэхээр 2013 онд батлагдсан Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль гээд 2014 оноос эхэлж хэрэгжиж эхэлсэн. Тэгэхээр энэ хууль 14 оноос хойш 10 гаруй жил ямар нэг байдлаар засвар ороогүй. Шинэчилсэн найруулгаар шинэчлэгдээгүй, өөрчлөгдөөгүй учраас энэ хууль бол нэг бол маш гайхамшигтай хууль болоод энэ амьдрал дээр маш сайн хэрэгжиж байгаа эсвэл асуудал байна гэж ингэж харж байгаа юм аа.

Тэгэхээр амьдрал дээр гарсан судалгаагаар бол хүний эрх эрх чөлөө бол яг энэ хохирогч болсон хүн дахиж хохирч байна. Ямар нэгэн буруутай үйлдлийн гэрч болсноороо дахиж хохирч байна аа. Тэгэхээр гэрч хохирогчийг хамгаалах энэ хуулийн хэрэгжилт ямар байдаг юм бэ? Одоо энэ орж ирж байгаа шинэчилсэн найруулга дээр энийг ямар хэлбэрээр засаж залруулж орж ирж байгаа юм бэ гэсэн нэг ийм асуулт байна.

Хоёрт нь 2014 оноос хэрэгжиж эхэлсэн одоо бас л энэ Тэмүүжин гишүүн сайд байхдаа энэ Тахарын алба гээд нэлээн мэдээллийг өгч энэ Тахрын албыг бол 2014 онд байгуулсан санагдаж байна. Харамсалтай нь 2017 онд энэ Тахарын албыг татан буулгасан байгаа. Ямар учраас татан буулгасан юм бэ? Яг энэ хохирогчийн асуудлыг ингээд яриад үзэхэд ер нь энэ хөгжчихсөн хүний эрхийг дээдэлсэн энэ улс орнууд чинь бүгдээрээ л энэ төрийн зүгээс энэ эмзэг бүлгийнхэндээ өмгөөллийг бол өгч байна, мөн Тахрын алба гээд энэ гэрч хохирогчийг хамгаалах ийм тусгай төвүүд албууд ингэж ажиллаж байна гэх мэтчилэн маш их энэ хохирогчийг бол эрх зүйн орчинд ч тэр эдийн засгийн хувьд ч тэр эргээд энгийн амьдралдаа ороход ч тэр маш их ийм дэмжсэн ийм дэмжлэгүүд бодлогын түвшинд хууль эрх зүйн орчинд ч гэсэн хамгаалагдсан байдаг юм байна лээ.

Тэгэхээр энэ хууль хэрэгжсэнээрээ ямар ямар өөрчлөлтүүд орох юм бэ гэдэг дээр нэг хэдэн асуулт ажлын хэсгээс асууя.

Энэ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль үүргээ гүйцэтгэж чадаж байгаа юу? Энэ хуульд тулгарч байгаа бэрхшээл юу байгаа вэ? Энэ одоо орж ирж байгаа энэ хууль батлагдсанаар ямар томоохон өөрчлөлт орох вэ гэсэн 1 дүгээр асуулт байна.

Хоёрт нь Монгол Улсад гэрч, хохирогчийг хамгаалах ямар арга зам ямар ач холбогдолтой бодит ажлыг авч хэрэгжүүлж байгаа юм бэ?

Гуравдугаарт нь бол энэ түр хамгаалах байрууд гээд энэ түр хамгаалах байруудаар очиж байсан. Ер нь хүний эрхийн зөрчил бол энэ түр хамгаалах байруудад бол маш их зөрчил гардаг юм байна лээ. Тэгэхээр энэ түр хамгаалах байрны асуудлыг ямар цогцоор харж байгаа вэ? Гэрч хохирогчдод ямар нэгэн төрлийн нөхөн олговор олгож байгаа юу? Ер нь энэ гэрч, хохирогчдод олгодог нөхөн олговрын ямар нэгэн сан ч юм уу, эс үгүй бол санхүүгийн нөхөн төлбөрийн ямар нэгэн механизм манайд үйлчилж байгаа вэ? Энэ асуудлыг энэ хуульдаа энэ шинээр оруулж ирж байгаа энэ өөрчлөлтдөө ямар байдлаар тусгаж байгаа вэ гэсэн ийм асуулт байна.

Эцэст нь 2024-өөс 28 оны Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт Ази тивийн хүний эрхийн төв байгуулна гэж ингэж орсон. Энэ мөрийн хөтөлбөр батлагдсан байгаа. Тэгэхээр энэ мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт явц энэ Ази тивийн хүний эрхийн төв байгуулах энэ асуудал ямар шатдаа явж байгаа вэ? Сайдаас асууж байна.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль 2013 онд батлагдсан. Тэгээд үүний дараа Тахрын алба байгуулагдаад яг гэрч, хохирогчийг хамгаалдаг шүүхийн аюулгүй байдлыг хамгаалдаг мэргэшсэн бүтэц үүсэж ингэж мэргэшиж эхэлсэн. Харамсалтай нь өнөөдөрт энэ Тахрын алба байхгүй. Үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа. Нэгэнтээ чиг үүргийг нь хариуцах алба байхгүй учраас энэ чиг үүргүүд доголдож байгаа ний нуугүй хэлэхэд. Шүүх бол аюулгүй байдалдаа маш их санаа зовж байгаа. Цагдаагийн байгууллага гүйцэтгэж байгаа боловч энэ шүүгч нарынхаа аюулгүй байдлыг хамгаалъя. Тахрын албаа ер нь байгуулаач гэсэн асуудлыг ШЕЗ, шүүхийн зүгээс тогтмол тавьж байгаа.

Гэрч, хохирогчтой холбоотой зүйлүүд дээр иргэний нийгмийн байгууллагууд холбогдох албан тушаалтнууд энэ ажлыг хариуцаж байгаа хууль сахиулах байгууллагын албан хаагчид энэ гэрч хохирогчийг хамгаалах асуудлаа нэг тийш нь шийдмээр байна гэж байгаа юм.

ХЗДХЯ-ан дээр энэ Шүүхийн аюулгүй байдлын алба гээд шинэ алба байгуулаад шүүхийнхээ аюулгүй байдлыг ч хангая. Гэрч хохирогчийн алба аюулгүй байдлаа ч хамгаалъя гээд хуулийн төсөл нь гараад олон нийтээс хэлэлцүүлэг холбогдох газруудаас санал аваад явж байгаа. Энэ хохирогч болсон хүн дахиж хохирч байна гэдэг асуудал ер нь үнэн. Тэгээд энэ асуудал дээр бол бид нар яг яригдаж байгаа асуудлын хувьд гэхэд энэ Хууль зүйн туслалцааны тухай хуульд оруулах өөрчлөлтөөр яг өнөөдөр бид нар хэлэлцэх гэж байгаа Хууль зүйн туслалцааны тухай хуульд оруулах өөрчлөлтөөр хамгаалалтад байгаа гэрч, хохирогч өмгөөллийн үнэгүй туслалцаа авах бололцоог бид нар нээж өгье өө гэж. Үнэгүй өмгөөлөгчөөр хангагдъя гэсэн ийм зүйл тавьж байгаа. Ингээд ер нь энэ

хамгаалах байгууллага нь өөрөө байгуулагдаад хууль нь батлагдаад ирэхээр тэр хамгаалах байр нь хаана байх вэ. Яах вэ үйл ажиллагааны зохион байгуулалтын шинжтэй юмнууд бол бүгд шийдэгдээд байх бололцоотой. Нөхөн олговрын хувьд бол тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчдод төрөөс нөхөн олговор олгож байгаа. Тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгож байгаа. Энэ нь өөрөө сантай нөхөн олговор олгох сантай, сангийн дүрэмтэй ийм ХЗДХЯ-ан дээр байдаг сан. Тэгээд яг ямар тохиолдолд нөхөн олговор олгох вэ гэдэг нь ингээд байж байгаа.

Энэ Ази тивийн хүний эрхийн төвийн хувьд бол өнөөдөр бид нар хэлэлцэх гэж байгаа энэ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд яагаад өөрчлөлт оруулах гээд байгаа вэ гэхлээр бид нар хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрөө хөгжлийн бодлого төлөвлөлтийн хөтөлбөр гэдэгт оруулахын тулд ер нь энд ингэж өөрчлөлтийг оруулж өгч байгаа. Тэгээд хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрөө бид нар энэ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн хуульд оруулаад цаашдын хэрэгжилтийн асуудал дээр нь бид нар одоо энэ Ази тивийн хүний эрхийн төв байгууллага болон бусад энэ хууль тогтоомжтой хүний эрхийн чиглэлийн асуудлыг тусгах хүний эрхийн чиглэлийн судалгааг дэмжих гэсэн энэ чиг үүргүүдээ цаашаа хэрэгжүүлэхэд дөхөмтэй болно оо. Энийгээ бид нар оруулах ёстой гэж үзэж өнөөдрийн хуулийн өөрчлөлтөд оруулсан байгаа юм аа.

Д.Амарбаясгалан: Энхтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Энхтуяа: Эмзэг бүлгийн болон мөн хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт хүмүүсийн хохирсон хохирогчдын өмгөөллийн чанар маш муу байна гэж ингэж яригддаг. Тэгэхээр энэ өмгөөлөгчдийн энэ нөхөн төлбөрийн асуудлыг энэ сангаасаа зохицуулдаг гэж ойлгож болох уу?

Д.Амарбаясгалан: Үг хэлчихлээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя. Манай гишүүд хурууныхаа хээг уншуулахгүй бол нэр нь гарч ирэхгүй байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан эрхүүдийг нь баталгаажсан эрхүүдийн нэг нь иргэний мэдэх эрхийн хүрээнд төрийн байгууллагаас иргэн хүн мэдээллээ авах эрхтэй л гэсэн байдаг. Үндсэн хууль дээр. Эдгээр нь зөвхөн Үндэсний аюулгүй байдал болоод батлан хамгаалахтай холбоотой асуудлаар мэдээж хязгаарлаж болно гэж байдаг. Гэтэл 2016 онд өөрчлөлт орсон байна уу? Төрийн болоод төрийн нууцын тухай хуулийг нэлээн өргөжүүлээд Төрийн болон албаны нууцын тухай хууль гээд өргөжчихсөн. Энэ хүрээнд тэгээд байгууллагууд асар олон гэрээ хэлэлцээр ашиг сонирхлын зөрчилтэй ч байж болох олон зүйлүүдийг төрийн нууцад авдаг болчихсон. Иргэний мэдэх эрх, энэ зөвхөн мэдэх эрх төдийгүй бид нарын ярьж байгаа өглөөхөн хүртэл яригдаж л байсан нь авлигалын тийм үржил шимтэй тийм хөрс суурь бий болчихсон. Төр хэчнээн том байдаг билээ. Салбар салбарт төр ТӨК. Тэгэнгүүтээ энийгээ бүгдийг нь төрийн болоод төрийн албаны тухай нууцаар бүгдийг нь нууцад авчихдаг. Тэгэхээр энэ өөрөө ингээд тал талдаа ингээд асуудал дагуулсан олон олон тэр авлига болоод олон олон хүний эрхийг хязгаарласан олон зүйлийг нь үржил шимтэй тийм суурь хөрс л болчихож байна л даа.

Тэгэхээр энэ асуудал энэ дагалдах хуулиуд дээр харагдаж байсан. Тэгэхээр энэ хуулийн хүрээнд мэдээж судалгаа хийсэн байх. Яг өнөөдөр Монгол Улсад

нууцад авчихсан төрийн нууцад авчихсан, энэ мэдээж дотор нарийн ширийн нь биш юм гэхэд тоо баримтууд нь энэ чинь хэлж болдог зүйл байдаг байх. Хэчнээн баримт бичиг байдаг юм, албаны нууцад авчихсан, аль аль байгууллага албаны нууцад авчихсан, хэчнээн ямар баримт, материалууд байдаг юм. Эдгээр нь санхүү эдийн засгийн харилцаатай холбоотой ер нь ямар мөнгөн дүн нь энэний цаана яригддаг юм. Төрийн болоод албаны нууцад авчихсан. Өнгөрсөн жилүүдэд баахан л юм ярьцгаасан бараг тэгээд бүгд нууцад орчихсон болоод л дууссан. Яг энэнтэй холбоотой тодорхой тоо баримтуудыг та хэлээч. Одоо тэгээд энэ дараагийнх нь энэ хуулийн үзэл санаа энэ хуулийн зүйл заалтын хүрээнд энэ хуульд ямар өөрчлөлтүүд орж байгаа юм? Энийг хүрээ хязгаарыг нь яаж хумьж байгаа юм? Энэн дээр тодорхой зүйлүүд хэлээч хэлж өгөөч?

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Өнгөрсөн хугацаанд энэ төрийн болон албаны нууцтай холбоотой асуудлууд нэлээн яригдсан. Тэр ногоон автобусны хэрэг гэдэг ч юм уу тодорхой зүйлүүд дээр ингээд нууцад авч байгаад ингээд худалдан авалт хийчихдэг хулгай луйвраа халхалдаг гэж асуудал яригдаж ирсэн. Өнөөдөр 39 төрийн байгууллагын өнөөдөр нөгөө нууцын талаар статистик нь нийт 572 төрийн нууц байна. 1043 байгууллагын нууц байна гэж гарч байгаа.

Тэгэхээр 39 байгууллага бол төрийн нууцтай холбоотой асуудал эрхэлж байна, 1043 байгууллага бол ингээд байгууллагын нууц гэдэг зүйлийг хэрэглэж байна аа. Байгууллагын нууц гэдэг дардас дардаг, олон нийт гаргамааргүй, бусдад мэдэгдмээргүй мэдээллээ ингээд тавьчихдаг. Уг чанартаа бол тэр дотор нь ерөөсөө албаны нууцад авах ямар ч шаардлагагүй зүйлүүдийг оруулаад нууцыг нь дардас дарчихдаг. Үүнийг нь ямарваа нэг албан тушаалтан юм уу олон нийтийн байгууллагын төлөөлөл тухайлах юм бол сэтгүүлч гаргах юм бол энэ өөрөө хуулийн дагуу хариуцлага хүлээх болчихоод байдаг ийм зүйл байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ албаны нууцад авах шалгуурыг тодорхой болгож байгаа юм. Ер нь юуг албаны нууц гэх юм бэ? Яг л ийм зүйлүүд албаны нууцад чинь хамаарна гээд одоогийн нууцалж байгаа зүйлүүдийн дийлэнх нь албаны нууцад хамаагүй зүйл дээр бид нар дардас дарж байна гэж үзэж байгаа.

Тэгээд энэ жагсаалтаа гаргаад энэ дээр нь тагнуулын байгууллага дүгнэлт гаргая. Энэ чинь яг албаны нууцад хамаарч байна уу үгүй юу гээд. Тэгээд бүтэн жилийн үйл ажиллагаанд нь өнгөрсөн хугацаанд албаны нууцдаа авч байсан тэр зүйлүүд нь яг албаны нууцдаа хамаарч байсан юм уу, хуулийн шаардлагыг хангаж байсан юм уу гэдэг талаас нь үнэлэлт дүгнэлт өгөөд хийгээд хяналт шинжилгээ хийдэг байя. Тэгээд хэрвээ албаны нууцад оруулахгүй зүйлийг өөрийнхөө хувийн эрх ашиг болоод явцуу эрх сонирхлоор албаны нууцад хамааруулаад энэ хуулиар хориглосон хэм хэмжээг давсан тухайн албан тушаалтанд хариуцлага тооцдог байя л гэж байгаа юм.

Урьд нь хэт ерөнхий байсан асуудлыг л бид нар энэ шалгуурыг тодорхойлж байгаа. Тэгээд өнгөрсөн хугацаанд яригдсан зүйлүүд дээр үнийн дүн бол тэр олон албаны нууцтай холбогдох санхүүгийн үнийн дүнг хариулж чадахгүй байна. Уучлаарай.

Тэгэхдээ тэр нэг оффтейк гэрээ гэдэг чинь л жишээлбэл албаны нууц гэдэг ийм ангилалтай л олон сая тонноор яригдах нүүрс олон 100 сая доллароор яригдах зүйлүүд л тэр оффтейк гэрээ гэдгээр чинь байсан. Гэтэл олон нийтийн зүгээс бол бид ер нь тийм нүүрс худалдаж байгаа, борлуулж байгаа гэрээг жишээлбэл тэр албаны нууцад хамааруулаад байх шаардлага байсан юм уу үгүй юү гээд үзвэл энэ чинь өөр л хариу гарч байгаа байхгүй юу.

Тэгэхээр хэдүүлээ нэг албаны нууцаа учиртай болгоё. Төрийн нууц бол тусдаа зохицуулагддаг, хуультай, хянадаг байгууллагатай, мэргэжлийн чиг үүргээрээ тагнуулын байгууллага энэ асуудлаа хариуцаад явчхаж байгаа. Бусад тэр нь албаны нууц гэдэг том малгайгаа л хэдүүлээ авч хаяа аа. Энэ нь өөрөө эргээд хүний эрхийг таны дурдаж байгаа энэ мэдэх эрхтэй холбоотой эрхийг хангахад чиглэгдэх юм байна гэсэн зорилгоор хуулийн төслийг боловсруулсан.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Би нэг 3 багц асуулт асуугаадахъя.

Нэгдүгээрт юуны өмнө ямар ч байсан энд манай Хүний эрх дэвшил бодлогын хүрээлэнгийн судалгаанууд дээр дурдсан нэлээн асуудлыг энэ удаагийн багц хууль дээр оруулж ирж байгаад талархаж байна. Гэхдээ бас нэлээн өнгөц дээрээс нь зарим нэг зүйлүүдийг жаахан орхигдуулсан зүйл байна. Гэхдээ яах вэ энийг бол би дараагийн удаа дахиж нэмж дахиад хүний эрхийн нөхцөл байдалтай холбоотой энэ зарим бусад хуулиудын асуудлыг оруулж ирэх байх гэж бодож байна.

Асуулт 1 дүгээрт энэ хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр гээд энэ 2 орж ирж байгаа. Дагалдаад үүнтэй холбоотой яг нөгөө хэрэгжүүлэх механизмынх нь асуудлууд, дахиад нөгөө Эдийн засаг, хөгжлийн яаман дээр нөгөө бусад хөтөлбөртэй адилхан Эдийн засаг, хөгжлийн яаман дээр энэ асуудал зангидагдаж орж ирэх үү яах вэ? Тэр механизм ерөөсөө энэ дээр тусаагүй байна, нэг. Энийг нэг тодруулъя.

Хоёрдугаарт сүүлийн үед бид нар ер нь юм л хөөн хэлэлцэх хугацаагаар л их л оролддог болчихлоо л доо. Зарим тохиолдолд бүүр хөөн хэлэлцэх хугацаагүй байх ёстой ч гэж яригдаж байна. Тэр нь нэг талдаа хохирогчийн эрхийг хамгаалж байгаа мэт боловч энэ чинь өөрөө хүний эрхийн асар том зөрчлийн асуудлыг үүсгэдэг маш үр дагавартай. Ер нь энэ хөөн хэлэлцэх хугацааны бодлогыг ялын бодлоготой уялдуулах энэ зүйлүүд дээр ер нь тийм цогц судалгаа Хууль зүйн яаман дээр хийгдэж байгаа юу? Хөөн хэлэлцэх хугацааг нэмчихлээр асуудал шийдэгдэх юм шиг энэ төрлийн гэмт хэрэг гарахгүй юм шиг ийм ойлголтыг бид нар нийгэмд асар их өгч байна. Тэгэхээр бид нар энийг л эрх зүйн системийн хувьд аягүй том алдаа гаргах гээд байна гэж болгоомжлоод байна. Тэгэхээр энэнтэй холбоотой судалгаа янз бүрийн зүйлүүд хийгдэж байна уу? Яагаад гэвэл энэ дээр Эрүүгийн хууль дээр хөөн хэлэлцэх хугацаа дахиад орж ирж байгаа учраас асууя.

Гуравдугаарт орж ирж байгаа хуулиуд дотор дандаа улс төрийн эрхтэй холбоотой асуудлууд нэлээн орж ирж байна. Иргэний эрхтэй холбоотой асуудлууд орж ирж байна. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхтэй холбоотой заалт зохицуулалт ер нь огт орж ирээгүй байна. Өөрөөр хэлбэл бид нар ямар ч эдийн засгийн баталгаагүй хүний эрхийг хангах эдийн засгийн баталгаа ерөөсөө хангалттай зохицуулалтууд байхгүй байгаа.

Тэгэхээр энэ тал дээр Хууль зүйн яам ер нь юу бодож ямар үе шаттай арга хэмжээ авч байна авна гэж бодож байгаа вэ вэ? Тухайлбал Хүүхдийн хорих 110 дугаар тусгай сургууль байгаа. Одоо болтол барилгын ажил ингээд л бид нар уг нь төсвийг нь баталсан боловч одоо болтол барилгын ажил нь эхлээгүй явж байсан. Бид нар өнгөрсөн тэрний өмнөх 7 хоног очиж үзэж байхад энэ мэтчилэн ерөөсөө яг ийм нийгмийн орхигдоод байгаа нийгмийн бүлгүүдийн асуудал дээр ялангуяа энэ эдийн засгийн баталгаан дээр маш онцгой анхаарах хэрэгтэй байна аа. Тэгээд тэр хүүхдийн хорихын асуудлын төсвийн асуудал дээр та нэг эргэж заавал нэг хараарай гэж хэлэх гээд байна. Баярлалаа. Энэ 3 асуулт.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Хэрэгжүүлэх механизм чухал. Тэгээд бид нар энэ удаад бол яг нэн яаралтай гэж байгаа тэгээд бид нар ер нь хэлэлцүүлээд баталчихад энэ хэсэг нь бололцоотой байна гээд хэсгээ тасалж авчхаад оруулж ирж байгаа юм. Цаашаа бол шийдвэрлэх ёстой хүний эрхтэй холбоотой асуудал зөндөө байна. Угаасаа л хүний эрх чинь тэгээд мөнхийн яригдаж байх ёстой мөнхийн анхаарч байх ёстой асуудал учраас байгаа. Энэ удаад бол бид нар энэ хэрэгжүүлэх механизмтай холбоотой зүйлийг оруулж ирсэнгүй. Тэгэхдээ хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрөө бид нар батлах юм бол тэрийг нь тунхгийн шинжтэй зүйл байна гэж ерөөсөө огт бодохгүй байгаа. Жинхэнэ энийгээ утгаар нь хэрэгжүүлэхийн тулд одоо бид нар жишээлбэл энэ хуультай холбоотойгоор ХЭҮК-той холбоотой хуулийн зохицуулалт оруулж ирэх гэж хичээсэн. Харамсалтай нь комисс маань дотроо байр суурь нь өөр байдлаас шалтгаалаад бид нар бол яг өөрсдийнх нь дотоод байр суурийг нэгтгэх л гээд байна. ХЭҮК-той холбоотой өөрчлөлтийг энэ удаад оруулж ирж чадаагүй гэх мэтчилэн ийм механизмтай холбоотой бидэнд оруулж ирэхээр санаж сэрж байгаа зүйлүүд байгаа.

Энэ хөөн хэлэлцэх хугацааны асуудал үнэхээр чухал аа. Улсын Дээд шүүхээс хамгийн сүүлд хөөн хэлэлцэх хугацааны талаар тайлбар гараад тэгээд ҮХЦ дээр хөөн хэлэлцэх хугацаатай асуудал шийдвэрлэгдээд ингээд явж байгаа. Нэг зүйлийг бол бид анхааралтай бодож байх ёстой. Ер нь гэмт хэрэгтэй тэмцэж байна гэдэг бол уг нь хуульчид бид нар бүгдээрээ л онол ном заалгаж байгаа юм. Энэ их өндөр ял шийтгэлтэй болгосноороо гэмт хэрэг байхгүй болдоггүй ээ. Хөөн хэлэлцэх хугацааг хэчнээн сунгалаа гээд гэмт хэргийн уг гаралд нь яг яаж нөлөөлж байна гэсэн криминологи судалгаа төдийлөн байхгүй ээ. Нотолгоо төдийлөн байхгүй. Тэгэхээр ер нь ингээд хэлчихвэл таалагдах болов уу гэдэг үүднээс энэ хууль тогтоомж нэн ялангуяа хөөн хэлэлцэх хугацаа бид нарын энэ эрүүгийн эрх зүйд баримтлах ёстой суурь үндсэн зарчмууд бол зөрчигдөх ёсгүй гэсэн ийм байр суурьтай байгаа. Энэ эдийн засаг соёлын эрхтэй холбоотой зүйл дээр бол таны саналыг тусгаж авлаа. Бид цааш цаашдаа үйл ажиллагаанд хэрэгжүүлье. Хүүхдийн хорихтой холбоотой асуудлууд дээр үгүй ер нь нэг ийм асуудал гарч ирж байгаа. Сая ШШГБ-тай холбоотой ер нь шүүхийн ШШГБ-д сүүлийн 10 жил огт төсөв мөнгийг нь нэмээгүй өөрсдийн дотоод орлогоороо бол гэсэн. Ингээд хорих байгууллагууд нь зарим нэг газар дусаал дусдаг, олноороо нэг өрөөнд байдаг, байр савны хангалт муутай, цэвэр ус, бохирын системийн хангалт муу гээд ингээд зарим нэг газар бүүр ерөөсөө хүн байхыг хориглочихсон шийдвэр гарсан зэрэг маш хүндрэлтэй нөхцөл байдал байсан.

Улсын Их Хурлынхаа дэмжлэгтэйгээр харин энэ жил энэ оны төсөв дээр 2025 оны төсөв дээр ШШГБ-д тодорхой хэмжээний төсөв хөрөнгө тавьж өгсөн. Энэ хүрээнд бид нар шийдвэрлэхийг зорьж байгаа. Энэ мөнгөндөө багтаагаад хийчихье гэж байгаа зөндөө олон асуудал байгаа. Тэгээд танд яг тухайлан энэ хүүхдийн хорихтой холбоотой асуудлаар танилцуулга өгье.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Хүний эрхийн олон улсын гэрээ конвенцод нийцүүлээд хүний эрхийг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өнөөдөр бид нар хэлэлцэж байна аа. Тэгээд сая Алтангэрэл сайдын хариултыг сонсоод сууж байхад зарим зүйлүүдийг жаахан хугацаа аваад нэмээд оруулчихсан бол ямар байсан юм болоо гэж бодож байсан зүйлүүд дээрээ нэмэлт тайлбар асуултуудыг танаас авъя.

Тэгээд хэдий олон улсын гэрээ конвенцод нийцүүлээд хүний эрхийг хангахтай холбоотой асуудлууд өнөөдөр яригдаж байгаа ч гэсэндээ ер нь бол Үндсэн хуулийнхаа 19 дүгээр зүйлийн 19.3-д заасан хүн эрх эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож болохгүй, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гээд яг энэ заалтынхаа дагуу л бас хөндөөд ороод ирчихсэн байсан бол дахин бүгдээрээ хүний эрхийг хангахтай холбоотой хуулиудыг ярилцахдаа илүү л хүн хөнгөн байх байсан юм болов уу гэж бодож байна аа.

Тийм учраас 4 асуулт байгаа. Тэгэхээр та сайхан хариулаад өгөөрэй. Энэ хуулиудад ер нь энэ эрх нь зөрчигдөж байгаа этгээдийн сэтгэл санааны хохирлыг арилгах тал дээр зохицуулалт ч хангалтгүй байдаг юм шиг санагддаг аа. Тэгэхээр энэ дээр Хууль зүйн яам ер нь ямар ажил хийж байгаа юм бол? Эрх зүйн орчныг нь хэзээ бүрдүүлэх вэ?

Хоёрдугаарт энэ хүчирхийллийн гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байна. Ер нь тоо хэмжээ маш их өсөж байна аа. Эмэгтэйчүүд хүүхдийг янз бүрээр дарамталж доромжилж байна, хүнлэг бус байна гээд нэлээн чих дэлсдэг. Тэгэхээр энэ дээр танай яаман дээр яг ямар хамгийн сүүлийн үеийн тоон мэдээлэл нь ямар байна вэ? Хүслээр болдог бол хариуцлагыг нь чангатгах юм сан. Тэгэхдээ та түрүүхэн хариуллаа. Хуулийн тэр санкцууд нь чанга байснаараа аливаа асуудал шийдэгдэхгүй гээд. Тэгвэл энэ чиглэлээрээ ямар ажлууд хийгдэж байна вэ? Яаж бүгдээрээ энэ гэмт хэргийн тоог багасгах вэ?

Гуравдугаар асуулт нь болохоороо гэм буруугүй хүнийг үндэслэхүйгээр баривчлаад л нэлээн тийм нэр хүндэд нь халдсан асуудлууд явдаг аа. Эрхийг нь ноцтой зөрчдөг өө. Тэгээд хэрвээ буруугүй бол нэн даруй тэр энэ хүн гэм буруугүй байсан юм гэдгийг нь нэг тийм мэдээлчихдэг бол нэг хэдэн жилийн дараа энэ хүн гэм буруугүй байсан юм байна гээд цагаатгаад байгаа нь ямар ч тийм хэрэггүй юм шиг санагдаад байдаг. Тэгэхээр энэ дээр ямар ажлуудыг хийж байна вэ?

Сүүлийнх нь болохоороо энэ эрх зүйн туслалцаа авах эрхийг хангах чиглэлээр хүсэлт гаргах тухай суусан байгаа юм. Тэгэхээр энэ дээр өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлуудад нь нэмж тусгах байдлаар энэ хуулиудад суулгах ёстой байсан юм биш үү. Энэ дээр хариулт авъя аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайдад хариулт өгье.

О.Алтангэрэл: Шүүх шинжилгээний тухай хуулийн холбогдох заалтуудаар энэ сэтгэцийн хор уршгийн зэргийг тогтоож нөхөн олговор олгох энэ журам бол хэрэгжээд явж байгаа. Шүүх шинжилгээний байгууллагаас энэ сэтгэцийн шинжээчдийг эрх олгох бэлтгэхтэй холбоотой шат дараалсан тодорхой арга хэмжээнүүд хийгээд явж байгаа. Мэдээж одоо ингээд хөгжлийнхөө үе шатад янз янзын л байдалтай байна л даа. Одоо зарим нэг хэсэг ойлгохгүй байна. Яагаад энэ сэтгэл санааны гэм хор гээд зарим хүн ингээд сэтгэл санааны хувьд гэм хор ч учирлаа гээд олон 100 саяар тоологдох хөрөнгө мөнгө яриад байна гэдэг асуудал ч ярьж байгаа. Тэгээд бид бол нэг зүйл хэлж байгаа. Гэмт хэрэгт хүн хохирохдоо зөвхөн зөвхөн бие махбодоороо гэмтэх гэмтээд ингээд үлддэггүй. Сэтгэл санааны гэм хорыг бид нар зайлшгүй ярих ёстой. Энэ хохирол нөхөн төлбөрийг ч гэсэн ярих ёстой. Боловсронгүй болгох шаардлагатай зүйлүүд байна.

Тухайлах юм бол ингээд гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хүмүүсийн ар гэрт сэтгэл санааны үнэлгээ хийхээр 3 хүүхдэд нь гурвуулаа өөр гарлаа гэдэг ч юм уу ингээд яаж зохицуулах вэ гэдэг дээр бид нар арга ажиллагааны хувьд зүйлүүд байна. Тэрнээс биш яг сэтгэл санааны гэм хорыг барагдуулах чиглэлийн энэ бодлого хэрэгжээд явж байгаа гэдгийг танд хэлье ээ.

Энэ хүчингийн гэмт хэргийн статистик мэдээлэл харамсалтай нь сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байгаа. Хорих байгууллагад ял эдэлж байгаа залуучуудын нэлээд хувийг энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгэгдсэн залуучууд, нэн аян, ялангуяа хөдөө орон нутаг алслагдмал газар амьдарч байсан залуучууд ийм хэрэгт холбогдох нь их байна аа. Ял шийтгэлийн бодлогын хувьд өнөөдөр насанд хүрээгүй этгээдийг хүчиндсэн гэмт хэрэг үйлдсэн этгээд 10-аас дээш жилийн ялтай байгаа. Тэгээд ял шийтгэлийн бодлогын хувьд харьцангуй тогтвортой байгаа. Бид бол энийг одоо цагдаагийн байгууллага юм уу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулахаас гадна ер нь энэ хөдөө байгаа залуучуудынхаа нийгэм соёлын эрхийн асуудлыг нь яаж хангах юм бэ? Хүйсийн тэнцвэртэй байдлаа бид нар яаж хангах вэ гэдэг энэ асуудалд анхаарал тавьж байгаа. Энэ Боловсролын сайдтай яриад 10 жилийн хүүхдүүдийн хичээлийн хөтөлбөрт нь энэ чиглэлийн агуулгыг тусгая гээд хамтарсан баг гараад гарын авлага гаргаад ингээд энэ чиглэлийн ажлууд хийгдэж байгаа. Гэм буруугүй хүнийг үндэслэлгүйгээр хорьсон шийтгэсэн тохиолдолд шүүхийн шийдвэр гаргаад ингээд энэ дээр гарцаагүй шүүхийн шийдвэр гарахаас өөр аргагүй байдаг.

Үндэслэлгүйгээр энэ хүнийг ингэж хорьж байсан байна гээд шүүхийн шийдвэр гарах юм бол энэнийх нь дагуу нөхөн олговор олгох асуудал явагдаж байгаа. ХЗДХЯ-ан дээр энэ гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох сангаас гадна яг энэ төрийн буруутай үйл ажиллагаанаас бусдад учирсан гэм хорыг нөхөн төлүүлэх энэ үйл ажиллагаа явагддаг. 2025 оны төсөв дээр бас энэ чиглэлийн хүмүүсийн төлбөрийг барагдуулсан ийм үйл ажиллагаа явагдсан. Харин энэ эрх зүйн туслалцаан дээр бол бид нар эрх зүйн туслалцааныхаа хүрээ хязгаарыг л аль болохоор өргөжүүлж байгаа учраас таны хэлж байгаа саналаар яваандаа та саналаа гаргаад ингээд явахад тус тусгаад явах бололцоотой гэж үзэж байна аа.

Д.Амарбаясгалан: Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Баярлалаа. 2 дугаар асуулт нь гэр бүлийн хүчирхийлэл байсан юм шүү сайд. Тэгэхээр тэрэнтэй холбоотой ямар үйл ажиллагаа ер нь явуулж байгаа юм болоо тэрэнд хариулаад өгөөрэй.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд нэмж хариулъя.

О.Алтангэрэл: Зөрчлийн тухай хуульд энэ асуудлыг авч үзэж байгаа. Өнөөдөр практик дээр ямар асуудал байна вэ гэхлээр энэ баривчлагдсан гэр бүлийн хүчирхийллийн улмаас баривчлагдсан хүмүүс дунд энэ баривчлах шийтгэлийг түгээмэл хэрэглээд байгаа юм. Хоорондоо маргалдлаа. Ингээд гэр бүлийн хүчирхийлэл болоод баривчиллаа. Энэнээс болоод маш олон гэр бүл салж байгаа. Биеийн хүчирхийлэл үйлдсэн, зодсон, дарамт үзүүлсэн бол зайлшгүй баривчилдаг байхаар. Харин бусад төрлийн тохиолдолд заавал баривчлах ялыг хэрэглэхгүй шийтгэх талаар бид нар энэ хуулийн өөрчлөлтөөр дагаж орж ирж байгаа. Практик дээр бол ерөөсөө яг энэ баривчлах байранд байгаа иргэдийг үзэхээр дийлэнх нь гэр бүлийн хүчирхийлэл байгаа. Маргалдсан муудалцсан. Тэгээд шүүх дээр хэрэг нь хүрээд ирэхээр яадаг вэ гэхээр өө бид 2 учраа олчихсон. Тэр өдөр жоохон маргалдсан юм аа, зодоогүй, ийм юм байхгүй. Тэгэхдээ ямар нэг байдлаар бид 2 эвлэрчихсэн гэдэг асуудал ярихад одоо тэр чигээр нь бүгдийг нь баривчилж байгаа хавтгайруулж байгаа явдлыг бид нар.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Улсын Их Хурал дээр хүний эрхийн асуудалд онцгой анхаарч хүний эрхийн зөрчилтэй хуулиудыг засах сайжруулах гээд олон зүйлүүд их дэвшилттэй сайн явж байгаа. Үүнийг дэмжиж байгаа. 1992 оныхоо энэ ардчилсан Үндсэн хуулиар энэ хүний эрхийг дээдлэх энэ тал дээр Монгол Улс маш дэвшил гаргасан ийм улс. Тэгээд өнөөдрийн бидний яригдаж байгаа энэ зүйлүүд ч гэсэн тэр Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйл буюу хүний эрхийн нэлээдгүй олон өргөн цар хүрээг хамарсан энэ асуудлын хүрээнд ингээд орж ирээд засаад сайжруулаад хүний эрхийг улам баталгаажуулаад ингээд явах нь гэж. Ингэж ойлгож байгаа.

Гэхдээ би энэ дээр Үндсэн хуулийн маань 17 дугаар зүйл дээр хүний үндсэн үүргийн асуудлыг бол бид нэлээн авч үзэх, харах ёстой юм уу гэж ингэж боддог. Яагаад би энэ асуудлыг ер нь ярьж байна гэвэл 2023 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах талаар ард иргэдийн санал хүсэлтийг авах энэ уулзалтуудыг Их хурлын гишүүд зохион байгуулаад явж байхад хүний эрхийн асуудал энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн нэг хэсэг болж ингэж явж байсан. Тэгээд тэр үеэр ялангуяа манай энэ ахмадууд Монгол Улсад хүний эрх ярихаас гадна яг нөгөө талд нь хүний үндсэн үүргийн асуудлыг Их хурал дээр ярьж байгаач ээ. Үүргээ биелүүлэхгүйгээс болоод бусад хүний эрх чинь хөндөгдөөд байгаа юм биш үү гэдэг ийм асуудлыг нэлээдгүй ярьдаг юм.

Тэгээд ингээд тэр асуудал ярьсан хүмүүсийг хараад байх нь ер нь голдуу ахмадууд байдаг. Тэгээд энэ ахмадууд маань бидэнд болохгүй байгаа зүйлийг анзаарч л хэлж байгаа болов уу? Их Хурлын гишүүний хувьд та энийг бүр Их Хурал дээр хэлээрэй яриарай гэж ингэж хэлж байсан юм байгаа юм. Сая ингээд чуулганы завсарлагаанаар Дорнод аймагт явж байхад Дорнод аймгийн Чойбалсан сумын иргэн ахмад хилчин Дэнзэн гэдэг хүн бас яг энэ асуудлаар хүний эрхийн асуудал

ярьж байгаа нь зөв өө дэмжиж байна аа. Нөгөө талдаа үүрэг гэдэг юмыг давхар явахгүй бол өнөөдрийн бидний яриад байгаа хүний эрхийн зөрчлүүд нөгөө талдаа үүргээ биелүүлээгүйгээс болж байгаа ийм тохиолдлууд байгаа шүү гэдэг ийм зүйлийг ярьж байгаа юм л даа.

Тийм учраас би өнөөдөр яах вэ хариулахад хаана хаанаа бэлэн биш байж магадгүй. Гэхдээ ер нь Монгол Улсын парламент цаашдаа энэ улс орныхоо энэ олон тулгамдсан асуудал юмнуудыг шийдэн энэ цаг үе, энэ хүний эрх ярьж байгаа цаг үед нөгөө талд нь үүрэг гэдэг юм нь салшгүй явах ёстой юм болов уу даа. Энийг хэлдэг, ярьдаг, сануулдаг ахмадууд маань ертөнцийн жамаар өдөр болгон л цөөрч байгаа нь гашуун үнэн.

Тийм учраас энэ парламент дээр энийг бол яриарай гэсэн учраас би бас энэ хүний эрхийн асуудал яригдаж байгаа энэ цаг үед нэг дурдъя, хэлье гэж ингэж бодсон. Яах вэ ер нь зүгээр энэ хүний эрхийн асуудлууд хаана зөрчигдөж байна гээд олон улсын байгууллагууд ч энэ дээр Монгол Улсын холбогдох хууль хуулийн байгууллагууд ч тэр, парламент ч тэр, Эмнести Интернэйшнелээс авхуулаад зөвлөмжүүд хүргүүлдэг. Ер нь зүгээр Монгол Улсын төрд энэ Үндсэн хууль дээр заагдсан энэ хүний үүргийн, иргэний үүргийн биелэлт дээр хийсэн ер нь дүн шинжилгээ юмнууд байдаг уу? Жишээ нь НДШ-ээ төлсөн төлөөгүйгээс авхуулаад л яг адилхан юу хүлээгээд байдаг, НӨАТ төлдөггүйгээс болоод л л ингээд төлдөг хэсэг нь дарамт аваад суугаад байдаг гээд л ингээд л олон зүйлүүд байдаг аа.

Тэгэхээр энэ дээр ер нь хийсэн судалгаа шинжилгээ байгаа юу? Энийг бол үүргээ биелүүлж байгаа иргэдийн хувьд маш их ярьдаг юм гэдгийг хэлж тодруулъя гэж ингэж бодсон юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Нийгмийн харилцааг хамгаалдаг хууль бол Эрүүгийн хууль байгаа. Мөн Зөрчлийн хууль байгаа. Тэгээд хуулиудад заасан үүргээ биелүүлээгүй асуудал гэвэл бид нар энийг хариуцлагажуулах гэдэг юм уу, хариуцлага тооцох тэр механизм нь бол Зөрчлийн хууль байгаа. Тэгээд Зөрчлийн хууль байгаа мөн гэмт хэргийн шинжтэй бол Эрүүгийн хууль байгаа. Тэгэхлээр ер нь бол Идэрбат гишүүний асуудал бол ерөнхийдөө бид нар энэ хууль тогтоомжийг батлахдаа заавал хэрэгждэг байх хууль хэрэгждэг байх. Хуулийг хэрэгжүүлэхэд учирч байгаа саад бэрхшээл болон гишүүний хэлж байгаагаар үүргээ биелүүлэхгүй байхад нь хүлээлгэдэг хариуцлагын асуудлыг тодорхой болгох л ёстой юм билээ.

Ер нь хүн үүргээ гүйцэтгэх ёстой гэдэг энэ зарчим бол үнэн. Тэгэхдээ бид нар аль хуулийг барьж та ямар үүрэг гүйцэтгэх ёстойг шаардах вэ гэдэг ийм л асуудал байгаа учраас ер нь цаашдаа хууль тогтоомжийг батлаад тэгээд тодорхой субъектэд үүрэг хүлээлгэж байгаа бол бид нар зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх вэ гэдэг энэ асуудлаа л ярих ёстой гэсэн ийм байр суурьтай байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Тийм яах вэ энэ эрх яригдаж байгаа цаг үед би энэ үүргийг ярьж байгаа юм. Яах вэ үүргийн хэрэгжилтийг ярихын хувьд бол зөвхөн эрүү, иргэн байдаг юм уу хууль зүйн талаасаа биш энэ нийгмийн бүхий л салбарыг хамрах байх.

Тийм учраас би бол Улсын Их Хурлын даргад холбогдох яамдуудад энэ Үндсэн хууль дээр заагдсан энэ үүргийн биелэлтийн асуудлууд дээр бид анхаарах ёстой юм байна аа. Эрхээ ярьж байгаатай адил үүргээ хэрэгжүүлэх тал дээр бид санаачилгатай ажиллах ёстой байх гэж ингэж бодож энэ үгийг хэлж байгаа юм. Тэгэхээр Их Хурлын дарга бас энэ тал дээр цаашдаа анхаарч энэ үүргийн биелэлтийн асуудал үүргээ сайн биелүүлж байж нөгөө хүний маань эрх нь хангагдах олон зохицуулалтууд энэ нийгэм дээр байдаг учраас анхаараасай гэж ингэж бодож цаг авч хэлсэн юм гэдгийг тодотгож хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Алтангэрэл сайдын Хууль зүйн сайдаар томилогдсоноос хойших анхны багц хуулиуд орж ирж байна.

Тэгээд хүний эрхийг хангах энэ багц хуулиуд орж ирж байгаа нь сайшаалтай байна. Гэхдээ энэ хэдэн хуулиар зогсохгүй гэж бодож байгаа. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 900 гаруй хуулиуд дээр бараг л бүх хууль дээр л хүний эрхийн зөрчлүүд байгаа. Тэгээд та бүхэн ер нь энэ мөрдөгдөж байгаа хуулиуд дээр хүний эрхийн зөрчлийн асуудал эрхийг хязгаарласан асуудал ер нь нэг бүрчлэн судалгаа хийж үзсэн үү үгүй юу? Яагаад зөвхөн энэ 11 хуулийг оруулж ирж байгаа юм. Дараа нь ахиад ээлж дараагаараа хүний эрхийг хангахтай холбоотой хуулийн зөрчлүүд орж ирнэ байх гэж би хувьдаа бодож байна. Энэ хуулиуд тухайлбал бид нар сүүлийн үед ҮХЦ-ийн 3, 4 дүгнэлтийг хэлэлцэж байна шүү дээ. Хүлээн зөвшөөрөөд хүлээж авч байна. Энэ чинь өөрөө улс төрийн эрх, эвлэлдэн нэгдэх эрх, хэн нэгэнд давуу байдлыг олох, тэгээд тэгш байх зарчмыг алдагдуулсан Сонгуулийн хуульдаа л ингээд л л хүний эрхийг зөрччихсөн. Энийгээ Улсын Их Хурал хүлээн зөвшөөрч хүлээж авч хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах гээд л явж байна шүү дээ.

Тийм учраас ер нь маш олон хуулиуд дээр. Тэгээд би энэ нэн тэргүүнд орж ирж байгаа энэ хууль дотор Алтангэрэл сайд нөгөө иргэний эрхийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл биелэлт маш хангалтгүй байгаа. Би таныг бас нэг номерт энийг оруулж ирнэ байх гэж бодсон. Яагаад оруулж ирсэнгүй вэ?

Өнөөдөр иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн биелэлт 30 хүрэхгүй хувьтай явж байгаа. Тэгээд энэнээс чинь болж маш олон хэргийн хохирогч иргэд хохирч, эд материал, эрүүл мэнд, сэтгэл санаа, эдийн засгаараа хохироод л явж байгаа. Яах вэ эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл ерэн хэдэн хувьтай яваа. Гэтэл Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн биелэлтээс болж иргэний эрх зөрчигдөх асуудал маш түгээмэл байгаа даа. Тэгээд энийг би орж ирэх юм болов уу гэж бодсон. Та бид нар чинь энэ чиглэлээр гадаад дотоодын хуулийг судалж очиж үзэж байсан. Энэ хууль яагаад орж ирэхгүй байна. Энэ хэзээ орж ирэх юм. Наад зах нь л дийлэнх олонх нь нөгөө гэр бүл салалт түүнээс үүдэлтэй хүүхэд хүүхдийн тэтгэмжээ олгохгүй байх асуудал чинь л хамаг эх хувийг нь эзэлдэг юм байна лээ шүү дээ. Энэнээс болоод тухайн хүүхдийн сурах эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах гээд ингээд эрхүүд зөрчигдөж байгаа гээд л асуудал байвал байгаа.

Энэ дээр та цаашдаа юу бодож байна вэ? Хэзээ оруулж ирэх вэ? Энэ дээр нэг хариулт өгөөч ээ. Ер нь бусад багц хуулийн хүний эрхийг хангахтай холбоотой энэ хуулийн төслийг дэмжиж байна. Хүний эрхийн зөрчлүүд тодорхой хэмжээнд буурч байгаа нь сайшаалтай байна аа. Гэхдээ энэний цаана үүгээр зогсохгүй маш

олон улс төрийн эрх, эдийн засгийн эрх, эвлэлдэн нэгдэх эрх, үзэл бодол, жагсаж цуглах эрхүүд гээд бүгд шил шилээ дараад хүлээж байгаа шүү дээ. Энэ эрхүүдийн асуудал энэ хуулийн зөрчлийн асуудлууд үе шаттайгаар орж ирнэ гэдэгт найдаж байгаа шүү. Энэн дээр нэг хариулт өгчих.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Сандаг-Очир гишүүндээ баярлалаа. Тэгээд энэ хэвлэлийн эрх чөлөөний тухай, жагсаал цуглаан хийх журмын тухай яг одоо бас залгуулаад бид нар ЭХХШТХ буюу эрүүгийн процесст хүний эрхийг хангах тухай гээд хуулиуд маань ингээд цаашаа явна аа. Бид энэ Монгол Улсад хүний эрхийн төлөв байдал тулгамдсан асуудал гэдэг судалгаан дээр ер нь үндэслэж Монгол Улсын 800 хуульд хийсэн энэ хүний эрхийн судалгаан дээр үндэслэж бид нар явж байгаа. Хүний эрхийн зөрчлүүд байгаа. Тэгэхдээ янз янзын статистик тоо баримт байгаа. Бид нар сая Цэцийн дүгнэлттэй холбоотой асуудал гардаг шиг бид нар энэ асуудлуудыг цааш залруулахын төлөө ингээд ажиллаад дараа дараагийн хуулиудыг өргөн бариад явна. Өнөөдрийн 11 хуулиар хязгаарлагдахгүй гэдгийг хэлье.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн хуулийн төсөл яг энэ 7 хоногт бэлэн болж дууслаа. Одоо бид эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэл буюу энэ хорих анги хоригдлуудын хөдөлмөрийн чиглэлийн өөрчлөлтүүдээ хийгээд дуусчихвал ирэх 7 хоногийн нэг дэх өдрөөс эхлээд холбогдох байгууллагууд руу саналд гаргаж байгаа. Тэгээд энэ чуулгандаа бид нар багтааж энэ хаврынхаа чуулганд багтааж өргөн барих төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байгаа. Бидний ер нь явсан туршлага судалсан нэн ялангуяа ХБНГУ-ын шийдвэр гүйцэтгэлийн энэ туршлагаас судалсан, бусад орны хууль тогтоомжоос бид нар туршлагыг нь авсан зүйлүүд одоогийн манай хуулийн төсөлд нэлээн зонхилох байр суурь эзэлж байгаа.

Тухайлах юм бол түрүүн Идэрбат гишүүн тэр үүргийн тухай асуудал ярьсан. Хүүхдийн тэтгэлэгтэй үүргээ биелүүлдэггүй тийм эцгүүд мянга мянгаараа байна. Ямар нэг хариуцлага яригддаггүй ингээд аргалаад яваад байдаг. Энэ хүмүүст бид нар төрөөс үзүүлж болох үйлчилгээг ямар хүрээнд хязгаарлаж болох юм бэ? Үүргийг нь биелүүлэхийн тулд. Яаж бид нар албадлагын арга хэмжээ хийх юм бэ? Энийг боловсронгуй, болгоё. Дээрээс нь ямар нэг байдлаар хөдөлмөрийн чадваргүй ажил хөдөлмөр хийх бололцоогүй ийм хүмүүс дээр гарсан тэтгэлгийг бид яг Герман улсын жишгээр энэ сангаас буюу төрөөс бий болгосон сангаас өгөөд эргээд тэр этгээдүүдээсээ ямар нэг замаар олж авдаг энэ систем рүү бид нар шилжихгүй бол болохгүй байна аа.

Дээрээс нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн бол энэ процессын хуулиудаа бид тэр холбогдох байгууллагууд руу танилцуулангуут жишээлбэл банкны төлөөллүүд манай хуулийн төслийг харчхаад тэгж байсан. Яг ингээд ингэж батлагдаж чадах юм бол бид нар жишээлбэл банкны хүү бууруулна гэж хууль батлах биш ийм хуулийг батлаад өгвөл бид нарын энэ активын чанар сайжраад банкны үйл ажиллагаа хурдасаад харин жинхэнээсээ хүү буурахад нөлөөлөх болно шүү гэж ийм тайлбарыг хүртэл хэлж байсан. Тэгэхээр иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн хууль бол эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэл нийлээд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга тун удахгүй орж ирнэ ээ. Тэгээд тэр үед та бүхнийг дэмжиж өгөхийг хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Тэгээд энэ Сандаг-Очир гишүүн чухал зүйл хөндөж байгаа нь энэ хуулиудад байгаа хүний эрхийн зөрчилтэй заалтууд гэж яриад байгаа юм. Мэдээж энэ байна байхгүй гээд л янз янзаар л асуудалд хандаад байдаг. Тэр 2021 онд хийсэн манай энэ Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргалаар ахлуулсан хуульчдын баг ажиллаад үндсэндээ 318 хуульд заалт тус бүрээр нь судлаад үзэхэд 800 гаруй заалт хүний эрхийн зөрчилтэй байна гэсэн урьдчилсан тийм дүгнэлт гарсан. Гарчихсан байдаг юм. Ном товхимол нь хүртэл гарчихсан. Энэ дээр Улсын Их Хурлын гишүүд тэр ном товхимолтой нь танилцаад өөрсдөө энэ хуулиудын хүний эрхийн зөрчлийг арилгах дээр санаачилга гаргаад ажиллах бүрэн боломжтой.

Тэгээд өнөөдөр энэ хэлэлцсэн Хууль тогтоомжийн хууль хэлэлцэгдээд батлагдсаны дараа бас энэ боломжууд өргөн хүрээгээр нээгдэх боломжтой гэж бол үздэг юм байна лээ. Тэгээд их олон хууль дээр ийм асуудлыг хөндөх боломжтой.

Нэгдүгээрт байгаа заалт нь өөрөө хүний эрхийг зөрчиж байна гэдэг нэг асуудал гарч ирдэг.

Хоёрдугаарт шинэ тутамд бий болж байгаа харилцааг зохицуулж чадахгүй байгаад байгаа хуулиуд нь бас хүний эрхийн зөрчил үүсгэж байна гэдэг ийм ойлголт гарч ирдэг. Тэгэхээр эдгээр асуудлыг өргөн хүрээгээр авч үзэж явбал зохимжтой гэж Улсын Их Хурал талаас харж байгаа.

Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Өнөөдөр чуулганы хуралдаанаар хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой багц хуулийн төслийг танилцуулж хэлэлцүүлж байгаад зарчмын хувьд үзэл баримтлалын хувьд хувьд бүрэн дэмжиж байна аа. Миний хувьд энэ Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруул болох тухай хуулийн төсөл, Төрийн албаны болон албаны нууцын тухай хуульд оруулах хуулийн төсөл дээр нэг хэд хэдэн асуулт байна.

Харилцаа холбооны салбар бол Монгол Улсыг дэлхийд таниулах хөгжлийн стратегийн хувьд маш чухал салбар гэж тооцогддог. Энэ утгаараа тус салбарын үйл ажиллагааг зохицуулах байгууллага нь Харилцаа холбооны зохицуулах хороо. Энэ зохицуулах хорооны бие даасан болон мэргэжлийн байх, хараат бус байх байдлыг бэхжүүлэх асуудал өнөөдрийн маш тулгамдсан асуудал байгаа. Тэгээд энэ оруулж ирж байгаа хуулийн төсөлд олон нийтээс ялангуяа мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа эрхлэгч нар салбарын мэргэжлийн холбоодоос ямар саналуудыг авсан юм болоо гэдгийг 1 дүгээрт асууя.

Хоёрдугаарт хуулийн төсөлд зохицуулах хорооны бүрэлдэхүүнд ЗГХЭГ тэгээд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Худалдаа аж үйлдвэрийн танхим бизнесийн байгууллага, тэгээд иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл байхаар тусгасан байгаа юм. Тэгэхээр энэ ямар үндэслэл судалгаагаар энэ байгууллагын бүрэлдэхүүнд энэ бизнесийн танхим дурын нэг ийм иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг багтааж байгаа юм бол? Энэ нь тэгэхээр энэ байгууллагын бие даасан энэ хорооны мэргэжлийн хараат бус байх байдлыг илүү сайжирна гэж үзсэн юм болов уу? Тэгээд олон улсад ийм жишиг байгаа юм болов уу? Тэрийг судалж үзсэн үү?

Хоёрдугаарт энэ түрүүн Цогтгэрэл гишүүн асуулаа. Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах талаар? Тэгэхээр энэ Төрийн болон албаны нууцын тухай хууль урьд өмнө Монгол Улсын Үндсэн хуулиар ингээд нууцад хамаарах асуудлаар мэдээлэл хайх хүлээн авах гээд л эрхтэй гээд ингээд хуулиар бүүр ингээд тогтоож хамгаалчихсан байсан. Тэгэхээр 1995 онд анх Улсын Их Хурлаас Төрийн нууцын тухай хуулийг баталж төрийн нууцад хамааруулах зүйлсийн жагсаалт гэдгийг хуулиар батална гээд зохицуулсан байгаа юм. 2004 онд болохоор Төрийн нууцын жагсаалт батлах тухай гээд хуулиар төрийн нууцад хамаарах мэдээллийг бүүр жинхэнэ утгаар нь хуульчилж тогтоож ирсэн ийм түүх байна л даа.

Тэгэхээр 2016 онд Улсын Их Хурлаас дээрх энэ 2 хуулийг хүчингүй болгоод одоогийн энэ төрийн болон албаны нууцын тухай гэсэн нэршилтэй болгочихсон энэ хуулийг баталчихсан байгаа. Тэгэхээр энэ хуулиар албаны нууц гэсэн ийм нэршлийг бий болгоод энд ямар мэдээллийг хамруулах эсэх эсэхээ төрийн бүх байгууллага төрийн байгууллагын дарга нар, чиглэлийн Засгийн газрын гишүүн сайд нар ингээд баталдаг болчихсон. Тэгэхээр одоо өнөөдөр яг 1043 албаны нууцад хамаарах мэдээлэл байна гэдэг чинь асар их том тоо. Энэ сайдын мэдээлэлд сая танилцуулгад гарсан. Тэгэхээр энэ 1043 гэсэн энэ тоог хамрах хүрээ өнөөдөр энэ гажуудсаны нотолгоо гэж та үзэж байгаа юу? Энийг яаж тэгвэл энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар засаж сайжруулах бэлэн ахисан түвшинд сайн гарц шийдэл олсон болов уу гэж асуумаар байна.

Тэгээд одоогоор ингээд албаны нууцыг жагсаалтаар гаргаад тэрийг төрийн албаны дарга нар бар тэгээд сайд батлаад явчихаар энд нөгөө иргэдийн мэдээлэл авах мэдээллийг хайх тэр хүний эрх зөрчигдөж байгаа гэдэгтэй санал нийлж байна уу? Тийм ээ.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайдад хариулт өгье.

О.Алтангэрэл: Тийм ерөөсөө албаны нууц нь өөрөө шалгуур багатай байгаад байхаар дур зоргын асуудал л үүсээд байгаа юм. Одоо ингээд Алтангэрэл хүсэх юм бол энэ энэ зүйлүүдээ би албаны нууцад оруулъя гээд ингээд албан тушаалтны хувьд оруулчихдаг. Гэтэл тэр нь бол иргэн хүний тэр мэдэх эрхээ хэрэгжүүлэх, тэр мэдээлэл дээр үндэслэж шийдвэр гаргах, хүсэлт, гомдол гаргах бүх зүйлийг хааж байдаг.

Дээрээс нь энэ нийгмийг эрүүл байлгахад чухал нөлөөтэй. Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд тулгардаг томоохон саадүүдын нэг нь энэ мөн. Нэг л үгээр ам хаана. Энэ албаны нууц аа. Ер нь ямар нууцаа ч тодорхой хэлэхгүй шүү дээ. Энэ нууц нууцад автсан гэнэ. Тэгээд булан дээрээ нэг нууц гэсэн нэг улаан дардастай. Тэгээд энэ нууц нууцыг задруулж болохгүй гээд хамаг юм халхлагдаад байгаа учраас энэ бол хүний эрхийн томоохон зөрчил үүсгэж байна гэсэн Батчимэг гишүүний дүгнэлттэй 100 хувь санал нийлж байна аа.

Энэ өөрөө их хортой байгаад байгаа юм 1043 байгууллагын нууц гэдэг бол ер нь асар их тоо дэндүү их тоо. Тэгээд үнэхээр нууц юм уу үгүй юу гэдгийг чинь нэг шалгуураар үзээд энэ бол нууц юм байна. Энэ бол нууц биш юм байна гэх тэр шалгуур нь ерөнхий болохоор үзэмжээр шийдээд байгаа юм. Одоо бид нар шалгуураа нарийвчилъя. Яг чухам ийм л зүйлийг нууц гэнэ. Нэг жилд үзээд энэ бол жилийн эцэст үзээд танай наад албаны нууц гээд байгаа зүйлүүд чинь энэ энэ нууц биш байна гээд албан тушаалтанд хариуцлага тооцдог болчихъё. Ингэнгүүт албан

тушаалтан нууцад авахдаа энэ Төрийн болон албаны нууцын тухай хуулийг үзээд энэ шаардлагыг хангаж байгаа юм байна, ийм учраас нууцад авч байна гэдэг талаараа ингээд дэлгэрэнгүй тусгаад дараа нь хянаж шалгадаг энэ л тогтолцоог бид нар хийж өгье гэж байгаа юм.

Харилцаа холбооны зохицуулах хорооны хувьд бас энэ нэг иргэдийн мэдэх эрхтэй холбоотой асуудал л үүсээд байгаа юм. Харилцаа холбооны зохицуулах хороо бол төрөл бүрийн тусгай зөвшөөрлүүд өгдөг. Жишээлбэл энэ телевиз, радио гэдэг юм уу энэ долгионы зарим тохиолдолд ХМХ-ийн үйл ажиллагааг хязгаарлах хүртэл ийм эрх эдэлдэг ийм байгууллага. Гэтэл энэ чинь өөрөө төрөөс 100 хувь хамааралтай ингээд томилогддог байх нь эргээд иргэдийн мэдэх эрхийг зөрчиж байгаа юм биш үү гэсэн ийм асуудал байгаа учраас өнөөдрийн өөрчлөлтийн тухай асуудлыг ярьж байгаа юм аа.

Тэгээд тэр нөгөө байгууллагуудаас авсан санал хэдэн байгууллагаас ямар санал авсан. Ямар хариу өгсөн тухай манай ажлын хэсгээс нэмж тодруулаад тайлбар өгчихье. Жамъянхүү дарга.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон нэмж хариулт өгье.

Н.Жамъянхүү: Батчимэг гишүүний асуултад нэмж хариулъя. ХЗДХЯ Жамъянхүү. 2 хуулийн талаар асуулаа.

Нэгдүгээрт нь Төрийн болон албаны нууцын тухай хууль дээр бид нар гол нь нөгөө албаны нууцыг бол тавигдах шаардлагыг бол нэмж оруулж байгаа. Энэ дээр 2, 3 хөшүүр болгох заалтыг мөн оруулж байгаа. Жишээлбэл төрийн байгууллага, албан тушаалтан, бусад хуулийн этгээд нь хууль бус үйлдлийг нуух зорилгоор мэдээллийг албаны нууцад хамруулахыг хориглохоор ийм хориглосон зохицуулалт оруулж байгаа.

Дээр нь нэмээд энэ төрийн байгууллагууд өөрсдөө албаны нууцаа жагсаалтаа батлаад ТЕГ-аас бол тодорхой саналыг авсны үндсэн дээр нөгөө жагсаалтаа бол батлахаар ингэж гаргаж байгаа. Мөн дараагийн нэг зохицуулалт нь бол энэ албаны нууцад хамрах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээлэл байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх ийм зохицуулалт байгаа. Тэгэхээр өнөөдөр нийтийн мэдээлэл ил тод байдал.

Д.Амарбаясгалан: Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууя.

Б.Хэрлэн: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Тэгэхээр өнөөдөр хөдөлмөрлөх эрхийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг өшөө илүү тодорхой болгож Зөрчлийн хуульд өөрчлөлт оруулахаар оруулж ирж байгааа дэмжиж байна. Зарчмын хувьд дэмжиж хүлээж авч байна. Мэгээд энэ дээр хөдөлмөрлөх эрхтэй холбогдуулаад ялангуяа нөгөө ажлын байран дахь дарамт хүчирхийллийг энэ өшөө илүү ноогдуулах энэ хариуцлагыг нь тодорхой болгох тухай асуудлыг та энэ өөрчлөлтдөө бас хамруулах уу, үгүй юу гэдэгтэй холбогдуулж асуулт асууя аа.

Тэгэхээр олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцод хөдөлмөрийн харилцаанд хүн бүр хүчирхийлэл дарамтаас ангид байж хөдөлмөрлөх эрх эрхтэй байхаар ингээд заасан байдаг. Тэгээд олон улсын хөдөлмөрийн байгууллагын гишүүний хувьд манайх хөдөлмөрийн харилцааг зохицуулж байгаа хуулиуддаа тэр

тусмаа Хөдөлмөрийн хууль, Төрийн албаны тухай хууль ингээд цаашлах юм бол Зөрчлийн тухай хуулиудад ерөнхийдөө хөдөлмөрийн хөдөлмөрлөх эрхийг хангах хамгаалах тухай тодорхой заалтуудыг оруулж ирсэн байгаа.

Ялангуяа Хөдөлмөрийн хуульд болоод ирэхээр ажлын байрны дарамт хүчирхийлэлтэй холбоотойгоор аливаа хэлбэрийн дарамт хүчирхийллийг хориглоно гэж ингээд тодорхой заасан байгаад байдаг. Гэтэл өнөөдөр бизнесийн болоод төрийн байгууллагуудад эрх мэдэлтнүүд албан тушаалаа урвуулан ашиглаж ажил үүргээс нь гадуурх ажил үүргийг ажилтнууддаа хариуцуулах ажлын бус цагаар ажиллахыг шаардах, аягүй бол цаашлах юм бол насаар нь ялгаварлаж харьцах улс төрийн нам үзэл баримтлалаар нь ялгаварлан харьцах, улмаар ажлаас нь халах, өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдөх ийм хүсэлтээ өгөхийг шахах шаардах ийм байдлууд их гарч ирж байгаа. Энийг бол бид нар ер нь бас ойрын хэдэн жилд болсон хэд хэдэн энэ томоохон гашуун үйл явдлуудаас бид нар энийг ер нь анзаарсан. Зарим нэг хүний амь насанд хүрсэн явдал байгаа. Зарим нэг ганц нэг хүн бас амиа хорлох ийм явдал гарч байсан.

Тэгэхээр ажлын байрны энэ дарамт хүчирхийлэл гэдэг бол яах аргагүй хүнийг бие махбодын болоод сэтгэл санааны эд хөрөнгийн ийм хохиролд хүргээд байдаг ийм зүйл байгаа. Тэгээд энэ нь өнөөдөр хэдийгээр хуулийн энэ зохицуулалтууд хуулиудад тодорхой хэмжээгээр заагдсан хэдий ч гэсэн маш ерөнхий зохицуулалтууд байгаад байгаа учраас энэ тухай асуудал өнөөдөр хараахан шийдэгдэж чадахгүй байгаад байна гэж үздэг. Түүнчлэн судлаачдын үзсэнээр болоод ирэхээр ажлын байрны дарамт, хүчирхийллийн тухай нэгдсэн ойлголт өнөөдөр байхгүй байна аа. Хуулийн тайлбар толинд энэ ойлголт тодорхой заагдаагүй байна аа.

Тийм учраас хэн нэгэн ажлын байрны дарамт хүчирхийлэлд өртсөн хүн гомдол гаргахад тэр хүний эрхийн комисс ч байдаг юм уу тийм ээ. Байгууллагын удирдлага нь ч байдаг юм уу хөдөлмөрийн маргаан шийдвэрлэж байгаа байгууллага нь хууль шүүхийн байгууллагууд нь өөр өөр хариу өгөөд байна гэж. Зарим нь болохоор энийг дарамтад өртсөн байна гэж үздэг, зарим нь болохоор үгүй гээд. Тэгэхээр энэ бол яах аргагүй энэ талаарх ойлголт нэг мөр болоогүй байгаатай холбоотой. Тэгэхээр энэ тайлбарыг энэ тухай ойлголтыг тодорхой болгох тухай дээр та яг юу хийх гэж байна вэ? 1 дүгээрт.

Хоёрдугаарт одоо энэ ажлын байрны дарамт хүчирхийллийн тухай хууль дээрх хуулиудад өгсөн зохицуулалтууд нь маш ерөнхий байгаад байгаа учраас өөрөөр хэлэх юм бол энэ зөрчлөөс яаж сэргийлэх вэ яаж туслан зогсоох вэ, буруутай этгээдэд ямар хариуцлага ноогдуулах вэ? Хохирлыг яаж барагдуулах вэ гэдэг тухай асуудлууд нь бүрэн сайн тодорхой гарч ирээгүй байгаад байгаа учраас хаа хаанаа ойлголт нь цэгцрэхгүй энэ ажлын байрны дарамт үргэлжилсээр байна гэж үзээд байгаа.

Гуравт нь болоод ирэхээр ер нь бол манай дээр ажлын байрны дарамтыг сэргийлэх удирдах албан тушаалтны үүрэг хариуцлага хэрвээ яг энэ үүргээ биелүүлээгүй энэ хүнд ямар хариуцлага ноогдуулах юм бэ гэдэг нь тодорхойгүй байгаад байгаа.

Д.Амарбаясгалан: Нэг минут нэмж өгье.

Б.Хэрлэн: Ялангуяа байгууллагын удирдлагууд харсаар байж мэдсээр байж ажлын байрны дарамтыг нь таслан зогсоохгүй ингээд өөгшүүлээд явчихдаг. Тэгээд энэ нь бүүр ингээд нэг хэвийн зүйл мэт ингээд болоод явчхаад байдаг энэ тал бол амьдрал дээр элбэг байгаад байгаа. Тэгэхээр энэ хариуцлагыг нь тодорхой болгож өгөх ажлын байрны дарамт хүчирхийллийг таслан зогсоохгүй бол удирдах албан тушаалтанд ямар хариуцлага ноогдуулах юм бэ гэдгийг тодорхой болгож өгөх тал дээр та яг ямар арга механизмуудыг нэвтрүүлж гэж бодож байна? Энэ тал дээр та ямар бодолтой байна вэ гэдгийгээ.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хуульд энэ ажиллах хүчин болон хөдөлмөрийн хууль зөрчсөн зөрчлийн талаар нэмж оруулж өгч байгаа. Яг таны саяын асуусан хөндөж байгаа бид нарын шийдэх ёстой асуудлууд энд орж байгаа. Энэ дотроос мөн ажлын байрны дарамт орж байгаа.

Жишээ нь жирэмсэн эмэгтэй 3 нас хүрээгүй хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй, насанд хүрээгүй ажилтан, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр шөнийн цагаар ажиллуулахыг хориглосон ажилтныг шөнийн цагаар ажиллуулсан бол хүнийг 151 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно оо гээд ингээд оруулж байгаа юм. Тэр дарамт гэж юу болох юм бэ. Тэр хуулиа янз янзаар ойлгож байна гэдэг энэ асуудал бол ганцхан энэ хөдөлмөр эрхлэхтэй холбоотой төдийгүй манай хуулиудад нийтлэг байгаа нэг ийм зөрчил байгаа юм.

Тухайлах юм бол одоо энэ хэвлэлийн эрх чөлөөний хувьд хуулийн эргэн тойронд бид нар ярьж байгаа юм. Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулах гэдэг гэмт хэрэг байгаа юм. Энүүгээр нь ерөөсөө хүн шийтгэгддэггүй. Яасан гээд асуухаар сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэж юу юм бэ гэдэг энэ тодорхойлолт нь байхгүй байх жишээний. Тэгэхээр бид бол энэ удаад Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд эдгээрт ямар хэмжээний хариуцлага оногдуулах юм бэ гэдгээ хийгээд өгчихнө. Цаашдаа харин яг энэ нэр томьёо нь ойлгомжгүй хууль хэрэглээнд хүндрэл учирч байгаа. Энэ асуудлын зүгээс нэн ялангуяа таны саяын хэлж байгаа энэ яг ажлын байрны дарамт гэж аль хэсгээ хэлэх юм, ажлын байрны бэлгийн дарамт гэвэл ямар байх юм гээд энэ зүйлүүдээ материаллаг хэм хэмжээгээ тусгаж цаашаа боловсронгуй болгох шаардлага байгаа.

Бид энэ удаад энэ асуудлыг зөрчвөл ямар хариуцлага хүлээлгэх юм бэ гэдгийг л оруулж өгч байгаа юм аа.

Д.Амарбаясгалан: Бадарчийн Хэрлэн гишүүн тодруулж асууя.

Б.Хэрлэн: Одоо тухайлах юм бол хүний нэр хүндэд халдах, хүнийг доог тохуу хийх, хүнийг дээрэлхэх. Энэ тохиолдолд яг ямар шийтгэл ноогдуулж байгаа юм гэдэг таны энэ оруулж ирж байгаа төсөл дотор байхгүй байна лээ л дээ. Тэгэхээр одоо хүнийг үл хүндэтгэж харьцах, үйлдэл эс үйлдлээрээ хүнийг үл хүндэтгэж харьцах энэнд ямар шийтгэл ноогдуулах юм бэ? Хүнийг ялгаварлан харьцахад ямар шийтгэл ноогдуулах юм бэ гэдэг тухай дээр энийг эргэж харах хэрэгтэй юм байна гэж хэлмээр байгаа юм.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа. Энэ дээр Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дээр улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам эвсэл хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байна гэсэн ийм хориг ороод ирж байгаа юм.

Гэтэл Үндсэн хуулийн 16.10-ыг Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4, 37.1.5 зөрчөөд байна Алтангэрэл сайд аа. Энэ дээр та нэг анхаарч өгнө үү. Тэгээд үүнтэй үүнээс улбаалж 3 асуулт асууя.

Төрийн тусгай болон төрийн захиргааны албан хаагчдын улс төрийн эрхийг хааж болох болно гэж үзэж байгаа юм. Харин төрийн үйлчилгээний албан хаагчид буюу эмч багш нарын улс төрийн эрхийг ингэж хааж боогдуулах нь зөв үү хэр тохиромжтой вэ гэдгийг сайдаас асууя.

Хоёрдугаар асуудал бол Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын хүний эрхийн гэрээ фактуудаа энэ юу чинь зөрчөөд байна. Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл чинь. Тэгэхээр энийг та зөрчиж байна гэж үзэж байна уу?

Гуравдугаарт нь. Ер нь энэ багц хуульдаа төрийн үйлчилгээний албан хаагчдын улс төрийн намын гишүүн байх үйл ажиллагаанд оролцох эрхийг нээгээд өгвөл тийм боломж байна уу гэдгийг бас та юу гэж бодож байна вэ гэсэн ийм 3 асуулт байна аа. Ер нь бол энэ төрийн үйлчилгээний албан хаагчдын улс төрийн эрх бол яг энэ Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл дээр ноцтой зөрчигдөж байгаа нь маш их гомдол дагуулж байгаа. Энийг бол багш нар сая өнгөрсөн сонгууль дээр бол бид нарт маш их гомдол ирж байсан. Тэгэхээр энэ тал дээр бас анхаарч ажиллаач ээ. Ер нь бол энэ хүний эрхийн зөрчилтэй холбоотой бас нэг хуулийн чинь нэг ийм алдаатай юу чинь энэ дээр байгаа шүү гэдгийг анхааруулж хэлмээр байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Төрийн албаны тухай хуультай холбоотой өөрчлөлт энэ удаад бол үзэл баримтлалын хүрээнд, тэгээд энэ өргөн барьж байгаа төслийн хүрээнд огт ороогүй ээ. Тэгэхээр одоо энэ дээр энэ харилцааг зохицуулаагүй. Төрийн албаны тухай хуульд энэ чиглэлийн өөрчлөлтийг хүний энэ эдгээр төрийн албан хаагчдын улс төрийн эрх чөлөөг сайжруулах чиглэлээр ийм өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэж үзвэл энэ тусдаа хуулийн төсөл төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тусдаа хуулийн төсөл болоод тусдаа үзэл баримтлалтай ийм хуулийн төсөл болоод явна аа.

Бид нарын өнөөдөр ярьж байгаа энэ хүний эрх чөлөөг хангахтай холбоотой хуулийн төслүүдэд энэ агуулга байхгүй. Мөн одоо бидэнд байгаа судалгаан дээр одоо энд энэ улс төрийн эрх, эрх чөлөөг зөрчсөн байна ч гэдэг юм уу энэ тал дээр гарсан ямарваа нэг тийм дүгнэлт судалгаа бидэнд байхгүй байгааг хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ ээ.

Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн 2 дугаар индрээс.

Л.Мөнхбаясгалан: Хүний эрх, эрх чөлөөг хангах ямарваа хуулийн өөрчлөлтийг дэмжиж ажиллана. Дэмжиж үг хэлэх гэж байгаа. Гэхдээ энд сануулах юм байна. Энд хүний эрх эрх чөлөө гэхээр хоригдох цагдах ямарваа нэгэн гэмт хэрэг хүчирхийлэл юм шиг ханддаг. Энэ дээр өнөөдөр мэдэх эрх орж ирж байна. Албаны нууцын тухай хууль орж ирж байна. Энэ нь бас давуу тал гэж үзэж байна. Хүний алдар хүнд сэтгэл санааны хохирол гэдэг бол энэ хүний эрхийн зөрчил мөн гэдэг байр суурийг илэрхийлж байна.

Тухайлбал Тавантолгой компанийн захирал Батсуурь гэдэг хүн байсан. Тэр хүн шүүхээс 2 жилийн ял авсан. Дээд шүүхэд давж заалдсан. 2 жилийнхээ ялыг эдлээд дуусчихсан. Гараад ирчихсэн хойно Дээд шүүх тэр хүнийг үндэслэлгүйгээр ялласан байна гэдэг шийдвэр гарч байгаа байхгүй юу, 1 дүгээр жишээ. Энэ хүний тэр сэтгэл санаа, бие махбод, ар гэрт хохирсон хохирлыг яах вэ гэдэг асуудал.

Дээрээс нь Завханы Эрдэнэ-Очир гэдэг хүн хүн амины хэргээр 3 шатны шүүхээс ял авсан, цаазаар авах ял. Сүүлд нь Бүгд хурал дээр цагаатгасан. Тэр хүн хүн алаагүй нь тогтоогдсон. Ингээд иймэрхүү хэргүүд дээр болохоор нэг нөхөн төлбөр яригддаг. Нөхөн төлбөр явахад тэр Эрдэнэ-Очир гэдэг хүн дээр цаазын ял өгснөө шүүгч нь цагаатгах шүүх хурлыг хийсэн тохиолдол Монголд нэг удаа болсон. Энэ бол 2 ийм Эрүүгийн хуулийн жишээ татлаа.

Дээрээс нь хууль хяналтын байгууллага, улс төрийн ямар нэгэн PR-д ороод хүнийг шууд зарладаг. Жишээ нь нүүрсний 17 гэмт хэрэгтэн гээд л шууд АТГ гарч ирээд зарлаж байсан. Тэндээс ял авсан нь цөөхөн. Энэ тэр хүмүүсээс 4, 5 гишүүн энэ Улсын Их Хурлын танхимд сууж байгаа. Тэр хүний тэр хүний эрхийн зөрчлийг яаж тооцох юм. Эрүүгийн хуулиар бол ингээд нэг нөхөн төлбөр олдог юм байна. Би өөрөө хилс хэрэгт яллагдаж явж байсан. Тэр хуулийн хонгилоор чирэгдэж байсан. Тэр сэтгэл санааны хохирол, алдар хүндийн хохирлыг хүний эрхийн зөрчил гэж үзэж байгаа.

Тэгэхээр энэ заалтуудыг энэ асуудлуудыг холбогдох хуульд нь оруулж өгөхийг ажлын хэсгийнхнээс хүсье. Хууль санаачлагчаас хүсье.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн 1 дүгээр индрээс үг хэлье.

М.Мандхай: Би болохоор энэ хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг дэмжиж байгаа дэмжиж өөрийнхөө байр суурь илэрхийлэх гэж байгаа. Энэ хуулийн 8 дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх бүхий хуульчдад олон улсын гэрээ конвенцын ойлголт мэдээллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээтэй холбоотойгоор энэ хуульчдад мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ олон улсын энэ гэрээ конвенцыг ашиглах, мөн үндэсний хууль тогтоомж дахь зохих заалт

зүйл заалт зохицуулалтыг эдгээртэй уялдуулж хэрэглэх талаар зохих ойлголт зайлшгүй шаардлагатай байгаа.

Хуульчийн энэ үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт ч гэсэн тусах нь зүйтэй гэж дэмжиж байгаа. Мөн удахгүй энэ хэлэлцэгдэх Цагдаагийн албаны тухай хуульд тухайлбал олон нийтийн цаг даа энэ хууль сахиулах үүрэг гүйцэтгэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, Монгол Улсын энэ Үндсэн хууль энэ хууль болон бусад хууль тогтоомжийг чанд сахиж зөвхөн гэрээнд заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Гэтэл яг одоо үндсэндээ бол энэ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэнэ гэдэг энэ өөрөө утга агуулга, цаагуураа яг ямар зүйлийг илэрхийлээд байгаа юм бэ гэдгийг энэ цагдаа нар ялангуяа шинээр цагдаа болж байгаа энэ залуучуудад сайн ойлгуулахгүй бол энэтэй холбоотой ямар хэрэг гарсан бэ гэхээр энэ цагдаагийн албан хаагчид хүний эрхийн мэдрэмжгүй ажилладаг олон ийм асуудлууд үүссэн.

Тэгээд саяхан энэ ХЭҮК-ын гишүүн Хунангийн хэвлэлд өгсөн ярилцлагыг харж байсан. Хүний эрхийг одоо хүндэтгэхдээ тухайн кэйс тухайн энэ иргэнд эрх нь хүнддэх эрсдэлтэйг практикт яаж бууж байгааг жишээ кэйсээр тайлбарлаж ойлгуулж байх шаардлага хэрэгцээ байгаад байгаа. Бүүр шаардлагатай гэж үзэх юм бол энийг хуульд аягүй нарийвчлан тусгахгүй бол жишээлбэл сая энэ эмэгтэй бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдээс мэдүүлэг авах үеэр асууж байгаа асуулт нь том хүнээс асууж байгаа асуулттай 1-д, 2-т эмэгтэй хүүхдээс асуухдаа та бэлгийн хүчирхийлэлд хэдэн удаа, хаана, хэдийд одоо ямар байдлаар хүчиндүүлж байсан бэ ч гэдэг юм уу ийм ноцтой асуудлуудыг асууж байгаа нь өөрөө тэр цагдаа хүн ямар ч хүний эрхийн мэдрэмжгүй ийм асуултууд асуудаг.

Тэгээд энэ нь өөрөө юу гэж хэлж байна гэхээр өөрөө цагдаа хүн өөрөө хүний эрхийг хүндэтгэнэ гэдэг агуулгаа ойлгохгүй байгаа учраас хохирогчоос асууж байгаа асуултууд нь хүртэл ийм алдаатай байх жишээтэй.

Тийм учраас энэ хэлэх гээд байгаа асуудал нь энэ өөрөө хэрэгжүүлэхдээ хуульчийн энэ үргэлжилсэн тэр сургалт болон энэ явуулж байгаа олон улсын гэрээ конвенцод энэ хийж байгаа, хэрэгжүүлж байгаа процессыг хүртэл маш сайн мэдрэмжтэй мэдлэгтэй байлгахгүй бол манай дээр ийм хүнд асуудлууд үүсэж байна гэдгийг хэлэх гэж байгаа юм.

Хоёрдугаарт болохоор энэ Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулах шаардлагад хүний эрхийг хангах шалгуур бий болгох зохицуулалт бүхий Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай санал орж ирсэн байсан. Хүний эрхийг хангах шалгуур бий болгох нь өөрөө зүйтэй боловч эргээд нөгөө энэ хэрэгжилтийг үнэлэх арга аргачлал нь өөрөө байгаа юу гэдэг бас асуудлыг хөндөх нь зүйтэй байх. Тэгэхгүй бол манайх ингээд нөгөө шалгуур үзүүлэлт тавьчихдаг.

Тэгээд эргээд ТББ ч юм уу энэ төрийн алба ч юм уу эсвэл хөндлөнгийн байгууллага өөрөө тухайн шалгуур үзүүлэлтийг дараа нь үнэлэх гэхээр үнэлэх тэр аргачлал, тэр метод нь өөрөө тодорхойгүй байгаад байдаг. Тэгэхээр энийг ингээд хэтэрхий тунхгийн шинж чанартай явчих вий гэдэг утгаар энийг бас сайн тэр аргачлал нь өөрөө бас тодорхой.

Д.Амарбаясгалан: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн үг хэлнэ. 2 дугаар индэрт урьж байна.

Х.Тэмүүжин: Юуны өмнө хүний эрхийг хангахтай холбоотой зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль өргөн барьж байна. Нэг зүйлтэй үнэхээр санал нэгдэхгүй байна эсэргүүцэж байна. Тэр нь юу вэ гэхээр Эрүүгийн хуульд хүний нэр төрийг доромжлох гэдэг гэмт хэргийг буцаан бичих гэж байгаа юм байна. Гүтгэх доромжлох гэдэг энэ гэмт хэрэг Монгол Улсад яг ардчилсан улсад байдаг арга барилаараа огт байгаагүй. Энэ өөрөө социалист үзэл суртлын хамгаалах даргыг вакум дотор барьж нийгмээс нь тусгаарлаж тусдаа бурхан адил дахин шүтэхэд зориулагдсан Эрүүгийн хуулийн тийм зохицуулалт байсан. Энэ гүтгэх доромжлох гэдэг энэ гэмт хэргийг Эрүүгийн хууль дээр бичихээр хамгийн амжилттай сайн ашиглаж чаддаг хүмүүс нь бол дандаа эрх мэдэлтнүүд. Худал мэдээлэл тараах гэдэг Эрүүгийн хуулийн заалтын ард уламжлалт гүтгэх гэмт хэргийг бичээд энэ гэмт хэргийг хэний эсрэг хэн ашиглаж байна вэ гэдэг статистикийг харахад маш ойлгомжтой байгаа шүү дээ.

Дандаа төрийн албан тушаалтан, эрх мэдэлтнүүд хэвлэлийн эрх чөлөөг боомилох, чөлөөт дуу хоолойг хязгаарлах өөрсдийг нь шүүмжилсэн тэр шүүмжлэлийн эсрэг жадлан яллах зорилготой л ашиглаж байгаа. Одоо араас нь доромжлох ороод ирнэ. Доромжлох ороод ирэхээр нөгөө түрүүчийн хэлдгээр 76 мал гэж хэлэхээр аягүй бол дахиад шүүхдээд эхлэх байх л даа. Тэгээд ийм байдлаар уламжлал социалист гэмт хэргүүдийг ардчилсан хүний эрхийг хангах гэж байгаа Эрүүгийн хууль руу орж ирэх бол зохимжгүй ээ. Энэ дээр сөрөг байр суурьтай байна.

Энэ Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтүүд дотор бас авууштай дэвшилттэй санаанууд зөндөө байгаа.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээ авах талаарх ажлын хэсэг ажлын хэсгийнхээ хүрээнд ер нь 5-аас 6 хүрээний ажил хийх ёстой юм байна гэж харсан.

Тэрний хамгийн чухал нэг хэсэг бол Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах. Олон улсын конвенцын үзэл санаатай эрүүгийн хуулийн эрүүдэн шүүх энэ төрлийн гэмт хэргийг нийцүүлэх хэрэгцээ байгаа юм байна аа. Тэгэхгүй бол манайх их явцуу цонхоор явцуу байдлаар хуульчилснаасаа болоод ямар нэгэн тайлбар мэдүүлэг авах зорилгогүйгээр. Гэхдээ хүнийг чөлөөтэй зорчиж болохгүй байгаа тэр хэсэгт хүнлэг хэрцгий хандаад байгаа тэр хандлагыг энэ эрүү шүүлтийн хэсэг рүү оруулж ирж чадахгүй байгаа юм байна гэдэг тийм дүгнэлтүүд ОУБ-аас ч ирсэн, манай хүний эрхийн дотоод байгууллагуудаас ч ирсэн. ХЭҮК-ын илтгэлүүдэд ч гэсэн дурдагдсан байсан. Энийг засахаар бол оруулж ирж байгаа. Энэ бро дэвшилттэй. Энийг засахаасаа гадна ард нь бол дахиад 3 юм үнэхээр хийх ёстой. Эрүү шүүлтэд өртсөн иргэд чинь ер нь ихэнх тохиолдолд гүйцэтгэх ажил гэдэг далд үйлдэгддэг төрийн хамгийн хүчирхэг хэрэгслийн ард эрүү шүүлтэд өртөж байгаа. Мэдээлэл нь нууц байдаг. Чи хэрвээ энийг ил болгох юм бол энэнээс аймшигтай юмыг чинь гаргана шүү гэж хувийнх нь мэдээллээр дарамталдаг. Тэгэхээр энэ далд байгаа энэ зүйлийг ил болгохын тулд юу хийх ёстой вэ гэхээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд дагнасан байгууллага байгуулахаас өөр арга байхгүй.

Энийгээ байгуулахдаа нөгөө талдаа нөгөө хохирсон гэрч, хохирогчийг хамгаалдаг үндэснийхээ тогтолцоог сэргээхээс өөр арга байхгүй. Тийм учраас Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дурдагдсан байгаа гэрч,

хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог сэргээх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ингээд Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. Энэ асуудал болон өнөөдөр өмнө нь хэлэлцсэн асуудлуудын санал хураалтыг маргааш өглөө чуулганы хуралдааны эхэнд явуулна.

Тийм учраас өнөөдрийн нэгдсэн чуулган дээр хэлэлцэх асуудал дууслаа.

Чуулганы хуралдаан хаасныг мэдэгдье.

17.32 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА